



Нээлттэй
Нийгэм
Форум

Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын
Хүрээлэнгийн шинэ гарын авлага



Нээлттэй
Нийгэм
Форум

Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгийн шинэ гарын авлага

Орчуулсан: Г.БАТБАЯР

Хянан тохиолдуулсан: З.ЕРЭНДОО
Д.ЭНХЦЭЦЭГ

© Нээлттэй Нийгэм Форум
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан болно.

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүрэн эхээр нь хувилж, олшруулахыг хүсвэл доорх хаягаар хандан зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж -5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Хэвлэлийн хуудас: 28.4
Хэвлэсэн хувь: 1000

DDC
324,6'023
C-567
ISBN 978-99929-56-12-7



"BCI" Хэвлэлийн компани
Утас: 319032

Монгол Улс,
Улаанбаатар хот, 2010 он

Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын
Хүрээлэнгийн шинэ гарын авлага

Зохиогчид:

Эндрю Рейнольдс

Бэн Райлли

Эндрю Эллис

Хамтран бүтээсэн:

Жозе Антонио Чейбаб

Карен Кокс

Донг Лишенг

Юрген Эклит

Майкл Галлагер

Аллен Хикен

Карлос Хьюнеус

Еоген Хаский

Стина Ларсеруд

Вижэй Патидар

Найжел С.Робертс

Ричард Венгрофф

Жеффри А.Уэлдон

Цуврал гарын авлага

Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн (АСТОУХ)-ээс эрхлэн гаргадаг цуврал гарын авлагын зорилго нь ардчиллын янз бүрийн институци, ардчилсан үйл явцын талаарх харьцуулсан судалгаа, шинэ соргог мэдээлэл, ойлголтыг түгээн дэлгэрүүлэхэд оршино. Эдгээр гарын авлагыг юуны өмнө бодлого боловсруулагчид, улстөрчид, иргэний нийгмийнхэн болон холбогдох чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдэд зориулан боловсруулсан. Цуврал гарын авлага нь судлаачид, ардчиллыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байгууллага, хүмүүсийн сонирхлыг мөн татна хэмээн найдаж байна.

АСТОУХ-ийн нийтлэл тодорхой нэг улс орны хийгээд улс төрийн ашиг сонирхлыг илэрхийлдэггүй. Энэхүү гарын авлагын агуулга нь АСТОУХ, түүний Удирдах зөвлөл, тэрчлэн Зөвлөлийн гишүүдийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Энэ номд танилцуулсан газрын зураг нь тус Хүрээлэнгийн зүгээс аливаа нутаг дэвсгэрийн эрх зүйн байдлыг үнэлж дүгнэх, эсвэл хил хязгаарыг нь хүлээн зөвшөөрч баталгаажуулах санаа агуулаагүй бөгөөд ямар нэг улсыг байрлуулсан байдал эсвэл дүрсэлсэн хэмжээ нь тус Хүрээлэнгийн улс төрийн үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг тэмдэглэе.

© Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн 2005

Энэхүү номыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн дахин хэвлэх, орчуулах зөвшөөрөл авах хүсэлтийг дараах хаягаар ирүүлнэ үү:

Information Unit
International IDEA
SE-103 34 Stockholm
Sweden

АСТОУХ өөрийн бүтээлийг түгээн дэлгэрүүлэхийг дэмждэг бөгөөд энэхүү номыг дахин хэвлэх, орчуулах зөвшөөрөл хүссэн тохиолдолд шуурхай хариу өгөх болно.

График дизайныг Magnus Alkmar
Хавтасны зургийг © Pressens Bild
Хэвлэсэн: Trydells Tryckeri AB, Sweden
ISBN: 91-85391-18-2



Electoral System Design:

The New International IDEA Handbook

Andrew Reynolds
Ben Reilly
and Andrew Ellis

With
José Antonio Cheibub
Karen Cox
Dong Lisheng
Jørgen Elklit
Michael Gallagher
Allen Hicken
Carlos Huneeus
Eugene Huskey
Stina Larsrud
Vijay Patidar
Nigel S. Roberts
Richard Vengroff
Jeffrey A. Weldon

Handbook Series

The International IDEA Handbook Series seeks to present comparative analysis, information and insights on a range of democratic institutions and processes. Handbooks are aimed primarily at policy makers, politicians, civil society actors and practitioners in the field. They are also of interest to academia, the democracy assistance community and other bodies.

International IDEA publications are independent of specific national or political interests. Views expressed in this publication do not necessarily represent the views of International IDEA, its Board or its Council members. The map presented in this publication does not imply on the part of the Institute any judgement on the legal status of any territory or the endorsement of such boundaries, nor does the placement or size of any country or territory reflect the political view of the Institute. The map is created for this publication in order to add clarity to the text.

© International Institute for Democracy and Electoral Assistance 2005

Applications for permission to reproduce or translate all or any part of this publication should be made to:

Information Unit

International IDEA

SE -103 34 Stockholm

Sweden

International IDEA encourages dissemination of its work and will promptly respond to requests for permission to reproduce or translate its publications.

Graphic design by: Magnus Alkmar

Cover photos: © Pressens Bild

Printed by: Trydells Tryckeri AB, Sweden

ISBN: 91-85391-18-2

Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлыг сонгох тогтолцоог өөрчлөх талаар ид хэлэлцэж буй энэ үед бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид, сонгуулийн тогтолцоог сонирхон судалдаг хэн бүхэнд зориулан Нээлттэй Нийгэм Форумгаас *Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт* номыг орчуулан хүргэж буйдаа баяртай байна.

Шведэд төвтэй Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгээс эрхлэн гаргасан уг номд 1990-ээд оноос хойш дэлхий даяар эрчимтэй өрнөсөн бүх нийтийн, чөлөөт сонгуулийн тогтолцоог хөгжүүлэхэд гарсан ололт амжилт, алдаа дутагдал, сонгуулийн тогтолцооны улс төр, нийгэмд үзүүлэх нөлөө, эерэг, сөрөг талыг сонирхолтой жишээ баримтад тулгуурлан энгийн ойлгомжтой тайлбарласан юм. Хэвлэгдсэнээсээ хойш 10 гаруй хэлээр орчуулагдан дэлхий олон орны уншигчдын хүртээл болсон энэхүү ном Монголын уншигчдын гарт очсоноор сонгуулийн тогтолцоог шинэчлэх асуудлыг олон улсын туршлага, сургамжийг харгалзан олон талаас нь нухацтай хэлэлцэн, өөрийн орны онцлог нөхцөлд зохицсон оновчтой шийдэлд хүрэхэд тус дөхөм болно хэмээн Нээлттэй Нийгэм Форум найдаж байна.

Монгол Улс 1990 оноос хойш Улсын Их Хурлыг сонгох сонгуулийн тогтолцоогоо өөрчилж ирсэн түүхтэй. Сонгуулийн тогтолцоог ийнхүү удаа дараа өөрчлөх болсон нэг шалтгаан нь тухайн тогтолцооны үзүүлж болох нөлөө, давуу болон сул талыг сайтар судалж, улс орныхоо нийгэм, улс төрийн нөхцөл байдал, цаашдын хөгжлийн төлөвт тохируулан зөв сонголт хийх асуудалд тулхтай хандаж тэр бүр чадаагүйтэй холбоотой. Үүний нэг тод жишээ нь 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийг олон мандаттай тойрог бүхий олонхийн тогтолцоогоор зохион байгуулсан явдал юм. Олон улсад багц саналын тогтолцоо гэж нэрийддэг уг тогтолцоог улс төрийн нам огт байхгүй буюу маш сул хөгжсөн орнууд сонгож авдаг байна. Харин улс төрийн намын институцийг хөгжүүлэх гэж эрмэлзэж буй орнуудын хувьд үүнээс татгалзсан жишээг Тайланд, Филиппин зэрэг олон орноос харж болно. Сонгуулийн тодорхой тойрогт нэг намаас нэр дэвшигчид өөр хоорондоо өрсөлдөн хагарал зөрчил үүсэх, хүч тарамдахад хүргэдэг нь энэ тогтолцооноос зайлсхийх гол шалтгаан болдог ажээ. Түүнчлэн сонгогчдын санал олноор гээгдэх явдал түгээмэл ажиглагддаг. Энэ мэтчилэн 2008 оны сонгуулиар өмнөх тогтолцооны олон сул талыг

давтсан төдийгүй улам дордуулсан байдал ажиглагдсан билээ. Тухайлбал, саналын хуудас тоолоход ихээхэн хүндрэл учирч сонгуулийн дүн гарах нь удааширч, улмаар олон маргаан гарч, зарим нь удаан хугацаанд шийдэгдэхгүй сунжирсан сургамж байна.

Улсын Их Хурлаас энэ удаад сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулахдаа улс орны хөгжлийг урагшлуулах тогтвортой, хяналттай, ард түмний хүсэл зоригийг бүрэн илэрхийлсэн төр засаг бүрэлдэх нөхцөлийг хангасан, урт хугацаанд тогтвортой хэрэгжих шийдэлд хүрнэ гэж гүнээ найдаж байна.

П.Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд “Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй” гэж заасан байдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь 1945 онд байгуулагдсан цагаасаа хойш сонгуульд дэмжлэг үзүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж, ардчилал, улс төрийн эрхийн зарчмуудыг бататган бэхжүүлэхийн төлөө ажиллаж байна.

НҮБ-аас сонгуулийн чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг Камбож, Эль Сальвадор, Мозамбикт, саяхнаас Афганистан, Иракт хэрэгжүүлсэн энхийг сахиулах болон бэхжүүлэх олон талт үйл ажиллагаатай холбож үзэх нь олонтаа. Гэвч эдгээр үйл ажиллагаа нь НҮБ-аас дэлхийн 50 гаруй оронд ардчилсан сонгуулийн үйл явцад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зөвхөн нэгээхэн хэсэг нь л юм.

Энэ үйл явцын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг бол сонгуулийн тогтолцоогоо сонгох явдал. Үүнийг үндсэн хуулийн болон төрийн институцийн илүү өргөн хүрээтэй бүтэц тогтолцооноос салган авч үзэх аргагүй. Сонгуулийн тогтолцоо нь сөргөлдөөнийг зохицуулах, хүйсийн тэгш байдлыг хангах, улс төрийн намын тогтолцоог хөгжүүлэх зэрэг олон талбарт шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. Зөв зүйтэй төлөвлөсөн сонгуулийн тогтолцоо нь улс төрийн өөрчлөлтөд эрч хүч нэмж, иргэдийн оролцоог хөхиүлэн дэмжихээс гадна улс орны өмнө тулгамдсан олон асуудлыг ойрын үед болон алсдаа шийдвэрлэх чадавхи бүхий хууль ёсны төлөөлөгчид сонгогдох боломжийг бүрдүүлдэг. Харин сонгуулийн тохиромжгүй тогтолцоог сонговол энэ нь улс орон ардчиллын замаар ахиж дэвшихэд саад тотгор болоод зогсохгүй улс төрийн тогтвортой байдлыг ч алдагдуулах үр дагавартай.

Сонгуулийн тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалтыг шийдэх үйл явц зөвхөн улстөрчид, сонгуулийн байгууллага төдийгүй иргэний нийгмийн байгууллагууд, судлаач-тайлбарлагчид, хамгийн гол нь ардчилсан шинэчлэлхийж буй улс орны ардиргэдийн харилцан ойлголцол, итгэлцэлд түшиглэн өрнөсөн цагт амжилтад хүрнэ. Сонгуулийн тогтолцооны зохиомж, бүтэц зохион байгуулалтыг зөвхөн тухайн үеийн нөхцөл байдалд тохируулах төдийгүй ирээдүйд иргэдийн сонгуульд оролцох хүсэл эрмэлзэл, хандлага, зан байдалд гарах өөрчлөлтийг ч харгалзан хийх ёстой. Сонгуулийн тогтолцоо нь ардчилал тогтвортой хөгжихөд тус болохын сацуу түүний хөгжилд томоохон чөдөр тушаа ч болох нь бий.

Иймээс миний бие Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэнгээс хэвлэн гаргаж байгаа энэхүү шинэ гарын авлагыг нэн талархалтайгаар хүлээн авч байна. Энэ номд сонгуулийн тогтолцоо, түүний үр дагаврын тухай маш чухал мэдлэг мэдээллийг багтааж, нарийн түвэгтэй ойлголтуудыг хүртээмжтэй байдлаар тайлбарлан танилцуулжээ. Ардчилсан шилжилт, шинэчлэлийн үйл явцын гол асуудлуудыг практик талаас нь дэлхийн цар хэмжээнд авч үзсэн, энгийн, ойлгомжтой байдлаар бичигдсэн зэрэг нь энэхүү гарын авлагыг тогтвортой ардчиллыг хөгжүүлэх үйлсэд гар бие оролцож буй хүн бүрт чухал хэрэгтэй ном болгожээ. Энэ номыг дэлхийн өнцөг булан бүрт сонгуультай холбоотой үйл ажиллагаа явуулж буй нийт хүмүүсийн хүртээл болгож өргөнөөр уншуулах нь зүйтэй бөлгөө.

Карина Перелли
НҮБ-ын Сонгуулийн тусалцааны хэлтсийн дарга

Сонгуулийн олон янзын тогтолцоо, тэдгээрийн нөлөөг өргөн хүрээтэй судлах ажлыг эхлүүлсэн Морис Дювержэгийн бүтээл анх гарснаас хойш 50 жил өнгөрчээ. Гэвч улс төрийн бодит ертөнцөд энэхүү судалгааны үр нөлөө олон жилийн турш хязгаарлагдмал байв. Улс төр судлаач эрдэмтэд болоод шийдвэр гаргагчид тэр бүр хоорондоо холбогдон ажиллаж байсангүй, түүнчлэн хүйтэн дайны үед дэлхийн улс орнуудад хийгдэж байсан институцийн өөрчлөлтийн цар хүрээ ч хязгаарлагдмал байлаа.

1990-ээд оноос сонгуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, шинэчлэх үйлсэд үсрэлт гарсан бөгөөд ялангуяа Африк, Ази, Зүүн Европ, Латин Америкийн ардчиллыг шинээр тогтоосон улс орнууд, түүнчлэн хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнууд улстөр, сонгуулийн тогтолцоогоо идэвхтэй шинэчилж, ямар боломж, туршлага байгааг энд тэндээс эрж хайж, судалж эхэлсэн билээ. Харьцуулсан судалгаа, мэдээллийн энэхүү шинэ эрэлт хэрэгцээний хариуд ардчилал, сонгуулийг төгөлдөржүүлэх, энэ чиглэлээр туслалцаа үзүүлэх зорилго бүхий олон улсын шинэ байгууллага АСТОУХ (IDEA)-ээс *Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтын тухай АСТОУХ-ийн гарын авлага* хэмээх анхны номоо 1997 онд хэвлүүлсэн юм. Түүнээс хойш энэ ном өргөнөөр хэрэглэгдэх болж, уншигчдын талархлыг хүлээсээр ирсэн. Гарын авлагыг АСТОУХ-ийн цахим хуудсанд тавьж, CD-ROM хэлбэрээр тарааснаас гадна Франц, Испани, Араб, Бирм хэлээр хэвлэн гаргаад байна.

Энэ ном ийнхүү ямагт эрэлт хэрэгцээтэй байж ирсэн ч анх хэвлэгдэн гарснаас хойших хугацаанд сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр олон шинэ зүйл, ахиц дэвшил гарчээ. Энэ хугацаанд цөөнгүй улс орон сонгуулийн тогтолцоогоо өөрчилсөн бөгөөд тэдгээрээс авах сургаж их байна. Сонгуулийн тогтолцоо хийгээд улс төрийн намын систем, ардчилсан институцийн тогтолцоо хоорондын хамаарлын талаар хүмүүс илүү өргөн ойлголттой болсон нь ялангуяа ардчиллыг шинээр тогтоосон орнуудад ажиглагдаж байна. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх гэдэг бол зүгээр нэг техник асуудал биш, олон нийтийн мэтгэлцээн, нухацтай зөвшилцөл шаардсан улс төрийн үйл явц гэдгийг бүр ч тодорхой ойлгож хүлээн зөвшөөрөх болсон байна. Энэ утгаараа сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт нь зөрчлийн удирдлагын стратегийн маш чухал арга хэрэгсэл болдог бөгөөд тогтвортой ардчиллын бат бэх үндэс суурийг тавихад тус дөхөм үзүүлдэг.

АСТОУХ-ээс *Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт: АСТОУХ-ийн шинэ гарын авлага* хэмээх энэхүү номыг арван жилийнхээ ойн арга хэмжээний нэг болгон гаргаж байна. Анхны хэвлэлийн үндсэн эхийг хадгалахын хамт түүнийг сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн үйл явцын холбогдолтой шинэлэг материал, жишээ баримтаар баяжуулж, төлөөллийн чанар, зөрчил мөргөлдөөний дараа тулгарах сорилтууд, шууд ардчиллын боломжуудыг ашиглах зэрэг хэд хэдэн тодорхой асуудлыг нэмж тусгаснаараа шинэ гарын авлага онцлог юм. Мөн дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцооны шинэчилсэн жагсаалтыг газрын зураг, хавсралт, хүснэгтээр харуулсан байгаа. Үүний үр дүнд ардчиллыг бэхжүүлэх үйлсэд хичээн зүтгэж буй хэн бүхэнд тус болох нийтэд хүртээмжтэй, хэрэгтэй ном болсон гэж бид найдаж байна. Энэхүү гарын авлагын талаар та бүхний санал, хүсэлтийг бид дуртайяа хүлээн авах болно.

Карен Фогг
АСТОУХ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга

Өмнөтгөл.....	I
Өмнөх үг.....	III
Оршил.....	V
Товчилж хураангуйлсан үгс.....	XIII
1. ЕРӨНХИЙ ТОЙМ.....	1
Удиртгал.....	1
Гарын авлагыг хэрхэн ашиглах вэ?.....	4
Сонгуулийн тогтолцоо гэж юу вэ?.....	7
Сонгуулийн тогтолцооны ач холбогдол.....	7
Сонгуулийн ба намын тогтолцоо.....	8
Сонгуулийн тогтолцоо ба зөрчлийн удирдлага.....	8
Сэтгэл зүйн болон механик нөлөө.....	9
Ерөнхий нөхцөл байдлын нөлөө.....	9
Ардчиллын тогтолцоо.....	10
Бүтэц, зохион байгуулалтын шалгуур.....	13
Төлөөллийг хангах нь.....	13
Сонгуулийг нийтэд хүртээмжтэй, утга учиртай болгох нь.....	14
Эвлэрэн зохицох итгэлцлийг бий болгох нь.....	15
Тогтвортой, үр бүтээлч засгийн газрыг дэмжих нь.....	16
Төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь.....	17
Сонгогдсон төлөөлөгчтэй хариуцлага тооцох нь.....	18
Улс төрийн намуудыг дэмжин хөгжүүлэх нь.....	18
Хууль тогтоох байгууллагад сөрөг хүчний хяналтыг хөхиүлэн дэмжих нь.....	19
Сонгуулийн үйл явцыг тогтвортой болгох нь.....	20
Олон улсын стандартуудыг харгалзан үзэх нь.....	20
Дүгнэлт.....	21
Өөрчлөлтийн үйл явц.....	22
Хэн боловсруулах вэ?.....	22
Шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ямар механизмууд байна вэ?.....	28
Хэлэлцүүлэг, санал солилцох ажиллагааны талаарх зөвлөгөө.....	30
Хэрэгжүүлэх талаарх зөвлөгөө.....	31
Өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэх нь.....	32
Сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн чиг хандлагууд.....	33
Бүтэц, зохион байгуулалтын бүрэлдэхүүн хэсэг.....	35

2. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ЕРТӨНЦ	37
Олонхи/дийлэнхийн тогтолцоо.....	39
Хувь тэнцүүлсэн тогтолцоо.....	39
Холимог тогтолцоо.....	40
Бусад тогтолцоо.....	40
3. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	47
Олонхи/дийлэнхийн тогтолцоо.....	47
Олонхи/дийлэнхийн тогтолцоо гэж юу вэ?.....	47
Харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ).....	47
Багц саналын тогтолцоо (БСТ).....	59
Намын багц саналын тогтолцоо (НБСТ).....	64
Альтернатив саналын тогтолцоо (АСТ).....	65
Хоёр шатлалт тогтолцоо (ХШТ).....	71
Хувь тэнцүүлсэн тогтолцоо	79
Хувь тэнцүүлсэн тогтолцоо гэж юу вэ?.....	79
Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ).....	83
Санал шилжүүлэх тогтолцоо (СШТ).....	100
Хувь тэнцүүлэх зарчимтай холбоотой асуудлууд.....	108
Тойргийн хэмжээ.....	108
Босго.....	116
Нээлттэй, хаалттай болон чөлөөт жагсаалт.....	117
<i>Холбоотны журмаар ажиллах нь</i>	126
Холимог тогтолцоо	126
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ).....	127
Параллель тогтолцоо.....	146
Бусад тогтолцоо	158
Санал үл шилжүүлэх тогтолцоо (СҮШТ).....	158
Хязгаарлагдмал саналын тогтолцоо (ХЯСТ).....	164
Борда тооллого (БТ).....	165
Сонгуулийн тогтолцооны давхарга ба эрлийз тогтолцоо	166
Төлөөллийн тухай асуудлууд	169
Эмэгтэйчүүдийн төлөөлөл.....	169
Үндэсний цөөнхийн төлөөлөл.....	171

Нийгмийн бүлгийн төлөөлөл.....	172
Сонгууль явуулах тов	174
Зайнаас санал өгөх арга	174
Ирцийн асуудлууд	175
Зөрчил мөргөлдөөний дараах болон шилжилтийн үеийн сонгууль.....	176
4. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ИНСТИТУЦИЙН БҮТЭЦ БА ЗАСАГЛАЛ.....	179
Ерөнхийлөгчийн сонгууль.....	180
Харьцангуй олонхийн тогтолцоо.....	181
Хоёр шатлалт тогтолцоо (ХШТ).....	184
Эрэмбэт саналын тогтолцоо.....	186
Газар зүйн хувьд саналын хуваарилалтад тавих нөхцөл.....	188
Дээд танхимын сонгууль.....	190
Засаглалын янз бүрийн шат давхарга	191
Улсуудын холбооны байгууллагын сонгууль.....	192
Холбооны болон мужийн сонгууль ба автономит нутаг дэвсгэр дээр явагдах сонгуулиуд ..	198
Орон нутгийн байгууллагуудын сонгууль.....	198
Сонгуулийн тогтолцоо ба улс төрийн намууд	205
Шууд ардчиллын боломжууд.....	206
5. СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ӨРТӨГ ЗАРДАЛ.....	209
6. БОДЛОГО БОЛОВСРУУЛАГЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ.....	217
Хүснэгт, зургийн жагсаалт	
Хүснэгт 1. Сүүлийн үед сонгуулийн тогтолцоонд хийгдсэн өөрчлөлт	34
Хүснэгт 2. Улс орнууд хууль тогтоох байгууллагаа сонгон бүрэлдүүлэхэд ашиглаж буй сонгуулийн тогтолцоо	41
Хүснэгт 3. Үндэсний хууль тогтоох байгууллагыг сонгож буй сонгуулийн тогтолцооны хувилбарын хэрэглээг газар нутгаар үзүүлсэн нь	42
Хүснэгт 4. ХХТТ-г ашиглаж буй орнууд	127
Хүснэгт 5. Параллель тогтолцоо ашиглаж буй орнууд.....	157
Хүснэгт 6. Хувь тэнцүүлсэн тогтолцооны хувилбарууд.....	166
Хүснэгт 7. Сонгуулийн тогтолцооны таван хувилбар: давуу ба сул талууд	167
Хүснэгт 8. Сонгуулийн 12 тогтолцооны зардал ба зохион байгуулалтыг харьцуулсан нь	213
Зураг 1. Сонгуулийн тогтолцооны төрөл зүйл.....	38
Зураг 2. Сонгуулийн тогтолцооны төрөл зүйл: Улс орнуудын тоо	43

Жишээ:

Бритиш Колумбия.....	24
Энэтхэг улс.....	52
Палестин	61
Папуа Шинэ Гвиней	68
Киргизстан.....	74
Өмнөд Африк.....	87
Индонези	93
Бүгд Найрамдах Ирланд Улс.....	101
Чили Улс	109
Бразил Улс	120
Лесото Улс	129
Мексик Улс.....	135
Шинэ Зеланд Улс	141
Тайланд Улс	148
Сенегал Улс	153
Япон Улс	160
Европын Парламент	193
Хятад Улс	200

Хавсралтууд

Хавсралт А.....	226
Хавсралт Б	234
Хавсралт В	243
Хавсралт Г	249
Хавсралт Д	252
Хавсралт Е	254
Хавсралт Ё	260
Хавсралт Ж	262

Товчилж хураангуйлсан үгс

АҮК	ANC	Африкийн Үндэсний Конгресс
АСТ	AV	Альтернатив санал
БСТ	BV	Багц санал
БТ	BC	Борда тооллого
ЖХТТ	List PR	Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо
НБСТ	PBV	Намын багц саналын тогтолцоо
НМТ	SMD	Нэг мандаттай тойрог
ОМТ	MMD	Олон мандаттай тойрог
СТБ	EMB	Сонгуулийн төв байгууллага
СҮШТ	SNTV	Санал үл шилжүүлэх тогтолцоо
СШТ	STV	Санал шилжүүлэх тогтолцоо
ХОТ	FPTP	Харьцангуй олонхийн тогтолцоо
ХТТ	PR	Хувь тэнцүүлсэн тогтолцоо
ХХТТ	MMP	Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо
ХШТ	TRS	Хоёр шатлалт тогтолцоо
ХЯСТ	LV	Хязгаарлагдмал саналын тогтолцоо

БҮЛЭГ 1

БҮЛЭГ 1

1. Ерөнхий тойм

Удиртгал

1. Сонгуулийн ямар тогтолцоог сонгох вэ гэдэг нь аливаа ардчилсан улс орны улс төрийн институцийн хувьд хамгийн чухал шийдвэрийн нэг байдаг. Сонгон авсан тогтолцоо нь улс орны улс төрийн ирээдүйн амьдралд гүн гүнзгий нөлөө үзүүлдэг бөгөөд тухайн тогтолцоог дэмжих улс төрийн сонирхол бэхжихийн хэрээр удаан хугацаанд тогтвортой хадгалагддаг. Сүүлийн үед сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтад ул суурьтай хандах байдал ажиглагдах болов. Урьд өмнө нь сонгуулийн тогтолцоог одоогийнх шиг ухамсартайгаар зориуд сонгох явдал ховор байлаа. Сонголт нь үндсэндээ тохиолдлын чанартай, тухайн үед үүссэн онцгой нөхцөл байдлын үр дагавар, ерөнхий хандлага, түүхийн тодорхой агшин, колончлолын болоод хүчирхэг хөрш орнуудын нөлөөн дор хийгдэх нь түгээмэл байв.

2. Ардчилалд шинээр хөл тавьсан аливаа улс орон хууль тогтоох байгууллагаа сонгохын тулд сонгуулийн аль нэг тогтолцоог сонгох (эсвэл өвлөн авах) хэрэгтэй болдог. Ардчилал тогтсон улс оронд ч улс төрийн хямрал, шинэчлэлийн төлөөх хүсэл эрмэлзлэл сонгуулийн тогтолцоог өөрчлөхөд хүргэж болно. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх, эсвэл хэвээр үлдээх шийдвэрт гол төлөв дараах нөхцөл байдлын аль нэг нь нөлөөлсөн байдаг. Үүнд:

- суурь мэдлэг, мэдээлэл дутсанаас улстөрчид сонгуулийн тогтолцооны янз бүрийн хувилбар, тэдгээрийн үр дагаврыг бүрэн ойлгож мэдээгүй байх,

- эсвэл эсрэгээрээ, улстөрчид сонгуулийн тогтолцооны талаарх мэдлэгээ өөрсдийн намдашигтай гэж үзсэн бүтэц, зохион байгуулалтыг сонгоход ашиглах.

Сонгуулийн тогтолцоог амьдралд хэрэгжүүлэх үед урьдаас тааварлаж байсан болон урьдчилан тооцоогүй үр дагавар үүсэн гарч болно. Сонгосон тогтолцоо нь урт хугацаанд тухайн улс орны улс төрийн эрүүл саруул байдалд тэр бүр таарч тохирохгүй байж болохын сацуу зарим тохиолдолд ардчилсан хөгжлийн хэтийн төлөвт ноцтой хор уршиг ч учруулж болно.

3. Сонгуулийн аль нэг тогтолцоог сонгох цаад учир шалтгаан, нөхцөл байдал нь хийх сонголтоосоо дутахааргүй чухал хүчин зүйл байдаг. Сонгуулийн тогтолцоог сонгох нь үндсэндээ улс төрийн үйл явц бөгөөд зөвхөн мэргэжилтнүүд л “зөв хариулт” өгөх асуулт үнэндээ биш юм. Шийдвэр гаргагчид өөртөө улс төрийн давуу байдал олгох хувилбарыг авч үздэг нь сонголт хийхэд ямагт нөлөөлдөг нэг гол (заримдаа *цорын ганц*) хүчин зүйл. Нөгөө талаар бодит байдалд шилж сонгох боломжтой хувилбар цөөн. Тогтолцоог сонгохдоо алс хэтийг бодолгүй улс төрийн явцуу эрх ашгийг урьдал болгох нь тухайн сонгуулийн тогтолцооны урт хугацаанд үзүүлэх үр дагавар хийгээд улс төрийн тогтолцооны илүү өргөн хүрээтэй ашиг сонирхлыг орхигдуулахад хүргэдэг. Энэхүү гарын авлагад бид энэ мэт бодит байдалд учирч болох хязгаарлалтыг харгалзан үзэхийн сацуу сонгуулийн тогтолцооны асуудлыг аль болох дэлгэрэнгүй, өргөн хүрээтэй авч үзэхийг хичээсэн.

4. Гарын авлагыг юуны өмнө ардчилал шинээр тогтсон болон шилжилтийн ардчилалтай орнуудын улстөрчид, улс төрийн яриа мэтгэлцээнд оролцогчид, үндсэн хууль болон улс төрийн институцийн талаар шийдвэр гаргахад оролцож буй хүмүүст зориулж гаргасан болно. Гэхдээ улс төрийн институцийг бүрэлдүүлэх нь дан ганц шинэ тулгар ардчилсан орнуудад төдийгүй, нийгэмд шинээр үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн сонгуулийн тогтолцоогоо өөрчлөхийг зорьж байгаа ардчилал тогтсон улс орнуудын хувьд ч чухал болохыг харгалзан үзэж ийм нөхцөлд тулгарч болох асуудлыг уг гарын авлагад тусгахыг хичээлээ. Уншигчдынхаа сонирхолд нийцүүлэн сонгуулийн тогтолцооны талаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажлаас нэлээдийг хялбарчлан оруулсны дээр энэ сэдэвтэй холбоотой зайлшгүй сөхөгддөг нарийн түвэгтэй зарим асуудлыг онцлон авч үзсэн болно. Хэрэв энэ гарын авлага зарим талаар хэт хялбарчилсан, заримдаа хэтэрхий хүнд ярвигтай мэт санагдвал энд багтаасан мэдээллийг ойлгомжтой тодорхой байлгахын зэрэгцээ аль болох өргөн хүрээтэй асуудлыг хамрах гэсэн хоёр зорилтыг гүйцээх гэж хичээсэнтэй холбож ойлгоорой.

Ардчилалд шилжиж байгаа болон ардчилал тогтсон орнуудыг харьцуулж үзэхэд улс төрийн институцид өөрчлөлт хийх нөхцөл байдал нь хоорондоо асар их ялгаатай байж болох ч хэтийн зорилгыг нь аваад үзэхэд ихэнхдээ адил байна. Тодруулбал, тогтвортой ардчиллыг хөгжүүлэхэд үндэс суурь нь болохуйц бат бөх бөгөөд өөрчлөгдөн буй орчин нөхцөлд зохицох чадвартай уян хатан институцийг бий болгох явдал гол зорилго нь болдог. Ардчиллын хөгжил нь ямар үе шатанд байгаагаас үл хамааран улс орнуудад бие биенээсээ суралцах зүйл их байна.

Институцийн бүтэц нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг бөгөөд энэхүү гарын авлагад дэлхийн янз бүрийн улс орны туулж өнгөрүүлсэн бодит туршлага, өөрчлөлт шинэчлэл хийх явцдаа олж авсан сургамжаас чухлыг нь шүүн орууллаа.

5. Дэлхийн олон улс үндсэн хуулиа харьцангуй саяхан баталсан байдаг. 1980, 1990-ээд онд өрнөсөн ардчилсан засаглалд шилжих үйл явцтай холбоотойгоор улс орнууд сонгуулийн тогтолцоогоо эргэн харж, төлөөллийн институцийн зохистой бөгөөд урт хугацаанд тэсвэртэй загвар эрж хайж эхэлсэн. Улс төрийн институцийг хэрхэн сонгож бүрэлдүүлэх нь улс төрийн тогтолцоонд бүхэлд нь үлэмж нөлөө үзүүлдэг болохыг хэн хүнгүй ухамсарлах болсноор энэ үйл явц улам эрчимжсэн гэхэд болно. Тухайлбал, сонгуулийн тогтолцоог газар зүйн хувьд тодорхой орон нутгийг төлөөлүүлэх юмуу эсвэл хувь тэнцүүлэх байдлаар шийдэж боловсруулж болдог, түүнчлэн тогтвортой бөгөөд хүчтэй улс төрийн намууд төлөвшин хөгжих, эмэгтэйчүүд, үндэсний цөөнхийн төлөөллийг хангах хөшүүрэг болгох боломжтой. Эдгээрээс гадна түйлширч хуваагдсан нийгэмд тодорхой сонирхол, хязгаарлалтыг бий болгон нэгдмэл байдалд хөтлөхөд сонгуулийн тогтолцоог бүтээлчээр ашиглах боломжтой нь олон улсын туршлагаас тодорхой байна. Иймээс өнөөдөр сонгуулийн тогтолцоо бол улс төрийн бүхий л институцийн дотроос хамгийн нөлөө бүхий нь бөгөөд засаглалын өргөн хүрээтэй асуудалд шийдвэрлэх нөлөөтэй болохыг нийтээр хүлээн зөвшөөрөх болжээ.

6. Гарын авлагад улс үндэстний түвшинд сонгууль зохион байгуулах тогтолцоог голлон авч үзэх боловч ямар ч түвшинд аливаа асуудлаар иргэдийн дунд санал хураалт явуулахад энд толилуулж буй хувилбаруудыг ашиглах боломжтой. Тодруулбал, энэхүү гарын авлагыг орон нутгийн болон улсуудын холбооны сонгуулийн мэргэжилтнүүд төдийгүй мэргэжлийн холбоод, үйлдвэрчний эвлэл, иргэний нийгмийн байгууллагууд ч ашиглах боломжтой.

Гарын авлагыг хэрхэн ашиглах вэ?

7. Сонгуулийн тогтолцооны хувилбарууд, тэдгээрийн нөлөө, ардчилсан ертөнцөд сонгуулийн тогтолцоо ямар зарчмаар ажиллаж ирснийг гарын авлагадаа дэлгэрэнгүй танилцуулснаар бид дараах хоёр үр дүнд хүрэхийн зорьж байна. Нэгдүгээрт, энэ асуудлаарх мэдлэгийн хүрээг тэлж улмаар улс төрийн болон бодлогын хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг мэдээлэлд үндэслэсэн, оновчтой тодорхой болгох, хоёрдугаарт, үндсэн хууль, улс төрийн институцийн бүтэц, сонгуулийн хууль тогтоомж боловсруулагчдыг мэдээлэлтэйгээр сонголт хийх, ингэснээр зарим сонгуулийн тогтолцооны хувилбарын гаж, сөрөг нөлөөнөөс зайлсхийхэд нь тус дөхөм болох явдал юм.

8. Гарын авлагын эхэнд сонгуулийн тогтолцоо гэж чухам юу болох (мөн юу биш болох), аливаа улс орны улс төрийн тогтвортой, нааштай байдалд яагаад чухал нөлөөтэй болох тухай авч үзнэ. Дараа нь, аливаа нийгэмд сонгуулийн ямар тогтолцоо хамгийн сайн тохирохыг шийдэхэд ашиглах арван шалгуурыг (27-45 дугаар хэсэгт) танилцуулж, сонгуулийн тогтолцоог үнэлж дүгнэх, өөрчлөхтэй холбогдон гардаг зарим асуудлыг авч үзнэ. Үүний дараа 2 ба 3 дугаар бүлэгт сонгуулийн тогтолцооны хувилбарууд, тэдгээрийн болзошгүй нөлөөний талаар танилцуулах бөгөөд хувилбар тус бүрийн давуу ба сул талыг тайлбарлан хүргэхдээ энэ салбарын эрдэмтэн судлаачдын бүтээл, түүхэн бодит туршлагыг үндэслэсэн болно.

9. Эдүгээ дэлхийн улс орнууд сонгуулийн маш олон тооны, янз бүрийн тогтолцоо ашиглаж буй бөгөөд хэлбэр тус бүр нь олон янзын хувилбартай байна. Үүнийг хялбарчлах үүднээс бид сонгуулийн тогтолцоог олонхи/дийлэнхийн тогтолцоо (ОД), хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХТТ), холимог тогтолцоо гэсэн *гурван өргөн хүрээтэй бүлэг*-т хувааж ангилсан. Эдгээр нь *есөн дэд бүлэг*-т хуваагдах бөгөөд ОД тогтолцоонд *First Past The Post* буюу харьцангуй олонхийн хувилбар, *Block Vote* буюу олон мандаттай тойрогт сонгогч мандатын тоогоор санал өгөх олонхийн тогтолцооны хувилбар, *Party Block Vote* буюу олон мандаттай тойрогт нэг намаас нэр дэвшигчдэд бөөнөөр нь санал өгөх хувилбар, *Alternative Vote* буюу альтернатив саналын хувилбар, *Two Round System* буюу хоёр шаттай тогтолцоог тус тус багтааж авч үзсэн бол ХТТ-нд намын жагсаалтаар санал хураах хувилбар, санал шилжүүлэх тогтолцоог, холимог тогтолцоонд холимог хувь тэнцүүлсэн болон параллель тогтолцоог тус тус жишээ болгон танилцуулна. Түүнчлэн аль нэг тодорхой ангилалд оруулахад бэрхшээлтэй байдаг санал үл

шилжүүлэх, хязгаарлагдмал саналын, Борда тооллого гэх мэт бусад тогтолцоо байдаг бөгөөд эдгээрийг тусад нь бүлэг болгож орууллаа.

10. Бүлгийн ангиллын энэхүү бүтцийг сонгуулийн тогтолцооны хувилбаруудыг товч тодорхой дүрслэн харуулах зорилгоор боловсруулсан юм. Уг бүтцийг боловсруулахдаа сонгуулийн тогтолцоог ангилж ирсэн уламжлалд тулгуурлахын сацуу өнөөдөр дэлхий дахинд хууль тогтоох байгууллагыг сонгоход ашиглаж буй сонгуулийн тогтолцооны олон хувилбарыг бүрэн хамруулахыг зорьсон. Гэхдээ үүнд ардчилал, хууль ёсны байдал зэрэг өргөн хүрээтэй ерөнхий асуудлыг тусгаагүй болно. Мөн эдгээр тогтолцоог гарах үр дүнгээр нь биш, ямар үйл явцад тулгуурласан бэ гэдгээр нь ангилсан билээ. Тухайлбал, ХТТ-оор явуулсан сонгуулийн үр дүнд үүссэн хууль тогтоох байгууллагын бүтэц намуудын төлөөллийн хувьд авч үзвэл ОД тогтолцоогоор явуулсан сонгуультай харьцуулахад илүү хувь тэнцүүлсэн шинжтэй байх нь ойлгомжтой мэт боловч бас ч үргэлж тийм байдаггүй.

11. Сонгуулийн тогтолцооны янз бүрийн хувилбарын хэрэгжих механизм, үр дагаврыг дүрслэн тайлбарласны дараа эмэгтэйчүүд ба цөөнхийн төлөөлөл, ард нийтийн төлөөлөл, сонгууль явуулах хугацаа, заавал санал хураах байранд биеэр ирж санал өгөх, эсвэл эзгүйгээр буюу гадаадаас санал өгөх гэх мэт сонгуулийн бүх тогтолцоотой холбоотой хэд хэдэн нийтлэг асуудлыг гуравдугаар бүлэгт хөндөнө. Энэхүү гарын авлагад үндэсний ассамблей, парламентын доод танхим, конгресс гэх мэт хууль тогтоох байгууллагыг сонгох сонгуулийг голлон авч үзэх боловч Ерөнхийлөгчийг сонгох, хоёр танхим бүхий хууль тогтоох байгууллагын дээд танхимыг сонгох болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох сонгуулийн тогтолцооны хувилбаруудын талаар дөрөвдүгээр бүлэгт тусгасан. Мөн Европын Парламент гэх мэт олон үндэстний байгууллагын сонгуульд тулгарч буй асуудлууд, холбооны улсын төрөл бүрийн хэлбэрт тохиолдох сонгуультай холбоотой асуудлууд болон улсын доторхи автономит засгийн талаар авч үзнэ.

Тавдугаар бүлэгт сонгуулийн тогтолцооны тодорхой хувилбарыг авсан тохиолдолд гарах өртөг зардлын болон захиргааны асуудлыг авч хэлэлцэх бөгөөд зургадугаар бүлэгт сонгуулийн тогтолцоог сонгож, шийдвэр гаргахад зориулсан зарим зөвлөгөөг танилцуулна. Дээрх зөвлөгөөг дэлхийн олон оронд үндсэн хууль, сонгуулийн хуулийн төсөл боловсруулахад оролцсон мэргэжилтнүүдийн туршлагаас нэгтгэн авсан болно. Хавсралтын хэсэгт дэлхийн 213 тусгаар улс, газар нутгийн сонгуулийн тогтолцооны онцлогийг харуулсан хүснэгт, нэр томъёоны

тайлбар, нэмж унших материал, ном зүй, сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөө болон сонгуулийн тойргийн хил хязгаар тогтоох жишээ зэргийг оруулсан.

12. Энэ номд нийт 18 бодит жишээг суулган өгч сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтын тухай хийсвэр онолыг практик бодит байдалтай холбож ойлгуулахыг зорьлоо. Эдгээр жишээг тухайн улсынхаа улс төрийн асуудлаар мэргэшсэн хүмүүс бэлтгэсэн бөгөөд жишээг бэлдэхдээ тухайн улс сонгуулийн ямар тогтолцоотой, энэ тогтолцоо хэрхэн бий болсон бэ? Сонгосон тогтолцоо нь ямар давуу болон сул талтай вэ? Тогтолцоонд шинэчлэл хийсэн бол яагаад ингэх болсон? Шинэ тогтолцоо нь хэр зэрэг шаардлага хангаж байна вэ? гэсэн асуултад хариу өгөхийг тэднээс хүссэн юм.

13. Гарын авлагад сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалттай холбоотой бүх асуудалд хариулт өгөх зорилт тавиагүй. Харин мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргахад тус дөхөм болох, тухайн оронд аль сонгуулийн тогтолцоо илүү тохирох талаар өргөн хэлэлцүүлэг өрнүүлэх үүд хаалгыг нээж өгөхийг зорьсон юм. Энэхүү гарын авлага нь заавал дагах заавар зөвлөгөө биш бөгөөд ямар оронд сонгуулийн аль тогтолцоо хамгийн тохиромжтойг хэлээд өгөх бэлэн жор гэж байдаггүй, байх ч ёсгүй. Тухайлбал, хүн амын 60 хувь нь лалын шашинтай, 40 хувь нь христийн шашинтай, гурван намын тогтолцоотой, салан тусгаарлах үзэл хурц ширүүн илэрч ирсэн түүхтэй улс нийгэм ийм л маягийн сонгуулийн тогтолцоотой байх ёстой гэсэн томъёолол байхгүй. Харин боломжтой хувилбаруудын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, улмаар ул суурьтай шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл өгөхөд бидний зорилго чиглэсэн. Номонд орсон жишээ, баримтаас дэлхийн бусад оронд ижил төстэй асуудлыг хэрхэн шийдвэрлэж ирснийг олж харах боломжтой. Улс орон бүр харилцан адилгүй, өөрийн гэсэн өвөрмөц онцлоготой бөгөөд тэрхүү онцлог нь тухайн улс орны нийгэм, соёл нь төлөөллийг хэрхэн үзэж тодорхойлж байгаа, үндэстэн ястны ялгарал, дотоодын зөрчил мөргөлдөөний түүх гэх мэт нийгэм-улс төрийн хүчин зүйлс хоорондоо хэрхэн найрч авцалдаж байгаагаар илэрхийлэгддэг. Ийм учраас сонгуулийн тогтолцоог сонгоход гар бие оролцож буй хүмүүс юуны өмнө сонгуулийн тогтолцооны хувилбарыг сонгох шалгуур үзүүлэлтээс (27-45 дугаар хэсэг) ажлаа эхэлж улс орных нь хувьд онцгой ач холбогдолтой асуудлуудыг эрэмбэлэн авч үзэхийг хичээх нь зүйтэй. Үүний дараа сонгуулийн тогтолцооны боломжит хувилбарууд, тэдгээрийн болзошгүй үр дагавар, шинэ тогтолцоог нэвтрүүлэхээс өмнө явагдах

зөвшилцөл, хэлэлцүүлгийн үйл явцад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Иймээс сонгуулийн хамгийн тохиромжтой тогтолцоог эрж хайна гэдэг нь байж болох хувилбаруудыг тодорхой шалгуур үзүүлэлттэй харьцуулж (чингэхдээ түүх, цаг хугацаа, улс төрийн бодит нөхцөл байдлыг ямагт анхаарч) үнэлэх замаар тухайн улсын өвөрмөц онцлогт тохирох нэг буюу хэд хэдэн боломжит хувилбарыг олж тогтоохыг хэлж байна. Түүнчлэн эцсийн сонголт нь хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлийг хангах байдлаар шийдвэр гаргах үйл явц өрнөх ёстой.

Сонгуулийн тогтолцоо гэж юу вэ?

14. Хамгийн энгийнээр хэлэхэд сонгуулийн тогтолцоо нь аливаа сонгуульд иргэдийн өгсөн саналыг нам, нэр дэвшигчдийн авах суудлын тоонд шилжүүлэх арга замыг хэлнэ. Үүнийг тодорхойлдог гол хувьсагчид нь сонгуулийн тогтолцооны хувилбар, суудал хуваарилах томъёо (олонхийн, хувь тэнцүүлсэн, холимог эсвэл өөр ямар тогтолцоо ашиглаж байгаа, суудлын хуваарилалтыг ямар математик томъёо ашиглан тооцоолох гэх мэт), саналын хуудасны бүтэц (сонгогч нам эсвэл нэр дэвшигчийн алинд санал өгч байна, зөвхөн нэг сонголт хийх үү эсвэл хэд хэдэн сонголт хийж боломжтой юу), сонгуулийн тойргийн цар хүрээ (тухайн тойрог хэдэн сонгогчтой байгаагаар биш, тойргоос хууль тогтоох байгууллагад хэдэн төлөөлөгч сонгогдож байгаагаар илэрхийлэгдэнэ) юм. Түүнчлэн хэдийгээр энэ гарын авлагад сонгуулийг зохион байгуулахтай холбоотой процессын шинжтэй асуудлуудыг (санал хураах байрын тархалт, нэр дэвшигчдийг нэр дэвшүүлэх ажиллагаа, сонгогчдын бүртгэл, хэн сонгуулийг зохион байгуулж явуулах вэ гэх мэт) онцлон авч үзэхгүй боловч эдгээр асуудал нь тогтолцооноос дутахааргүй ач холбогдолтой бөгөөд зохих анхаарал хандуулахгүй бол сонгуулийн тогтолцооны ямар ч давуу талыг үгүйсгэж мэдэх сөрөг нөлөөтэй. Сонгуулийн тогтолцоо нь сонгуулийн хуулийн бусад асуудалд ч нөлөөлнө. Тухайлбал, сонгуулийн тогтолцооны ямар хувилбарыг сонгож авснаас шалтгаалаад тойргийн хил хязгаар тогтоох арга, сонгогчдыг бүртгэх байдал, саналын хуудасны бүтэц, санал тоолох ажиллагаа болон сонгуулийн үйл явцтай холбоотой бусад олон асуудал янз бүрээр шийдэгдэх жишээтэй.

Сонгуулийн тогтолцооны ач холбогдол

15. Улс төрийн институци нь ардчиллыг амьдралд хэрэгжүүлэх тоглоомын дүрмийг тодорхойлж байдаг бөгөөд сайн, муу аль ч талаар ашиглахад хамгийн хялбар нь сонгуулийн тогтолцоо гэж үзэх нь олонтаа. Сонгуулийн тогтолцоо нь сонгогчдын өгсөн саналыг хууль тогтоох байгууллагын

суудалд хэрхэн тооцож шилжүүлэх, улмаар аль нам засгийн эрх авч, хэн сонгогдохыг шийдвэрлэх чухал нөлөө бүхий институци. Аливаа улс орон улс төрийн бүтэцтэй холбоотой гол асуудлуудаа үндсэн хуулиараа тогтоож тодорхойлсон байх бөгөөд түүнд нэмэлт өөрчлөлт оруулахад хүндрэлтэй. Харин сонгуулийн тогтолцооны хувьд ихэнхи тохиолдолд шинэ хууль тогтоомж гарган өөрчлөхөд харьцангуй хялбар байдаг.

16. Сонгогч бүр яг ижилхэн санал өгч, нам бүр яг ижилхэн тооны санал авсан ч сонгуулийн тогтолцооны нэг хувилбараар явахад эвслийн, эсвэл цөөнхийн Засгийн газар байгуулагдаж, нөгөө хувилбараар нь тооцоход ганц нам олонхи болж эрх мэдлийг гартаа авах боломж бүрддэг. Хавсралт Г-д үзүүлсэн жишээ сонгуулийн өөр өөр тогтолцоо санал хураалтын ижил дүнг хэрхэн тэс өөр эцсийн үр дүнд хувиргаж байгааг харуулж байна.

Сонгуулийн ба намын тогтолцоо

17. Сонгуулийн тогтолцоо нь нүдэнд шууд үзэгдэх дээрх нөлөөнөөс гадна дагалдах янз бүрийн үр дагавартай байдаг. Зарим тогтолцоо улс төрийн нам бүрэлдэх үйл явцыг зайлшгүй болгож, хөхиүлэн дэмждэг бол зарим нь зөвхөн нэр дэвшигчид чиглэсэн байдаг. Улс төрийн нам хөгжих бололцоотой, ялангуяа хууль тогтоох байгууллагад эзлэхтөө, хувьжингийн хувьд өсөн дэвжих бололцоо бүхий олон намын системд сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөө асар их байдаг. Сонгуулийн тогтолцоо намуудын дотоод эв нэгдэл, сахилга батад ч нөлөө үзүүлнэ. Тухайлбал, зарим тогтолцоо улс төрийн нам дотроо жигүүр бүлгүүдэд хуваагдан байнга санал зөрөлдөх байдалд хүргэдэг бол өөр нэг тогтолцоо нь нам нэгдмэл дуу хоолойтой байж, дотоод санал зөрөлдөөнөө нуун далдлах хандлагыг бий болгоно. Сонгуулийн тогтолцоо нь намууд кампанит ажлаа зохион байгуулах байдал, улс төрийн элитүүдийн зан үйлдэлд нөлөөлж, ингэснээр улс төрийн уур амьсгалыг бүхэлд нь тодорхойлох нэг хүчин зүйл болдог ажээ. Түүнчлэн намууд өөр хоорондоо эвсэж хамтрахад зарим тогтолцоо таатай уур амьсгал бүрдүүлдэг бол зарим нь саад учруулдаг байна. Улс төрийн нам гишүүдийн өргөн бааз суурьтай, нээлттэй байх, эс бөгөөс үндэс угсаа, ураг төрлийн холбооны явцуу эрх ашигт тулгуурлах хандлагад мөн тогтолцоо нөлөөлнө.

Сонгуулийн тогтолцоо ба зөрчлийн удирдлага

18. Дээрх олон талт нөлөөнөөс нь үзэхэд сонгуулийн тогтолцоо нийгэм дэх зөрчилдөөнийг зохицуулахад чухал үүрэг, ач холбогдолтой нь илэрхий байна. Сонгуулийн тогтолцоо хурцадмал байдлыг намжаах,

эсвэл даамжруулах нөлөөтэй. Цөөнхийн төлөөлөлд таатай тогтолцоо, ганц хүчтэй намд илүүтэй үйлчилдэг тогтолцоо хоорондоо зөрчилдөж байдаг. Сонгуулийн тогтолцоог шударга бус гэж үзэх, сонгуульд шударгаар өрсөлдөх боломжтой гэж итгэхгүй байгаа нөхцөлд ялагдсан тал ардчилсан бус, сөргөлдөөний, тэр ч байтугай хүчирхийллийн арга сонгохоос өөр замгүй гэж үзэхэд хүрэх тохиолдол байна. Тогтолцооны ямар хувилбар, хэлбэрээр сонгуулийг зохион байгуулахаас шалтгаалаад санал хураалт нь энгийн эсвэл нарийн түвэгтэй болдог. Үүнтэй холбоотой үндэсний цөөнх болон нийгмийн эмзэг бүлгийнхний эрх ашиг хөндөгдөх талтай. Ялангуяа сонгогчдын нэлээд хувь нь сонгуульд оролцох туршлагагүй, эсвэл бичиг үсэг мэдэхгүй нийгэмд энэ асуудлыг онцгой анхаарах ёстой (Зардал ба захиргааны асуудлуудын тухай 5 дугаар бүлгээс үзнэ үү).

Сэтгэл зүйн болон механик нөлөө

19. Сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөөг ерөнхийд нь “механик” болон “сэтгэл зүйн” гэж хувааж болохоор байна. Сонгуулийн тогтолцооны хувилбарууд улс төрийн намын системд хэрхэн тусч үйлчилж буйгаар механик нөлөөлөл нь тодорхой харагддаг. ОД тогтолцоо нь улс төрийн намын тоог ерөнхийд нь хязгаарлах нөлөө үзүүлдэг бол ХТТ-ны нөлөөнд намуудын тоо олшрох хандлага ажиглагдана. Сонгуулийн тогтолцооны сэтгэл зүйд үзүүлэх нөлөө нь энэхүү механик нөлөөллийг улам бэхжүүлдэг ажээ. Тухайлбал харьцангуй олонхийн тогтолцоонд нэг мандатай тойргоос зөвхөн нэг л хүн сонгогдох учир сөрөг хүчнийг дэмжиж буй сонгогч тэртэй тэргүй ялалт байгуулах магадлал багатай хүнд саналаа өгч “дэмий үрэх вий” гэсэн болгоомжлолтой тулгардаг. Ийм нөхцөлд сонгогч өөрийн дэмждэг намынхаа нэр дэвшигчид санал өгөхийн оронд сонгуульд ялах бодит боломжтой гэж үзсэн нэр дэвшигчийн (голдуу том намын) төлөө саналаа өгөх магадлал өндөр байна. Үүний нөлөөнд жижиг намууд золиос болж том намууд хожиж таардаг. Харин ХТТ болон саналын хуудсанд олон сонголт хийх боломж бүхий нөхцөлд сонгогч жижиг намуудыг дэмжих магадлал өндөр байдаг бөгөөд ингэснээр дээр дурдсанчлан стратегийн хувьд тооцож санал өгөх явдал багасгадаг байна.

Ерөнхий нөхцөл байдлын нөлөө

20. Тодорхой нэг сонгуулийн тогтолцоо улс орон бүрт заавал адилхан үйлчлэх албагүйг ойлгох нь чухал. Дэлхийн зарим оронд нийтлэг туршлага байдаг ч сонгуулийн тогтолцооны нөлөө нь түүнийг авч хэрэгжүүлж байгаа улсын нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас асар их

хамаарч байдаг. Жишээлбэл, ОД тогтолцоонд парламент дахь намуудын төлөөлөл цөөвтөр байхад ХТТ-оор сонгууль явуулахад илүү олон нам парламентад орж ирэх боломжтой. Гэвч ОД тогтолцооны нөлөөнд хоёр намын систем бий болно, ХТТ-ны нөлөөнд олон намын систем бэхжинэ гэсэн хэвшмэл үзэл улам бүр хоцрогдож байна. Сүүлийн жилүүдийн жишээнээс харахад Канад, Энэтхэг зэрэг ардчилал тогтсон орнуудад харьцангуй олонхийн тогтолцоо хэрэглэж байгаа ч улс төрийн намууд нь байр сууриа бэхжүүлж томроогүй, Папуа Шинэ Гвинейд ч хүчирхэг, тогтвортой улс төрийн намууд цойлж гараагүй байна. ХТТ-той Намиби, Өмнөд Африк болон бусад хэд хэдэн газар хүчирхэг нэг нам засгийн эрх барьж буй дүр зураг ажиглагддаг. Сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөө нь тухайн нийгэм үзэл суртал, шашин шүтлэг, үндэс угсаа, арьс өнгө, бүс нутаг, хэл, ангийн ялгааны хувьд ямар бүтэцтэй байна, тухайн улсад ардчилал шилжилтийн үе шатанд байна уу, эсвэл баттай төлөвшин тогтсон уу, улс төрийн намын систем төлөвшин тогтсон эсэх, эсвэл намууд дөнгөж өсч өндийх үр хөврөлийн шатандаа байна уу, тэднээс хэд нь “ул суурьтай” чамбай нам болох, түүнчлэн тодорхой нэг намын дэмжигчид газар зүйн хувьд нэг дор төвлөрч үү, эсвэл өргөн уудам нутагт тархаж байрласан уу зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Ардчиллын тогтолцоо

21. Сонгуулийн тогтолцоог дангаар нь салган авч үзэхгүй байх нь чухал. Тэдгээрийн зохиомж бүтэц, үзүүлэх нөлөө нь үндсэн хууль болон бусад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байдаг. Сонгуулийн тогтолцоо бол төрийн тогтолцоо, засгийн эрх мэдэлд хүрэх янз бүрийн боломж, дүрэм процессын харилцан уялдаатай нийлмэл бүтцийн зөвхөн нэгээхэн хэсэг гэж хэлж болно. Сонгуулийн тогтолцооны загварыг амжилттай шийдэхийн тулд улс төрийн институцийг бүхэлд нь анхааралтай ажиглан харах хэрэгтэй болдог. Учир нь энэхүү өргөн цар хүрээ бүхий бүтцийн нэг хэсгийг өөрчлөхөд түүний доторх бусад хэсэгт тохируулга хийх шаардлага гарах магадлалтай.

22. Жишээлбэл, сонгуулийн тогтолцоо нь намын удирдлагууд ба жирийн идэвхтэн гишүүдийн хоорондох зөрчлийг шийдвэрлэх хөшүүрэг болж байна уу? Намаас сонгогдсон гишүүдийг удирдлага нь хяналтандаа хэр зэрэг барьж байна? Үндсэн хуульд төлөөллийн ардчиллын институцид хүч нэмэхүйц бүх нийтийн санал асуулга зэрэг шууд ардчиллыг хөхиүлэн дэмжсэн заалтууд байна уу? Үндсэн хуульд шууд болон хавсралт маягаар сонгуулийн тогтолцооны талаар нарийвчилсан заалтууд тусгагдсан эсэх,

эсвэл жирийн хууль тогтоомжоор зохицуулсан байна уу? Үүгээр тухайн тогтолцоо хэр их хамгаалалтайг, парламент дахь олонхийн саналаар хялбар өөрчилж болох эсэхийг тодорхойлдог (49 дүгээр хэсгийг үзнэ үү).

23. Энэ сэдвийн хүрээнд илүү нарийвчлан авч үзвэл зохих хоёр асуудал бий. Эхнийх нь засаглалын төвлөрлийн түвшиний тухай юм. Тухайн улс холбооны улс уу, нэгдмэл улс уу, хэрэв холбооны улс бол засаг захиргааны нэгжүүдэд эрх мэдэл тэгш тэнцвэртэй хуваарилагдсан уу? Хоёрдугаарт, парламентын болон ерөнхийлөгчийн засаглалын алийг нь сонгох вэ гэсэн асуудал юм. Эдгээр нь хоёулаа өөрийн гэсэн талархан дэмжигчидтэй бөгөөд тухайн улс орны өвөрмөц уламжлал, ёс заншил ямар тогтолцоог сонгох вэ гэдэгт нөлөөлөөд зогсохгүй заримдаа энэ талаар хэлэлцүүлэг өрнүүлэх ч аргагүй нөхцөл үүсгэх нь бий. Хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын хоорондын харилцаа ямар байх нь аль ч засаглалын хэлбэрт сонгуулийн тогтолцоог боловсруулахад чухал нөлөө үзүүлдэг. Орон нутгийн түвшинд хотын даргыг буюу гүйцэтгэх засаглалын тэргүүнийг шууд сонгох тухай мэтгэлцээн байнга гардаг нь дээрх асуудлуудтай холбоотой.

24. Холбооны улсад хууль тогтоох байгууллагын хоёр танхимын сонгууль нь ихэнхдээ өөр өөр аргаар явагддаг. Энэ нь федерализмын суурь онолтой холбоотой дараах хоёр үндсэн шалтгаанаар тайлбарлагддаг. Нэгдүгээрт, хууль тогтоох байгууллагын дээд танхим нь тухайн улсын бүс нутгууд буюу муж улсуудыг төлөөлөх зорилготой бөгөөд тэдгээр нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээнээс үл хамааран дээд танхимд адил тэгш төлөөлөлтэй байдаг (тухайлбал, АНУ-ын Сенат, Өмнөд Африкийн Мужуудын Үндэсний Зөвлөл). Хоёрдугаарт, энэ хоёр танхимын гүйцэтгэх үүрэг, эрх мэдэл тодорхой хэмжээний ялгаа зөрүүтэй байх шаардлагатай, эс бөгөөс хууль тогтоох байгууллага хоёр танхимтай байхын утга учир бага бөгөөд хоёуланг нь ижил сонгуулийн тогтолцоогоор сонгох тохиолдолд доод танхимд хяналт тогтоосон олонхийн эрх мэдлийг лавшруулж, улам бэхжүүлэх (ялангуяа хоёр танхимын сонгууль нэгэн зэрэг явагддаг тохиолдолд) магадлал өндөр байна. Гарын авлагын 189-192 дугаар хэсэгт дурдсанчлан бүх нийтийн сонгуулиар доод танхимд хангалттай төлөөлөлтэй болж чадаагүй бүлгүүдэд боломж нээх зорилгоор сонгуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх санаачлагыг дээд танхим гаргадаг. Энд анхааруулахад хууль тогтоох байгууллагын дээд, доод танхим, орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох зэргээр гурав ба түүнээс дээш түвшинд сонгууль явуулж буй бол эдгээр сонгуулийг явуулж буй тогтолцоог цогцоор нь авч үзэх нь чухал. Тухайлбал, орон нутгийн

түвшинд цөөнхийн төлөөллийг хөхиүлэн дэмжиж, харин үндэсний түвшинд дэмжихгүй байх, тэр байтугай саад учруулах явдал заримдаа ажиглагддаг. Ингэх шаардлагатай, үгүй эсэх нь улс төрийн мэтгэлцээн, сонголтоор шийдвэрлэх асуудал юм.

25. Саяхныг хүртэл ерөнхийлөгчийн засаглал бүхий тогтвортой ардчилсан орны жишээ цөөн байлаа. Гэтэл Латин Америк болон Зүүн Өмнөд Азийн зарим орон ерөнхийлөгчийн засаглалаа үнэнч тууштай хадгалсан хэвээр байгаагаас үүдэн институцийн бүтэц, зохион байгуулалтыг яаж шийдвэл ерөнхийлөгчийн засаглал амжилттай хэрэгжих вэ гэсэн асуулт урган гарч байна. Үндсэн хуулиар тогтоосон ерөнхийлөгчийн засаглалтай, олон жижиг нам бүхий орнуудад тогтвортой байдал хүндрэлтэй асуудал болдог. Тэрчлэн ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо нь хоёр үе шаттай, хууль тогтоох байгууллагын сонгууль нь намын жагсаалтаар санал хураах ХТТ-оор явагддаг, мөн эдгээр сонгууль нэг зэрэг явагддаггүй тохиолдолд хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын хоорондын хагарал хурцаддаг болохыг Латин Америкийн орнуудын туршлага нотлон харуулдаг. Ийм нөхцөлд ерөнхийлөгчийг дэмжигч нам, эвслийн бүлгүүд хууль тогтоох байгууллагад олонхи болохгүй ч нөлөө бүхий томоохон бүлэг байх боломжтой сонгуулийн тогтолцоог авч хэрэглэх нь ашигтай байна.

26. Ерөнхийлөгчөө олонхийн тогтолцоогоор сонгож, ерөнхийлөгчийн ба хууль тогтоох байгууллагын сонгуулиа нэг зэрэг явуулах нь намын тогтолцоо цөөн тооны, засгийн эрхийн төлөө өрсөлдөх чадвартай намаас бүрдэхэд дөхөм үзүүлдэг. Гэвч угсаатан ястны хувьд хуваагдмал бөгөөд аль нэг улс төрийн бүлэг үнэмлэхүй олонхи болдоггүй, ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүний асар их эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн оронд харьцангуй олонхийн (*plurality*) тогтолцоо ноцтой аюул дагуулж болох талтай юм. Ийм сонгуулийн үр дүн түүний хууль ёсны байдалд, мөн энхийг тогтоох үйл явцын амжилтад ч халтай нөлөө үзүүлж болно. Мөн нэр дэвшигч ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулахын тулд дан ганц бүх нийтийн сонгуульд давуу санал аваад зогсохгүй тодорхой тооны муж улсад сонгогчдын нэлээд хэсгийн саналыг авсан байх шаардлага тавьснаар ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо нь холбооны улсын тогтолцоог улам бэхжүүлж болох талтай (Индонези, Нигери улсуудын жишээг 187-188 дугаар хэсгээс үзнэ үү).

Бүтэц, зохион байгуулалтын шалгуур

27. Сонгуулийн тогтолцооны талаар шийдвэр гаргахад юуны өмнө ямар үр дүнд хүрэх, юунаас зайлсхийх, ерөнхийдөө ямархуу дүр төрхтэй хууль тогтоох байгууллага болон гүйцэтгэх засаглалтай байх эрмэлзлэлтэй зэргээ эрэмбэлж нэгтгэсэн шалгуурууд гаргахаас ажлаа эхлэх нь зөв. Энэ номд олон салбарыг хамарсан шалгуурын тухай ярих боловч холбогдох бүх асуудлыг бүрэн дүүрэн хамарсан гэж үзэх нь өрөөсгөл юм. Иймд уншигч ач холбогдолтой гэж үзсэн бусад асуудал байвал бас шалгуур болгон нэмж болно. Мөн энд дурдагдах зарим шалгуур давхардсан, зөрчилдөж буй мэт санагдаж магад. Энэ нь шалгуурууд угаасаа ихэнх тохиолдолд хоорондоо зөрчилдөж байдагтай холбоотой бөгөөд институцийн бүтэц, зохион байгуулалтыг шийдэх ажлын мөн чанар нь өөр хоорондоо өрсөлдөх олон хүсэл сонирхол, зорилтуудаас авахыг нь авч, гээхийг гээхэд оршдог.

Жишээлбэл, бие даан нэр дэвшигчдэд сонгогдох боломж олгохын сацуу хүчтэй улс төрийн намууд өсч хөгжих нөхцөл бүрдүүлэх хоёр зорилтыг хамтад нь гүйцэлдүүлэх ярвигтай. Түүнчлэн сонгогч нэр дэвшигч ба намуудын дотроос аль болох өргөн сонголт хийх боломжтой тогтолцоо сайхан санагдаж болох ч ийм тогтолцоо нь саналын хуудасны бүтцийг түвэгтэй болгож улмаар боловсрол багатай сонгогч сонгуульд оролцоход хүндрэл учруулах сөрөг талтай байж болно. Сонгуулийн тогтолцоог шинээр шийдэхэд (буюу өөрчлөхөд) хэрэглэдэг нэг арга нь дээрх шалгууруудыг ач холбогдлоор нь эрэмбэлж, дараа нь тэдгээрийг гүйцэлдүүлэхэд аль сонгуулийн тогтолцоо, эсвэл тогтолцооны холимог хувилбар хамгийн дөхөм байна вэ гэдэгт үнэлгээ хийх явдал юм.

Төлөөллийг хангах нь

28. Төлөөлөл нь дор хаяж дөрвөн хэлбэртэй байна. Нэгдүгээрт, *газар зүйн* төлөөлөл гэдэг нь хот, дүүрэг, аймаг, сонгуулийн тойрог гэх мэт тодорхой нутаг дэвсгэр хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй байж, тухайн газраас сонгогдож, сонгогчдынх нь өмнө хариуцлага хүлээдэг гишүүнтэй байна гэсэн үг. Хоёрдугаарт, нийгмийн доторх *үзэл суртлын* бүлгүүд бие даасан нэр дэвшигчид, улс төрийн намын төлөөлөгчид эсвэл тэдгээрийн нэгдлээр дамжуулан хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй байж болно. Гуравдугаарт, улс төрийн намууд ямар нэг үзэл суртлын бааз суурьгүй байсан ч хууль тогтоох байгууллага нь тухайн улсад байгаа *нам-улс төрийн* нөхцөл байдлыг тусгасан төлөөлөлтэй байж болно. Хэрвээ нийт сонгогчдын тал хувь нь тодорхой нэг улс төрийн намын

төлөө саналаа өгсөн ч тэр нам хууль тогтоох байгууллагад огт суудал аваагүй буюу бараг суудалгүй хоцорсон бол ийм тогтолцоо ард түмний хүсэл эрмэлзлэлийг зохих ёсоор илэрхийлж байна гэж хэлэх аргагүй юм. Дөрөвдүгээрт, *тухайн нийгмийнхээ бүтцийн тусгал болсон* төлөөллийн тухай ойлголтоор хууль тогтоох байгууллага нь зарим талаар “тухайн улс үндэстний толин тусгал” байж ард түмэн шигээ харагдаж, мэдэрч, сэтгэж, үйлдэл хийдэг байх ёстой гэж үздэг. Ийм хууль тогтоох байгууллага нь эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу, баян, ядуу хүмүүсийн төлөөлөл болоод тухайн нийгэм дэх янз бүрийн шашин, хэл соёл, үндэстэн ястны бүлгийн төлөөллийг оруулсан байх юм.

Сонгуулийг нийтэд хүртээмжтэй, утга учиртай болгох нь

29. Сонгууль хэдий сайхан явагдлаа ч сонгогчид санал өгөхөд түвэг чирэгдэл учирдаг, эцсийн дүнд өгсөн санал нь улс орныг удирдан жолоодох хэрэгт нөлөө үзүүлэхгүй бол ард түмний хувьд учир утга багатай байх нь ойлгомжтой. “Санал өгөхөд хялбар” байх гэдгийг саналын хуудас нь сонгогч саналаа тэмдэглэхэд хэр ойлгомжтой, санал хураах байранд очиход хүндрэлтэй эсэх, сонгогчдын нэрийн жагсаалтыг шинэчилж гаргасан эсэх, өгсөн саналын нууцлал найдвартай гэдэгт сонгогчид аль хэр итгэлтэй байгаа зэргээр тодорхойлно.

30. Улс орон даяар юм уу тодорхой нэг тойрогт явагдсан сонгуулийн үр дүн төр засгийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлагад бодитой нөлөөлнө гэх итгэл үнэмшил байгаа тохиолдолд сонгогчдын сонгуульд оролцох идэвх (ядаж чөлөөт сонголт гэдэг үүднээс) нэмэгддэг гэж үздэг. Хэрвээ ялаасай гэж хүссэн нэр дэвшигч нь сонгуульд ялалт байгуулж суудал авах боломж огт байхгүй тохиолдолд сонгогчийн санал хураалтад оролцох хүсэл эрмэлзэл сул байх нь ойлгомжтой. Зарим сонгуулийн тогтолцоонд “гээгдсэн” (өөрөөр хэлбэл, нэр дэвшигчийг сонгоход тоологдоогүй хүчинтэй саналуудыг хэлэх бөгөөд энэ нь санал тоолох явцад хасагддаг, гэмтээсэн зэрэг шалтгаанаар хүчингүйд тооцсон саналын хуудсаас ялгаатай) саналын тоо нийт сонгогчдын өгсөн саналын үлэмж хувийг эзлэх явдал гардаг.

31. Ард түмнээс сонгогдон байгуулагдсан байгууллагад хүлээлгэсэн эрх мэдэл нь нэг талаас сонгуулийн утга учрыг тодорхойлдог. Тухайлбал, авторитар дэглэмийн жүжиглэл төдий сонгуулиуд нь ард түмэнд бодитой сонголт хийх боломж олгодоггүй, хууль тогтоох байгууллага нь засгийн газрыг бүрэлдүүлэхэд, улмаар засгийн газрын бодлогод үзүүлэх нөлөө багатай байдаг тул ард түмний өдөр тутмын амьдралын амин чухал

асуудлыг шийдвэрлэх бодит эрх мэдэл бүхий хууль тогтоох байгууллагын сонгуулиас хамаагүй бага ач холбогдолтой байх нь ойлгомжтой.

32. Ардчилсан тогтолцоонд ч гэсэн сонгуулийн тогтолцооны сонголт тухайн институцийн хууль ёсны байдалд нөлөөлж болдог. Тухайлбал, 1919-1946 оны үед Австралийн Сенатийн сонгуулийг олон мандаттай тойрогт альтернатив саналын тогтолцоогоор явуулж байсан учраас хэтэрхий өрөөсгөл, ард түмний төлөөллийг огтхон ч хангаагүй үр дүн гарч байв. Үүний улмаас Сенатийг хууль ёсны гэж хүлээн зөвшөөх байдал сонгогчдын төдийгүй улстөрчдийн дунд унах хандлагатай болсон бөгөөд олон нийтийн зүгээс төрд үзүүлэх дэмжлэгийг ч ерөнхийд нь сулруулсан гэж зарим ажиглагч үзэж байв. 1948 онд уг тогтолцоог арай шударга хувь тэнцүүлсэн тогтолцоо (санал шилжүүлэх тогтолцоо) болгож өөрчилсний дараа Сенатийг итгэл хүлээлгэж болохуйц, төлөөлөл сайтай байгууллага гэж үзэн олон нийтийн зүгээс хүндэтгэлтэй хандах болсон төдийгүй шийдвэр гаргахад гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь ч харьцангуй нэмэгдсэн билээ.

Эвлэрэн зохицох итгэлцлийг бий болгох нь

33. Сонгуулийн тогтолцоо бол зөвхөн төр засгийн байгууллагыг бүрдүүлэх арга зам төдийгүй бас нийгэмд оршиж буй аливаа том, бага зөрчлийг зохицуулах хэрэгсэл мөн. Сонгуулийн зарим тогтолцооны нөлөөгөөр намууд өөрсдийн үндсэн дэмжигчдээс гадна бусад сонгогчдын дэмжлэгийг олж авахыг эрмэлзэх нь бий. Тухайлбал, голдуу хар арьст сонгогчдын дэмжлэг хүлээдэг нам цагаан арьст болон бусад сонгогчдын дэмжлэгийг олж авахаар хичээх, улмаар намын мөрийн хөтөлбөр нь явцуу, ялгаварлан гадуурхсан шинжтэй байхаа больж илүү нэгдмэл, нийтэд хандсан агуулгатай болоход сонгуулийн тогтолцоогоор дамжуулан нөлөөлөх боломжтой. Ийм маягаар сонгуулийн тогтолцооны зарим онцлог нь улс төрийн намууд үндэс угсаа, бүс нутаг, хэл соёл, үзэл суртлын хувьд ялгаварлах үзлээс ангид илүү нээлттэй ажиллах хөшүүрэг болдог. Сонгуулийн тогтолцооны янз бүрийн хувилбар хэрхэн зөрчлийн удирдлагын хэрэгсэл болж ирсэн тухай жишээг энэхүү гарын авлагад олонтаа дурдаж оруулсан байгаа.

34. Нөгөө талаар, сонгогчид өмнө сонголт хийж ирсэн хүрээнээсээ гадуур харж өөрсдөөс нь өөр бүлгийн эрх ашгийг төлөөлж ирсэн намыг сонгох боломж нөхцөлийг сонгуулийн тогтолцоо мөн олгодог. Ингэснээр нийгэм дэх янз бүрийн бүлэг өөр хоорондоо зохицож, нэгдэн нягтрах нааштай хандлага бий болно. Тухайлбал, нэгээс дээш хүнд санал өгөх, эсвэл хэд

хэдэн нэр дэвшигчийг эрэмбэлж санал өгөх боломж олгодог тогтолцоо нь сонгогч нийгмийн ялгаа, хил заагийг давж саналаа илэрхийлэх бололцоог нээдэг. Жишээлбэл, 1998 онд Умард Ирландад болсон Белфастын гэрээний дагуу явагдсан сонгуулийг санал шилжүүлэх тогтолцоогоор явуулсан нь “энхийн төлөөх” намуудад ашигтай туссан ихээхэн тэнцвэртэй үр дүнд хүргэсэн байдаг. Харин 2003 оны сонгуулиар эхний сонголтын зарчмаар (*first-preference votes*) сонгууль явуулахад санал хатуу чиг шугам баримтлагч намууд руу шилжиж өмнөх үр дүнгээс ухрах хандлага бий болсон.

Тогтвортой, үр бүтээлч засгийн газрыг дэмжих нь

35. Тогтвортой, үр бүтээлч засгийн газартай болох төлвийг дан ганц сонгуулийн тогтолцоо тодорхойлохгүй, гэвч аливаа тогтолцоо нь үүнд олон талаар чухал нөлөө үзүүлж байдаг. Сонгогчид тухайн тогтолцоог шударга гэж үзэж байна уу, сонгогдсон төр засаг нь хууль тогтоомжоо үр дүнтэй гаргаж, засаглаж чадах уу, тухайн тогтолцоо тодорхой нам, эсвэл сонирхлын бүлгийг ялгаварлахгүй үйлчилж байна уу зэрэг нь энд нэн тэргүүнд авч үзэх учиртай гол асуудлууд юм.

36. Сонгуулийн үр дүнг шударга гэж үзэх эсэх нь улс орон бүрт харилцан адилгүй ойлголтоос хамаарч байдаг. Их Британид сонгуулийн дүнг улсын хэмжээнд нэгтгэн үзэхэд хамгийн олон санал авсан нам өрсөлдөгчөөсөө цөөн суудал авч байсан тохиолдол хоёр удаа гарсан (1951 болон 1974 онд) боловч сонгууль тэр чигтээ шударга бус болсон, үр дүнг цуцлах ёстой гэж үзэхээс илүүтэй энэ нь үндсэндээ эрүүл саруул тогтолцоонд (харьцангуй олонхийн тогтолцоо, энэ талаар 76-79 дүгээр хэсгээс үзнэ үү) гарсан санамсаргүй сонин тохиолдол гэж үзсэн юм. Нөгөө талаар, үүнтэй төстэй үр дүн 1978, 1981 онуудад Шинэ Зеланд улсад гарч, тус улсын Үндэсний Нам сөрөг хүчин болох Хөдөлмөрийн Намаас цөөн санал авсан хэдий ч засгийн эрхэнд хэвээр үлдэх болсон нь сонгуулийн тогтолцоог өөрчилсөн шинэчлэлийн хөдөлгөөний эхлэл болсон гэж үздэг (Шинэ Зеландын тухай жишээг үзнэ үү).

37. Хууль тогтоох байгууллага үр дүнтэй ажиллаж чадах эсэх нь олонхи ямар тоотой байгаагаас зарим талаар хамаарах бөгөөд энэ нь эргээд сонгуулийн тогтолцоотой холбогддог асуудал юм. Зарчмын хувьд ОД тогтолцоонд хууль тогтоох байгууллагад олонхи болсон нам нь сөрөг хүчнүүдийн нийлбэрээс давах саналын хүчтэй байх магадлалтай байдаг бол ХТТ-нд эвслийн засгийн газар байгуулагдах магадлал өндөр байдаг. Гэвч ХТТ-нд нэг нам дангаар олонхи болж байсан болон ОД тогтолцоонд

нэг нам олонхийг бүрдүүлж чадаагүй тохиолдол гарч байсан. Үүний учир нь улс төрийн намын тогтолцооны бүтэц, тухайн нийгмийн өөрийнх нь шинж төрхөөс олон зүйл хамаарч байдагтай холбоотой.

38. Тухайн тогтолцоо аль болохоор бүх нам, нэр дэвшигчдэд тэгш тэнцүү байдлаар үйлчлэх учиртай бөгөөд аль нэг улс төрийн бүлгийг илэрхий ялгаварлан гадуурхах ёсгүй. Аливаа ардчилалд сонгууль нь улс төрийн тэнцвэргүй тоглолтын талбар гэсэн ойлголт байгаа бол энэ нь улс төрийн дэг журам сул, мөдхөн тогтворгүй байдал үүсэх магадлал өндөр байгаагийн шинж тэмдэг болно. Үүнийг харуулах тодорхой жишээ 1998 онд Лесотод явуулсан сонгууль байлаа. Харьцангуй олонхийн тогтолцоогоор явуулсан сонгуульд нийт саналын 60 хувийг авсан Лесотогийн Ардчиллын төлөө Конгресс нам хууль тогтоох байгууллагын бүх суудлыг авсан байна. Үүнээс үүдэн олныг хамарсан үймээн самуун гарч, улмаар Өмнөд Африкийн Хөгжлийн Хамтын Нийгэмлэгээс тус улсад цэрэг оруулж зохицуулахаас өөр аргагүй байдалд хүртэл зөрчил даамжирсан байдаг. Энэ үйл явдал сонгуулийн дээрх шиг үр дүн шударга бус төдийгүй аюултай болохыг харуулсан. Улмаар энэ явдлын дараа тус улс сонгуулийн тогтолцоогоо өөрчлөх арга хэмжээ авсан байдаг (Лесотогийн талаарх жишээг үзнэ үү).

Төрийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь

39. Хариуцлагатай байх нь төлөөллийн төр засгийн оршин тогтнох үндэс суурь юм. Төр нь хариуцлагагүй бол улс орон урт хугацааны тогтворгүй байдалд орж хямрах эрсдэл өндөр байдаг. Хариуцлагатай улс төрийн тогтолцоо гэдэг бол төр засаг нь сонгогчдынхоо өмнө дээд зэргийн өндөр үүрэг хариуцлага хүлээдэг тогтолцоог хэлнэ. Сонгогчид нэг бол засгийн эрхэнд байгаа намуудын эвслийг өөрчлөх, эсвэл хариуцлагатай байж чадаагүй намыг засгийн эрхээс буулгах замаар төр, засгийн бүтэц бүрэлдэхүүнд нөлөөлж чаддаг байх ёстой. Энэ зорилтыг хангахад зөв зүйтэй шийдсэн сонгуулийн тогтолцоо тус дөхөм болдог.

40. Сонгуулийн тогтолцооны талаар зарим нэг хэвшсэн ойлголт байдаг нь асуудлыг хэтэрхий энгийнээр авч үзсэн байдаг. Тухайлбал, харьцангуй олонхийн гэх мэт ОД тогтолцооны хувилбараар сонгууль явуулахад нэг нам засгийн эрх барих, ХТТ-оор бол олон намын, эсвэл байгуулагдаж засгийн эрх барина гэж үздэг уламжлалтай байв. Энэ үзлийн ерөнхий логик бодитой хэвээр байгаа боловч сүүлийн жилүүдэд нэг мандаттай тойрогт харьцангуй олонхийн тогтолцоогоор явуулсан сонгуулиуд олон намын эвслийн засгийн газар байгуулахад хүргэсэн (жишээлбэл, Энэтхэгт), эсвэл ХТТ-оор явуулсан сонгуулиуд (тухайлбал, Өмнөд Африкт) хүчтэй

нэг нам засгийн эрх барихад хүргэсэн жишээ хангалттай гарч байгаа нь сонгуулийн тогтолцооны тодорхой нэг хувилбар засаглалын тодорхой хэлбэрт хүргэнэ гэж автоматаар дүгнэж болох эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Гэвч парламентын ба ерөнхийлөгчийн засаглалын алинд ч сонгуулийн тогтолцоо засаглалын өргөн хүрээтэй асуудлуудад ихээхэн нөлөө үзүүлдэг нь тодорхой.

Сонгогдсон төлөөлөгчтэй хариуцлага тооцох нь

41. Хувь хүнтэй хариуцлага тооцно гэдэг нь нэгэнт сонгогдсон хүмүүс сонгуулийн үеэр өгсөн амлалтуудаасаа буцах, ажил хийх чадваргүйгээ харуулах юмуу албан үүргээ хесөрдүүлсэн тохиолдолд сонгогчид хатуу хяналт тавьж, сонгогдсон албан тушаалаас нь зайлуулж чаддаг байна гэсэн үг юм. Сонгуулийн зарим тогтолцоонд аль нэг хүчтэй намаас дэвшүүлсэн нэр дэвшигчдээс илүү тухайн нутаг орондоо нэр хүндтэй нэр дэвшигчдэд илүү ач холбогдол өгөх хандлага ажиглагддаг.

Од тогтолцоонд сонгогчдын хувьд санаанд нь хүртэл ажиллаж чадахгүй байгаа төлөөлөгчөө эгүүлэн татах боломж хамгийн өндөр байдаг гэж үзэж ирсэн уламжлалтай. Энэ нь зарим талаар үндэслэлтэй хэвээр байна. Харин Их Британид байдаг шиг сонгогчид нэр дэвшигчдээс илүү намыг нь харж сонгодог тохиолдолд ингэж үзэх хэцүү. Үүний зэрэгцээ нээлттэй юмуу чөлөөт жагсаалтаар санал хураадаг болон санал шилжүүлэх тогтолцоо зэрэг ХТТ-ны хувилбаруудад нэр дэвшигчдийг харж сонгох боломжтой байдаг нь хариуцлага тооцох нөхцөлийг бүрдүүлж буй хэрэг юм.

Улс төрийн намуудыг дэмжин хөгжүүлэх нь

42. Ардчилал тогтсон болон шинээр тогтоосон орнуудын аль алины туршлагаас харахад ардчилал урт хугацаанд бэхжин төлөвших нэг нөхцөл нь улс төрийн тогтвортой байдалд нөлөөлөх дотоодын аливаа сорилтоос хангалттай түвшинд хамгаалагдсан байх явдал бөгөөд үүний тулд эрч хүчтэй, чадварлаг улс төрийн намуудтай болох, тэдний хөгжих нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Иймээс сонгуулийн тогтолцоо нь намуудын жижгэрч задрах бус, харин хүчирхэгжиж, чадавхжих нөхцөл болох ёстой. Бага, эсвэл маш бага дэмжлэг авсан намуудыг хязгаарлах байдлаар сонгуулийн тогтолцооны хүрээг тогтоож болдог. Улс төрийн намыг удирдагчдад зориулсан хэрэгсэл хэмээн үзэх чиг хандлага байдаг бөгөөд сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн шийдэх нь үүнд нэг бол эерэгээр, эсвэл сөргөөр нөлөөлнө.

Сонгуулийн тогтолцоо нь үндэс угсаа, арьс өнгө, бүс нутгийн явцуу эрх ашиг гэхээсээ илүү улс төрийн өргөн хүрээтэй үнэт зүйлс, үзэл баримтлал болон тодорхой бодлогын хөтөлбөрт тулгуурласан намууд институцийн хувьд бүрэлдэн хөгжих хөшүүрэг болох ёстой гэж мэргэжилтнүүд санал нэгтгэй үздэг. Энэ нь нийгэмд хагарал зөрчил үүсэх эрсдлийг бууруулахаас гадна ийм өөр хоорондоо ялгаатай боловч харилцан холбоо бүхий үзэл баримтлалд тулгуурласан намууд нь тодорхой бүлгийг юм уу бүс нутгийг төлөөлсөн намуудыг бодвол улс үндэсний нийтлэг эрх ашгийг бодлого, үйл ажиллагаандаа тусгал болгох магадлал илүүтэй байна.

Хууль тогтоох байгууллагад сөрөг хүчний хяналтыг хөхиүлэн дэмжих нь

43. Үр дүнтэй засаглал нь дан ганц эрх баригчдаас төдийгүй тэднийг сөрөн зогсож, хяналт тавьж байгаа бүлгээс үлэмж хэмжээгээр хамаарна. Парламентын гаргаж буй хууль тогтоомжид шүүмжлэлтэй хандаж үнэлэлт өгөх, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хянах, цөөнхийн эрхийг хамгаалахын хажуугаар тойргийнхоо сонгогчдыг сайн төлөөлөх чадварлаг сөрөг хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлэхэд сонгуулийн тогтолцоо дэмжлэг үзүүлэх ёстой. Сөрөг хүчин үр бүтээлтэй ажиллахын тулд хангалттай тооны төлөөлөлтэй байх ёстой (сонгуульд өрсөлдөх чадвар нь үүнд бас чухал үүрэг гүйцэтгэнэ) бөгөөд парламентын засаглалд засгийн газраас ялгарах бодлогын бодитой сонголтыг санал болгох чадвартай байх ёстой. Сөрөг хүчний чадал сонгуулийн тогтолцооноос гадна бусад олон хүчин зүйлээс хамаарах нь мэдээж боловч сонгуулийн тогтолцоо нь сөрөг хүчнийг мохоох нөлөөтэй бол ардчилсан засаглал уг үндсээрээ сул байна гэсэн үг. Тухайлбал, Шинэ Зеланд холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ)-нд шилжих болсон нэг гол шалтгаан нь хуучин харьцангуй олонхийн тогтолцоогоор сонгууль явуулахад сөрөг хүчний жижиг намуудын төлөөлөл байнга дутмаг байж ирсэнтэй холбоотой. Үүний сацуу сонгуулийн тогтолцоо нь “ялагч бүгдийг авах” хандлагыг өөгшүүлэхгүй байх нь чухал. Ийм хандлага нь эрх баригчдыг бусдын үзэл бодол, сөрөг хүчний талын сонгогчдын хэрэгцээ, сонирхлыг олж харах чадваргүй болгодог бөгөөд сонгууль, төр засгийн аль аль нь үл хожих өрсөлдөөн болж хувирдаг.

Ерөнхийлөгчийн засаглалтай оронд Ерөнхийлөгч нь хууль тогтоогчдын нөлөө бүхий бүлгийн баттай дэмжлэгийг авах шаардлагатай. Гэвч, нөгөө талаар засгийн газраас дэвшүүлсэн хууль тогтоомжийн төсөл, санаачлагыг нягтлан шалгах, эсэргүүцэх үүрэг гүйцэтгэх сөрөг хүчний ач холбогдол түүнээс дутахгүй. Гэхдээ хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын хооронд

эрхмэдлийг зохистой хуваарилсан үед зөвхөн сөрөг хүчин төдийгүй, хууль тогтоох байгууллага бүхлээрээ гүйцэтгэх засаглалд хяналт тавих үүрэг хүлээх учиртай. Үүнтэй холбоотойгоор улс төрийн нам, нэр дэвшигчдийн, мөн нам болон сонгогдсон гишүүдийн хоорондын харилцаанд нөлөөлөх сонгуулийн тогтолцооны элементүүдэд анхаарал хандуулах нь чухал.

Сонгуулийн үйл явцыг тогтвортой болгох нь

44. Сонгууль нь судалгаа, эрдэм шинжилгээний номын хуудаснаа бус бодит ертөнцөд болдог үйл явц. Үүнийг дурдахын учир нь, сонгуулийн тодорхой тогтолцоог авч хэрэглэх шийдвэр нь сонгуулийн санхүүжилт, зохион байгуулах хүн хүч, нөөц бололцооноос олон талаар хамааралтай. Ардчилалд шилжиж байгаа улс орнуудын анхны ганц хоёр сонгуулийг хандивлагчид санхүүжүүлэх нь байдаг ч урт хугацаанд ийм санхүүжилт үргэлжлэх бололцоогүй. Иймээс улс төрийн тогтвортой байдлыг хангахад улс орнуудын хувьд нөөц бололцоогоо нарийн тооцоолох, чингэхдээ сонгууль зохион байгуулах мэдлэг чадвар бүхий хүний нөөц, төсвөөс гаргах боломжтой зардлын аль алийг бодолцож үзэх нь чухал.

Жишээлбэл, ядуу буурай орнууд хоёр шаттай тогтолцоогоор олон дахин сонгууль явуулах санхүүгийн бололцоогүй, эсвэл нэр дэвшигчдийг эрэмбэлсэн санал хураалтын дүнг (*preferential vote count*) тоолох нарийн түвэгтэй ажиллагааг удирдан зохион байгуулах хүн хүч дутагдалтай байж болно. Гэхдээ урт хугацаанд үр ашигтай байх эсэхийг нь бодолцохгүйгээр богино хугацаанд энгийн хялбар, зардал багатай тогтолцоо сонгох нь оновчтой биш. Сонгуулийн тогтолцоо хямд төсөр, зохион байгуулахад энгийн хялбар байвч улс орны тулгамдсан хэрэгцээг хангахгүй байгаа бол тохиромжгүй гэж үзнэ (сонгуулийн тогтолцоо улс орны хэрэгцээ шаардлагатай нийцэхгүй бол бүр ч хор хохиролтой үр дагавар авчирж болзошгүй). Нөгөө талаар анхандаа өртөг зардал өндөр, зохион байгуулахад түвэгтэй мэт санагдсан тогтолцоо яваандаа улс орны тогтвортой байдлыг хангаж, ардчиллыг зөв чиглэлд төлөвшүүлэн бэхжүүлэхэд тустай байж болно.

Олон улсын стандартуудыг харгалзан үзэх нь

45. Эцэст нь тэмдэглэхэд сонгуулийн тогтолцооны талаар шийдвэр гаргахад олон улсын пакт, гэрээ хэлэлцээр, холбогдох бусад олон улсын хууль эрх зүйн актуудыг харгалзан үзэх зайлшгүй шаардлага өнөө үед бий болсныг мартаж болохгүй. Сонгууль зохион байгуулахтай холбоотой бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын иж бүрэн багц стандарт байхгүй

боловч бүх нийтийн сонгуулийн эрх, саналын нууцлал, албадлагаас ангид байх эрх чөлөө, нэг хүн нэг санал өгөх зарчим зэрэг чөлөөт, шударга, тогтмол сонгуульд баримтлах нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд бий. Цаашилбал, тодорхой нэг төрлийн сонгуулийн тогтолцоо бусдаасаа илүү гэж томъёолсон эрх зүйн акт байхгүй ч бүх иргэдийн шударга төлөөлөл, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн адил тэгш байдал, цөөнхийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцгой хэрэгцээг анхаарч үзэх зэрэг сонгуулийн тогтолцооны нөлөөллөөс хамааралтай асуудалд улам бүр ач холбогдол өгч шийдвэр гаргахад харгалзан үзэх хандлага дэлхий нийтэд ажиглагдаж байна. Эдгээр зарчмуудыг 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1966 оны Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пакт зэрэг олон улсын эрх зүйн актууд, түүнчлэн Европын Холбоо (ЕХ), Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ) зэрэг бүс нутгийн байгууллагуудын ардчилсан сонгуультай холбоотой янз бүрийн конвенц, тэдгээрээр хүлээсэн үүрэгт албан ёсны болгон баталгаажуулсан байдаг.

Дүгнэлт

46. Дээр дурдсан арван шалгуур нь зарим тохиолдолд бие биетэйгээ зөрчилддөг, эсвэл нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн шинж чанартай санагдаж магад. Иймээс сонгуулийн тогтолцооны талаар шийдвэр гаргахад аль тогтолцоо хамгийн үр дүнтэй вэ гэдэгт үнэлэлт дүгнэлт өгөхийн өмнө улс төрийн тодорхой ямар нөхцөл байдалд аль шалгуур хамгийн чухал вэ гэдгийг нарийвчлан судалж тогтоох хэрэгтэй. Үүнийг гүйцэтгэх нэг арга нь ардчилалд аюул учруулах магадлалтай, улс төрийн эмгэнэлт байдалд хүргэж болзошгүй, ямар ч нөхцөлд зайлсхийх ёстой хүчин зүйлийг юун түрүүнд тогтоож тодорхойлох явдал байж болно. Жишээлбэл, үндэстэн угсаатны хувьд хуваагдмал улс орон сонгуулийн үйл явцын хууль ёсны байдлыг баталгаажуулах, түүнчлэн сонгуулийн тогтолцоо нь шударга бус гэж ойлгогдохоос зайлсхийх үүднээс үндэсний цөөнхийн төлөөллийг хангахад анхаарах нь чухал. Нөгөөтэйгүүр ардчилал шинээр тогтоосон орнуудын хувьд дээрхээс гадна төр засаг нь гацаанд оролгүй хууль тогтоомжоо үр дүнтэй батлан гаргах нөхцөлийг бүрдүүлэх, сонгогчид нь итгэл алдсан төлөөлөгчтэйгээ хариуцлага тооцох боломжтой байх зэрэг нь чухал. Ийм маягаар шалгууруудыг үнэлж эрэмбэлэх нь улс орныхоо нөхцөл байдлыг хэн хэнээс илүүтэй мэдэх дотоодын мэргэжилтнүүд, бодлогын хэлэлцүүлэгт оролцогчдын эрхлэн гүйцэтгэх ажил болно.

Өөрчлөлтийн үйл явц

47. Сонгуулийн тогтолцоог боловсруулах, өөрчлөх процесс нь өөрөө түүний үр дүнд бий болох тогтолцооны тухайн үеийн улс төрийн нөхцөлд таарч тохирох байдал, хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрөгдөн ард түмний дэмжлэгийг хүлээхэд асар их нөлөө үзүүлдэг.

Сонгуулийн тогтолцоог урьд өмнөх жишгийг огт харгалзалгүйгээр, цоо шинээр эхэлж боловсруулах нь маш ховор. Афганистан, Ирак улсууд хүртэл сонгуулийн тогтолцоогоо боловсруулахдаа иш татчихаар олон намын тогтолцооны түүхэн туршлагатай (хэдийгээр цаг хугацааны хувьд алслагдсан, ирээдүйд юу нь үр дүнтэй байх боломжтой нь бүдэг бадаг ч) байна.

Сонгуулийн тогтолцоог боловсруулах үйл явцтай холбоотой тавигддаг зарим чухал асуудлыг дурдвал: сонгуулийн тогтолцоог өөрчлөх санааг хэн улс төрийн хэлэлцэх асуудал болгон дэвшүүлж байна вэ, тогтолцоог шинээр буюу нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилж боловсруулах үүргийг хэн, ямар үйл явцаар дамжуулан хүлээж байна вэ? Шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулахад улс төр, эрх зүйн хүрээнд ямар механизмууд үйлчлэх вэ? Шинээр боловсруулсан буюу, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулсан тогтолцоог нийтээр хүлээн зөвшөөрүүлэхэд ямар хэлэлцүүлэг, яриа хэлэлцээ зайлшгүй шаардлагатай вэ? Нэгэнт шийдвэрт хүрсэн бол түүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ? зэрэг болно.

Хэн боловсруулах вэ?

48. Сонгуулийн тогтолцоо бүрэлдэн бий болох хэд хэдэн арга зам байна.

Нэгдүгээрт, колончлогчдынхоо тогтолцоог нэг их өөрчлөлгүйгээр өвлөн авсан байж болно (Малави, Мали, Соломоны арлууд, Палау).

Хоёрдугаарт, дотоодын хагарал, дайн мөргөлдөөнийг зогсоохыг эрмэлзсэн энхийн хэлэлцээрийн үйл явцаас үүссэн байж болно (Лесото, Өмнөд Африк, Ливан) Ийм нөхцөл байдалд сонгуулийн тогтолцооны талаарх шийдвэрийг олон нийтийн оролцоо, хяналтаас гадуур нээлттэй бус байдлаар гаргах нь бий.

Гуравдугаарт, тогтолцоог зөрчил мөргөлдөөний дараа улс төрийг сэргээн босгох үйл явцад идэвхтэй оролцож буй бүлгүүдийн тулгалтаар хийх нь байна (Ирак, Афганистан).

Дөрөвдүгээрт, өмнөх авторитар дэглэмийн төлөөлөгчид албан тушаалаас буух үедээ сонгуулийн шинэ тогтолцоог боловсруулахад хүчтэй нөлөөлсөн байж болно (Чили).

Тавдугаарт, зөвхөн сонгуулийн тогтолцоог судлах үүрэгтэй мэргэжилтнүүдийн зөвлөлийг дангаар нь байгуулах замаар (Их Британи, Маврикий), эсвэл үндсэн хууль боловсруулах, шинэчлэх өргөн хүрээтэй санаачлагын нэг хэсэг болгож (Фижи) авч үзэх нь бий. Ийм тохиолдолд үндэсний хэмжээнд бүх нийтийн санал асуулга явуулж (Шинэ Зеланд), эсвэл зөвлөлөөс гаргасан санал зөвлөмжөөр хууль тогтоох байгууллага нь санал хурааж (Фижи) шийдвэрлэдэг.

Зургадугаарт, сонгуулийн тогтолцооны асуудлаар иргэдийн зөвлөл байгуулах замаар сонгуулийн тогтолцоог шинэчилсэн туршлага байна. Тухайлбал, энэ аргыг Канад улсын Бритиш Колумбия мужид хэрэглэсэн байх бөгөөд иргэдийн зөвлөл нь харьцангуй олонхийн тогтолцоог олон санал шилжүүлэх тогтолцоо болгон өөрчлөх зөвлөмж гаргаж, улмаар мужийн хэмжээнд бүх нийтийн санал асуулга явуулан асуудлыг шийдвэрлэсэн байна (Бритиш Колумбия мужийн тухай жишээг үзнэ үү).

Бритиш Колумбия: Иргэдийн эрх мэдэлтэй оролцоо

Бритиш Колумбиягийн Сонгуулийн Шинэтгэл Хариуцсан Иргэдийн Зөвлөл

Канадын Бритиш Колумбия мужийн засаг захиргаанаас тус мужийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн зөвлөл байгуулж, улмаар сонгуулийн тогтолцоог хараат бусаар үнэлж дүгнэх, гаргасан зөвлөмжөө бүх нийтийн санал асуулгаар шийдвэрлүүлэх боломж олгосон нь урьд өмнө хаа ч байгаагүй, өвөрмөц бөгөөд цоо шинэ туршлага болсон юм.

Энэ үйл явдлын эхлэл нь 1996 онд болсон тус мужийн парламентын сонгуулиас үүдэлтэй. Харьцангуй олонхийн тогтолцоогоор явуулсан уг сонгуульд Шинэ Ардчилсан Нам (ШАН) нийт сонгогчдын 39 хувийн саналаар 39 суудал авсан нь 42 хувийн санал авсан Либераль Намын 33 суудлаас илүү байв. Улмаар Либераль Намаас бага дэмжлэг авсан ШАН олонхи болж дараагийн таван жилд эрх барих засгийн газраа бүрдүүлжээ. Энэ сонгуулийн дараа Либераль Нам сонгуулийн шинэчлэлийг улс төрийн эн тэргүүний зорилт болгон дэвшүүлсэн ба 2001 оны сонгуульд оролцохдоо бие даасан Иргэдийн Зөвлөл байгуулах замаар сонгуулийн тогтолцоог шинэчлэх амлалт өгсөн байна. Уг сонгуульд Либераль Нам нийт саналын 58 хувь, парламентын нийт суудлын 97 хувийг авч ялалт байгуулснаар сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэх бүрэн бололцоотой болж авчээ.

Канадад төрийн бодлогын асуудлаар иргэдийн санал бодлыг сонсох үйл явц нь ихэвчлэн шүүгчид, мэргэжилтнүүд, улстөрчдөөр ахлуулсан хороод томилон сонсгол зохион байгуулах замаар явагддаг. Тодруулбал, олон нийтийн асуулга, санал хүсэлтийг хүлээн аваад хэсэг хугацаанд өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явуулж зөвлөлдсөний дараа тухайн хорооны гаргасан тайланг харгалзан цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээ шийддэг байна.

Иргэдийн зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, эрх, үүргийн хэмжээ, хүрээ хязгаарыг бодож боловсруулах ажлыг улс төрийн нэгэн намын удирдагч асан, нэр хүндтэй сэтгүүлч, бизнесмен, улстөрч Гордон Гибсон шинэ Засгийн газар болон сонгуулийн шинэчлэлийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөн гүйцэтгэжээ. Бритиш Колумбиагийн хувьд энэ санаачлагыг гаргаснаар дараах хоёр өвөрмөц онцлог бүхий анхдагч жишгийг тогтоосон гэж болно. Үүнд, уг ажлыг гүйцэтгэх үүрэг хүлээсэн хүмүүс нь мэргэжилтэн, судлаачид биш жирийн иргэд байв. Хоёрдугаарт, хэрэв зөвлөл сонгуулийн тогтолцоог өөрчлөх дүгнэлтэд хүрвэл уг асуудлыг Засгийн газрын шүүлтүүрээр дамжуулалгүй шууд мужийн хэмжээнд бүх нийтийн санал асуулгаар шийдвэрлэхээр тогтсон нь байв.

Иргэдийн зөвлөлийг Бритиш Колумбия мужийн сонгогчдын нэрийн жагсаалтаас санамсаргүй байдлаар түүвэрлэн авсан бүх насны эрэгтэй, эмэгтэй, нам бус, хараат бус 160 хүнээс бүрдүүлсэн байна. Зөвлөлийг ийнхүү байгуулахдаа 2001 оны мужийн хүн амын тооллогод үндэслэн нас, хүйсийн хувьд тэнцвэртэй, мужийн газар нутгийг бүхэлд нь төлөөлсөн байх шалгуурыг үндэс болгосон ба мөн уугуул иргэдээс хоёр хүнийг оролцуулжээ. Үүний дараа гишүүдийг эрчимтэй сургалтад хамруулан сонгуулийн тогтолцооны төрөл, хувилбаруудын тухай мэдээлэл өгч, давуу ба сул талыг нь танилцуулан (энэ мэдээллийг бүх иргэдэд нээлттэй болгосон) хэлэлцсэн байна.

Энэхүү суралцах шатны төгсгөлд Иргэдийн зөвлөлөөс гаргасан урьдчилсан дүгнэлт бүхий тайланг (*Preliminary statement to the People of British Columbia*) парламентын гишүүд, номын сан, хот дүүргийн захиргаад, их дээд болон дунд сургуулиудад тарааж нийгмийн янз бүрийн бүлэгт танилцуулжээ. Үүний дараа олон нийтийн санаа бодлыг сонсох хэлэлцүүлгийг үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эхэлсэн бөгөөд мужийн хэмжээнд 50 орчим нээлттэй сонсгол зохион байгуулсанд 3,000 гаруй хүн оролцсон байдаг. Эдгээрийн эцэст Иргэдийн зөвлөл сонгуулийн хоёр тогтолцоогонончтой гэж тогтсон батус бүрийн онцлогийг нарийвчлан судалж гаргажээ. Шийдвэр гаргахын өмнө Зөвлөлийн анхны нэгдсэн хэлэлцүүлгийн үеэр нээлттэй сонсголд авууштай санал дэвшүүлсэн зарим илтгэлийг давтан сонгосон байна. Энэ бүхий л үйл явцад Бритиш Колумбиагийн сонгуулийн тогтолцоонд онцгой чухал, заавал харгалзах ёстой элементийг олж тодорхойлох, сонгуулийн тогтолцооны боломжит хувилбаруудыг эдгээр элементтэй холбож нарийвчилсан үнэлэлт дүгнэлт өгөх, хамгийн гол нь олон нийтийн мэдлэг, оролцоог ханган нэмэгдүүлэх зорилт дэвшүүлж ажилласан ажээ. Эцэст нь сонгуулийн тогтолцооны гурван чухал элементийг тогтоосон нь сонгогчдын саналаараа дамжуулан илэрхийлсэн хүсэл зориг, орон нутгийн төлөөлөл, хувь тэнцүүлсэн байдал

гурав байв. Ингээд тус Зөвлөлөөс 2004 оны 10 дугаар сард зөвлөмжөө гаргаж танилцуулсан нь харьцангуй олонхийн хуучин тогтолцоог нэг шилжих саналын тогтолцоо болгож өөрчлөх санал (энэ саналыг 145 хүн дэмжиж, 7 хүн эсрэг санал өгсөн байна) дэвшүүлсэн байв. Эцэст нь Иргэдийн Зөвлөлийн албан ёсны эцсийн тайланг нийтэлж, зөвлөмжид тусгасан тогтолцоог сонгох эсэх асуудлыг бүх нийтийн санал асуулгаар шийдвэрлэжээ.

Оролцооны энэ загвар Канад даяар янз бүрийн бүлгийн сонирхлыг ихэд татсан агаад иргэдэд хамаатай, тэдний эрх мэдлийн хүрээнд байх ёстой асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийг татан оролцуулах сайн арга гэж үзэн Канадын бусад мужуудад авч хэрэглэхийг зөвлөмж болгосон ажээ. Улмаар үүнтэй төстэй нэгэн ажиллагааг Онтарио мужийн захиргаанаас санаачилсан байдаг.

Канадад болж өнгөрсөн бусад сонгуулийн туршлага ч сонгуулийн үйл явцыг эргэн харж үнэлж дүгнэх үйл явц улам эрчимжихэд нөлөөлж байна. Тухайлбал, холбооны сонгуульд нийт саналын 50 хувиас нэлээд доогуур тооны санал авсан нам эрх барих явдал олонтаа тохиолдож байв. Үүнээс үүдэлтэй холбооны түвшинд сонгуулийн тогтолцоог өөрчлөх хэд хэдэн санаачлага, түүний дотор Fair Vote Canada буюу Канадын Шударга Сонголт (КШС) иргэдийн санаачлага төрөн гарсан бөгөөд үүний зэрэгцээ олон тооны бие даасан лобби, нөлөөллийн үйл ажиллагаа идэвхтэй өрнөх болжээ.

Бритиш Колумбиагийн Иргэдийн зөвлөлийн туршлага цаашид Канадад сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн асуудлаар явагдах мэтгэлцээн, тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгч, өөрчлөх үйл явцад ихээхэн нөлөө үзүүлнэ гэж үзэх үндэстэй юм. Тухайлбал, ШАН болон Консерватив Намын аль аль нь шахалт үзүүлсний үр дүнд 2004 оны 10 дугаар сард “Сонгуулийн тогтолцоогоо үнэлж дүгнэн, бүх боломжийг судлах ажилд иргэд, парламентын гишүүдийг оролцуулах ажиллагааны талаар санал зөвлөмж гаргахыг Хуралдааны дэг болон парламентын хэрэг эрхэлсэн байнгын хороонд үүрэг болгох” тухай Хатан Хааны Зарлигт¹ оруулахыг санал нэгтэй зөвшөөрсөн байна.

¹ Канад Улс нь Хамтын Нөхөрлөлийн гишүүн улс бөгөөд Хатан Хаан Хоёрдугаар Элизабет төрийн тэргүүн нь юм. Хамтын нөхөрлөлийн орнуудад Хатан Хаан парламентын чуулганыг нээж үг хэлдэг уламжлалтай агаад Канад ч бас энэ уламжлалыг дагаж парламентын шинэ чуулганаа “*Speech from the Throne*” буюу Хатан Хааны Зарлигаар эхлүүлдэг. Зарлигт парламентаас шийдвэрлэх асуудлын төлөвлөгөө, зорилго, чиглэлийг ерөнхийд нь танилцуулдаг байна (Орч).

Бритиш Колумбиагийн Иргэдийн Зөвлөлийн туршлага олон улсын хэмжээнд сонгуулийн тогтолцоог шинэчлэх үйл явцад ямар үлгэр дууриал болж нөлөөлөх нь тодорхойгүй ч иргэдийн оролцоотой шийдвэр гаргах үйл явцын талаар эмперик мэдлэгт хувь нэмэр болж, олон хүний сонирхлыг татсан үйл явдал болсон нь дамжиггүй билээ.

Шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ямар механизмууд байна вэ?

49. Сонгуулийн тогтолцоо нь аливаа улсын төр засгийн үйл ажиллагаанд нөлөөтэй туйлын чухал институци бөгөөд хамгийн дээд эх хууль болох үндсэн хуульд энэ талаар албан ёсоор заадаггүй байсан уламжлалтай. Гэхдээ сүүлийн жилүүдэд энэ нь өөрчлөгдөж эхэлжээ.

Өнөөдөр цөөнгүй улс орон үндсэн хууль болон үндсэн хуулийнхаа тусгай хавсралтад сонгуулийн системийн нарийн ширийнийг “суулгаж” өгөөд байна. Энэ нь сонгуулийн тогтолцоог шинэчлэгчдийн хувьд ямар учир холбогдолтой вэ гэвэл үндсэн хуулийн заалтыг бусад жирийн хуулийг бодвол өөрчлөхөд хэцүү байдаг бөгөөд үүний тулд хууль тогтоох байгууллагын дийлэнх олонхийн санал, бүх нийтийн санал асуулга, бусад нарийн төвөгтэй механизм шаардагддаг. Энэ нь тухайн тогтолцоог хялбар өөрчлөхөөс хамгаалсан хамгаалалт болно. Жишээлбэл, Өмнөд Африкийн Үндсэн хуульд Үндэсний Ассамблейн сонгууль явуулах тогтолцоо нь “ерөнхийдөө хувь тэнцүүлсэн” байна гэж заасан байдаг учраас үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахгүй л бол шинэчлэл хийх боломж нь хязгаарлагдмал ажээ.

Гэхдээ сонгуулийн тогтолцоог жирийн хууль тогтоомжоор хуульчлах нь түгээмэл хэвээр байгаа бөгөөд хууль тогтоох байгууллага энгийн олонхийн саналаар түүнийг өөрчлөх боломжтой юм. Энэ нь тухайн тогтолцоог олон нийтийн үзэл бодлын өөрчлөлт, улс төрийн хэрэгцээ шаардлагын дагуу өөрчилж болох давуу талтай ч хууль тогтоох байгууллагын олонхийн зүгээс өөрсөддөө улс төрийн давуу байдал олж авах зорилгоор сонгуулийн тогтолцоонд дангаар өөрчлөлт оруулж болох эрсдлийг дагуулдаг.

50. Шинэчлэлт хийх боломж нь өөрчлөлтийн эрх зүйн механизм, өөрчлөлт хийхийг шаардаж байгаа улс төрийн нөхцөл байдал хоёрын аль алинаас нь хамааралтай байдаг. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх хөдөлгөөн бүр амжилтад хүрдэггүй. Томоохон өөрчлөлт хийсэн сүүлийн үеийн бараг бүх жишээ дараах хоёр орчин нөхцөлийн аль нэгэнд явагдсан байдаг. Үүнд, нэгдүгээрт, ардчилалд шилжих явцад буюу түүний дараахан улс төрийн хүрээ бүхэлдээ “хэний ч гарт орж болохоор” үед, хоёрдугаарт, ардчилал тогтсон аль нэг оронд засаглалын ямар нэг хямрал нүүрлэсэн үед. Тухайлбал, Шинэ Зеланд Улсын эрх баригч нам томоохон сөрөг хүчний намуудаас цөөн тооны санал авсан атлаа олонхи болон сонгогдож хоёр ч удаа дараалан засгийн эрх барьсныг хууль ёсны бус гэж үзсэн жишээ

байна. Мөн Итали, Япон Улсад авлига өндөр түвшинд байдаг нь тодорхой хувь хүмүүсийн үйлдэл гэхээсээ илүү улс төрийн тогтолцооны гажиг гэж үздэг. Шинэ Зеланд, Япон Улсын жишээг хойно дэлгэрэнгүй өгүүлсэн байгаа.

51. Хэдийгээрardtтүмэнулстөрийнтогтолцоондасарихээритгэлалдарсан, сэтгэл ханамжгүй байлаа ч өөрчлөлт хийхийн тулд эрх баригчидтай тохиролцох шаардлагатай болно. Улс төрийн элитүүдийн хувьд өөрчлөлт хийснээр өөрсдөө хүртэх үр өгөөжийг олж харсан юмуу өөрчлөлт хийж чадаагүй тохиолдолд сонгуулийн үр дүнд тэдэнд учирч болох уршгаас айсан үедээ л хөдлөх магадлалтай. Хэчнээн ятгаж үнэмшүүлээ ч гэсэн тэд өөртөө хамгийн их ашигтай тогтолцоог сонгоход гайхах зүйлгүй. Хэрвээ нөхцөл байдлыг өөртөө ашигтайгаар эргүүлэх арга олохгүй юмуу янз бүрийн ашиг сонирхол өөр өөр тогтолцоог сонгохоор өрсөлдөж буй бол харилцан буулт хийх магадлалтай бөгөөд ийм нөхцөлд холимог тогтолцооны аль нэг хувилбарыг сонгох нь бий. Гэвч зөвшилцлөөр хүрсэн өөрчлөлт нь түүнийг талархан дэмжигчдийн хүссэн үр дүнг үзүүлж чадахгүйгээр барахгүй, огт таамаглаагүй үр дүн авчрах нь бий. Тухайлбал, 1994 онд Мексик Улсын эрх баригч намаас сөрөг хүчиндээ буулт хийх үүднээс хийсэн шинэчлэл нь сүүлийн жилүүдэд хамгийн пропорциональ бус үр дүн гарахад хүргэсэн байна (Мексик Улсын жишээг үзнэ үү).

52. Өмнөд Африк, Чилийн жишээ нь улс төрийн бодит нөхцөл байдал, эрх баригч намын хүч нөлөөгөө хадгалах хүсэл эрмэлзэл нь сонгуулийн тогтолцооны шинэчлэлд томоохон саад тотгор учруулдагыг тод харуулсан. Тодруулбал, Өмнөд Африкт томсгосон тойрогт хаалттай жагсаалтаар санал хураах дүрэм бүхий ХТТ нь сонгогдсон төлөөлөгчдийг сонгогчдоос нь холдуулж байна гэж үзэн орон нутгийн түвшинд хариуцлага тооцох элемент нэмж суулгах уриалга хүчтэй өрнөсөн. Түүгээр зогсохгүй Ерөнхийлөгчийн дэргэд байгуулсан комиссын 2003 оны нэгдүгээр сарын тайлан илтгэлд хийсэн дүгнэлтийн нэлээд хэсэг үүнийг улам бататгасан боловч шинэчилэл хийснээр нам нь нэр дэвшигчдийг сонгох, улмаар намын бүлгээр асуудал шийдвэрлэхэд нөлөөлөх боломж буурах байсан учир өөрчлөлт хийхээс цэрвэж татгалзсан байна (Өмнөд Африкийн жишээг үзнэ үү). Чили Улсад ноёрхож байсан генерал Пиночетийн дэглэм сонгуулийн тогтолцоог өөрсдийн холбоотнуудад ашигтайгаар өөрчлөн зохион байгуулсан байна. Пиночетийг засгийн эрхнээс зайлуулснаас хойш арав гаруй жил болчихоод байхад энэ тогтолцоо бараг өөрчлөгдөөгүй хэвээр үлджээ (Чили Улсын жишээг үзнэ үү).

53. Шинэ Зеланд Улсад (жишээг үзнэ үү) сонгуулийн тогтолцоог бүх нийтийн санал асуулгаар өөрчлөх үйл явц анх сонгуулийн кампанит ажлын үеэр нэгэн томоохон намын дарга нөгөө нэг том намаа хүнд байдалд оруулах гэсэн улс төрийн алхмаас үүдэлтэй байв. Хоёр үе шаттай явагдсан санал асуулгаар эхлээд сонгогчдоос сонгуулийн тогтолцоог бүхэлд нь өөрчлөхийг хүсч байгаа эсэхийг асуухаас гадна сонгуулийн тогтолцооны дөрвөн сонголтоос алийг нь илүүд үзэж байгаагаа тэмдэглэхийг хүссэн байна. Хоёр дахь санал асуулгаар сонгогдсон тогтолцоог шинээр нэвтрүүлэх, эсвэл хуучин тогтолцоогоо хэвээр үлдээх хүсэлтэй эсэхийг асуусан байна. Үүний эцэст олон мандаттай ХТТ-г олон нийтийн дэмжлэгтэйгээр авч хэрэглэх болжээ.

54. Сонгуулийн тогтолцоо улс төр, хүн ам зүй, эрх зүйн шинэ чиг хандлага, эрэлт хэрэгцээг зохистой хангаж байхын тулд цаг хугацаа өнгөрөхөд тухайн нөхцөл байдалд зохицон өөрчлөгдөж байх зайлшгүй шаардлагатай. Гэтэл аль нэгэн тогтолцоог хэрэглэж байгаа нөхцөлд үр шимийг нь хүртэгчид түүнийг өөрчлөх асуудлыг эрс эсэргүүцэх магадлалтай. Улс төрийн тогтолцооны шилжилт хийгээгүй, эсвэл ямар нэг томоохон улс төрийн хямрал зэрэг өөрчлөлтийн хурдастгаар болох хүчин зүйл нөлөөлөөгүй тохиолдолд ул суурьтай шинэчлэлээс илүүтэй нэр төдий өнгөцхөн өөрчлөлт хийгдэх магадлал өндөр болох нь туршлагаас харагддаг. Нөгөө талаар зөрчил мөргөлдөөний дараах шилжилтийн үед, тухайлбал, нэн даруй энхийн гэрээ байгуулах улс төрийн шаардлага зэрэг хойшлуулшгүй хэрэгжүүлэх практик алхмууд бүр эхнээсээ зөв зүйтэй сонгуулийн тогтолцоотой болох хүсэл эрмэлзлэлтэй зөрчилддөг.

Хэрэв шинэчлэгчид одоо байгаа тогтолцоогоо сайжруулах замаар өөрчлөлт хийе гэвэл сонгуулийн тойргийн мандатын тоо (113-118-р хэсгийг үзнэ үү), саналын босгын түвшин (119-р хэсгийг үзнэ үү), эсвэл квот тогтоох томъёогоо өөрчлөх асуудлыг (Хавсралт Б-г үзнэ үү) судлан үзэж болох юм. Сүүлийн хэдэн жилд амжилттай хийгдсэн олон чухал шинэчлэлийн дотор хуучин байсан харьцангуй олонхийн тогтолцоондоо намын жагсаалтаар санал хураах ХТТ -ны элемент нэмж илүү хувь тэнцсэн шинжтэй холимог тогтолцоо бий болгосон жишээ олон байна (тухайлбал, Лесото, Тайландад хийгдсэн өөрчлөлтийн талаарх жишээг үзнэ үү).

Хэлэлцүүлэг, санал солилцох ажиллагааны талаарх зөвлөгөө

55. Өөрчлөлтийн эрх зүйн асуудлын хэлбэр, техникийн үндэслэлийг, түүнчлэн хийгдэх боломжтой өөрчлөлтийн тухайн орны улс төрийн

өргөн хүрээнд үзүүлэх үр дагавар, учир холбогдлыг ойлгож, тайлбарлаж чаддаг байх нь шинэчлэгчдийн үүрэг юм. Өөрчлөлт зайлшгүй хийх шаардлагатай талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд иргэний нийгмийнхэн, судлаач шинжээчид, хэвлэл мэдээллийнхний дуу хоолой багагүй хувь нэмэр оруулдаг. Гол нь шийдвэр гаргахад нөлөөтэй эрх баригчдад шинэчлэл ашигтай болохыг ухуулан таниулж итгүүлэх шаардлага гарна.

56. Сонгуулийн тогтолцоог ихээхэн сонирхож буй өнөө үед элитийн хүрээнд ч, ер нь нийгэм дотор ч өөрчлөлтийн болзошгүй үр дагаврыг ойлгодог хүн маш цөөхөн байх талтай. Сонгуулийн тогтолцоог практик амьдралд хэрэгжүүлэх нь өнгөц харахад яльгүй жижиг зүйл мэт харагдах нарийнширийн асуудлаас ихээхэн хамааралтай байдаг нь нөхцөл байдлыг улам чярвигтай хүнд болгодог. Шинэчлэгчид өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эрх зүйн нарийнширийн асуудлыг тал бүрээс нь нягтлан тайлбарлаад зогсохгүй техник тооцоолол, загварчлал гаргаж (гол төлөв өмнөх сонгуулийн тоо баримтуудыг ашиглан), сонгуулийн тойргуудын хэлбэр хэмжээ, улс төрийн намуудын төлөөлөлд үзүүлэх нөлөөг жишээгээр харуулах хэрэгцээ тулгарч болно. Түүнчлэн бүхий л үүсч болзошгүй нөхцөл байдал, хүчин зүйлсийг бүрэн тооцох, биелэх магадлалбагатай үр дагаврыг ч гэсэн үнэлэнцэгнэхэд техник загварчлалыг ашиглах боломжтой. Тулгарах асуудлын хариуг хожим хямрал үүссэн үед биш харин өөрчлөлтийг хэлэлцэж сурталчлах явцад олж мэдэх нь дээр!

57. Сонгогчдыг татан оролцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, жишээлбэл, саналболгожбуйшинэ тогтолцооны дагуу загвар сонгууль зохион байгуулж иргэдийг урьж оролцуулах нь хэвлэл мэдээллийнхний анхаарлыг татаж, улмаар тухайн өөрчлөлтийн талаар ойлголт мэдлэгийг дээшлүүлэх тустай арга зам болдог. Мөн иймэрхүү үйл ажиллагаа нь сонгогчид саналын хуудсыг бөглөхөд хүндрэлтэй байх гэх мэт тухайн шинэ тогтолцооноос үүдэн гарч болох хүндрэл бэрхшээлийг олж тогтооход туслах нь бий.

Хэрэгжүүлэх талаарх зөвлөгөө

58. Сонгогчид, сонгууль зохион байгуулагчид, улстөрчид, тоймчид гээд бүгд л өөрсдийн дасал болсон зүйлд дуртай байх хандлагатай байдаг. Олон жил ашиглаж ирсэн тогтолцооны өө сэв дарагдаж арилсан ч байж болно. Гэтэл шинэ тогтолцоо нэвтрүүлнэ гэдэг нь мэдэхгүй зүйл рүү үсрээд орохтой адил бөгөөд танил дасал болоогүйгээс болж хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл гарч болно. Энэ бэрхшээлээс бүрэн зайлах аргагүй бөгөөд хууль тогтоомжид өөрчлөлт оруулчихлаа гээд хойш суучихаж

болохгүй. Шинэ тогтолцоо хэрхэн ажилладагыг бүх оролцогчдод тайлбарлаж өгөх сонгогчдын боловсролын хөтөлбөрийг эрчимтэй зохион байгуулж, тогтолцоог амьдралд хэрэгжүүлэх дүрэм журмыг хэрэглэгчдэд ойр дөхөм байдлаар боловсруулж, харилцан ойлголцсон цагт л өөрчлөлтийн үйл явц дуусах ёстой.

59. Сонгогчдын болон сонгуулийг удирдан зохион байгуулагчдын боловсролыг дээшлүүлэх ажиллагааг үр өгөөжтэй зохион байгуулахад багагүй цаг хугацаа шаардагдана. Гэтэл шинэ тогтолцоогоор сонгууль зохион байгуулах сонгуулийн байгууллагад цаг хугацаа тун бага байх нь олонтаа тохиолддог. Эцсийн тохиролцоонд хүрэхэд цаг хугацааны энэ дарамт шахалтыг ашиглах хүмүүс байна. Ялангуяа хүндхэн яриа хэлэлцээний үр дүнд шинэ тогтолцоо төрөн гарч буй бол энэ байдал тодорхой ажиглагддаг. Гэсэн хэдий ч сонгуулийн байгууллага нь үнэхээр сайн ажилладаг бол бэлтгэлээ аль болох эртнээс сайн хангахад анхаарна.

Өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэх нь

60. Өөрчлөлтийн үйл явцыг тодорхой түвшинд гүнзгийрүүлэн авч хэлэлцсэний дараа түүнээс үүсэх үр дагаврын талаар нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Сонгуулийн тогтолцоо нь сэтгэл зүйн төдийгүй механик нөлөөтэй байдаг учраас өөрчлөлтийн үзүүлэх урт хугацааны үр нөлөө илэрч гартал тодорхой цаг хугацаа шаардлагатай. Тухайн өөрчлөлтийг хийх болсон шалтгаан, үзүүлэх нөлөөг намууд, нэр дэвшигчид болон сонгогчид бүрэн ажиглаж, хариу арга хэмжээ авах хүртэл хоёроос гурван сонгуулийн хугацаа ч шаардагдаж магад. Холимог тогтолцоонд шилжих үйл явцад энэ байдал улам тод томруун мэдрэгдэж болзошгүй юм. Учир нь энэ тогтолцооны янз бүрийн нөлөөлөл нэр дэвшигчид болон сонгогчдод ямар байдлаар тусч буй нь шууд тодорхой биш байх магадлал өндөр байна.

Шинэ буюу засч шинэчилсэн тогтолцоонд тохиолдож буй хүндрэл бэрхшээл ердөө л шилжилтийн чанартай, эсвэл тухайн тогтолцоо үндсээрээ алдаа мадагтай учраас яаралтай засч залруулах буюу солих шаардлагатай эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх зайлшгүй хэрэгцээ тулгарч болно. Фижи Улсад 2000 оны Жорж Спейгтийн хийсэн төрийн эргэлтээс хойш угсаатан хоорондын харилцаанд аядуу зөөлөн байдлыг хадгалах эрмэлзлийг харгалзан намууд ба сонгогчид альтернатив саналын тогтолцоог хэвээр үлдээж нутагшуулах уу, эсвэл 1997 онд энэ тогтолцоог нэвтрүүлснээс хойш болсон үйл явдлууд уг тогтолцоо Фижигийн нөхцөл

байдалд угаасаа тохирохгүй гэдгийг харуулаад байна уу гэсэн маргаан одоо ид өрнөж байгаа билээ.

Сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн чиг хандлагууд

61. 1993 онд Италид бүх нийтийн санал асуулгаар сонгуулийн тогтолцоогоо холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ)-оор сольж өөрчилсөн нь дэлхий дахинаа сонгуулийн тогтолцооны томоохон өөрчлөлт гарах эхлэл болсон юм. Эдгээрийн дийлэнхид нь суудал хуваарилах томъёог шинэчлэх, сонгуулийн тойргуудын тоог өөрчлөх, хууль тогтоох байгууллагын суудлыг цөөн тоогоор нэмэгдүүлэх зэрэг өнгөц өөрчлөлт хийж ирсэн боловч 26 улс Италийн жишээг дагаж, сонгуулийн тогтолцоогоо бүхэлд нь өөрчлөх шинэчлэлийн үйл явцыг туулж өнгөрөөд байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Хүснэгт 1-ээс үзэхэд сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн чиг хандлага нэлээд тодорхой харагдаж байна. Сонгуулийн тогтолцоогоо өөрчилсөн ихэнх орон нэг бол харьцангуй олонхийн тогтолцоогоо ХТТ-ны элементээр (Параллель, эсвэл ХХТТ болгож) баяжуулах, эсвэл хуучин тогтолцоогоо бүхэлд нь намын жагсаалтаар санал хураадаг хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ)-гоор солих замаар хувь тэнцүүлэх тал руугаа илүү чиглүүлэх болсон байна. Хамгийн түгээмэл хийгдсэн шилжилт бол харьцангуй олонхийн тогтолцооноос холимог тогтолцоонд шилжих явдал байсан бөгөөд үүний эсрэг чиглэлд шилжилт хийсэн жишээ огт байхгүй байна. Харьцангуй олонхийн тогтолцоог шинээр авч хэрэглэсэн тохиолдлуудаас Мадагаскар Улсаас бусад нь бүгд нэг төрлийн тогтолцооны хүрээнд хийгдсэн шилжилтүүд байна. Харин Мадагаскар Улсын хувьд цэвэр ЖХТТ-оос харьцангуй олонхийн системийн элемент давамгайлсан эрлийз ЖХТТ-нд шилжжээ.

Хүснэгт 1. Сүүлийн үед сонгуулийн тогтолцоонд хийгдсэн өөрчлөлт

Өмнөх тогтолцоо (ангилал)	Шинэ тогтолцоо (ангилал)			
	Олонхийн/ Мажоритар	Холимог	Хувь тэнцүүлсэн төлөөлөл	Бусад
Олонхийн	Бермуда (БСТ-с ХОТ)	Лесото (ХОТ-с ХХТТ)	Ирак (ХШТ-ЖХТТ)	Иордан (БСТ-с СҮШТ)
	Фижи (ХОТ-с АСТ)	Монако (ХШТ-с Параллель)	Руанда (ХОТ-с ЖХТТ)	Афганистан (ХОТ-с СҮШТ)
	Монтсеррат (ХОТ-с ХШТ)	Шинэ Зеланд (ХОТ-с ХХТТ)	Сиерра Леоне (ХОТ-с ЖХТТ)	
	Папуа Шинэ Гвиней (ХОТ-с АСТ)	Филиппин (БСТ-с Параллель)	Өмнөд Африк (ХОТ-с ЖХТТ)	
	Монгол (БСТ-с ХШТ)	Тайланд (БСТ-с Параллель)	Молдав (ХШТ-с ЖХТТ)	
		Украин (ХШТ-с Параллель)		
		ОХУ (ХШТ-с Параллель)		
Холимог		Мексик (Параллелиас ХХТТ)	Македон (Параллелиас ЖХТТ)	
			Хорват (Параллелиас ЖХТТ)	
Хувь тэнцүүлсэн	Мадагаскар (ЖХТТ-с холимог ХОТ ба ЖХТТ)	Болив (ЖХТТ-с ХХТТ)		
		Итали (ЖХТТ-с ХХТТ)		
		Венесуэл (ЖХТТ-с ХХТТ)		
Бусад		Япон (СҮШТ-с Параллель)		

Тайлбар: 1993-2004 оны хооронд тусгаар тогтносон орнууд ба харьяа нутаг дэвсгэрийн хууль тогтоох байгууллагын сонгуулийн тогтолцоонд (хоёр танхимт хууль тогтоох байгууллагатай орнууд ба нутаг дэвсгэрийн хувьд доод танхимын сонгуулийн тогтолцоонд) хийгдсэн шинэчлэл. Киргизстан Улс энэ хугацаанд ХШТ-оо өөрчилж Параллель тогтолцоонд шилжээд, эргээд ХШТ-доо орсон бөгөөд энэ хүснэгтэд оруулаагүй болно.

Бүтэц, зохион байгуулалтын бүрэлдэхүүн хэсэг

62. Нэгэнт сонгуулийн шинэ тогтолцоогоор хүрэх ёстой чухал зорилтууд болон зайлсхийвэл зохих хүчин зүйлсийн талаар зөвшилцөлд хүрсэн бол эдгээр зорилтыг хангахад ашиглаж болох сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтын бүлэг арга хэрэгсэл байдаг. Эдгээрийн дотор сонгуулийн тогтолцооны төрөл зүйл, тойргийн хэмжээ, улс төрийн намууд ба нэр дэвшигчдийн үүрэг, саналын хуудасны хэлбэр, сонгуулийн тойргийн хил тогтоох журам, сонгогчдын бүртгэлийн механизм, сонгуулийн товыг тогтоох, квот болон бусад тусгай заалт багтдаг.

Эдгээр хэрэгслийг янз бүрээр хослуулан ашиглахад гарах үр дүн нь харилцан адилгүй байна. Эдгээрийг хэрхэн ашиглах нь гарын дор ямар мэдээлэл байгаа болон байж болохоос (тухайлбал, хүн амын тоо, ялгарал, байршил зэрэг) басхүү хамаарна. Мөн тэдгээрийн үзүүлэх нөлөө нь парламентын ба ерөнхийлөгчийн засаглалын алийг сонгосон, улс төрийн намуудыг бүртгэх, удирдахад тавигдах шаардлагууд, улс төрийн намууд ба сонгогдсон гишүүдийн хоорондын харилцаа холбоо төдийгүй бүх нийтийн санал асуулга, иргэдийн санаачлага, гишүүнийг эгүүлэн татах механизм зэрэг шууд ардчиллын хэрэгслийн гүйцэтгэх үүрэг гэх мэт институцийн хүрээний бусад хэрэгслээс хамаарах болно. Хоосон орон зайд хүчээр хэрэгжүүлж болох цорын ганц “зөв шийдэл” гэж хэзээ ч байдаггүй гэдгийг энд дахин онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

БҮЛЭГ 2

БҮЛЭГ 2

2. Сонгуулийн ТОГТОЛЦООНЫ ЕРТӨНЦ

63. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТООЛЖ БАРШГҮЙ ОЛОН ХУВИЛБАР БАЙДАГ тухай 9 дүгээр хэсэгт дурдсан. Гэхдээ тэдгээрийг 12 үндсэн тогтолцоонд хувааж, дийлэнхийг нь гурван ерөнхий ангилалд хамаатуулах боломжтой. Сонгуулийн тогтолцоог цэгнэн үзэх хамгийн нийтлэг арга бол үндэсний хэмжээнд авсан саналыг хууль тогтоох байгууллагад авах суудлын тоонд хэрдэхүү хөрвүүлж байгаагаар нь буюу хэрхувь тэнцүүлсэн байгаагаар нь бүлэглэж ангилах явдал юм. Ингэж бүлэглэхийн тулд санал ба суудлын тооны харьцаа, сонгогдоогүй нэр дэвшигчид өгсөн саналын түвшин хоёрыг нь зэрэгцүүлж харах хэрэгтэй. Жишээ дурдвал, Өмнөд Африк 2004 оны сонгуулиа сонгодог хувь тэнцүүлсэн тогтолцоогоор явуулсан бөгөөд нийт сонгогчдын 69,69 хувийн санал авсан Африкийн Үндэсний Конгресс (АҮК) нам Ассамблейн нийт суудлын 69,75 хувийг авсан байна. Энэ сонгуулийн тогтолцоо ихээхэн пропорциональ шинжтэй байсан бөгөөд сонгогдоогүй нэр дэвшигчид өгсөн саналын (өөрөөр хэлбэл, Ассамблейд суудал авч чадаагүй намуудад өгсөн саналын) эзлэх хувь нийт саналын дөнгөж 0,74 хувь байлаа. Үүнээс эрс ялгаатайгаар 2000 онд Монгол Улсад хоёр шатлалт тогтолцоогоор явуулсан сонгуульд нэр дэвшигчид сонгогдохын тулд дөнгөж 25 хувийн харьцангуй олонхийн санал авахыг шаардсанаар нийт сонгогчдын 52 орчим хувийн санал авсан Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) 76 гишүүнтэй Парламентын 72 суудлыг авч ялалт байгуулахад хүргэсэн байна. Энэ үр дүн ч Жибутид 2003 онд Намын багц саналын тогтолцоогоор явуулсан сонгуульд давтагдаж 62,7 хувийн санал авсан *Rassemblement Populaire pour le Progrès* нам хууль тогтоох байгууллагын 65 суудлыг бүгдийг нь авсан юм.

64. Гэхдээ зарим нөхцөл байдалд хувь тэнцүүлсэн бус сонгуулийн тогтолцоо (харьцангуй олонхийн тогтолцоо гэх мэт) ч харьцангуй пропорциональ ерөнхий үр дүнд хүргэх нь бий. Жишээлбэл, намын дэмжлэг нөлөөний хүрээ тодорхой бүс нутагт төвлөрсөн үед ийм үр дүн гарах магадлал өндөр байна. Ийм тохиолдол 2004 онд Өмнөд Африкийн Малави Улсад гарсан юм. Энэ сонгуулиар Малавийн Конгресс Нам нийт сонгогчдын 25 хувийн санал авч нийт суудлын 30 хувь, Нэгдсэн Ардчилсан Фронт 25 хувийн саналтайгаар суудлын 27 хувь, Ардчиллын төлөө Альянс дөрөв хүрэхгүй хувийн саналаар суудлын гурав илүүтэй хувийг авсан байна. Ийнхүү суудлын хуваарилалтыг харахад пропорциональ байдлын ерөнхий түвшин өндөр байсан боловч нийт өгсөн саналын бараг тэн хагас сонгогдоогүй нэр дэвшигчдэд очиж дэмий үрэгдсэн нь энэ тогтолцоо ХТТ биш байсны нэг шинж болж байна.

Сонгуулийн зохион байгуулалтын зарим хүчин зүйлс пропорциональ бус байдлыг нэмэгдүүлдэг. Тэгш бус хуваарилалт ихтэй тогтолцоо пропорциональ бус үр дүн үзүүлдэгтэй нэгэн адилаар өндөр босготой ХТТ ч их хэмжээний санал гээгдэхэд хүргэж болно. Тухайлбал, 2002 онд Турк Улсад 10 хувийн босго тогтоосон нь нийт саналын 46 хувь нь дэмий үрэгдэхэд хүргэсэн юм.

65. Хэрэв бид пропорциональ байдлын зарчмаас гадна нэг тойргоос хэдэн гишүүн сонгогдох, нэг сонгогч хэдэн санал өгөх зэрэг зарим нэг асуудлыг харгалзвал Зураг 1-д үзүүлсэн сонгуулийн тогтолцооны бүтэц харагдана.

Зураг 1. Сонгуулийн тогтолцооны төрөл зүйл



Олонхи/дийлэнхийн тогтолцоо

66. Олонхи/дийлэнхийн (ОД) тогтолцооны ялгарах онцлог бол ихэвчлэн нэг мандаттай тойргоор сонгууль явуулна. Харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ)-гоор (заримдаа нэг мандаттай тойрог бүхий олонхийн тогтолцоо ч гэдэг) сонгууль явуулахад хамгийн их санал авсан нэр дэвшигч ялагч болох ба заавал үнэмлэхүй олонхийн санал авах албагүй байдаг (76-79 дүгээр хэсгийг үзнэ үү). Энэ тогтолцоог олон мандаттай тойрогт хэрэглэх тохиолдолд багц саналын тогтолцоо (БСТ) гэнэ. Сонгогчид тойргийн мандатын тоогоор санал өгөх бөгөөд хэдэн хувийн санал авснаас үл хамааран хамгийн олон санал авсан нэр дэвшигчид дарааллын дагуу ялагчаар тодорно (80-85 дугаар хэсгийг үзнэ үү). Энэ тогтолцоонд сонгогчид нэр дэвшигчдийн төлөө бус намд санал өгөх өөрчлөлт оруулбал намын багц саналын тогтолцоо (НБСТ) болдог (86-88 дугаар хэсгийг үзнэ үү). Альтернатив саналын (АСТ) болон хоёр шатлалт тогтолцоо (ХШТ) зэрэг ОД тогтолцооны хувилбаруудад ялалт байгуулах нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн (өөрөөр хэлбэл, 50-иас дээш хувийн) санал авсан байхыг шаарддаг. Ийм тогтолцоонд санал хураалтын эхний шатанд ялагч тодроогүй тохиолдолд үнэмлэхүй олонхийн санал авсан нэр дэвшигч тодруулах үүднээс сонгогчдын хийсэн хоёр дахь сонголтыг нэмж ашигладаг (89-99 дүгээр хэсгийг үзнэ үү).

Хувь тэнцүүлсэн тогтолцоо

67. Хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХТТ)-ны гол утга учир нь намын авсан нийт саналын хувь, түүний парламентад эзлэх суудлын хувь хоёрын хоорондын зөрүүтэй байдлыг аль болох багасгахад оршино. Энэ зарчмын дагуу хэрвээ томоохон нам сонгогчдын 40 хувийн санал авсан бол парламентын нийт суудлын 40 орчим хувийг авах ёстой бөгөөд жижиг нам сонгогчдын 10 хувийн санал авсан бол мөн төдий хувийн суудал авах ёстой гэсэн үг. Хувь тэнцүүлсэн тогтолцооны хамгийн түгээмэл хувилбар нь намын жагсаалтаар санал хураах хувилбар байдаг. Тодруулбал, улс төрийн намууд үндэсний, эсвэл орон нутгийн хэмжээгээр гаргасан нэр дэвшигчдийн жагсаалтыг сонгогчдод танилцуулан санал хураана (106-108 дугаар хэсгийг үзнэ үү). Энэ хувилбараас гадна сонгогчид нэр дэвшигчдийг дэмжих дарааллаараа эрэмбэлэн санал өгөх бас нэг хувилбар байна. Тухайлбал, сонгогчид олон мандаттай тойрогт нэр дэвшигчдийг эрэмбэлэн санал өгдөг санал шилжүүлэх тогтолцоо нь маш түгээмэл хэрэглэгддэг хувь тэнцүүлсэн тогтолцооны хувилбар юм (109-112 дугаар хэсгийг үзнэ үү).

Холимог тогтолцоо

68. Параллель тогтолцоонд ХТТ-ны элементийг ОД болон бусад тогтолцооны элементтэй тус тусд нь зэрэгцүүлэн хэрэглэнэ. Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ) хоёр өөр тогтолцооны элементийг мөн агуулсан байна. Гэхдээ параллель тогтолцооноос ялгаатай нь ОД болон бусад тогтолцооноос үүссэн пропорциональ бус байдлыг ХХТТ-ны элемент нь нөхөж байдаг. Үүнээс үүдэлтэй параллель тогтолцоог бодвол хамаагүй илүү пропорциональ үр дүн гарахад хүргэдэг. Параллель ба ХХТТ-г Африкийн болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан ардчилалд шинээр шилжсэн орнууд өргөнөөр авч хэрэглэсээр ирсэн байна (128-137 дугаар хэсгийг үзнэ үү).

Бусад тогтолцоо

69. Дээр дурдсан гурван ангиллын алинд ч сайн тохирдоггүй гурван тогтолцоо байдаг. Санал үл шилжүүлэх тогтолцоо (СҮШТ) бол нэр дэвшигчдэд чиглэсэн тогтолцоо бөгөөд олон мандаттай тойрогт сонгогчид нэг нэр дэвшигчид санал өгдөг. Хязгаарлагдмал саналын тогтолцоо (ХЯСТ) нь СҮШТ-той маш төстэй бөгөөд ялгаатай тал нь сонгогч нэгээс дээш нэр дэвшигчид санал өгөх боломжтой (гэхдээ БСТ-оос ялгаатай нь заавал мандатын тоогоор санал өгөх албагүй). Харин Борда тооллого бол нэг, эсвэл олон мандаттай тойрогт сонгогч нэр дэвшигчдийг дэмжих дарааллаараа дугаарлаж санал өгдөг тогтолцоо (138-144 дүгээр хэсгийг үзнэ үү) юм.

70. Хүснэгт 2-г болон энэхүү номд хавсаргасан газрын зургаас үзэхэд, хууль тогтоох байгууллагын шууд сонгууль бүхий дэлхийн 199 улс, нутаг дэвсгэрийн тал орчим нь (91 буюу нийт улсуудын 46 хувь нь) ОД тогтолцоо, 72 буюу 36 хувь нь ХТТ, 30 буюу 15 хувь нь холимог тогтолцоо, дөнгөж зургаа буюу 3 хувь нь өөр бусад тогтолцоог хэрэглэдэг байна. Энэ тоог хүн амын тоонд хувааж ангилж үзвэл ОД тогтолцоо зонхилж байгаа нь бүр тодорхой харагдах бөгөөд ХОТ, БСТ, НБСТ, АСТ, ХШТ-оор сонгогддог хууль тогтоох байгууллага нийлбэр дүнгээр 2,65 тэрбум хүнийг төлөөлж байна (энэ нь хүснэгтэд багтаасан 199 орны нийт хүн амын 54 хувь болж байна). ХТТ ашигладаг улс орнуудад нийт 1,19 тэрбум хүн, холимог тогтолцоотой орнуудад 1,07 тэрбум, бусад тогтолцоо ашигладаг орнуудад дөнгөж 34 сая хүн оршин сууж байна.

Хүснэгт 2. Улс орнууд хууль тогтоох байгууллага сонгон бүрэлдүүлэхэд ашиглаж буй сонгуулийн тогтолцоо

Улс орон/ нутаг дэвсгэрийн тоо	Нийт хүн ам		Ардчилал тогтсон орнууд		Хүн ам		Шинэ ардчилсан орнууд		Хүн ам		Бусад орнууд		Хүн ам			
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11					
ХОТ	47	23,6%	2148870177	43,5%	22	32,4%	1458403073	7,3%	4	13,0%	205865	0,1%	21	21,0%	690261239	27,0%
БСТ	15	7,5%	32105545	0,6%	8	11,8%	1515622	0,1%	0	%	0	0	7	7,0%	30586923	1,2%
НБСТ	4	2,0%	30423015	0,6%	0	0%	0	%	0	%	0	0	4	4,0%	30423015	1,2%
АСТ	3	1,5%	26214298	0,5%	2	2,9%	25333424	%	0	%	0	0	1	1,0%	880874	0,0%
ХШТ	22	11,1%	409376918	8,3%	3	4,4%	60534006	%	2	%	14708102	4,8%	17	17,0%	334134810	13,1%
ЖХТТ	70	35,2%	1181718922	23,9%	21	30,9%	195051175	%	19	%	168528219	55,0%	30	30,0%	818139528	32,0%
СШТ	2	1,0%	4366409	0,1%	2	2,9%	4366409	%	0	%	0	0	0	0,0%	0	0%
ХХТТ	9	4,5%	298619263	6,0%	4	5,9%	153200059	%	1	%	10032275	3,3%	4	4,0%	135386829	5,3%
Параллель	21	10,6%	773091334	15,7%	2	2,9%	175931177	%	5	%	112701569	36,8%	15	14,0%	484458588	18,9%
СҮШТ	4	2,0%	34327534	0,7%	2	2,9%	202655	%	0	%	0	0	2	2,0%	34124879	1,3%
Сайжруулсан БТ	1	0,5%	12809	0,0%	1	1,5%	12809	%	0	%	0	0	0	0,0%	0	0%
ХЯСТ	1	0,5%	27883	0,0%	1	1,5%	27833	%	0	%	0	0	0	0,0%	0	0%
Нийт	199		4939151057		68		2074578242		31		306176130		100		2558396685	

Тайлбар: 2004 оны 11 дүгээр сарын байдлаар. Зөвхөн үндэсний хууль тогтоох байгууллага ба доод танхимын сонгуулийг оруулав. Аренд Лийпхартын *Ардчиллын хэв загвар: Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл* (1999) бүтээлдээ ашигласан аргачлалд тулгуурлав. “Ардчилал тогтсон орнууд” гэдэгт Фрийдом Хаусын олон улсын зэрэглэлээр (2004), (<http://www.freedomhouse.org/ratings/index.htm> хаягаар танилцана уу.) одоогоор болон дор хаяж сүүлийн 20 жилд ардчилсанд тооцогдож байгаа орнуудыг; “шинэ ардчилсан орнууд” гэдэгт одоогоор болон дор хаяж сүүлийн 10 жилд ардчилсанд тооцогдож байгаа орнуудыг; “бусад орнууд” гэдэгт сүүлийн 10 жилийн турш ардчилсанд тооцогдож байгаагүй орнуудыг оруулав. Фрийдом Хаусаас гаргасан олон улсын зэрэглэлд ороогүй улс орон, нутаг дэвсгэрийн хувьд (250,000-аас доош хүн амтай орнууд) бид бусад эх сурвалжид тулгуурлан ангилсан болно. Шүүд сонгууль байхгүй, эсвэл шилжилтийн засгийн газартай 14 улсыг энд хүснэгтэд оруулаагүй юм. Хоёр сонгуулийн тогтолцоо нэг зэрэг (эрлийз тогтолцоо) ашиглаж байгаа орнуудын хувьд хууль тогтоох байгууллагад хамгийн олон суудал хуваарилж байгаа тогтолцоогоор нь ангилсан болно.

- 1 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой орнуудын нийт 199 оронд эзлэх хувь
- 2 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой оронд оршин суудаг хүн амын нийт 199 орны хүн амд эзлэх хувь
- 3 = Улс орон, нутаг дэвсгэрийн тоо
- 4 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой ардчилал тогтсон орнуудын эзлэх хувь
- 5 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой ардчилал тогтсон орнуудад амьдарч буй хүн амын эзлэх хувь
- 6 = Улс орон, нутаг дэвсгэрийн тоо
- 7 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой шинэ ардчилсан орнуудын эзлэх хувь
- 8 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой шинэ ардчилсан орнуудад амьдарч буй хүн амын эзлэх хувь
- 9 = Улс орон, нутаг дэвсгэрийн тоо
- 10 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой “бусад” орнуудын эзлэх хувь
- 11 = Энэ төрлийн сонгуулийн тогтолцоотой “бусад” орнуудад амьдарч буй хүн амын эзлэх хувь.

Эх сурвалж: АСТОУХ-ийн мэдээллийн сан; ардчилсан орнуудын ангиллыг Фрийдом хаусын олон улсын зэрэглэлээс <<http://www.freedomhouse.org/ratings/index.htm>>; хүн амын тоог АНУ-ын Тагнуулын төв газрын Дэлхийн тоо баримтууд (*World Factbook*) номоос, энэ номд ороогүй улс орон, нутаг дэвсгэрийн хувьд нэмэлт тооцооноос авав.

71. ЖХТТ хамгийн түгээмэл буюу 199 улс, харъяа нутаг дэвсгэрийн 70 нь хэрэглэж байгаа нь нийт дүнгийн 35 хувь болж байна. Үүний дараа ХОТ-г 47 улс хэрэглэж байгаа нь нийт 199 улсын 24 хувь болж байна. Харин хүн амын тоотой нь харьцуулан авч үзвэл ХОТ-г хэрэглэдэг улс орны хүн ам ЖХТТ бүхий орнуудынхаас бараг хоёр дахин их байна. Хүснэгт 2-оос харахад ХОТ-г 2,1 тэрбум хүн хэрэглэж байгаа нь хүн ам ихтэй Энэтхэг (1.1 тэрбум), АНУ-д (293 сая) энэ тогтолцоогоор сонгууль явуулдагтай холбоотой. Гэхдээ ХОТ-г Карибийн тэнгисийн болон Далайн орнуудын олон жижиг арлууд бас хэрэглэж байна. ЖХТТ-г хэрэглэдэг хамгийн том улс бол 238 сая хүнтэй Индонези Улс ба Баруун Европ, Латин Америк, Африкийн дунд зэргийн хэмжээтэй орнууд мөн зонхилон хэрэглэдэг байна. Үүний дараагаар хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй тогтолцоонд параллель (дэлхийн хүн амын 16 хувь) болон хоёр шатлалт (дэлхийн хүн амын найман хувь) тогтолцоо орж байна. ХШТ-г илүү олон орон хэрэглэдэг боловч хүн амын тооны хувьд аваад үзвэл параллель тогтолцоо нь илүү байна. Энэ нь Оросын Холбооны Улс (144 сая хүн амтай), Япон Улс (127 сая хүн амтай) хоёр сонгодог параллель тогтолцоо хэрэглэдэгтэй холбоотой.


Хүснэгт 3. Үндэсний хууль тогтоох байгууллагыг сонгож буй сонгуулийн тогтолцооны хувилбарын хэрэглээг газар нутгаар үзүүлсэн нь

	Африк	Хойд ба Өмнөд Америк	Ази тив	Зүүн Европ	Баруун Европ	Далайн орнууд	Ойрхи Дорнод	Нийт
ХОТ	15	17	5	0	1	7	2	47
БСТ	1	3	2	0	3	2	4	15
НБСТ	3	0	1	0	0	0	0	4
АСТ	0	0	0	0	0	30	0	3
ХШТ	8	3	6	1	1	1	2	22
ЖХТТ	16	19	3	13	15	0	4	70
СШТ	0	0	0	0	2	0	0	2
ХХТТ	1	3	0	2	2	1	0	9
Параллель	4	0	8	7	1	1	0	21
СҮШТ	0	0	1	0	0	2	1	4
БТ	0	0	0	0	0	1	0	1
ХЯСТ	0	0	0	0	1	0	0	1
Дүн	48	45	26	23	26	18	13	199


Тайлбар: Зөвхөн үндэсний хууль тогтоох байгууллагыг сонгох сонгуулийг 2004 оны байдлаар оруулав. Хоёр танхимт хууль тогтоох байгууллагын хувьд доод танхимын сонгуулийг тооцов.

Зураг 2. Сонгуулийн тогтолцооны төрөл зүйл: Улс орнуудын тоо


1- Улс орон, нутаг дэвсгэрийн тоо



2- Сонгуулийн тогтолцоо: Улс орон, нутаг дэвсгэрийн тоо



3- Нийт хүн ам (саяар)



72. Багц саналын тогтолцоог 15 улс, нутаг дэвсгэрт хэрэглэж байгаа нь нийт улс орны найман хувь боловч эдгээр орны 32 сая хүн ам нь Хүснэгт 2-т орсон 199 орны нийт хүн амын дөнгөж 0,7 хувийг төлөөлж байна. Нөгөө талаар холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог зөвхөн Албани, Болив, Герман, Унгар, Итали, Лесото, Мексик, Шинэ Зеланд, Венесуэл зэрэг есөн улсад хэрэглэдэг боловч эдгээр улсын 299 сая хүн ам нийлээд дэлхийн нийт хүн амын зургаан хувийг эзэлж байна. Өнөөдөр хэрэглэж буй хамгийн ховор тогтолцооны тоонд СШТ, ХЯСТ, сайжруулсан Борда тооллого (БТ), АСТ, НБСТ, СҮШТ орох бөгөөд тус бүр нь нэгээс дөрөв хүртэл тооны улсад хэрэглэгдэж байна. АСТ-г зөвхөн Австрали, Фижи, Папуа Шинэ Гвиней Улсад хэрэглэж байгаа ба нийлбэр дүнгээр ийм тогтолцоотой орнуудад 26 сая хүн амьдарч байна. Мөн СҮШТ хэрэглэж буй Афганистан, Иордан, Питкэйрний арлууд, Вануату 34 сая, СШТ хэрэглэж буй Ирланд, Мальт улсууд нийлбэр дүнгээрээ дөрвөн сая хүн амтай байна.

73. Ардчилал тогтсон орнуудын сонгуулийн тогтолцоог авч үзэхэд хувь тэнцүүлсэн тогтолцоог хамгийн олон орон буюу нийт 68 орны 21 нь (31 хувь) хэрэглэж байна. Гэхдээ эдгээр 68 оронд амьдарч буй нийт хүн амд Энэтхэг, АНУ-ын хүн амын тоог харгалзвал 70 хувь нь харьцангуй олонхийн тогтолцоотой оронд амьдарч байна гэсэн үг. Ардчилал тогтсон орнуудын дотор ХХТТ-той орон харьцангуй цөөхөн буюу нийт орнуудын зургаан хувь байдаг бөгөөд дэлхийн хэмжээнд ХХТТ хэрэглэдэг орон дөнгөж 4,5 хувьтай байна. СШТ-ны жишээ болсон БН Ирланд Улс, Мальт улсууд хоёулаа ардчилал тогтсон орнуудын ангилалд ордог.

74. Тивүүдийг харьцуулж харахад сонгуулийн тогтолцооны тархалт илүү холимог байдалтай харагдаж байна. Хүснэгт 3 болон энд хавсаргасан газрын зургаас үзэхэд, Африк, Америктив, Далайн орнуудын ойролцоогоор 35 хувьд нь харьцангуй олонхийн тогтолцоо хэрэглэж байна. Харин энэ тогтолцоо Европ, Ази, Ойрхи Дорнодод тийм ч түгээмэл биш байх аж. ЖХТТ ч Африк, Америктивээр үүний нэг адил тархжээ. Гэхдээ, ЖХТТ Зүүн ба Баруун Европт илүү зонхилдог бөгөөд ХТТ-ны хоёр хувилбар (ЖХТТ ба СШТ) нийлээд Европ дахь нийт сонгуулийн тогтолцооны гуравны хоёр орчим хувийг эзэлдэг байна. Параллель тогтолцоог гол төлөв Ази болон Зүүн Европын орнуудад ашигладаг.

БҮЛЭГ 3

БҮЛЭГ 3

3. Сонгуулийн тогтолцоо, түүний үр дагавар

Олонхи/дийлэнхийн тогтолцоо

Олонхи/дийлэнхийн тогтолцоо гэж юу вэ?

75. Олонхи/дийлэнхийн (ОД) тогтолцоо энгийн зарчимтай. Санал хураалт явуулж дүнг гаргасны дараа хамгийн олон санал авсан нэр дэвшигч буюу намыг ялагчаар зарладаг (нэмэлт нөхцөлүүд байж болно). Гэхдээ үүнийг практикт хэрэгжүүлэх арга зам олон янз байна. ОД тогтолцооны таван янзын хувилбарыг нэрлэж болно. Үүнд, харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ), багц саналын тогтолцоо (БСТ), намын багц саналын тогтолцоо (НБСТ), альтернатив саналын тогтолцоо (АСТ), хоёр шатлалт тогтолцоо (ХШТ) зэргийг дурдаж болно.

Харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ)

76. Харьцангуй олонхийн тогтолцоо бол ОД тогтолцооны хамгийн энгийн хэлбэр бөгөөд сонгогч нэг мандаттай тойрогт өрсөлдөж буй нэр дэвшигчдээс зөвхөн нэг хүнд санал өгөх дүрэмтэй. Улмаар хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялалт байгуулах бөгөөд онолын хувьд бусад бүх нэр дэвшигч ганц, ганц санал авсан тохиолдолд хоёрхон санал авсан нэр дэвшигч сонгогдох боломжтой гэсэн үг.

Харьцангуй олонхийн тогтолцоо бол ОД тогтолцооны хамгийн энгийн хэлбэр юм. Өрсөлдөгчдөөсөө илүү санал авсан нэр дэвшигч хэдийгээр нийт хүчинтэй саналын үнэмлэхүй олонхийг авч чадаагүй ч гэсэн ялалт байгуулдаг. Нэг мандаттай сонгуулийн тойрогт санал хураах ажлыг зохион байгуулах бөгөөд сонгогчид намаас илүүтэй нэр дэвшигчийг харж санал өгдөг байна.

77. Өнөөгийн байдлаар цэвэр ХОТ-г гол төлөв Их Британи болон түүний нөлөөнд байсан орнууд хэрэглэж байна. Их Британиас гадна

Канад, Энэтхэг, АНУ-ын ХОТ хамгийн их судлагдсанд тооцогддог. Мөн ХОТ-г Карибийн тэнгисийн хэд хэдэн орон, Латин Америкаас Белиз Улс, Ази тивээс Бангладеш, Бирм, Энэтхэг, Малайз, Балба зэрэг таван улс төдийгүй Номхон далайн өмнөд хэсгийн жижиг арлын олон орон хэрэглэдэг ажээ. Африк тивийн 15 орноос ихэнхдээ Британийн колони байсан орнууд энэ тогтолцоогоор сонгуулиа зохион байгуулж байна.

Нийтдээ Хавсралт А-д жагсаасан 213 орны (шилжилтийн орнууд ба шууд сонгууль явуулдаггүй орнуудыг оруулаад) 22 хувь нь ХОТ-г ашигладаг байна.

78. *Давуу талууд*: ХОТ нь бусад ОД тогтолцооны хувилбаруудын нэг адил үндсэндээ энгийн хялбар байх зарчимд тулгуурласан, газар зүйн төлөөлөл буюу сонгогдсон газрынхаа иргэдэд эргээд үйлчлэх өртэй ялагч төрүүлэх хандлагатай байдаг. Энэ тогтолцооны олонтаа дурдагддаг давуу талууд нь:

а. Хоёр томоохон намын хооронд тодорхой сонголт хийх боломжийг сонгогчдод олгодог. ХОТ угаасаа гуравдагч ба цөөнхийн жижиг намуудад ашиггүй бөгөөд олон тохиолдолд эрх мэдэл нэг бол “зүүний”, эсвэл “барууны” намд төвлөрөн, тэд ээлжлэн эрх барихад хүргэдэг. Ингэснээр гуравдагч намууд сулран ганхах нь олонтаа тохиолдох бөгөөд тэдний үндэсний хэмжээний сонгуульд авсан санал, олон нийтийн дэмжлэг нь хууль тогтоох байгууллагад түүнтэйгээ адилтгах тооны суудалтай болох боломжийг бараг олгодоггүй.

б. Нэг нам дангаар засгийн газар байгуулах боломж олгодог. ХОТ нь том намуудад “бонус суудал” олгодог (тухайлбал, үндэсний хэмжээнд нийт саналын 45 хувийг авсан нам нийт суудлын 55 хувийг авах тохиолдол байдаг) учраас зөвхөн онцгой тохиолдолд л эвслийн засгийн газар байгуулагдах боломжтой гэсэн үг. Үүнтэй холбоотой эвсэл байгуулахын тулд цөөнхийн жижиг хамтрагчтай тохиролцох шаардлагагүйгээр нэг нам дангаараа танхим бүрдүүлэн ажиллах боломж олгодог гэдэг үүднээс энэ тогтолцоог сайшаах нь бий.

в. Хууль тогтоох байгууллагад тууштай сөрөг хүчин төрөн гарах боломж олгодог. Онолын хувьд нэг намын хүчтэй засгийн газар бүрдэхийн хажуугаар хүчтэй сөрөг хүчин гарч ирэх учиртай. Энэхүү сөрөг хүчин нь засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандан хяналт тавьж чадахуйц хэмжээнд хангалттай суудалтай, мөн засгийн газраас ялгарахуйц бодлогын хөтөлбөр, байр суурьтай байна.

г. Энэ тогтолцоо өргөн хүрээтэй бааз суурь бүхий улс төрийн намуудад давуу тал олгодог. ХОТ нь үндэс угсаа, эсвэл бүс нутгийн хувьд ихээхэн хуваагдмал нийгэмд буй улс төрийн намууд “өргөн олныг хамарсан нигүүлсэнгүй байгууллага” болон хувирч нийгмийн олон янзын элементийг эгнээндээ багтаах нөхцөлийг бүрдүүлдэг. Ялангуяа хоёрхон том намтай, олон жижиг нийгмийн бүлэгтэй тохиолдолд бүр ч ач холбогдолтой. Намууд нийгмийн гишүүдийн янз бүрийн төлөөллийг сонгуульд нэр дэвшүүлэх боломжтой болдог. Тухайлбал, Малайз Улсын Барисан Насионал нам үндэстэн угсаатны хувьд ялгаатай тойргуудад Малайз, Хятад, Энэтхэг гаралтай тохирох нэр дэвшигчдийг өрсөлдүүлдэг жишээ байна.

д. Энэ тогтолцоо хэт туйлширсан үзэлтэй намуудыг хууль тогтоох байгууллагад оруулдаггүй. Аливаа хэт туйлшрагч үзэлтэй жижиг намыг дэмжигчид газар зүйн хувьд нэг газар төвлөрчихөөгүй л бол ХОТ-оор явуулсан сонгуулиар суудал авах боломжгүй (харин улс нь нэг тойрог болж жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоонд нийт саналын нэг хувьтай тэнцэх өчүүхэн дэмжлэг авахад л хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болж болдог).

е. Хууль тогтоох байгууллага нь газар зүйн хувьд тодорхой нутаг дэвсгэр, бүс нутгыг төлөөлсөн төлөөлөгчдөөс бүрддэг учраас ХОТ нь сонгогч, сонгогдсон төлөөлөгчдийн хооронд шууд холбоо үүсгэдэг сайн талтай. Сонгогдсон гишүүд зөвхөн намаар овоглоод зогсохгүй тодорхой хот, суурин газрууд эсвэл бүс нутгийн нэрийг зүүж, тэндэхийн иргэдийг төлөөлж байдаг. Энэ нь ялангуяа хөдөө аж ахуй эрхэлдэг нийгэмд болон хөгжиж байгаа орнуудад чухал ач холбогдолтой гэж зарим шинжээч үздэг байна.

ё. Энэ тогтолцоо нь хүмүүст намууд гэхээсээ илүү нэр дэвшигчдийн хооронд сонголт хийх боломж олгодог. Сонгогчид жагсаалтаар санал хураадаг ХТТ шиг аль нэг намын санал болгосон нэр дэвшигчдийн жагсаалтыг хүлээн зөвшөөрөх биш, нэр дэвшигч бүрийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх боломжтой.

ж. Мөн олны танил бие даасан нэр дэвшигчдэд сонгогдох боломж олгодог. Намын систем нь шинээр бүрэлдэн хөгжиж буй бөгөөд хүчтэй нам, улс төрийн байгууллагаас илүүтэй гэр бүлийн холбоо, бүлэглэл, ураг төрлийн холбоо тойрсон улс төр явагддаг газар энэ онцлог чухал байж болно.

з. Эцэст нь ХОТ нь хэрэглэх, ойлгоход хялбар дөхөм гэдгээрээ онцгой талархал хүлээдэг. Санал хүчинтэй байхын тулд зөвхөн нэг нэр

дэвшигчийн нэр, эсвэл түүний нэрийг төлөөлөх тодорхой тэмдгийн (бичиг үсэггүй сонгогчдод зориулсан) өмнө тэмдэглэгээ хийх шаардлагатай. Саналын хуудсанд бичигдэх нэр дэвшигчдийн тоо хэчнээн олон байсан ч сонгуулийн ажилтнуудын хувьд саналыг тоолоход хялбар байна.

79. *Сул талууд*: Гэхдээ ХОТ хэд хэдэн үндэслэлээр шүүмжлэлд өртдөг. Үүнд:

а. Жижиг намуудад “тэгш шударга” төлөөлөлтэй байх боломжолгодоггүй. Ойролцоогоор нийт саналын 10 орчим хувийг авсан нам хууль тогтоох байгууллагын суудлын 10 орчим хувийг авах ёстой гэдэг утгаар жижиг намын хувьд шударгаар мандатын хуваарилалтад оролцох боломж хомс байна. 1993 оны Канадын холбооны сонгуулиар тус улсын Дэвшилтэт Консервативууд нийт хүчинтэй саналын 16 хувийг авсан боловч парламент дахь бүх суудлын дөнгөж 0,7 хувийг, 1998 оны Лесотогийн бүх нийтийн сонгуулиар Үндэсний Басото Нам нийт саналын 24 хувийг авсан боловч нийт суудлын дөнгөж нэг хувийг авсан байдаг. Энэ бол ХОТ-нд үе үе давтагддаг хэв шинж юм.

б. Уг тогтолцоонд цөөнх адил тэгш төлөөлөлтэй байх боломж хомс. ХОТ-нд намууд сонгогчдын дэмжлэгийг алдахаас сэргийлж тойрогт хамгийн танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн нэр дэвшигчийг өрсөлдүүлдэг. Тухайлбал, Их Британи, АНУ-д цагаан арьстан сонгогч олонтой тойрогт хар арьстны нэрийг дэвшүүлэх нь ховор. Ер нь дэлхийд хаана ч ХОТ-оор явуулсан сонгуульд үндэстний болон бусад цөөнх хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болох магадлал туйлын бага байдаг нь тоо баримтаар нотлогддог. Үүний улмаас хэрвээ сонгогчдын санал өгөх байдал нь үндэс угсааны ялгарлыг дагах хандлагатай нөхцөлд цөөнх төлөөлөлгүй үлдэх нь улс төрийн тогтолцоог бүхэлд нь тогтворгүйжүүлэхэд нөлөөлдөг сөрөг талтай.

в. Энэ тогтолцоонд эмэгтэйчүүд сонгогдох боломж бага байна. Мөн л “олонд танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн нэр дэвшигч” гэсэн дүрэм үйлчилж эрчүүд давамгайлдаг намын институцээс эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх нь бага байдагтай холбоотой тэдний хууль тогтоох байгууллагад сонгогдох боломж багасдаг. Олон улсын туршлагаас үзэхэд харьцангуй олонхийн тогтолцоонд эмэгтэйчүүдийн сонгогдох магадлал нь ХТТ-той харьцуулахад бага байдаг нь нотлогдож байна. Тухайлбал, Парламент хоорондын холбооноос парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан хууль тогтоох байгууллагын доод танхимын төлөөлөгчдийн дунджаар 15,6 хувь нь эмэгтэйчүүд (2004 оны зургадугаар сарын байдлаар) байсан байна. Ардчилал тогтсон орнуудын

үзүүлэлтийг 2004 оны байдлаар харьцуулахад, ХОТ бүхий орнуудын хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдийн 14,4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байхад, ХТТ-ны аль нэг хувилбарыг ашигладаг орнуудын хувьд энэ тоо бараг хоёр дахин их буюу 27,6 хувь байжээ. Энэ хэв шинж шинээр ардчилал тогтоосон орнууд, тэр дунд Африкийн орнуудад түгээмэл давтагдсан байна.


5-MUMBAI SOUTH CENTRAL H. P./96—Genl.

Electoral Roll Part No.

Serial No. of Elector

Nº 0811199

Signature /
Thumb Impression.

<p>अजिजभाई Azizbhai عبد یزید</p> 	<p>नायक गोविंदा सुत्राय Naique Govinda Subrai نايک گوویندا سوبرائے</p> 
<p>Nº 0811199 5-MUMBAI SOUTH CENTRAL H. P./96-Genl.</p> <p>अन्सारी महम्मदसईम जरीवाला Ansari Mohammad Shamim Zariwala انصاری محمد شمیم زری والا</p> 	<p>महेंद्र सदाशिव साळवे Mahendra Sadashiv Salve مہیندر سداشिव साळवे</p> 
<p>चन्द्र किशोर गुप्ता Chandra Kishor Gupta چندر کیشور گپتا</p> 	<p>मोहन विष्णु रावळे Mohan Vishnu Rawale موہن ویشنو راولے</p> 
<p>डॉ. जमखानवाला इस्हाक अबेदीन Dr. Jamkhanwala Ishaq Abedin ڈاکٹر جمن خان والا ایشاق ابیدین</p> 	<p>रणजीत भौमीक Ranjit Bhowmick رنجیت بھومک</p> 
<p>तेंदुलकर भुषण सुरेश Tendulkar Bhushan Suresh تینڈولکر بھوشن سورش</p> 	<p>डॉ. शापूरजी सी. सुरती Dr. Shapoorjee C. Surty ڈاکٹر شاپور جی سی سورتی</p> 
<p>डॉ. दत्ता सामं Dr. Datta Samant ڈاکٹر دत्ता سامنت</p> 	<p>साहिवाला जोयब अब्बास Sahiwala Zueb Abbas سہی والا زویب عباس</p> 

Харьцангуй олонхийн тогтолцоотой Энэтхэг Улсын саналын хуудас

ЭНЭТХЭГ: Харьцангуй олонхийн ТОГТОЛЦООНЫ СОНГОДОГ ЖИШЭЭ

Вижэй Патидар

Энэтхэг Улс өнөөг хүртэл дэлхийн ардчилсан хамгийн том улс хэвээр байгаа бөгөөд 2004 оны парламентын сонгуульд 670 сая сонгогч оролцсон байна. Тусулсын парламентын засаглал, харьцангуй олонхийн сонгуулийн тогтолцоо нь 1947 онд дуусгавар болсон Британийн колончлолын үеэс өвлөгдөн үлджээ. Британичууд Энэтхэгт өөртөө засах эрхийг үе шаттайгаар олгосон бөгөөд колонийн дэглэм төгсөж, 1949 оны 11 дүгээр сард Энэтхэгийн анхны парламент Үндсэн хуулиа батлан гаргах хүртэл бүх нийтийн сонгуулийн эрхийн асуудал сураггүй байв. Нэртэй шүүгч, хуульч, үндсэн хуулийн мэргэжилтэн, улс төрийн зүтгэлтнээс бүрдсэн тусгаар тогтносон Энэтхэгийн анхны Парламент бараг гурван жилийн турш ажиллан тус улсад ямар сонгуулийн тогтолцоо хамгийн сайн тохирох талаар удтал маргаж мэтгэлцсэний эцэст харьцангуй олонхийн тогтолцоог хэвээр үлдээхээр шийдсэн байна. Энэтхэг Улс маш олон тооны үндэстэн ястны өлгий нутаг учир хувь тэнцүүлсэн тогтолцооны янз бүрийн хувилбарыг хэрэглэх боломжийг басхүү судлан хэлэлцэж, энэ нь олон хүний дэмжлэгийг хүлээж байсан авч эцэстээ харьцангуй олонхийн тогтолцоог авч хэрэглэх болсон нь хэд хэдэн шалтгаантай. Үүнд, юуны өмнө хууль тогтоох байгууллага хэтэрхий талцан хуваагдахаас зайлсхийх, тогтвортой засгийн газар бүрэлдэх нөхцөлийг хангах нь чухал зорилт болоод байв. Колончлолын дараахан эхэлсэн угсаатан хоорондын цуст мөргөлдөөн дөнгөж намдаад байсан, тэрчлэн бүх нийтийг хамарсан ядуурал, бичиг үсэг үл мэдэх байдал газар авсан зэрэг асуудлаас үүдэлтэй улс орондоо тогтвортой байдлыг хангах нь шийдвэр гаргахад юу юунаас илүү чухал хүчин зүйл болж байжээ.

Энэтхэгийн Үндсэн хуулиар Лок Сабха буюу парламентын доод танхимын 543 гишүүнийг нэг мандаттай тойргоос сонгогчдын олонхийн саналаар сонгодог. Парламентын дээд танхим болох Ражя Сабха буюу Мужуудын зөвлөл, түүнчлэн зарим мужийн хууль тогтоох байгууллагын дээд танхимыг, мужийн ассемблейгаас шууд бусаар сонгоно. Түүнчлэн дарга, дэд даргыг дээрх субьектүүд шууд бусаар сонгодог.

Парламентын сонгууль таван жилд нэг удаа явагдах боловч ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө тарааж болох хуультай (саяхан 2004 онд ийм явдал тохиолдсон). Эсвэл тогтвортой засгийн газар бүрдүүлж чадаагүй тохиолдолд Лок Сабхаг хугацаанаас нь өмнө тараадаг. (1991 онд ийм шалтгаанаар тараасан). Ерөнхий сайд Лок Сабхагийн гишүүдийн олонхийн дэмжлэгийг хүлээж чадахгүй бол огцорно. 1977 оныг хүртэл засгийн эрхийг тасралтгүй барьсан Конгресс Намын байгуулсан удаа дараагийн засгийн газар нь бараг таван жилийн турш буюу Үндсэн хуульд заасан дээрх хугацааг дуустал тогтвортой засгийн эрх барьж байв. 1977-1997 оны үеийн засгийн газрууд арай тогтвор муутай болж эхэлсэн бөгөөд намууд задарсан, засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө итгэл үл үзүүлэх санал хураалт явуулснаас болж нэлээд хэдэн ерөнхий сайд огцорчээ. 1997 оноос намууд эвсэх болсноор засгийн газрын үйл ажиллагаа дахин тогтворжиж эхэлсэн гэж болно. Улс төрд өрнөсөн энэ бүх үйл явц бүгд харьцангуй олонхийн тогтолцооноос үүдэн гарсан юм.

1977 он хүртэлх хугацаанд энэ сонгуулийн тогтолцооны үзүүлсэн гол үр нөлөө бол сонгогчдын үлэмжхэн хэсгийн саналаар сонгогдсон олонхи засгийн газар байгуулах боломжтой байсаар ирсэн явдал юм. Харьцангуй олонхийн тогтолцоо нь анхандаа эрх баригч Конгресс Нам ихэвчлэн тархай бутархай сөрөг хүчинтэй өрсөлдөж Лок Сабхагийн олонхийн суудлыг байнга тогтвортой авах нөхцөл бүрдүүлж байв. Энэхүү тархай бутархай байдал нь зарим газарт бүс нутгийн болон мужийн хэмжээний намууд төрөн гарсантай холбоотой байлаа. Сөрөг хүчний намууд хүчээ нэгтгэн эвсэл байгуулж, Конгресс намын нэр дэвшигчидтэй өрсөлдөх хүмүүсийг дундаасаа нэр дэвшүүлж эхэлснээр (1977, 1989 оны бүх нийтийн сонгуульд) Конгресс нам олонхийн байр сууриа алдсан юм. Цаашилбал, энэ тогтолцооны нөлөөнд саналын хувь хэмжээнд гарсан өчүүхэн өөрчлөлт парламентад авах суудлын тоонд огцом нөлөө үзүүлэх нь олонтаа байв. Үүнийг удаа дараагийн сонгуулиудад Конгресс намын авсан санал ба суудлын тоог харьцуулсан дараах хүснэгтээс харж болно.

Энэтхэгийн бүх нийтийн сонгуульд Конгресс намын үзүүлсэн амжилт: харьцангуй олонхийн тогтолцоо нь санал өгөх чиг хандлага бага зэрэг өөрчлөгдөхөд суудлын тоонд огцом өөрчлөлт гарахад нөлөөлдөг

Бүх нийтийн сонгуулийн жил	Конгресс Намын авсан саналын эзлэх хувь	Конгресс Намын авсан саналд гарсан өөрчлөлтийн хувь	Конгресс намын авсан суудлын тоо	Парламентад авсан суудлын өөрчлөлтийн хувь
1971 (ялсан)	43,7%	-	352 (64,8%)	-
1977 (ялагдсан)	34,5%	-21,0%	154 (28,4%)	-56,2%
1980 (ялсан)	42,7%	-	353 (65,0%)	-
1984 (ялсан)	48,1%	-	405 (74,6%)	-
1989 (ялагдсан)	39,5%	-17,8%	197 (36,3%)	-51,4%
1991 (ялсан)	36,5%	-	232 (42,7%)	-
1996 (ялагдсан)	28,8%	-21,1%	140 (25,8%)	-39,7%
1998 (ялагдсан)	25,8%	-10,3%	141 (26,0%)	+0,7%
1999 (ялагдсан)	28,3%	+9,6%	114 (21,0%)	-19,1%
2004 (ялсан)	26,7%	-5,7%	145 (26,7%)	+27,2%

Үүнтэй адил Энэтхэг Улсад харьцангуй олонхийн тогтолцоогоор явуулсан сонгуульд сонгогчдоос авсан саналын эзлэх хувь ба парламентад авсан суудлын эзлэх хувь хоёр тэнцвэргүй байсан жишээг тус улсад 2004 он хүртэл эвслийн засгийн газар удирдаж байсан өөр нэг томоохон нам болох Бхаратия Жаната Нам (БЖН)-ын сонгуулийн үр дүнг харуулсан дараах хүснэгтээс үзэж болно.

Энэтхэгийн бүх нийтийн сонгуульд БЖН-ын үзүүлсэн амжилт

Сонгууль явуулсан жил	БЖН-ын авсан саналын хувь	БЖН-ын парламентад авсан суудлын тоо
1984	7,7%	2 (0,4%)
1989	11,5%	86 (15,8%)
1991	20,0%	121 (22,3%)
1996	20,3%	161 (29,7%)
1998	25,6%	182 (33,5%)
1999	23,6%	182 (33,5%)
2004	22,2%	138 (25,4%)

Дээрх жишээнээс үзэхэд Лок Сабхагийн сонгуулийн үр дүн бүхэлдээ хувь тэнцвэртэй байдалд хэзээ ч ойр байсангүй. Тэрчлэн нэг анги давхарга, шашин, эсвэл бүс нутгийн нэр дэвшигчдийг өөр хооронд нь өрсөлдүүлэх байдлаар санал хуваах явдал олонтаа гарч байв. Өөрөөр хэлбэл, сөрөг хүчнээс олон нэр дэвшигч өрсөлдүүлэх тусам эрх баригч намын хувьд нийт саналын үнэмлэхүй олонхиос хамаагүй бага санал авсан нэр дэвшигч нь ялагчаар тодрох боломжтой байж иржээ.

Гэхдээ олон үндэстэн угсаатнаас бүрдсэн Энэтхэгийн нийгмийн хуваагдмал байдлаас үл хамааран энэ сонгуулийн тогтолцоо ихээхэн дэмжлэг хүлээсээр ирсэн нэг шалтгаан нь нийгмийн доторх эрх дарх муутай, сул дорой бүлэг парламентад төлөөлөлтэй байх боломжийг хангадаг практиктай холбоотой. Энэтхэгт нийгмийн эдгээр бүлэг энд тэнд сийрэг тархан суурьшсан байдаг бөгөөд харьцангуй олонхийн тогтолцоог сонгодог хэлбэрээр ашиглах нь тэдний хувьд парламентад төлөөлөлтэй байх боломжийг багасгахурдагавартай байв. Үүнээсүүдэлтэй Үндсэн хуулиар дээрх бүлгүүдэд зориулж хүн амд эзлэх тоотой нь хувь тэнцүүлсэн хэмжээний сонгуулийн тойрог байгуулах, эдгээр тойрогт хэдийгээр бүх сонгогч санал өгөх эрхтэй боловч нэр дэвшигч нь зөвхөн тухайн анги давхарга буюу овог аймгийн хүн байхаар зааж хуульчилсан байдаг. Ийм байдлаар хүн амын 15 хувийг эзлэх доод кастынханд зориулж парламентын 79 суудал, мөн хүн амын 8 хувийг эзлэх овог аймгуудад 41 суудал хуваарилдаг байна. Энэ нь тэдний парламент дахь төлөөлөл хүн амд эзлэх тооных нь хувь хэмжээнд нийцсэн байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Тус улсын үндэсний болон мужийн түвшний хууль тогтоох байгууллагын суудлын 3 хувийг эмэгтэй төлөөлөгчдөд хуваарилах Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар удтал маргасан боловч өнөөг хүртэл амжилт олоогүй байна. Гэхдээ 1993 оноос эхлэн засаг захиргааны гурав дахь түвшин болох Панчаят (дүүрэг)-ад нийт суудлын 33 хувийг эмэгтэйчүүдэд хуваарилах болжээ.

1977 оноос сонгуулийн тогтолцооны шударга байдлыг дэмжих олон нийтийн дэмжлэг илт гүнзгийрч ирсэн байна. Конгресс нам хууль тогтоох байгууллагын суудлын гуравны хоёрыг авч ялалт байгуулсан 1971 оны сонгуулийн дараа ерөнхий сайдын алба хашиж байсан Индра Гандигийн сонгуулийг шүүх хүчингүй болгосон байна. Үүний хариуд тэрбээр Үндсэн хуулиар олгосон иргэдийн сонгох эрхийг хоёр жилийн турш (1975-1977 онд) хязгаарласан нь Энэтхэгийн өрсөлдөөнт ардчиллын түүхэнд гараагүй авторитар дэглэмт завсрын үе байв. 1977 оны сонгуулиар шударга санал хураалт явуулж түүний засгийн газар засгийн эрхээс буусан нь Энэтхэгийн сонгогчид ардчилсан бус засгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагийн дохио болсон юм.

1977-1997 он хүртэлх 20 жилийг авч үзвэл нийтлэг зарчимгүй, улс төрийн намуудын явцуу эрх ашигт хөтлөгдсөн эвслийн засгийн газар удаа дараа байгуулагдан унасан тогтворгүй байдлын эрин үе байсан нь харьцангуй олонхийн тогтолцоотой холбоотой. 1977 онд сөрөг хүчний намууд (коммунист бус) Жаната Нам хэмээх эвсэл байгуулан сонгуульд өрсөлдөж засгийн эрхийг гартаа авсан юм. Энэ нам хоёр жил бололгүй задарсан байна. 1989 оны 12 дугаар сард түүний залгамжлагч Жаната

Дал хэмээх нам коммунист намуудын болон Хиндийн сэргэн мандалтын БЖН-ын дэмжлэгтэйгээр засгийн эрхэнд гарсан бөгөөд засгийн газар нь арван сар л оршин тогтножээ. 1996 оны сонгуулиар БЖН 161 суудал, Конгресс Нам 140 суудал авсан ба тогтвортой засгийн газар бүрдүүлж чадах нам гарсангүй. Харин 1999 онд харьцангуй олонхийн тогтолцооны давуу тал дахин харагдаж БЖН тэргүүтэй намуудын эвсэл засгийн газраа бүрдүүлж чадсан төдийгүй бүрэн эрхийн хугацаагаа бараг дуустал эрх барьсан юм. 2004 оны тавдугаар сард болсон бүх нийтийн сонгуулийн дараа Энэтхэгийн Үндэсний Конгресс Нам зүүний болон бусад намын хамтаар үндэсний хэмжээний эвслийн засгийн газар байгуулсан.

2000 онд Энэтхэгийн засгийн газраас Үндсэн хуулийн хэрэгжилтийг хянах үндэсний зөвлөл байгуулав. Тус зөвлөл үндсэн хуульд орсон сонгуультай холбоотой заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах буюу өргөтгөх эсэх тухай авч хэлэлцсэн байна. Зөвлөлөөс 2002 онд засгийн газарт ирүүлсэн тайландаа Үндсэн хуульд ямар нэг өөрчлөлт оруулахын эсрэг байгаагаа зөвлөмж болгохын зэрэгцээ шаардлагатай гэж үзвэл иймэрхүү өөрчлөлтийг сонгуулийн тухай ердийн хуулинд, болон дагалдах хууль тогтоомж, журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хийж болох юм гэдгийг онцолсон байна.

Гэхдээ Зөвлөлийн зүгээс сүүлийн гурван удаагийн бүх нийтийн сонгуульд Энэтхэгийн парламентын гишүүдийн дунджаар гуравны хоёр нь 50+1 хувийн санал аваагүй харьцангуй олонхийн саналаар сонгогдож ирснийг харгалзан парламент дахь төлөөллийн хууль ёсны байдалтай холбогдон гарч буй асуудлуудыг анхаарч үзсэн байна. Улмаар 2004 онд бүх нийтийн сонгуульд электрон санал хураалтын технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд хоёр шатлалт тогтолцоонд шилжих асуудлыг нарийн, нухацтай авч үзэхийг засгийн газарт болон Энэтхэгийн сонгуулийн хороонд зөвлөмж болгосон ажээ. Ингэхдээ сонгуулийн эхний үе шат өнгөрснөөснэгдрийндараа тойрог бүрт тэргүүлсэн хоёр нэр дэвшигчийн хооронд хоёр дахь шатны сонгууль явуулахыг санал болгосон байв. 2004 оны сонгуулийн дараа Энэтхэгийн сонгуулийн хорооноос гаргасан тайланд энэ саналтай холбогдуулж ямар нэг санал дэвшүүлээгүй боловч саналын хуудсанд “эдгээр нэр дэвшигчийн аль нь ч биш” гэж санал өгөх нэмэлт оруулах, мөн нэг хүн хоёр өөр тойрогт нэр дэвшиж болох тухай заалтыг хүчингүй болгохыг зөвлөмж болгосон байв.

Улс төрийн хоёр томоохон намтай оронд харьцангуй олонхийн тогтолцоо хамгийн сайн үйлчилдэг гэж ярих нь олонтаа. Гэтэл Энэтхэг Улсын Конгресс нам 1952-1977 онд хүчтэй өрсөлдөгчгүйгээр засгийн эрхийг тасралтгүй барьсан байна. Энэхүү монопольт байдал 1977 онд дуусгавар болжээ. Улс төрийн тавцанд нэг нам ноёрхож ирсэн хэв маяг

өөрчлөгдөж эхлээд нэг нам ба улс төрийн намуудын эвслийн хоорондын өрсөлдөөнд, дараа нь улс төрийн намуудын хоёр эвслийн хоорондын өрсөлдөөнд шилжсэн бөгөөд энэ чиг хандлага 2004 оны сонгуулиар ч үргэлжилсэн юм. БЖН анхандаа хинду шашныг хатуу баримталсан мөрийн хөтөлбөртэйгээр гарч ирэн Энэтхэгийн парламент дахь байр сууриа дээшлүүлж эхэлсэн боловч нэг бүрэн эрхийн хугацаанд засгийн эрхийг барьсны эцэст сонгуульд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх шаардлагын үүднээс хэт барууны цэрэг дайнч байр сууриа хязгаарлахаас аргагүй болсон байна. Ингээд тус нам бодлогын хөтөлбөрөө өргөжүүлж нэгэн цагт Конгресс Намын тууштай дэмжигчид асан лалын шашинтнууд, овог аймгийн болон доод ангийн сонгогчдод хандах болжээ.

г. Энэ тогтолцоо нь тодорхой бүлэг, үндэс угсаа, бүс нутгийн сонирхолд тулгуурласан улс төрийн намууд хөгжих нөхцөл болдог бөгөөд ийм намууд сонгуулийн амлалт, бодлогын хөтөлбөрөө тухайн тойрог эсвэл бүс нутгийн сонгогчдын анхаарлыг татсан асуудлуудад чиглүүлж, бусад хүмүүсийн хүсэл сонирхлыг гээгдүүлэх эсвэл бүр дайсагнасан байдлаар хандах явдал тохиолддог. Энэ нь нийгмийн доторх хүн амын томоохон бүлгүүд бүс нутгаар ялгаран суурьшсан Малави, Кени зэрэг орнуудад байнга тохиолддог бэрхшээлтэй асуудал юм. Энэ үзэгдлийн улмаас улс төрийн намуудын сонгогчдын дэмжлэгийг хүлээх боломж нь тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хязгаарлагдан, газар зүйн хувьд хуваагдмал болж, намууд тухайн хязгаараас гадна буюу нутаг ус, улс төр, соёлын тодорхой хүрээнээс гадуур сонгогчдын дэмжлэг эрэх сонирхолгүй болдог байна.

д. Энэ тогтолцоо нь тодорхой нутаг дэвсгэр буюу тойрогт нэг нам бүх суудлыг байнга авч “жалга довны ноёрхол” тогтох үзэгдлийг дэвэргэдэг. Хэрвээ нам тодорхой нэг газар, нутаг дэвсгэрт хүчтэй дэмжлэг хүлээн, нэр дэвшигч нь бусад өрсөлдөгчдөөс давуу санал авдаг бол тухайн тойргийн мандатыг бүгдийг авна. Ингэснээр тэнд оршин сууж буй цөөнх төлөөлөлгүй үлдээд зогсохгүй, улстөр бол хувь хүн ямар итгэл үнэмшилтэй байгаагаас бус харин хаана амьдардаг хэн бэ гэдгээс хамаарах тулааны талбар юм гэсэн өрөөсгөл ойлголтыг лавшруулах нөлөөтэй. Энэ асуудлыг Канад Улсад ХОТ-г буруутгах үндэслэл болгон дэвшүүлж байжээ.

е. Мөн энэ тогтолцоо нь сонгогдож чадаагүй аль нэг нэр дэвшигчид өгсөн асар олон санал дэмий хоосон үрэгдэхэд хүргэдэг. Энэ нь “жалга довны ноёрхол”-ын үзэгдэлтэй хослох юм бол бүр ч аюултай аж. Учир нь тухайн бүс нутагт буй цөөнхийн намыг дэмжигчид өөрсдийн нэр дэвшигчийг сонгогдоно гэдэгт бүрэн итгэл алдарч болох ба энэ байдлыг хэт туйлшрагч үзэлтнүүд эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэхэд ашиглах явдал гардаг.

ё. Санал хуваагдахад хүргэж болно. ХОТ-оор ижил төстэй хоёр нам эсвэл нэр дэвшигч өрсөлдөхөд тэднийг дэмжигчдийн санал голдуу хоёр хуваагдаж өөр нэг нэр хүнд муутай нам буюу нэр дэвшигч дундаас нь ялж суудал авах боломж олгодог. Папуа Шинэ Гвиней Улсын туршлага үүний маш тодорхой нэг жишээ болдог (холбогдох жишээг үзнэ үү).

ж. Энэ тогтолцоо нь олон нийтийн санаа бодолд гарсан өөрчлөлтөд мэдрэг бус байх сул талтай. Сонгогчдын намд үзүүлэх дэмжлэг бүс нутаг, тойргоор хуваагдаж төвлөрсөн байгаа нөхцөлд олон нийтийн зүгээс үзүүлэх дэмжлэг мэдэгдэхүйц буурсан ч нэг нам засгийн эрхийг дангаар

барьсан хэвээр үлдэх боломжтой. ХОТ-той зарим ардчилсан оронд үндэсний хэмжээний нийт хүчинтэй саналын тоонд тодорхой нэг намын авсан саналын эзлэх хувь 60-40 хувь хүртэл буурахад парламентад авах суудлынх нь тоо 80-60 хувь болж буурах нь бий ч энэ нь тухайн намын ноёрхох байр суурьт ерөнхийдөө нөлөө үзүүлэхгүй. Ямар ч нам ялж болзошгүй онцлогтой тойргуудад хуваарилсан ихээхэн өрсөлдөөнтэй суудлын тоо хангалттай олон биш л бол энэ тогтолцоонд олон нийтийн санаа бодлын савалгаа ямар ч нөлөөгүй байна.

3. Эцэст нь тэмдэглэхэд ХОТ нь сонгуулийн тойргийн хилийг яаж тогтоохоос хамааралтай байдаг. Сонгуулийн тойргийн хилийг хэрхэн тогтоох нь ямар ч нөхцөлд улс төрийн үр дагавартай байдаг. Улс төрийн, эсвэл өөр бусад асуудлаас тусгаар цорын ганц “зөв хариу” өгдөг техник үйл ажиллагаа гэж байдаггүй (хавсралт Д-д үзүүлсэнчлэн). Сонгуулийн тойргийн хилийг зөв тогтоож, үр дүнг нь хууль ёсны гэж хүлээн зөвшөөрүүлэхэд ихээхэн цаг хугацаа, хөрөнгө хүч шаардаж болно. Мөн тойргийн хилийг тогтоох явцад элдэв заль мэх хэрэглэх, дарамт учруулах үзэгдэл гарах нь бий. Ийм явдал, тухайлбал, 1993 оны Кенийн сонгуульд тодорхой ажиглагдсан бөгөөд тойргууд нь хэмжээний хувьд харилцан адилгүй, хамгийн том тойргийн сонгогчдын тоо хамгийн жижиг тойргийнхоос даруй 23 дахин их байсан байна. Энэ нь эрх баригч Кенийн Африкийн Үндэсний Эвлэл нам нийт сонгогчдын гучхан хувийн санал авсан атлаа хууль тогтоох байгууллагад хүчтэй олонхи болоход нөлөөлсөн байдаг.

Багц саналын тогтолцоо (БСТ)

80. Багц саналын тогтолцоо (БСТ) нь ердөө харьцангуй олонхийн тогтолцоог олон мандаттай тойрогт ашиглаж байгаа хувилбар юм. Сонгогчид тухайн тойрогт хуваарилсан мандатын тоогоор санал өгөх бөгөөд намын харъяаллаас үл хамааран ямар ч нэр дэвшигчдэд саналаа чөлөөтэй өгөх боломжтой байна. Ихэнх БСТ-нд сонгогчид мандатын тоотой тэнцүү буюу эсвэл хүссэн хэмжээгээрээ түүнээс цөөн санал өгч болдог.

Багц саналын тогтолцоо бол олон мандаттай тойргоор санал хураах ОД тогтолцооны хувилбар юм. Сонгогчид мандатын тоотой тэнцүү санал өгөх боломжтой ба нийлбэр дүнгээр хамгийн олон санал авсан нэр дэвшигчид ялалт байгуулдаг. Сонгогчид ихэвчлэн намын төлөө бус нэр дэвшигчдийн төлөө саналаа өгдөг бөгөөд ихэнх ийм тогтолцоонд сонгогчид мандатын тооноос цөөн ч санал хүссэнээрээ өгч болдог байна.

82. БСТ нь улс төрийн намууд нь сул дорой юмуу огт нам байхгүй орнуудад түгээмэл. 2004 онд Кэйманы арлууд, Фолклэндийн арлууд, Гвернсий, Кувейт, Лаос, Ливан, Мальдив, Палестин, Арабын Бүгд Найрамдах Сири

Улс, Тонга, Тувалу улсууд бүгд багц саналын тогтолцоо хэрэглэсэн байна. Мөн энэ тогтолцоог 1989 онд Иорданд, 1992 онд Монголд, 1997 он хүртэл Филиппин, Тайланд улсуудад хэрэглэж байсан боловч гарах үр дүн нь сэтгэлд нийцэхгүй байснаас бүгд энэ тогтолцоог өөрчилсөн байна.

82. *Давуу талууд*: БСТ-нд сонгогчид бие даан нэр дэвшигч хувь хүмүүст санал өгөх боломж нээлттэй, сонгуулийн тойргууд нь газар зүйн хувьд хэт том биш байхаас гадна энэ тогтолцоо нь ХОТ-той харьцуулахад намуудын үүрэг ролийг нэмэгдүүлж, хамгийн эвнэгдэлтэй, зохион байгуулалт сайтай намууд шалгаран бэхжих нөлөө үзүүлдэг хэмээн талархал хүлээдэг.

83. *Сул талууд*: Гэвч БСТ нь сонгуулийн үрдүнд урьдчилан таашгүй бөгөөд ихэнхдээ таагүй нөлөө үзүүлэх нь бий. Жишээлбэл, сонгогч бүх саналаа нэг намаас нэр дэвшсэн хүмүүст өгөх тохиолдолд энэ тогтолцоо ХОТ-ны ихэнх сул талыг, түүний дотор суудлын хуваарилалтын пропорциональ бус байдлыг улам нэмэгдүүлэх хандлагатай байна. Ялангуяа намууд мандатын тоогоор нэр дэвшигч сойж, нэр дэвшигч бүрийг дэмжихийг сонгогчдод уриалж байгаа тохиолдолд ийм үзэгдэл гарах боломжтой. Тухайлбал, Бүгд Найрамдах Маврикий Улсад 1982, 1995 онд болсон сонгуулиудад сөрөг хүчин байсан нам 64 ба 65 хувийн саналтайгаар хууль тогтоох байгууллагын бүх суудлыг авч байв. Энэ нь олонхийн засаглал ба сөрөг хүчний зарчимд тулгуурладаг парламентын тогтолцоо үр дүнтэй ажиллахад ноцтой хүндрэл учруулдаг. Маврикийд “хамгийн хүчтэй ялагдагч”-дад (*best loser seats*) суудал хуваарилах аргыг (153 дугаар хэсгийг үзнэ үү) ашигласан нь энэ сул талын хагас хугасхан нөхсөн байна.

84. Тайланд Улсад багц саналын тогтолцоо нь намууд задарч, сулрахад хүргэж байна гэж үзэх хүн олон байдаг. Сонгогч нэг тойрогт нэг намаас нэр дэвшсэн хэд хэдэн хүнд санал өгөх боломжтой учир нэг намын нэр дэвшигчид саналын төлөө өөр хоорондоо өрсөлдөх байдал ажиглагддаг. Иймээс энэ тогтолцоог намын дотор жигүүр үүсэх, авлига газар авахад нөлөөлдөг гэж өөлөх нь бий.

85. Сүүлийн жилүүдэд нэлээд олон орон бусад тогтолцоог илүүд үзэж БСТ-гоо орхисон байна. 1990-ээд оны сүүлээр Тайланд, Филиппин улсууд хоёулаа БСТ-оос холимог тогтолцоонд шилжсэн юм. Энэ хоёр орны жишээнд хоёуланд нь тогтолцоогоо шинэчлэх болсон гол үндэслэл нь санал худалдан авах үзэгдэлтэй тэмцэх, улс төрийн намуудын хөгжлийг дэмжих шаардлага байжээ (Тайландын жишээг үзнэ үү).

ПАЛЕСТИН: Улс төрийн нөхцөл байдал сонгуулийн тогтолцоог тодорхойлох нь

Эндрю Эллис

1993 оны сүүлээр Израиль Улс, Палестиний чөлөөлөх байгууллага (ПЧБ)-ын хооронд хийсэн Ослогийн гэрээнд сонгуулиар байгуулах Палестины зөвлөлийн тухай заалт орсон билээ. Ослогийн гэрээг хэрэгжүүлэх явцад Дунд хугацааны буюу илүү нарийвчилсан гэрээг тохирох шаардлага тулгарсан байна. Үүнийг 1995 оны есдүгээр сард Табад боловсруулж дууссан бөгөөд Палестины Хууль тогтоох зөвлөлийн болон Гүйцэтгэх байгууллагын тэргүүнийг тус тусад нь сонгох сонгууль явуулах тухай дэлгэрэнгүй заалтууд багтсан байв. Ингээд 1996 оны нэгдүгээр сарын 20-ны өдөр Палестины ерөнхийлөгч (Раиес) болон Палестины Хууль тогтоох зөвлөлийг сонгох сонгууль явагджээ.

Сонгуулийн бэлтгэлийг хангах ажлыг 1994 онд Дунд хугацааны гэрээ байгуулах яриа хэлэлцээтэй зэрэгцүүлэн эхлүүлсэн байдаг. Сонгуулийн хуулиа баталж, сонгууль явуулах нь бүхэлдээ Палестинчуудын үүрэг боловч сонгуулийн зохицуулалтын зарим нарийн ширийн зүйл Дунд хугацааны хэлэлцээрийн заалтуудад нийцсэн байх шаардлагатай байв. Сонгуулийн хуулийн эцсийн хувилбар болон гол зохицуулалтууд дөнгөж 1995 оны сүүлээр бэлэн болсон байна.

Сонгуулийн тогтолцооны боломжит хувилбаруудыг гаргахад тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал хүчтэй нөлөөлжээ. Тус улсын ерөнхийлөгчөөр Яссир Арафат сонгогдоно гэдэгт бараг хэн ч эргэлзэхгүй байсан учраас ерөнхийлөгчийн сонгуулийг нэг шаттай ХОТ-оор зохион байгуулах шийдвэрийг хэсэгхэн хугацаанд хэлэлцээд шууд баталсан юм. Энэ төсөөлөл ч амьдралд биелэлээ олж Арафат бусад нэр дэвшигчээс хол тасархай буюу 80 гаруй хувийн санал авч ялалт байгуулсан байна.

Хууль тогтоох зөвлөлийг бүрдүүлэх сонгуулийн тогтолцоог харин дээрх шиг шулуун дардан замаар шийдвэрлэх боломж байсангүй. Юуны өмнө, Палестины ард иргэд Дунд хугацааны хэлэлцээрийн үйл явцад оролцох, түүнийг хүлээн зөвшөөрөх тал дээр санал нэгтэй биш байв. Шинээр байгуулагдсан Палестины удирдах байгууллагаас Хамас болон Исламын бусад хөдөлгөөний гишүүдтэй хөшигний ард, хаалттай байдлаар маш удаан яриа хэлэлцүүлэг өрнүүлсний дотор тэдний сонгуульд оролцох оролцооны талаар асуудал хөндөгдсөн байна. Хоёрдугаарт, улс төрийн намын тогтолцоо нь үр хөврөлийн төдий байлаа. Фатах нь үндсэндээ Үндэсний чөлөөлөх хөдөлгөөний хэлбэртэй байгууллага байсан бөгөөд Израильтай “эцсийн шатны” хэлэлцээр хийхэд (амжилт олоогүй) эв нэгдэл чухал учир хөдөлгөөний хэлбэрээр үйл ажиллагаа үргэлжлүүлэх хэрэгцээтэй гэж үзэж байв. Зарим нэг жижиг нам байгуулагдсан ба олон боломжит нэр дэвшигч Фатахаас хараат бусаар бие даан сонгуульд оролцохыг хүсч байв. Гуравдугаарт, урьд нь сонгууль явуулж байсан зарим туршлага байв. Тухайлбал, 1940-өөд онд Газад явагдсан орон нутгийн сонгуульд Египетээс хуулбарласан дүрэм, журмыг дагасан бол 1970-аад онд Баруун эргийн хот, суурингуудад явуулсан сонгуульд Иорданд Британийн дэглэмээс уламжлагдан үлдсэн дүрэм журмыг ашигласан байна. Үүнээс үүдэлтэй, ялангуяа, Иорданы практикийг дагая гэсэн санал хүчтэй байв.

Иймээс 1) сонгуулийг албан ёсоор эсэргүүцсэн байр суурьтай байсан хөдөлгөөнд харъяалагдах нэр дэвшигчид албан бусаар нэр дэвших суваг бий болгох, 2) нэр нөлөө бүхий хүмүүсийн бие даан нэр дэвших хүсэл эрмэлзлийг биелүүлэх, 3) өмнөх сонгуулийн туршлага, уламжлалыг харгалзахгэсэн гурваншаардлагад нийцүүлэн нэр дэвшигчид тулгуурласан сонгуулийн тогтолцоо сонгох болжээ. Мөн сонгуулийн процессыг энгийн хялбар, ил тод байлгах, тооллогын үйл явцыг хурдасгах, үр дүнд итгэл төрүүлэхэд ач холбогдол өгсөн нь санал тоолох ажиллагааг хэсгийн хороод дээр зохион байгуулах, улмаар альтернатив саналын тогтолцоо (АСТ), санал шилжүүлэх тогтолцоо (СШТ) гэх мэт нэр дэвшигчдийг дэмжих дарааллаар эрэмбэлэн санал өгөх хувилбаруудыг боломжгүй гэж үзэхэд хүргэжээ. Эцсийн сонголт нь багц саналын тогтолцоо (БСТ) байсан бөгөөд сонгуулийн тойргийн хэмжээ нь Газад 12, Жерико, Салфит, Тюбас зэрэг жижиг хотод нэг гэх мэтээр янз бүр байлаа.

Дээрхээс гадна цөөнхийн төлөөлөл, түүний дотор Христийн шашинт иргэд (нийт сонгогчдын 10 орчим хувь) ба Самаританчуудын төлөөллийг хэрхэн хангах талаар хэлэлцүүлэг явагдсан байна. Үүний үр дүнд БСТ-ны хүрээнд Христийн шашинтнууд хамгийн их төвлөрсөн дөрвөн тойрогт (Бетлехем, Иерусалем хотуудад тус бүр хоёр, Рамалла, Газа хотуудад

тус бүр нэг) зургаан суудал, Наблус дахь Самаританчуудад тус тус нэг суудал ногдохоор тооцож зохицуулжээ. Христийн шашинт нэр дэвшигч өөрийгөө Христийн шашинтны төлөөлөл гэдгээ зарлах боломжтой байв. Хэрэв саналыг тоолоход хамгийн олон санал авч сонгогдох боломжтой болсон хүмүүсийн дотор Христийн шашинтай нэр дэвшигч байхгүй бол тэдний дотроос хамгийн бага санал авсан нэр дэвшигчийг хасан, Христийн шашинтай гэдгээ зарлаад хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчээр солихоор заасан бөгөөд үнэхээр дээр дурдсан тойргуудад дөрвүүлэнд нь ийм явдал тохиолдсон байна. Энэ нь Хууль тогтоох зөвлөлд зарим нэг сонгогдоогүй нэр дэвшигчээс ч цөөн санал авсан хүмүүс сонгогдон орсон гэсэн үг. Үүнтэй холбоотой маргаан гарсан боловч сонгогчдын төлөөллийг өргөн хүрээтэй хангасан, сонгууль амжилттай явагдсаны дараа асуудал тавигдсан гэдэг үүднээс сонгуулийн дүнг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрсөн ажээ.

Практикт БСТ нь хүсэн хүлээсэн үр дүнг ерөнхийдөө үзүүлжээ гэж дүгнэхэд хилсдэхгүй. Гааза хотод гэхэд 87 нэр дэвшигч өрсөлдсөн боловч сонгогчид нэг метрийн урттай саналын хуудсыг түүртэлгүй бөглөж чадсан байна. Энхийг тогтоох үйл ажиллагааг эсэргүүцэгч бүлгүүдээс цөөхөн нэр дэвшигч сонгуульд өрсөлдсөн боловч тэдний нэг нь ч болтугай сонгогдсон нь Зөвлөлийг тэдгээр хөдөлгөөнтэй холбох гүүр болсон гэж үзэх боломжтой. Фатах бүлгээс нэр дэвшигчид давуу талтай байсан боловч сонгогчид олон түмэнд танил болон танил бус нэр дэвшигчдийг сайн ялгаж байв. Түүнчлэн нэр нөлөө бүхий бие даан нэр дэвшигчид болон цөөнхийн төлөөлөгчид ч сонгогдож чадсан байна. Ингээд 1996 оны сонгуулиар Палестины ард иргэдийн өргөн хүрээтэй дэмжлэг авсан хууль ёсны шинэ Ерөнхийлөгч, Хууль тогтоох зөвлөл хоёр засгийн эрхийг авсан юм.

Намын багц саналын тогтолцоо (НБСТ)

86. Харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ)-оос ялгаатай нь НБСТ-нд сонгууль олон мандаттай тойргоор явагддаг. Сонгогчид ганцхан санал өгөх бөгөөд өмнө тайлбарласан БСТ-оос ялгаатай нь намаас дэвшүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалтыг харьцуулж сонголт хийдэг байна. Хамгийн их санал авсан нам тухайн тойргийн бүх мандатыг авч, жагсаалтад орсон нэр дэвшигчид нь парламентын гишүүн болно. ХОТ-нд байдаг шиг нэр дэвшигч заавал үнэмлэхүй олонхийн санал авах албагүй байдаг. 2004 оны байдлаар НБСТ-г Камерун, Чад, Джибути, Сингапур гэсэн дөрвөн улс дангаар нь буюу холимог сонгуулийн тогтолцооныхоо гол бүрэлдэхүүн хэсэг болгон ашиглаж байна.

87. *Давуу талууд.* НБСТ нь хэрэглэхэд хялбар, хүчтэй намуудыг хөхиүлэн дэмждэг төдийгүй нэр дэвшигчдийн жагсаалтад цөөнхийн төлөөлөл багтах бололцоо олгодог. Тухайлбал, нам үндэс угсааны хувьд янз бүрийн гаралтай нэр дэвшигчдийг жагсаалтдаа оруулж сонгуульд өрсөлдүүлэх боломжтой учир хууль тогтоох байгууллага дахь төлөөллийн тэнцвэртэй байдлыг

Намын багц саналын тогтолцоо бол олон мандаттай тойргоор санал хураадаг олонхи/дийлэнхийн тогтолцооны бас нэг хувилбар бөгөөд өмнөхөөс ялгаатай нь сонгогчид нэр дэвшигчдээс сонголт хийх биш, харин намд санал өгдөг байна. Тухайн сонгуулийн тойрогт хамгийн олон санал авсан нам тухайн тойргийн бүх мандатыг авна.

хангахад дөхөмтэй байна. Намууд жагсаалтаа тийнхүү тэнцвэртэй байдлаар гаргах шаардлагыг тогтолцоонд суулгаж өгч болно. Тухайлбал, Джибутид намын жагсаалт бүр үндэстэн ястны бүлгүүдийн холимог төлөөллийг оруулсан байх ёстой байдаг. Сингапурт парламентын гишүүдийн ихэнх нь хүн амын янз бүрийн бүлгийн төлөөлөл бүхий олон мандаттай тойргуудаас сонгогддог. Энд сонгуульд өрсөлдөж буй аливаа нам буюу бүлгийн жагсаалтад орсон нэр дэвшигчдээс дор хаяж нэг нь Малайз, Энэтхэг, эсвэл бусад үндэсний цөөнхийн бүлгийн гишүүн байх ёстой. Түүнчлэн Сингапур Улс зарим тохиолдолд сөрөг хүчний нэр дэвшигчдэд боломж олгох зорилгоор “шилдэг ялагдагч”-ын суудлыг ашигладаг. Бусад орон, тухайлбал Сенегал, Тунист, намын багц саналын тогтолцоог холимог параллель тогтолцооныхоо нэг бүрэлдэхүүн болгож ашигладаг байна (Сенегал Улсын жишээг үзнэ үү).

88. *Сул талууд:* Гэхдээ намын багц саналын тогтолцоо нь ХОТ-ны ихэнх сул талуудыг шингээсэн байдаг бөгөөд ихээхэн тэнцвэртэй бус үрдүн гарч, нийт саналын ердийн олонхийг авсан нам хууль тогтоох байгууллагын

бараг бүх суудлыг авах боломж бүрдүүлэх нь бий. Джибутигийн 1997 оны сонгуульд Ерөнхийлөгчийн олонхийн төлөө эвлэл хэмээх эрх баригч эвсэл бараг бүх суудлыг авч, сөрөг хүчний хоёр нам хууль тогтоох байгууллагад ямар ч төлөөлөлгүй үлдсэн байна.

Альтернатив саналын тогтолцоо (АСТ)

89. АСТ-нд сонгууль нь ХОТ-ны нэг адил ихэвчлэн нэг мандаттай тойргуудад явагдана. Гэхдээ АСТ нь ХОТ-г бодвол сонгогчид саналын хуудсан дээр сонголтоо илэрхийлэх илүү боломж олгодог. АСТ-нд сонгогч зүгээр хэн нэгнийг дэмжиж буйгаа тэмдэглээд өнгөрөх биш хамгийн их дэмждэг нэр дэвшигчээ '1', хоёр дахь сонголтоо '2', гурав дахь сонголтоо '3' гэх мэтчилэн эрэмбэлж саналаа өгдөг. Ингэснээр энэ тогтолцоо нь сонгогчид зөвхөн эхний сонголтоо хийх бус, бусад нэр дэвшигчдээс хэнийг илүүдүзэж байгаагаа илэрхийлэх боломж олгож байна. АСТ-г ашигладаг зарим оронд түүнийг “эрэмбэт санал”-ын тогтолцоо ч гэж нэрийдэх нь бий (АСТ-оос гадна Борда тооллого, Санал шилжүүлэх, Нэмэлт саналын гэх мэт эрэмбэт саналын тогтолцоо байдаг).

Альтернатив саналын тогтолцоо бол нэг мандаттай тойрогт сонгогч нэр дэвшигчдийг дэмжих дарааллаараа дугаарлан санал өгдөг олонхи/дийлэнхийн тогтолцооны хувилбар юм. Сонгогч хамгийн их дэмжиж буй нэр дэвшигчийг '1', дараагийнх нь хүнийг '2' гэх зэргээр хэнийг эхэлж, хэнийг удаалуулж сонгохоо саналын хуудсан дээр цифр ашиглан тэмдэглэнэ. Улмаар эхний буюу нэгдүгээр сонголтоор үнэмлэхүй олонхийн (50+1) санал авсан нэр дэвшигч шууд сонгогдоно. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч нийт хүчинтэй саналын талаас илүүг авч чадаагүй бол '1' гэсэн санал авсан нэр дэвшигчдээс хамгийн бага саналтайг нь хасч тухайн саналын хуудас дээр '2' гэж тэмдэглэсэн саналыг үлдсэн нэр дэвшигчдэд нь нэмж тоолох ба энэ процессыг үнэмлэхүй олонхийн саналаар ялах нэр дэвшигч тодрох хүртэл үргэлжүүлнэ. Сонгогчид намд бус, нэр дэвшигчдэд саналаа өгнө.










90. АСТ нь санал тоолох аргын хувьд ХОТ-оос ялгаатай. Харьцангуй олонхийн эсвэл хоёр шаттай тогтолцооны нэг адил үнэмлэхүй олонхийн (50+1) санал авсан нэр дэвшигч шууд сонгогддог. Харин, АСТ-нд нэр дэвшигчдийн хэн нь ч үнэмлэхүй олонхийн санал авч чадаагүй бол эхний сонголтоор хамгийн цөөхөн санал авсан нэр дэвшигчийг тооллогоос “хасч”, тухайн саналын хуудас дээр хэнийг дараагийн ээлжинд сонгохоор тэмдэглэсэн байгааг харна. Хасагдсан хүний авсан саналыг эрэмбээр хамгийн өндөрт байгаа нэр дэвшигчид шилжүүлдэг. Энэ ажиллагааг аль нэг нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал автал давтах бөгөөд ингэж сонгогдсон нэр дэвшигчийг ялагчаар зарладаг. Ийм болохоор АСТ бол ОД тогтолцооны бүлэгт багтаж буй юм.

You may vote in one of two ways

Do NOT do both

EITHER





By placing a single tick in one and only one of these boxes to indicate which party's or candidate's preference you wish to adopt as your vote

	or		or		or
VLV		DAKUVULA		SVT	
	or		or		or
FAP		FLP		GVP	
	or		or		or
NFP		FNP		UGP	

OR

Number the boxes from 1 to 4 in the squares next to the symbols of each of the candidates in your order of preference

In this case number **every** box to make your vote count

Epeli Gavidu GANILAU		
Jone DAKUVULA		
Rakuita Saurara VAKALALABURE		
Epeli LIGAMAMADA		

АСТ-той Фижи Улсын саналын хуудас

91. АСТ-нд сонгогчид саналын хуудсан дээрх нэр дэвшигчдийг бүгдийг эсвэл ихэнхийг нь дугаарлах шаардлага тавих нь бий ч заавал ингэх албагүй. Бүрэн дугаарлаагүй саналын хуудас тооллогын сүүлийн шатуудад тоологдох боломжгүй болж “үрэгдэх” эрсдэлтэй. Гэхдээ бүх нэр дэвшигчийг дугаарлах шаардлага тавих нь хүчингүй саналын тоо нэмэгдэхэд хүргэдэг бөгөөд зарим тохиолдолд сонгогчид өөрт нь огт падгүй, эсвэл маш их дургүй нэр дэвшигчийг дугаарлахаас өөр аргагүйд хүргэдэг байна.

92. АСТ-г Австрали, Фижи, Папуа Шинэ Гвиней Улсад хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, өмнө авч үзсэн (74 дүгээр хэсгийг үзнэ үү) сонгуулийн тогтолцооны тархалтыг бүс нутгаар үзүүлсэн графикт тодорхой үзүүлсэнчлэн одоогийн байдлаар АСТ-г үндэсний хэмжээнд хэрэглэж буй тохиолдол Номхон Далайн орнуудад л гарч байна. Харин Европ, Хойд Америк дахь муж орон нутгийн түвшний цөөнгүй хууль тогтоох байгууллагад АСТ-ны хувилбаруудыг хэрэглэж байгаа төдийгүй Бүгд Найрамдах Ирланд Улс ерөнхийлөгчийн сонгуулиа энэ тогтолцоогоор зохион байгуулдаг байна.

93. *Давуу талууд*: Саналыг шилжүүлэхийн нэг давуу тал бол хэд хэдэн нэр дэвшигчийн саналыг нэгтгэж, зарим талаар ялгаатай боловч харилцан уялдаатай сонирхлуудыг төлөөлөх хүн сонгогдох нөхцөл бүрддэг. Мөн сонгогдох найдвар багатай нэр дэвшигчийг дэмжигч сонгогчид нь хоёр дахь болон дараа дараагийн сонголтуудаараа дамжуулан нөлөө бүхий нэр дэвшигч мандат авахад нөлөөлөх боломжийг АСТ олгодог. Түүнчлэн энэ шалтгаанаас үүдэн нэр дэвшигчид зөвхөн өөрийг нь дэмжигч сонгогчдын саналыг аваад зогсохгүй бусад сонгогчдын “хоёр дахь сонголт” болохыг эрмэлзэхэд хүргэдэг учраас АСТ бол төвийг сахисан аядуу бодлогыг дэмжих тал дээр хамгийн сайн тогтолцоо гэж заримдаа үздэг. Сонгогчдын саналыг татахын тулд нэр дэвшигчид явцуу асуудлуудад тулгуурласан биш, нийтийг хамарсан өргөн хүрээтэй асуудлыг хамарсан мөрийн хөтөлбөр гаргах ёстой. Австралид АСТ хэрэглэсэн туршлага үүнийг нотлон харуулж байна. Жишээлбэл, томоохон намууд сонгуулиас өмнө жижиг намуудтай харилцан тохиролцож, тэдний дэмжигчдийн хоёр дахь сонголт одоохыг хичээдэг бөгөөд энэ нь “сонголт наймаалцах” арга гэдгээр танил болсон байдаг. Цаашилбал, АСТ-нд нэр дэвшигч ялахын тулд үнэмлэхүй олонхийн дэмжлэг авсан байхыг шаарддаг учраас хууль тогтоох байгууллагад орж ирэх төлөөллийн нийтээр хүлээн зөвшөөрөгдөх, хууль ёсны байдлыг дээшлүүлэх сайн нөлөөтэй байна.

АСТ-г Папуа Шинэ Гвинейд болон Австралид хэрэглэсэн туршлагаас үзэхэд улс төрийн харилцан найр тавин зохицох, хамтрах бодлогод ихээхэн түлхэц өгдөг байна. Сүүлийн жилүүдэд АСТ, эсвэл түүний нэг хувилбар нэмэлт саналын тогтолцоог (*supplementary vote*) Босни, Лондон, Сан Францискогийн ерөнхийлөгчийн болон хотын даргын сонгуульд авч хэрэглээд байна (182-186 дугаар хэсгийг үзнэ үү).

94. *Сул талууд*: Гэсэн хэдий ч АСТ-нд хэд хэдэн сул тал байдаг. Нэгдүгээрт, сонгогчид нь бичиг үсэг тайлагдсан, тооны зохих мэдлэгтэй байх ёстой болно. Мөн нэг мандаттай тойрогт явагддаг тул ХТТ, заримдаа бүр ХОТ-оос ч илүү тэнцвэргүй үр дүн гарах нь олонтаа тохиолдоно. Мөн АСТ-ны төвийг сахисан аядуу үр дүнд хүргэх нөлөө нь нийгэм, хүн ам зүйн нөхцөл байдлаас маш их хамааралтай байдаг. Тухайлбал, энэ тогтолцоо 1960, 1970-аад оны үед Папуа Шинэ Гвиней Улсад угсаатан хоорондын зохицолдооныг бий болгоход амжилттай хөшүүрэг болсон ба одоо тус улсад дахин хэрэглэж эхлээд байгаа (жишээ үзнэ үү) юм. Харин Номхон далайн өөр нэг улс Фижид энэ тогтолцоог 1997 онд нэвтрүүлснээс хойш шүүмжилсээр байна. Цаашилбал, 1919-1946 онд Австралийн Сенатын сонгуульд хэрэглэсэн туршлагаас харахад (32 дугаар хэсгийг үзнэ үү) олон мандаттай томсгосон тойрогт АСТ тохиромжгүй байна.

ПАПУА ШИНЭ ГВИНЕЙ: Сонгуулийн угсаатан хоорондын зохицолдоонд үзүүлэх нааштай нөлөө

Бен Райлли

Номхон далайн өмнөд хэсэгт орших Папуа Шинэ Гвиней) Улс хоёр өөр сонгуулийн тогтолцоо хэрэглэж ирсэн бөгөөд эдгээр нь 1964-1975 онд Австралийн нутаг дэвсгэрт байхдаа хэрэглэж байсан альтернатив саналын тогтолцоо (АСТ), 1975-2002 онд хэрэглэсэн харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ) хоёр юм. Үүнээс хойш АСТ-нд оо эргэж орсон байна.

Тус улсын туршлага хэд хэдэн шалтгаанаар сонирхолтой байдаг. Нэгдүгээрт, Папуа Шинэ Гвиней бол өрсөлдөөнт сонгууль тасралтгүй явуулж ирсэн амжилтаа алдаагүй, төр засгаа олон удаа энхийн замаар өөрчилж ирсэн хөгжиж байгаа цөөхөн орны нэг юм. Хоёрдугаарт, сонгуулийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих явцад урьдчилан төсөөлөөгүй цуврал үр дагавар гарсан нь бараг адилхан сонгуулийн тогтолцоонууд ч өөр өөр үр нөлөө үзүүлж болохыг харуулж байна. Гуравдугаарт, Папуа Шинэ Гвиней бол тодорхой нэг сонгуулийн тогтолцоог авч хэрэглэсэнээ болиод дараа нь түүнийг дахин авч хэрэглэсэн цөөхөн улсын нэг юм.

Папуа Шинэ Гвиней Улс АСТ-г Австралиас өвлөж авсан бөгөөд 1964, 1968, 1972 оны гурван сонгуульд хэрэглэжээ. Гэхдээ Австралиас ялгаатай нь Папуа Шинэ Гвиней нь олон жижиг үндэстэн угсаатантай улс бөгөөд 850 янзын хэлээр ярьдаг хэдэн мянган овог аймагтай байна.

Тус улсын туршлага нь АСТ нь сонгогчдод зөвхөн нэг хүнд санал өгөөд зогсохгүй, хоёр дахь, гурав дахь гэх мэтээр хэд хэдэн нэр дэвшигчийг дэмжиж саналаа илэрхийлэх боломж олгосноор хуваагдмал нийгэмд угсаатнууд хоорондоо зохицох хөшүүрэг болж, аядуу зөөлөн байдлыг хөхиүлэн дэмждэг гэсэн үзлийг нотолдог. Папуа Шинэ Гвиней Улсын нийгмийн онцлогоос үүдэн АСТ-оор сонгууль зохион байгуулахад ихэнх

сонгогчид эхний сонголтоороо өөрийн “нутгийн” нэр дэвшигчээ сонгох нь гарцаагүй. Гэхдээ нэр дэвшигчийн хувьд ялалт байгуулахын тулд эхний сонголтоор авсан санал нь хүрэлцэхгүй учраас өөр бусад сонгогчдын хоёр дахь сонголт хэрэг болдог. Иймээс нэр дэвшигч ялалт байгуулах боломжоо нэмэгдүүлэхийн тулд эдгээр бусад сонгогчдод хандан өөрийгөө “хоёр дахь” сонголт нь гэдгийг батлан харуулах шаардлагатай. Ингэснээр тухайн нэр дэвшигч зөвхөн өөрийн дэмжигчдийн бус бусад сонгогчдын эрх ашигт басхүү анхаарал тавих нөхцөл хангагдаж байна гэсэн үг. Үүнээс гадна, зөвхөн нутгийнхаа сонгогчдын саналаар ялах найдвар тавьж буй нэр дэвшигчийг бодвол холбоотон болж, хамтран ажиллаж байгаа нэр дэвшигчдийн хувьд ялах магадлал нь илүүтэй байдаг байна.

Энэ нь олон нэр дэвшигчийн хувьд угсаатны бусад бүлэгтэй харилцан зохицож хамтран ажиллах сонирхол төрүүлдэг. Энэ тогтолцоонд ялалт байгуулах нэр дэвшигч сонгогчдын үнэмлэхүй олонхийн санал авах ёстой агаад нэлээд олон бодит жишээнд дэмжигчдийн хамгийн том бааз суурьтай нэр дэвшигчид биш, харин сонгогчдын дэмжлэгийг хэд хэдэн бүлгийн хүрээнд амжилттай хүлээж чадсан нэр дэвшигчид ялж байв.

Папуа Шинэ Гвиней Улс 1975 онд тусгаар тогтнолоо олж авсны дараа АСТ-той ижил төстэй үр нөлөө үзүүлж болох арай энгийн хялбар тогтолцоо гэж үзэн ХОТ-нд шилжсэн байна. Гэвч ХОТ нь бодож байснаас нэлээд өөр үр дүн үзүүлсэн байдаг. Нэр дэвшигч сонгогдохын тулд үнэмлэхүй олонхийн санал авах шаардлагагүй болсон (зүгээр л бусдаас олон санал авах хэрэгтэй) учраас томоохон овог аймгаас гаралтай нэр дэвшигч шууд сонгогдох боломж нээгджээ. Үүнтэй холбоотой нэр дэвшигч хэн нэгэнтэй хамтран ажиллах сонирхол алга болов. Зарим нэр дэвшигч АСТ-нд байсан шиг хоёр дахь сонголт одоохын төлөө кампанит ажил явуулахын оронд өрсөлдөгчийнхөө дэмжигчдийг санал өгүүлэхгүй байх сонирхолтой байх болсон ба үүнтэй холбоотой сонгуулийн зөрчил нэмэгдэж эхэлсэн байна. Түүнчлэн маш олон бүлэг суудал авахын төлөө өрсөлдөж байгаа учраас дэмжигчдийнх нь хүрээ хязгаарлагдмал байсан ч гэсэн нэр дэвшигч амжилт олж болохоор нөхцөл бүрдсэн байв.

2002 оны сонгуулиар Парламентад суудал авсан гишүүдийн талаас илүү хувь нь 20 хүрэхгүй хувийн саналаар сонгогдсон байлаа. Хэд хэдэн нэр дэвшигч дөнгөж таван хувийн саналаар сонгуульд ялсан байв. Сонгуулийн явцад авлига, эрх мэдэл, мөнгөний асуудал улам бүр нэмэгдэх болсон ба сөрөг кампанит ажил явуулах олон янзын тактик төржээ. Тухайлбал, гол өрсөлдөгч нэр дэвшигчийн саналыг хуваах хүнийг сонгуульд зориуд оролцуулах гэх мэт. Энэ бүхэн нь АСТ-г дахин нэвтрүүлэх шахалт шаардлагыг нэмэгдүүлжээ. Ингээд 2003 онд Папуа Шинэ Гвинейн Парламент “хязгаарлагдмал” сонголтын (*limited preferential*) аргаар дараа

дараагийн сонгуулиа зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ тогтолцоогоор бол сонгогчид дор хаяж гурван нэр дэвшигчид санал өгөх шаардлагатай болжээ.

Папуа Шинэ Гвинейн туршлагаас харахад сонгуулийн тогтолцооны онолын хувьд үзүүлэх магадлалтай үр нөлөө нь амьдрал дээр тухайн нийгмийн бүтцээс ихээхэн хамааралтай байдгийг харуулж байна. Тухайлбал, ХОТ-той байсан боловч Папуа Шинэ Гвинейн намууд нь үзэл баримтлал гэхээсээ илүүтэй хувь хүмүүст тулгуурласан маш уян хатан институци байж иржээ. ХОТ-ны үед байгуулагдсан бүх засгийн газар нь сул дорой эвслийн засгийн газар байсан бөгөөд сонгуулиар солигдохоос гадна зарим үед парламентын шийдвэрээр ч өөрчлөгдөж байв. Парламентын гишүүд Порт Моресби дахь парламентын чуулгандаа суухын хажуугаар тойрогтоо байнга үзэгдэж харагдаад байж чадахгүй учраас нэг мандаттай тойргоор явагдах сонгуульд дахин сонгогдох боломж нь хязгаарлагдаж иржээ.

Үүнээс үүдэлтэй орон нутгаас сонгогдсон гишүүдийн хувьд тойргийнхоо сонгогчдын өмнө хариуцлага хүлээх сэтгэлгээ хүчтэй болж эхэлсэн бөгөөд ийм мэдрэмжгүй бол дахин сонгогдох магадлал хумигдах нь ойлгомжтой. Нөгөөтэйгүүр сонгосон гишүүнийх нь үйл ажиллагаа нутгийн ард иргэдэд шууд үр шимээ өгөхүйц байх ёстой буюу “томчууд” нь ард иргэдтэйгээ эд баялаг, сайн сайхан бүхнээ хуваалцаж байх ёстой гэсэн Меланези маягийн ёс заншил энэ улсад түгээмэл аж. Энэ талаар нэгэн парламентын гишүүн дурсан ярихдаа, “Хүмүүс намайг Парламентад сонгохдоо Папуа Шинэ Гвинейн Банкны эзэн болж байгаа юм шиг л боддог” гэсэн нь бий.

АСТ-нд бол энэхүү хариуцлага хүлээх асуудал цөөнгүй бүлгийн сонгогчдын хүрээнд яригдах учраас угсаатан хоорондын зөрчлийг эв зүйгээр зохицуулахад тус дөхөм болдог байна. Гэхдээ энэ байдал нь өөрөө нийгэм хэт хуваагдмал, тархай бутархай байгаагийн нэг илэрхийлэл болж байгааг анхаарах нь зүйтэй.

Хоёр шатлалт тогтолцоо (ХШТ)

95. Хоёр шатлалт тогтолцооны гол онцлог бол түүний нэрнээс харахад тодорхой байгаа юм. Энэ бол нэг удаагийн сонгууль биш, голдуу нэг эсвэл хоёр долоо хоногийн завсартай хоёр үе шаттай явагддаг сонгууль юм. Эхний шат нь нэг мандаттай тойрогт харьцангуй олонхийн тогтолцоогоор явагддаг сонгуультай адил. Ер нь ХШТ-ны хамгийн нийтлэг хэлбэр нь нэг мандаттай тойрогт ХОТ ашиглах явдал байдаг. Гэвч олон мандаттай тойрогт багц саналын (Кирибати шиг), эсвэл намын багц саналын (Мали шиг) тогтолцоо ашиглах нь ч бий. Эхний шатанд тодорхой тогтоосон хувь хэмжээний санал авсан нэр дэвшигч буюу нам хоёр дахь шатанд өрсөлдөлгүй шууд сонгогддог. Энэ хувь хэмжээ нь ихэнхдээ нийт хүчинтэй саналын үнэмлэхүй олонхи байдаг боловч хэд

Хоёр шатлалт тогтолцоо бол сонгуулийн эхний шатанд аль ч нэр дэвшигч буюу нам тогтоосон тооны санал авч чадаагүй буюу ихэвчлэн үнэмлэхүй олонхийн (50+1) санал авч чадаагүй бол хоёр дахь шатны сонгууль явуулдаг олонхи/дийлэнхийн тогтолцооны хувилбар юм. Хоёр шатлалт тогтолцоо нь нэг бол харьцангуй олонхийн тогтолцооны хэлбэртэй (хоёр дахь шатанд хоёроос дээш нэр дэвшигч өрсөлдөж хэн нэг нь үнэмлэхүй олонхийн санал авсан эсэхээс үл хамааран авсан санал нь өрсөлдөгчдөөсөө илүү бол ялалт байгуулдаг), эсвэл эхний шатнаас шалгарсан шилдгүүдийг хооронд нь халз өрсөлдүүлж олонхийн саналаар сонгох хэлбэртэй (эхний шатанд хамгийн өндөр санал авсан хоёр нэр дэвшигч хоёр дахь үед өрсөлддөг) байдаг.

хэдэн газар ерөнхийлөгчийн сонгуульд ХШТ ашиглахдаа өөр хувь хэмжээг зааж өгсөн нь бий (179 дүгээр хэсгийг үзнэ үү). Хэрэв аль ч нэр дэвшигч эсвэл нам үнэмлэхүй олонхийн санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалт явуулж ялагчийг тодруулдаг.

96. Практикт хоёр дахь шатны санал хураалтыг хэрхэн явуулах нь тухайн тохиолдол бүрт харилцан адилгүй байдаг. Хамгийн түгээмэл арга бол эхний шатанд хамгийн өндөр санал авч шалгарсан хоёр нэр дэвшигчийг халз өрсөлдөөнд уралдуулж, ялагчийг олонхийн саналаар тодруулах байдаг. Хоёр нэр дэвшигчийн хэн нэг нь үнэмлэхүй олонхийн санал авч ялагчаар тодрох нь гарцаагүй учраас энэ аргаар явуулсан сонгуулиас жинхэнэ

мажоритар үр дүн гардаг. Хоёр дахь арга буюу харьцангуй олонхийн ХШТ-г Францын хууль тогтоох байгууллагын сонгуульд ашигладаг. Ийм сонгуульд эхний шатанд нийт сонгогчдын 12,5 хувийн болон түүнээс дээш хувийнх нь саналыг авч чадсан бүх нэр дэвшигч дараагийн үед өрсөлдөж болдог. Хоёр дахь шатанд хэн нэг нь үнэмлэхүй олонхийн санал авсан, аваагүйгээс үл хамааран хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог. Халз өрсөлдөөнөөр ялагчийг тодруулах өмнөх хэлбэрээс ялгаатай нь ийм сонгуулийн хоёр дахь шатанд дээд тал нь таваас зургаан нэр дэвшигч өрсөлдөж болох учраас үнэмлэхүй олонхийн тогтолцоо биш юм.

97. Хоёр шатлалт тогтолцоог 22 улсын үндэсний хууль тогтоох байгууллагын сонгуульд ашигладаг бөгөөд ерөнхийлөгчийг шууд сонгох зорилгоор дэлхий дахинаа хамгийн түгээмэл хэрэглэдэг арга юм (178 дугаар хэсгийг үзнэ үү). Францаас гадна, ХШТ ашигладаг бусад орны дотор Францын харъяанд байсан нутаг дэвсгэрүүд, эсвэл ямар нэг байдлаар тус улсын түүхэн нөлөөнд орж байсан орнууд олон байдаг. Хууль тогтоох байгууллагын сонгуулийн хувьд ХШТ-г Африк тивийн Сахар орчмын бүсийн франц хэлтэй улсууд болох Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Конго, Габон, Мали, Мавритани, Того улсууд, Хойд Африкийн Египет Улс, мөн Коморын арлууд, Гайти, Иран, Кирибати, Вьетнам улсууд төдийгүй хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан зарим бүгд найрамдах улс (Беларусь, Киргизстан, Туркменистан, Узбекистан) хэрэглэдэг. Түүнчлэн Гүрж, Казахстан, Таджикистан гэх мэт цөөн хэдэн улс сонгуулийн холимог тогтолцооныхоо нэг хэсэг болгож ХШТ-г ашигладаг байна.

98. Давуу талууд

а. Юуны өмнө, ХШТ-нд сонгогч дэмжиж буй нэр дэвшигчийнхээ төлөө хоёр удаа санал өгөх боломжтой, тэр ч байтугай эхний ба хоёр дахь үеийн хооронд санал бодлоо өөрчлөх боломж нээлттэй. Иймээс энэ нь сонгогчид нэр дэвшигчдийнхээ эрэмбэ дарааллыг тогтоодог хувилбарт санал гэх мэт эрэмбэт саналын тогтолцооны зарим нийтлэг сайн талыг агуулахын зэрэгцээ сонгогч хэрвээ хүсвэл хоёр дахь шатанд цоо шинэ сонголт хийх боломж олгодог.

б. ХШТ нь эхний үед амжилттай оролцож хоёр дахь шатны сонгуульд өрсөлдөх гэж байгаа нэр дэвшигчдийн ард янз бүрийн ашиг сонирхол эвсэн нэгдэхэд түлхэц өгдөг бөгөөд улмаар намууд ба нэр дэвшигчид өөр хоорондоо тохиролцон, хамтран ажиллах хөшүүрэг болдог. Мөн эхний ба хоёр дахь шатны санал хураалтын хооронд гарч буй улс төрийн тавцанд гарсан өөрчлөлтийг харгалзан намууд, сонгогчдын зүгээс хариу үйлдэл үзүүлэх боломж бүрддэг ажээ.

в. Од тогтолцоонд түгээмэл тохиолддог “санал хуваах” үзэгдэл буюу хоорондоо төстэй хоёр нам, эсвэл, нэр дэвшигчид нэг тойрогт өрсөлдөн сонгогчдын саналыг хуваан авч, улмаар олон нийтэд төдийлөн сайн танигдаагүй нэр дэвшигч дундаас нь сугарч гарах боломжийг ХШТ бууруулдаг. Мөн сонгогч хоёр дахь шатанд сонголтоо илэрхийлэхдээ нэр дэвшигчдийг эрэмбэлж дугаарлах шаардлагагүй учраас энэ тогтолцоо нь альтернатив саналын эсвэл санал шилжүүлэх гэх мэт сонгогч

саналаа эрэмбэлэн дугаарладаг тогтолцоотой харьцуулахад бичиг үсэг тайлагдаагүй хүн ам олонтой улс орнуудад илүү тохиромжтой байж болох юм.

99. Сул талууд

а. ХШТ-нд эхний шатны сонгуулийн дараа хэдхэн хоногийн зайтай хоёр дахь шатны сонгууль явуулах учир сонгуулийг зохион байгуулах үүрэг хүлээсэн байгууллагад нэлээд дарамт учруулдаг ба зохион байгуулалтын зардал ч өндөр байна. Түүнчлэн санал хураах, сонгуулийн дүнг зарлах хооронд нэлээд хугацаа шаардагддагтай холбоотой нийгэмд тогтворгүй, тодорхойгүй нөхцөл байдал үүсч болох талтай. Мөн дахин дахин санал өгөх нь сонгогчдод түвэгтэй санагдаж болох бөгөөд үүнээс үүдэн заримдаа нэг болон хоёрдугаар шатны хооронд сонгогчдын ирц огцом буурдаг байна.

б. ХШТ нь ХОТ-ны олон сул талыг давхар агуулдаг. Судалгаанаас үзэхэд, Франц Улсад энэ тогтолцоо барууны аль ч ардчилсан орныхоос илүү тэнцвэртэй бус үр дүн үзүүлдэг бөгөөд шинээр ардчилал тогтоосон орнуудын намын системийг сулруулж бутлах нөлөө ч ажиглагддаг ажээ.

в. ХШТ-той холбоотой яригдах учиртай хамгийн ноцтой асуудал бол нэгдмэл бус нийгэмд үзүүлдэг таагүй нөлөө нь юм. 1992 онд Анголд энхийг тогтоох үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой сонгууль явагдаж байлаа. ХШТ-оор явуулсан ерөнхийлөгчийн сонгуулийн эхний үед босогчдын удирдагч Жонас Савимби 40 хувийн санал авч, 49 хувийн санал авсан Жозе дос Сантосын дараа хоёрдугаарт бичигдэн гарч иржээ. Тэрээр хоёр дахь халз өрсөлдөөний үед ялагдах нь тодорхой болсон учраас түүнд ардчилсан сөрөг хүчний дүрд тоглох сонирхол байсангүй. Ингээд тэр дороо Анголд иргэний дайны гал дахин асч арван жилийн турш намдаагүй үргэлжилсэн юм. 1993 онд Конгод ХШТ-оор явуулсан сонгуулийн хоёр дахь шатанд засгийн газрын тал илт дийлэнх олонхийн саналаар ялах төлөвтэй байсан учраас сөрөг хүчин сонгуулийн хоёр дахь шатыг эсэргүүцэж зэвсэгт тэмцэлд шилжсэн байна. Дээрх хоёр жишээнд, сонгуульд ялагдах нь тодорхой болсон нь өрсөлдөгч тал хүчирхийллийг өдөөх шалтаг болсон байна. 1992 онд Алжирт болсон сонгуулийн эхний шатанд Исламын Авралын Фронт (*Front Islamique du Salut* буюу ИАФ)-оос нэр дэвшигч тэргүүлээд ирмэгц цэргийнхэн хөндлөнгөөс оролцож сонгуулийн хоёр дахь шатыг явуулахыг зогсоожээ.

КИРГИЗСТАН: Төв Азид сонгуулийг хэрхэн гуйвуулдаг жишээ

Еоген Хаский

Өнөө үед Төв Азид явагдаж байгаа сонгуулиудыг нэг талаар засгийн эрхийн төлөө өрсөлдөөн нөгөө талаар улс төрийн жүжиг гэж болно. 1991 оны сүүлээр Зөвлөлт Холбоот Улс задран унасны дараа тус бүс нутгийн ихэнх орнууд нэг хүний авторитар дэглэмд, эсвэл иргэний дайнд шилжсэн юм. Зөвлөлтийн дэглэмийн сүүлийн саруудад явагдсан хагас өрсөлдөөнт сонгуулиуд тусгаар тогтнолын эхний жилүүдэд ард иргэдийн талархлыг жинхэнэ ёсоор хүлээсэн сонгуулиудаар солигдсон ч улс төрийн эрх мэдэл аажмаар бүгд найрамдах улсуудыг үүсгэн байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн цөөн хүний гарт төвлөрөх болсон ажгуу. Нэг хэсэгтээ Киргизстан улс авторитар дэглэм тогтоох оролдлогыг эсэргүүцэж магадгүй бололтой харагдаж байлаа. Гэтэл 1990-ээд оны дунд үе гэхэд тус улсын ерөнхийлөгч ард иргэдийнхээ төр засагтай хариуцлага тооцох боломжийг хязгаарлаж эхэлсэн юм.

Тус улсын анхны бөгөөд цорын ганц ерөнхийлөгч Аскар Акаевыг засгийн эрхэнд гаргасан сонгуулиас үзэхэд сонгуулийг зохион байгуулах дүрмийг яльгүй өөрчлөх нь сонгуулийн үр дүнг тодорхойлоход ямар их үүрэгтэйг харуулж байна. Зөвлөлтийн эриний төгсгөл үед шинэ бүгд найрамдах улсуудын парламент нь төрийн тэргүүн буюу Төрийн зөвлөлийн даргаа сонгосон юм. Киргизстан улсын сонгуулийн хуульд хэрэв парламент нь хоёр шаттай санал хураалтын дараа ялагч тодруулж чадахгүй бол бүх нэр дэвшигч хасагдана гэж заасан байв. Сонгуулийн дүрмийн энэ эгзэгтэй сонин заалт 1990 оны 10 дугаар сард болсон БН Киргиз улсын төрийн тэргүүнийг сонгох санал хураалтын хоёр дахь шатанд ялах боломжийг Акаевт (нэг их нөлөөтэй гэж тооцоогүй Горбачёвийн үнэнч дэмжигч байсан энэ хүн Киргизийн Коммунист Намын эрх баригч хуучинсаг

хүчинтэй өрсөлдсөн байна) олгожээ. Дараагийн жил нь Киргизстан Улс Зөвлөлтийн ихэнх бусад бүгд найрамдах улсын нэг адилаар задран унаж буй Коммунист намынхаа удирдагчдын оронд төрийн эрх барих үүрэгтэй ерөнхийлөгчийн албыг шинээр байгуулж, түүнийг сонгох бүх нийтийн шууд сонгуулийг нэвтрүүлсэн байна. Ингээд Киргизстан Улс тусгаар тогтносон улс болохоос хэдхэн долоо хоногийн өмнө буюу 1991 оны 10 дугаар сард болсон ерөнхийлөгчийн сонгуульд Акаев өрсөлдөгчгүйгээр ялалт байгуулжээ. Тэрбээр дараа дараагийн ерөнхийлөгчийн сонгуульд хоёр удаа дараалан (1995 оны 12 дугаар сар, 2000 оны 10 дугаар сард) эхний шатанд илт давуу ялсан хэдий ч эдгээр сонгуулиудын явцад хууль зөрчих явдал газар авсан талаар мэдээлж байв.

Киргизстаны ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, дүрэм журам нь хэвшсэн уламжлал болон хэвшмэл бус шинэ элементийн аль алийг агуулсан байв. Сонгуулийг таван жил тутамд явуулж, хоёр шатлалт тогтолцоогоор ялагчийг тодруулдаг. Хэрэв эхний шатанд аль ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авахгүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч дараагийн үед өрсөлдөх ба хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялалт байгуулна. Сонгуулийн эхний болон хоёр дахь шатны аль нэгэнд сонгогчдын ирц тавиас доош хувьтай байвал сонгуулийг шинээр зарлах ёстой. Ерөнхийлөгч хоёроос илүү удаа сонгогдож болохгүй боловч Киргизстаны Үндсэн хуулийн шүүх нь эрх барьж буй ерөнхийлөгчид зориулсан онцгой тайлбар хийж, ерөнхийлөгчийн эхний бүрэн эрхийн хугацаа нь 1993 онд батлагдсан Үндсэн хуульд хоёр бүрэн эрхийн хугацааны хязгаарлалт оруулахаас өмнө эхэлсэн учраас эхнийхийг нь тооцохгүй гэсэн шийдвэр гаргасан байна.

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигч 35-аас доошгүй, 65-аас дээшгүй настай байх ёстой. Мөн нэр дэвшигчид бусад хэд хэдэн шаардлагыг хангасан байх ёстой. Нэгдүгээрт, тэд Хэлний зөвлөлийн шалгалтад орж, төрийн хэл болох Киргиз хэлийг төгс эзэмшсэн болохоо харуулах ёстой. Энэ нь оросууд болон оросжсон киргизүүдийг ерөнхийлөгчид өрсөлдөх боломжийг хаасан шаардлага бөгөөд 2000 оны сонгуульд энэ шаардлагыг ашиглаж Акаевын эсрэг хамгийн нэртэй өрсөлдөгч Феликс Куловыг нэр дэвшигчээс хассан байна. Хоёрдугаарт, нэр дэвшигчид хувийн хөрөнгөнөөсөө сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1000 дахин нэмсэнтэй тэнцэх дэнчин төлөх ёстой нь үнэн хэрэгтээ ядуу хүний бүх насаараа олох орлоготой тэнцэхээр мөнгө юм. Дэнчингээ буцааж авахын тулд нэр дэвшигч 10 хувийн санал авсан байх ёстой бөгөөд энэ саналыг одоо Парламентаар хэлэлцэж 15 хувь болгох эсэх талаар маргалдаж байна. Нэр дэвшихэд тавигддаг өөр нэг хаалт саад нь нэр дэвшигч 50,000 гарын үсэг цуглуулсан байх, түүнийхээ дор хаяж

гурван хувийг тус улсын найман бүс нутгаас цуглуулсан байх шаардлага юм. Энэ заалт нь ерөнхийлөгч тус улсын өмнөд ба хойд хэсгийн хоёулангаас хангалттай дэмжлэг авсан байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд сүүлийн жилүүдэд өмнөд ба хойд хэсгийн элитүүд өөр хоорондоо зөрчилтэй байгаатай холбоотой.

Киргизстаны ерөнхийлөгчийн сонгууль явуулах дүрэм журам харьцангуй тогтвортой байсан бол парламентын сонгуулийн тогтолцоонд нь байнга өөрчлөлт орж байв. Магадгүй хамгийн эрс өөрчлөлтийн нэг нь парламентын суудлын тоо, бүтцэд орсон өөрчлөлт юм. Тусгаар тогтносон Киргизстан Улс 350 депутат бүхий нэг танхимтай парламентыг Зөвлөлтийн үеэс өвлөж авсан бөгөөд хамгийн сүүлд 1990 оны хоёрдугаар сард болсон сонгуулийг нэг мандаттай тойргуудад хоёр шатлалт тогтолцоогоор зохион байгуулсан байна. 1994 онд бүх нийтийн санал асуулгаар (ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийг нэмэгдүүлж, парламентын хүч нөлөөг багасгахын тулд хэрэглэх дуртай байсан арга) Үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар нэг танхимт парламентыг хоёр танхимтай болгон өөрчилжээ. Тодруулбал, Хууль тогтоох ассамблей 60 гишүүн, Ард түмний төлөөлөгчдийн ассамблей 45 гишүүнтэй болсон байна. 1995 оны хоёрдугаар сар, 2000 оны хоёрдугаар сард явагдсан парламентын сонгуулиар Ард түмний төлөөлөгчдийн ассамблейн бүх гишүүн, Хууль тогтоох ассамблейн 45 гишүүнийг нэг мандаттай 45 тойргоос хоёр шатлалт саналын тогтолцоо ашиглан сонгосон байна. Хууль тогтоох ассамблейн үлдсэн 15 гишүүнийг ЖХТТ-оор сонгож, ингэхдээ улс нь нэг тойрог болж хаалттай жагсаалтаар, таван хувийн албан ёсны босготойгоор сонгууль явуулсан байна. Өөрөөр хэлбэл, намууд Парламентад төлөөлөлтэй болохын тулд үндэсний хэмжээний нийт саналын дор хаяж таван хувийг авах ёстой байв. ХТТ-оор хуваарилсан 15 суудлын хувьд нам бүр 30 хүнтэй нэр дэвшигчдийн жагсаалт гаргах эрхтэй бөгөөд хэрвээ уг жагсаалтад орсон нэр дэвшигч нэг мандаттай тойргуудад өрсөлдөөд ялсан тохиолдолд намын жагсаалтаас нэрийг нь хасч байв.

Депутатуудын тоог 350-аас 150 болгож бууруулсан нь зардал хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ мэт харагдаж байгаа боловч үнэн хэрэгтээ нэг мандаттай тойргуудын тоог гурав дахин нэмэгдүүлж, жижиг намууд суудал авах боломжийг багасгах замаар ерөнхийлөгчийн парламентад тавих хяналтыг хялбар дөхөм болгосон хэрэг байв. Шинэ Парламентад цөөн тооны ЖХТТ-оор хуваарилсан суудал бий болсон нь жижиг намуудад цөөхөн суудал ногдох сул талыг өчүүхэн төдий л нөхсөн байна.

Цаашилбал, коммунист тогтолцооны дараах сонгуулиуд нь автоматаар гар өргөн хууль гаргадаг нэг хэвэнд цутгасан юм шиг Зөвлөлтийн үеийн байгууллагуудаас бүтэц, бүрэлдэхүүний хувьд эрс ялгаатай парламентуудыг бий болгосон. Коммунист намаас нэр дэвшигчдийг хянах механизм нь

эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр дамжин хэрэгждэг байсан ба үр дүнд нь бий болсон байгууллагад нийгмийн янз бүрийн хүрээний хүмүүс багтаж байжээ. Үүнтэй харьцуулахад коммунизмын дараах Киргизстаны парламент нь бараг бүхэлдээ эрэгтэйчүүдээс, тэр дундаа асар олон тооны удирдах албан тушаалтнууд ба шинэ баячуудаас бүрдэж байв.

Саяхнаас Киргизстан Улс парламентын сонгуулийн хуулиа дахин өөрчилсөн байна. 2003 оны хоёрдугаар сард явуулсан бүх нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу одоогийн 105 суудалтай хоёр танхимт ассамблейг дараагийн сонгуулиас эхлэн 75 суудалтай нэг танхимт хууль тогтоох байгууллага болгон өөрчлөхөөр болжээ. Гадаад, дотоодод ихээхэн шүүмжлэлд өртсөөр байгаа 2004 оны нэгдүгээр сард баталсан сонгуулийн хуулиар 75 депутатыг нэг мандаттай тойргоос сонгохдоо хоёр шатлалт тогтолцоо хэрэглэх тухай заасан байна. Ассамблейн суудлыг тоог дахин цөөлж, намын жагсаалтаар хуваарилах суудлуудыг байхгүй болгож байгаа нь мөн л цөөнхийн төлөөллийг шахан багасгах, гүйцэтгэх засаглалаас хууль тогтоох байгууллагад үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх, аль хэдийн сулдаж доройтсон намын тогтолцоог улам сулруулах сөрөг үр дагавар авчрах магадлалтай. Мөн намын төв байгууллагын лидерүүдийн зүгээс нэр дэвшигчдийн сонголтод нөлөөлөх боломжийг хязгаарлан бүс нутгуудын улс төрийн онцлогийг улам тодотгож өгөх талтай байж болох юм.

Парламент цөөн тооны суудалтай болж сонгуулийн тойргуудын хэмжээ томорсны улмаас Киргиз үндэстний хувьд сонгуульд ялалт байгуулах боломж үндэсний цөөнхийг бодвол илүү хялбар болжээ. Одоогоор тус улсын Парламентад Киргизүүд бусдаас давуу төлөөлөлтэй байхад Узбек, Орос, Герман гаралтай үндэстний цөөнхийн хувьд маш цөөн төлөөлөлтэй байгаа юм. Тухайлбал, Узбекчүүд нийт хүн амд эзлэх хувийнхаа талд нь ч хүрэхгүй хувийн суудал авсан байна.

Сүүлийн жилүүдэд Киргизстанд Улс төрийн сөрөг хүчнийхэн ерөнхийлөгчийн болон парламентын сонгуульд өрсөлдөхөд янз бүрийн бэрхшээлтэй тулгарах болжээ. Шүүх, Сонгуулийн хороо, Хэлний зөвлөл нь ерөнхийлөгчөөс хараат ажилладагтай холбоотой сонгуульд нэр дэвшигчдэд ялгавартайгаар ял тулгах, эсвэл нэр дэвшигчийн жагсаалтаас хасах үзэгдэл гарах болсон байна. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ерөнхийлөгчийн нөлөөнд байдгаас үүдэлтэй сөрөг хүчний нэр дэвшигчид кампанит ажлаа үр нөлөөтэй явуулахад хүндрэл учирдаг ажээ. Жишээлбэл, 2000 оны ерөнхийлөгчийн сонгуулиар Ерөнхийлөгч Акаев үндэсний телевизийн КТР сувгаар бараг арван цагийн нэвтрүүлэг явуулсан бол түүний гол өрсөлдөгчдөд тав хүрэхгүй минутын эрх олдсон байна. Сонгуулийн кампанит ажлын талаар хараат бусаар мэдээлдэг

цөөн эх сурвалжуудын нэг болох гадаадын нэгэн сониныг эрх баригчдын нэр дэвшигчдийг шүүмжилбэл хуулийн хариуцлага хүлээлгэнэ гэж сүрдүүлсэн явдал гарчээ. Санал хураалтын явцад ч олон тооны зөрчил гарсан байдаг. Сонгуулийг зохион байгуулж буй байдал, сонгуулийн хууль, журамд оруулж ирсэн өөрчлөлт нь Киргизстанд Улс төрийн эрүүл саруул өрсөлдөөн хөгжихөд саад учруулсаар өнөөг хүрчээ.

Тусгаар тогтносноос хойших эхний арван жилд орон нутгийн төлөөлөгчдийн хурлыг ихэнх сонгуулийг нэг мандаттай тойргуудад хоёр шатлалт тогтолцоогоор явуулсан байна. Харин 1999 оноос хойш мужийн болон орон нутгийн хурлын сонгуулиудыг олон мандаттай тойрог бүхий СҮШТ-оор явуулж эхэлжээ. Хэдийгээр тус улсын долоон мужийн захирагчийг ерөнхийлөгч томилсон хэвээр байгаа боловч хот, дүүрэг, тосгодын дарга нарыг орон нутгийн хурлын гишүүдээс шууд сонгож байна. Энэ хэв шинжээс гажсан цорын ганц практик бол тус улсын нийслэл Бишкек хотын захирагчийг иргэд шууд сонгодог явдал юм.

Гүрж, Украинд тохиолдсонтой адил сонгуулийн дүрэм журмыг гүйвуулж, сонгуулийн үйл ажиллагааг санаан зоргоороо будлиулж байсан нь эцэстээ сонгуулийн хууль ёсны байдлыг алдагдуулж, улмаар 2005 оны гуравдугаар сарын 24-ний өдөр Киргизстанд хувьсгал гарахад хүргэсэн. Энэхүү хувьсгалаар ерөнхийлөгч Акаевийг суудлаас нь буулгаж, шинээр сонгогдсон парламентад төрийн эрх мэдлийг олгосноос гадна сонгуулийн тогтолцоог бүхэлд нь эргэн харж, үнэлэх болжээ.

Хувь тэнцүүлсэн тогтолцоо

Хувь тэнцүүлсэн тогтолцоо гэж юу вэ?

100. Хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХТТ)-ны зорилго нь бүх нийтийн сонгуульд намын авсан саналыг хууль тогтоох байгууллагад эзлэх суудлын хувьд зориуд тэнцвэртэйгээр хөрвүүлж шилжүүлэх явдал юм. Ерөнхийдөө намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ), санал шилжүүлэх тогтолцоо (СШТ) гэсэн ХТТ-ны хоёр гол хувилбар байдаг. ХТТ-нд сонгуулийг заавал нэгээс дээш мандаттай тойрогт зохион байгуулна. Учир нь нэг мандаттай тойргын ганц суудлыг хувь тэнцүүлэн хуваарилах боломжгүй. Израиль, Нидерланд зэрэг зарим оронд улс нь бүхэлдээ сонгуулийн олон мандаттай нэг тойрог болдог байна. Бусад оронд тухайлбал, Аргентин, Португалд тосгон сууриндаа тулгуурлан сонгуулийн тойрог байгуулдаг бол, Индонезид сонгуулийн тойргуудыг байгуулах үүргийг Сонгуулийн төв байгууллага нь хариуцдаг аж.

101. ХТТ нь ардчилалд шинээр шилжиж буй олон орны нийтлэг сонголт байдаг бөгөөд ардчилал тогтсон 23 оронд ХТТ-ны аль нэг хувилбарыг хэрэглэж (Хүснэгт 2-ыг үзнэ үү) байна. ХТТ-г Латин Америк, Африк, Европт зонхилон хэрэглэдэг. Энэхүү гарын авлагыг бүтээх явцад судалсан 72 ХТТ-ны олонхид ЖХТ хувилбарын зарим хэлбэрийг, зөвхөн хоёр нь СШ хувилбарыг хэрэглэдэг байна.

102. ХТТ үр дүнтэй хэрэгжихэд нөлөө үзүүлж болох олон чухал асуудал байдаг. Тойргийн мандатын тоо хэдийчинээ олон байх тусам (тойргийн хэмжээний талаар 113-118 дугаар хэсгийг үзнэ үү)

Хувь тэнцүүлсэн тогтолцоо нь сонгуулийг нэгээс дээш мандаттай тойрогт зохион байгуулахыг шаардана.

сонгуулиас гарах үр дүн нь төдий чинээ хувь тэнцүү байх болно. ХТТ-ны хувилбарууд нь сонгогчдын саналаа ямар байдлаар илэрхийлж байгаагаар буюу сонгогч зөвхөн улс төрийн намуудаас, нэр дэвшигч хувь хүмүүсээс, эсвэл хоёулангаас нь сонголт хийж боломжтой эсэхээрээ ялгардаг.

103. *Давуу талууд.* Олон талаас нь авч үзэхэд ХТТ-г дэмждэг хамгийн хүчтэй үндэслэл бол уг тогтолцоо харьцангуй олонхийн тогтолцоонд гардаг гаж үр дүнгээс зайлсхийж, хууль тогтоох байгууллагын төлөөллийг илүү чанартай, тэнцвэртэй болгох нөлөө үзүүлдэг явдал юм. Шинээр ардчилал тогтоосон олон орон, ялангуяа нийгэм нь гүнзгий хуваагдсан орнуудад хууль тогтоох байгууллагадаа нийгмийн нөлөө

бүхий бүлгүүдийн төлөөллийг тэнцвэртэй оруулах нь ардчилсан нэгдэл нягтралын салшгүй чухал нэг нөхцөл байж болно. Харин хөгжиж буй улс төрийн тогтолцоонд олонхи ба цөөнхийн аль алинд нь оролцох боломжтой байх нөхцөлийг бүрдүүлж чадахгүй бол аюултай үр дагавартай тулгарч болдог (Лесотогийн жишээг үзнэ үү).

104. Ерөнхийдөө дараах онцлогуудыг үндэслэн ХТТ-г сайшаадаг. Үүнд:

а. Сонгогчдын өгсөн саналыг нам, нэр дэвшигчдийн авах суудлын тоонд шударгаар хуваарилдаг, ингэснээр ОД тогтолцоонд гардаг зарим сөрөг, нийгэмд тогтворгүй байдал үүсгэх эрсдэл дагуулдаг шударга бус үр дүнгээс зайлсхийх боломж олгоно. Томоохон намуудын хүртдэг “бонус суудал”-ыг аль болох багасгах ба жижиг намууд цөөн тооны санал авсан ч хууль тогтоох байгууллагад суудал авах боломжтой.

б. Ижил үзэл бодолтой иргэд нэгдэн зохион байгуулалтад орж улс төрийн нам байгуулах буюу өөр хэлбэрийн бүлэг үүсгэн, улмаар нэр дэвшигчдийн жагсаалт гарган сонгуульд өрсөлдөхийг дэмждэг буюу шаарддаг. Энэ нь ялангуяа Зүүн Тимор дөнгөж тусгаар тогтноод байсан үеийнх шиг улс төрийн намын тогтолцоо төлөвшөөгүй буюу огт байхгүй нөхцөлд нийгмийн доторх бодлого, үзэл баримтлал эсвэл манлайллын ялгааг тодорхой болгож өгөх сайн талтай.

в. Маш цөөхөн санал хоосон үрэгддэг. Саналын босго доогуур үед ХТТ-оор явуулсан сонгуульд сонгогчдын өгсөн бараг бүх санал нэр дэвшигчийг сонгогдоход нөлөө үзүүлдэг. Сонгогч өөрийнх нь санал сонгуулийн үр дүнд бага ч болов нөлөөтэй гэдэгт илүү итгэх ба улмаар энэ нь сонгуульд оролцох иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх сайн хөшүүрэг болдог ажээ.

г. Цөөнх парламентад төлөөлөлтэй болоход тус дөхөм үзүүлдэг. Саналын босго хэт өндөр бус, мөн тойргийн цар хүрээ хэтэрхий жижиг биш л бол бага хэмжээний санал авсан улс төрийн нам хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болох үүд хаалга нээлттэй. Тэнцвэртэй төлөөллийг хангах энэхүү шинж нь хуваагдмал нийгмийн тогтвортой байдалд шийдвэрлэх ач холбогдолтой төдийгүй ардчилал тогтсон орнуудад ч зөв оновчтой шийдвэр гаргах үйл явцад ашиг тусаа өгдөг.

д. Намууд баттай дэмжлэг хүлээх боломжтой гэсэн тойргуудаас гадна бусад тойргийн сонгогчдод хандсан кампанит ажил явуулах хөшүүрэг

болдог. ХТТ-ны мөн чанараас үүдэлтэй намуудын хувьд хаанаас санал авах нь чухал биш, харин нийт авах саналынхаа тоог аль болох ихэсгэх сонирхолтой байна. Сонгогчдын өгөх санал бүр, үүнд тухайн нам дэмжлэг хүлээх магадлал тун бага байгаа тойргоос авсан ганц санал хүртэл суудал хуваарилах тооцоонд нэмэр болдог.

е. Жалга довны ноёрхлыг хязгаарладаг. ХТТ нь цөөн суудалтай жижиг намуудад ашигтай байдаг ба тодорхой нэг муж, сонгуулийн тойрогт ганц нам бүх суудлыг авах магадлал бага байна. Энэ нь тодорхой бүс нутагт төвлөрөн суурьшаагүй, эрх мэдэлд хүрэх боломж нь хязгаарлагдмал цөөнхийн хувьд ашиг тустай тогтолцоо юм.

ё. Бодлогын залгамж чанар, тогтвортой байдалд сайн нөлөөтэй. Баруун Европын туршлагаас үзэхэд парламентын сонгуулийг ХТТ-оор зохион байгуулах нь төр, засгийн тэсвэртэй оршин тогтнох чадвар, сонгогчдын оролцоо, эдийн засгийн байдалд эерэгээр нөлөөлөх тал дээрээ илүү өндөр оноо авдаг байна. Энэ нь харьцангуй олонхийн тогтолцоонд үзэл баримтлалын хувьд эрс тэс ялгаатай намууд засгийн эрх ээлжлэн барьж эдийн засгийн хөгжлийг урт хугацаанд төлөвлөн хангахад хүндрэл учруулдаг бол ХТТ-ны үр дүнд бий болсон эвслийн засгийн газрууд нь бодлогын тогтвортой байдал, уялдаа холбоог хангаж, улмаар үндэсний хөгжилд түлхэц өгдөг гэж үздэгтэй холбоотой.

ж. Намууд ба сонирхлын бүлгүүдийн эрх мэдлийн хуваарилалтыг илүү нүдэнд ил болгодог. Шинээр ардчилал тогтоосон улс оронд улс төрийн эрх мэдлийг барьж буй олонхи ба эдийн засгийн эрх мэдлийг барьж буй цөөнхийн хооронд эрх мэдлийг хуваарилах асуудал зайлшгүй тавигддаг. Олонхийн ашиг сонирхол хууль тогтоох байгууллагад ноёрхож, цөөнх нь эдийн засгийг хянаж байгаа тохиолдолд энэхүү өөр өөр эрх мэдлийн бүлэглэлийн хоорондох яриа хэлэлцээр нүднээс далд, ил тод бус явагддаг байна (тухайлбал, Зимбабве Улсад тусгаар тогтносноос нь хойш 20 жилийн турш ийм байсан). ХТТ нь бүхий л ашиг сонирхлыг хууль тогтоох байгууллагад нэгтгэн оруулж өгснөөрөө аливаа шийдвэр олон түмний нүдэн дээр ил гарч, нийгмийн янз бүрийн бүлгийн оролцоог илүүтэй тусгах давуу талтай гэж үзсээр ирсэн байна.

105. *Сул талууд.* Ерөнхийдөө ХТТ-ны тухай ихэнх шүүмжлэл нь эвслийн засгийн газар байгуулагдах, олон жижиг нам бий болгох хандлагатай холбоотой. ХТТ-г шүүмжилдэг үндэслэл нь:

а. Эвслийн засгийн газар хууль тогтоох байгууллагыг гацаанд оруулж, улмаар тууштай бодлого явуулж чадахгүйд хүргэдэг. Нэн ялангуяа зөрчил мөргөлдөөний дараах шилжилт явагдаж, шинэ засгаас хүмүүс ихийг хүсэн хүлээж байгаа үед эрсдэл ихтэй байна. Жигүүр, бүлгүүдээс бүрдсэн эвслийн болон үндэсний эв нэгдлийн засгийн газрууд нь түргэн шуурхай, нийцтэй шийдвэр гаргах чадавхаар дутах нь олонтаа.

б. Намын системийн тогтвортой байдал алдагдаж, олон хэсэгт задрахад хүргэдэг. ХТТ нь намын системийн тархай бутархай байдлын тусгал болж улам задлах нөлөөтэй. Хэт олон ургальч үзэл нь өчүүхэн жижиг намууд хүртэл эвслийн хэлэлцээрт орж том намуудтай наймаалцах боломж олгодог. Энэ үүднээсээ ХТТ-ны улс төрийн оролцоог хүртээмжтэй болгодог чанар нь нэг дутагдалд тооцогддог. Жишээлбэл, Израиль Улсад шашны хэт даврагч үзэлтэй намууд засгийн газар бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй байж ирсэн бол, Итали олон жилийн турш эвслийн засгийн газрын тогтворгүй шилжилтийн үеийг туулсан юм. Ардчилал дөнгөж тогтоогоод байгаа орнуудад улс төрийн намын тогтолцоо хөгжөөгүй байгаа үед нь ХТТ-г нэвтрүүлбэл хувь хүнд тулгуурласан, эсвэл үндэсний салан тусгаарлалтад чиглэсэн намууд үүсч хөгжинө гэж эмээн болгоомжлох нь бий.

в. Хэт туйлширсан үзэлтэй намууд ашиглах бололцоотой. Тухайлбал, ХТТ зүүний, эсвэл барууны хэт туйлширсан үзэлтэй намуудад хууль тогтоох байгууллагад орох боломж олгодог гэж шүүмжилдэг. Ваймарын Герман Улс задран унасан нь ХТТ хэт барууны ба зүүний туйлширсан үзэлтэй бүлгүүд өсч өндийх боломж олгосонтой зарим талаар холбоотой гэж үзэх нь бий.

г. Бодлогын хувьд ялгаатай, сонгогч дэмжигчид нь ч харилцан адилгүй намууд эвсэхээс өөр гарцгүй байдалд хүргэдэг. Иймэрхүү ашиг сонирхлоор нэгдсэн эвсэл нь альтернатив саналын гэх мэт бусад тогтолцоогоор сонгууль явуулахад үүссэн эвсэлтэй харьцуулахад хэврэг, тогтворгүй байх талтай. Тодруулбал, альтернатив саналын тогтолцоонд намууд сонгуульд ялах эсэх нь өөрсдийнх нь дэмжигчдээс гадна бусад сонгогчдын саналаас хамаарах хандлагатай байдаг учраас тэдний эвсэл илүү хүчтэй байх хандлагатай.

д. Жижиг намууд хэтэрхий их эрх мэдэлтэй болоход хүргэдэг. Томоохон намууд харьцангуй жижиг намуудтай эвсэл байгуулахаас өөр замгүй болдгоос том намуудын дэвшүүлсэн аливаа саналд сонгогчдын өчүүхэн бага хувийн дэмжлэг авсан жижиг нам хориг тавих эрх мэдэл олж авдаг байна.

е. Сонгогчдын хувьд аль нэг намыг засгийн эрхнээс буулгаж хариуцлага тооцох чадваргүй болдог. ХТТ-той үед жижиг биш, төвийг баримтлагч намыг засгийн эрхээс буулгахад маш хэцүү байх болно. Засгийн газрууд ихэвчлэн эвслийн хэлбэртэй байх тул улстөрийн зарим нам үе үе сонгуульд тааруухан амжилт үзүүлдэг ч гэсэн байнга засгийн газрын бүрэлдэхүүнд багтаж чаддаг. Тухайлбал, Германы Чөлөөт Ардчилсан Нам (ЧАН) хэзээ ч нийт саналын 12-оос дээш хувийг авч байгаагүй боловч 1948-1998 оны хоорондох 50 жилийн хугацаанд эрх барьсан найман эвслийн бараг бүгдийнх нь бүрэлдэхүүнд багтаж байв.

ё. Нарийн түвэгтэй дүрэм журам нь сонгогчид ойлгоход бэрхшээлтэй төдийгүй зарим үед сонгуулийн хороод ойлгож хэрэгжүүлэхэд ч хүндрэлтэй байдаг. ХТТ-ны зарим хувилбар хэрэгжүүлэхэд хамгийн хүндрэлтэй тогтолцоонд тооцогддог бөгөөд сонгуулийг амжилттай зохион байгуулахын тулд сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, санал хураах байранд ажиллагсдыг сургалтад хамруулах шаардлага гарна.


Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ)

Энэ тогтолцооны үед нам, эвсэл, бүлгүүд олон мандаттай тойрогт нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж өрсөлдөнө. Сонгогчид намд саналаа өгөх бөгөөд нийт хүчинтэй саналаас нам хэдий хэмжээний санал авсан байна төдий тооны суудлыг хувь тэнцүүлж авдаг. Зарим (хаалттай жагсаалттай) тогтолцоонд нэр дэвшигчдэд намын жагсаалтад орсон дарааллын дагуу мандат олгодог. Харин “нээлттэй” буюу “чөлөөт” жагсаалтаар санал хураах үед сонгогчдын санал нэр дэвшигчдийн суудал авах дараалалд нөлөөлөх боломжтой.

106. Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ)-ны хамгийн энгийн хэлбэр нь намууд олон мандаттай тойрогт нэр дэвшүүлж буй хүмүүсийнхээ жагсаалтыг танилцуулж өрсөлддөг. Сонгогчид аль нэг намын төлөө саналаа өгөх ба намууд тухайн сонгуулийн тойрогт авсан саналынхаа хувьтай тэнцүү суудал авна. Нэр дэвшигчдийг намын жагсаалтад орсон дарааллын дагуу ялагчаар тодруулдаг.

ЖХТТ-г сонгож авснаар бүх асуудал амар шийдэгдэхгүй бөгөөд зарим нарийн ширийн элементэд нь нухацтай хандах шаардлагатай. Саналыг тоолж нэгтгэсний дараа суудал хуваарилах арга нь нэг бол Хамгийн их дунджийн арга, эсвэл Хамгийн их үлдэгдлийн арга (Хавсралт Б-д үзүүлсэн нэр томъёоны тайлбарыг үзнэ үү) байдаг. ХТТ-оор явуулах сонгуулийн үр дүнд суудал хуваарилах томъёоны үзүүлэх нөлөө ерөнхийдөө бага байдаг ч зарим тохиолдолд ноцтой нөлөөлөх нь бий. 1998 онд Камбож Улсад сонгууль болохоос хэдхэн хоногийн өмнө томъёог өөрчилсөн нь нөлөө бүхий нэгэн нам 121 суудалтай Үндэсний Ассамблейд 59 биш, 64

суудал авахад нөлөөлсөн байдаг. Энэ өөрчлөлтийг олон нийтэд сайтар сурталчилаагүй байсан бөгөөд сөрөг хүчний хувьд ийм үр дүнг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байв. Нарийн ширийн ийм зүйлд бодолтой хандах нь ямар чухал болохыг дээрх жишээ харуулж байна.



Камбоджийн хаалттай жагсаалтаар санал хураадаг ХТТ-ны саналын хуудас

Энэ тогтолцоонд суудал хуваарилах аргаас гадна шийдвэрлэх үүрэгтэй хэд хэдэн чухал асуудал бас бий. Юуны өмнө сонгуульд өрсөлдөгчид суудал хуваарилахад оролцохын тулд давах ёстой саналын босгыг тогтоох асуудал байна (119-121 дүгээр хэсгийг үзнэ үү). Босго өндөр байх нь жижиг намуудад халгаатай (Турк 10 хувийн босготой) бол босго нам байх тусам тэдний хувьд суудал авах боломж нь нэмэгдэнэ (Израилд 1,5 хувийн босго хэрэглэдэг). Өмнөд Африк Улсад ямар ч албан ёсны босго байдаггүй бөгөөд 2004 онд Африкийн Христийн Ардчилсан Нам үндэсний хэмжээнд нийт саналын дөнгөж 1,6 хувийг авсан атал парламентын 400 суудлаас зургааг нь авсан байна. Мөн ЖХТТ нь сонгогч намд санал өгөх үү, эсвэл нэр дэвшигчид өгөх үү гэдгээс, өөрөөр хэлбэл, жагсаалт нь хаалттай, эсвэл нээлттэй чөлөөт байхаас хамаарч янз бүр байдаг (122-126 дугаар хэсгийг үзнэ үү). Үүнтэй холбоотой саналын хуудасны бүтэц нарийн төвөгтэй байх эсэх нь басхүү шийдэгдэнэ.

Дээрхээс гадна сонгуульд өрсөлдөж буй намууд албан, эсвэл албан бусаар “саналаа нэгтгэх” зохицуулалтууд, *аппарентмент* буюу эвсэл холбоо байгуулах боломж (127 дугаар хэсгийг үзнэ үү), тойргийн хил хязгаар тогтоох зэрэг хэд хэдэн чухал асуудлыг энэ тогтолцоог авахад анхаарч шийдэх шаардлагатай.

107. Давуу талууд

а. ЖХТТ нь ХТТ-ны ерөнхий давуу талуудаас гадна цөөнх сонгогдох боломжилүүтэй байдгаараа онцлог юм. Сонгогчдын санал өгөх зан байдал нь ихэвчлэн тухайн нийгэмдэх соёлын, эсвэл нийгмийн бүлгийн ялгарлын тусгал байх ба ЖХТТ нь хууль тогтоох байгууллагад олонхи, цөөнхийн аль аль нь төлөөлөлтэй байх нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Энэ тогтолцоонд намууд авах саналынхаа тоог аль болох нэмэгдүүлэх үүднээс нийгмийн янз бүрийн бүлгийн сонгогчдын анхаарлыг татахуйц нэр дэвшигчдийн тэнцвэртэй жагсаалтыг гаргаж танилцуулах сонирхолтой байдаг байна. Ардчилал шинээр тогтоосон цөөнгүй улсын (тухайлбал, Өмнөд Африк, Индонези, Сьерра Леоне) туршлагаас үзэхэд ЖХТТ нь намууд олон арьс өнгө, үндэстэн угсаатнаас бүрдсэн нэр дэвшигчдийн жагсаалт гаргах боломжтой улс төрийн орон зайг бий болгодог ажээ. 1994 онд Өмнөд Африкийн Үндэсний Ассамблейд сонгогдсон гишүүдийн 52 хувь нь хар арьстан (11 хувь нь Зулу, үлдсэн хувь нь Кшосо, Сото, Венда, Цвана, Педи, Швази, Шэнгаан, Ндебеле үндэстэн), 32 хувь нь цагаан арьстан (гуравны нэг нь англи хэлтэй, гуравны хоёр нь африк хэлтэй), долоон хувь нь өнгөт арьстан, найман хувь нь улаан арьстан байлаа. Намибийн парламент ч мөн адил олон үндэстнээс бүрддэгийн дотор Овамбо, Дамара, Хереро, Нама, Бастер үндэстнээс гадна цагаан арьст (англи болон герман хэлтэй) иргэдийн төлөөлөгчид орсон байдаг.

б. ЖХТТ-нд эмэгтэйчүүд сонгогдох магадлал өндөр байна. ХТТ-ны хувилбарууд нь ОД тогтолцоотой харьцуулахад парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд бараг ихэнх тохиолдолд ээлтэй нөлөө үзүүлдэг ажээ. Намууд жендерийг мөрийн хөтөлбөртөө тухайланасуудал болгон дэвшүүлэхгүйгээр нэрдэвшигчийн жагсаалтаараа дамжуулан эмэгтэй улстөрчдийн ахиж дэвшихийг дэмжиж, сонгогчдод тэдний төлөө санал өгөх боломж олгодог. Дээр нэгэнтээ дурдсанчлан, нэг мандаттай тойргоор сонгууль явуулахад намууд тухайн тойрогт “хамгийн өргөн дэмжлэг авах” хүн олж нэр дэвшүүлэх сонирхолтой байдаг ба нэр дэвшигч нь эмэгтэй хүн байх магадлал багасдаг. Дэлхийн бүх бүс нутгийн хэмжээгээр сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоог авч үзэхэд ХОТ-той орнуудтай харьцуулахад ХТТ-той оронд илүү байгаа нь харагддаг бөгөөд эмэгтэйчүүдийн төлөөлөөрөө тэргүүлдэг 20 орны 14 нь ЖХТТ хэрэглэж

байна. 2004 онд ЖХТТ-оор хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо нийт хууль тогтоох байгууллагуудын дундаж үзүүлэлтээс 15,2-4,3 хувиар өндөр байсан бол ХОТ-оор сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо 4,1 хувиар доогуур байв.

108. Сул талууд. Өмнө дурдсан хувь тэнцүүлсэн тогтолцоонд байдаг ерөнхий сул талуудаас гадна дараах сул талууд энэ тогтолцоонд ажиглагддаг. Үүнд:

а. Сонгогдсон гишүүд ба сонгогчдын хооронд уялдаа холбоо сул байдаг. Тодруулбал ЖХТТ-той, түүнчлэн Намиби, Израиль зэрэг улсууд шиг үндэсний хэмжээний ганц тойргоор сонгууль явагддаг тохиолдолд сонгогчид ба сонгогдсон төлөөлөгчдийн хооронд зай завсар үүсдэг гэсэн шүүмжлэлд өртдөг. Тэр тусмаа хаалттай жагсаалт хэрэглэдэг тохиолдолд сонгогчид хэн тэднийг төлөөлж байгааг тогтоох ямар ч боломжгүй, хот, дүүрэг, тосгоных нь төлөөлөгч гэгчихээр хүн байхгүй төдийгүй, сонгосон төлөөлөгчөө муу ажиллалаа гэж үзвэл хялбархан татаад авчих боломж ч байхгүй. Түүнчлэн хүн ам нь хөдөө голдуу суурьшсан хөгжиж буй зарим оронд сонгогчдын оршин сууж байгаа газартаа харьяалагдах сэтгэлгээ аль нэг улс төрийн нам, бүлэгт харьяалагдах сэтгэлгээнээс илүү хүчтэй байдаг. Гэхдээ энэ шүүмж нь голдуу намын төлөө санал өгөх тогтолцоо ба нэр дэвшигчийн төлөө санал өгдөг тогтолцооны ялгаатай холбоотой сөхөгддөг байна.

б. Энэ тогтолцоонд, ялангуяа хаалттай жагсаалтаар санал хурааж буй нөхцөлд намын удирдах төв байгууллага болон намын дээд удирдлагуудын гарт хэт их эрх мэдэл төвлөрдөг. Аливаа нэр дэвшигчийн намын жагсаалтад эзлэх байр суурь, улмаар амжилт олох магадлал нь намынхаа удирдлагуудтай хэр сайн харилцаатай байхаас хамаарах бөгөөд сонгогчидтой ямар харилцаатай байх нь хоёрдугаар асуудал болон хувирдаг. Гаяана Улс ЖХТТ -нд оо нэг өвөрмөц өөрчлөлт оруулсан нь намууд нэр дэвшигчдийнхээ жагсаалтыг сонгогдох дарааллаар нь бус, цагаан толгойн үсгийн дарааллаар нийтэлдэг явдал юм. Энэ тохиолдолд сонгуулийн үр дүн гарч дууссаны дараа л хүмүүст суудал хуваарилах болдог учраас намын тэргүүний зүгээс үнэнчээр зүтгэснийг нь шагнаж, бие даан дураар дарвисныг нь шийтгэх боломж бүр ч их нэмэгддэг.

в. Тодорхой хэмжээнд олонд танигдсан нам, эсвэл улс төрийн бүлэглэлтэй байх шаардлагатай. Энэ онцлогоос шалтгаалан нам огт байхгүй, улс төрийн намын тогтолцоо нь задгай, дөнгөж өсөлт бойжилтынхоо шатанд яваа Номхон далайн арлын олон оронд ЖХТТ-г хэрэгжүүлэхэд маш хэцүү байдаг.

ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС: Сонгуулийн тогтолцоо нийгмийн зөрчлийг арилгаж нэгдмэл байдалд ХӨТЛӨХ НЬ

Эндрю Рейнольдс

1994 онд Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад явагдсан Үндэсний Ассамблейн болон орон нутгийн сонгууль нь авторитар дэглэмээс олон намын систем бүхий ардчилалд шилжсэн оргил үе байв. 1994 оны дөрөвдүгээр сарын хорин долооны шөнө дунд Африкт хамгийн их жигшигдсэн далбааг буулгаж, тус улсад 300 жил үргэлжилсэн колонийн дэглэм, 40 жилийн турш ноёрхсон апартейдийн дэглэмийн үе дууссаныг зарлан тунхагласан билээ. Үүний дараах анхны ардчилсан сонгуулиуд нь Преториагийн дэглэмийн арьс өнгөөр ялгаварлан захирах бодлогын улмаас нууц байдалд байсан улс төрийн хөдөлгөөнүүд ил гарч улс төрийн амьдралд идэвхийлэн оролцох замыг нээсэн юм. Нелсон Манделагийн Африкийн Үндэсний Конгресс (АҮК) засгийн эрхэнд гарахад бэлтгэж, Азанийн Пан-Африкчдын Конгресс (ПАК) мөн өрсөлдөгчөөр тодрохын зэрэгцээ Мангосото Бутелезигийн Инкатагийн Эрх Чөлөөний Нам (ИЭЧН) КваЗулу-Ната мужийн хойд хэсэгт ноёрхлоо тогтоох найдлага тавьж байлаа. Эдгээр шинэ нам Ф.У. Де Клеркийн Үндэсний Нам (ҮН), либераль үзэлтэй Ардчилсан Нам (АН), шинэхэн Эрх Чөлөөний Фронт (ЭЧФ) намуудтай (“цагаан талын” намуудын хойч үе) нийлж шинээр улс төрийн сонгуулийн эрх авсан сая сая хүмүүсийн саналын төлөө өрсөлдсөн юм.

Сонгуулиудыг ЖХТТ-оор явуулсан бөгөөд Үндэсний Ассамблейн гишүүдийн талыг (200 гишүүн) орон нутгийн есөн мужаас жагсаалтаар сонгож, бусдыг нь үндэсний хэмжээний нэг жагсаалтаас сонгосон байна. Сонгогчдын саналыг суудалд шилжүүлэхдээ улс бүхэлдээ сонгуулийн нэг тойрог (400 гишүүнтэй) гэж үзсэн ба саналын босго тавиагүй байна.

Суудал хуваарилахад Дрүүпийн Квот ашиглаж, илүү гарсан суудлыг хамгийн их үлдэгдлийн зарчмаар шилжүүлж тооцжээ. Сонгуулийн хуулийн эхний төсөлд парламентад төлөөлөлтэй болохын тулд нийт хүчинтэй саналын таван хувийг авсан байх босго тавих асуудал дэвшүүлсэн боловч жижиг намуудад буулт хийх үүднээс “заавал мөрдөх” ямар нэг босгогүй байхаар АҮК ба ҮН-ын хооронд 1994 оны эхээр хэлэлцэж тохирсон байна. Харин, зөвхөн 20 буюу түүнээс дээш суудал авсан намууд (Ассамблейн гишүүдийн таван хувь) үндэсний эв нэгдлийн засгийн газрын анхны танхимд багтах эрхтэй байхаар зохицуулжээ.

Ерөнхийдөө ямар ч тогтолцоогоор сонгууль явуулсан бай “Манделагийн чөлөөлөх хөдөлгөөн” Үндэсний Ассамблейн сонгуульд ялахаар байсан ч Өмнөд Африк Улс анхны сонгуульдаа ЖХТТ-г ашигласны ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй юм. Шинэ үндсэн хуульд заасан эрх мэдэл хуваах механизмын салшгүй нэг хэсэг болох ХТТ нь нийгэмд эвлэрэн зохицох уур амьсгал бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй байгаад зогсохгүй апартейдийн дэглэмийн дараах Өмнөд Африк Улс улс төрийн хүчирхийлэлд цэг тавин, Африк тивийн бусад зовж шаналсан орнуудын хувьд итгэл найдварын гэгээ, тогтвортой байдлын үлгэр жишээ болох үүд хаалгыг нээсэн билээ.

1990 онд Нелсон Манделаг шоронгоос суллагдах үед Өмнөд Африк Улс ХТТ-г авч хэрэглэх ямар нэг тодорхой нөхцөл, шалтгаан үүсээгүй байв. Өмнө нь харьцангуй олонхийн тогтолцоогоор дан цагаан арьстнуудаас бүрдсэн Парламент сонгогдож байсан бөгөөд хэрвээ энэ тогтолцоог хэвээр үлдээсэн бол тухайн үед нэлээд хүчирхэгжээд байсан АҮК илт давуу ялалт байгуулах нь тодорхой байлаа. Нийт 700 гаруй тойргийн дөнгөж тавд нь л цагаан арьстнууд олонхи байв. Харьцангуй олонхийн тогтолцооны онцлогийн дагуу нийт сонгогчдын 50-60 хувийн саналаар АҮК парламентын суудлын 70-80 хувийг хялбархан авч дөнгөхөөр байжээ. Гэвч АҮК уг тогтолцооны “ялагч бүхнийг авах” тэгш бус нөлөө нь яваандаа олонхи ба цөөнхийн аль альны хувьд тогтворгүй, муу нөлөө үзүүлнэ гэж үзэн хэвээр үлдээх гэж шамдсангүй. Үүнээс гадна ЖХТТ нь тойргийн хилийг тогтоохтой холбоотой улс төржсөн маргаанаас зайлсхийх боломж олгоод зогсохгүй АҮК ба үндэсний үзэлтнүүдийн аль аль нь шилжилтийн үед баримтлахаар гаргасан Үндсэн хуулийн гол асуудал гэж чухалчилж байсан гүйцэтгэх эрх мэдлийг хуваалцах тухай үзэл санаанд тохирч байв.

Газар зүйн хувьд сонгогчдынх нь дэмжлэг харьцангуй нэг дор төвлөрсөн хэдий ч Эрх Чөлөөний Фронт (шинэ Үндэсний ассамблейд есөн суудал авсан), Ардчилсан Нам (долоон суудал), Пан-Африкчуудын Конгресс (таван суудал), Африкийн Христийн Ардчилсан Нам (хоёр

суудал) зэрэг намууд олонхийн тогтолцоогоор нэг мандаттай тойргуудад сонгууль зохион байгуулсан бол ганц ч суудал авч чадахааргүй байв. Эдгээр нам нийлээд шинэ Ассамблейн суудлын зургаахан хувийг авсан ч засаглалын бүтцэд эзлэх ач холбогдол нь энэ тооноос хавьгүй илүү жинтэй байсан юм.

1994 оны ЖХТТ-оор явуулсан сонгуулийн нарийвчилсан үр дүнгээс харахад хэмжээний хувьд дунд зэрэг ҮН ба ИЭЧН олонхийн тогтолцоогоор авч болох байсан суудлаас илүү суудал авч чадаагүй байв. Сонгуулийн кампанит ажил үндсэндээ үндэсний санал асуулга аятай явагдсан бөгөөд шинэ, хуучин хоёр намын хооронд жинхэнэ тулаан өрнөсөн байдаг. Тодруулбал, КваЗулу-Натал мужид АҮК ба ИЭЧН, бусад газруудад АҮК ба ҮН хоёрын хооронд ширүүн өрсөлдөөн явагджээ. Цаашилбал, Өмнөд Африкт сонгуулийн нэг тойрогт ерөнхийдөө үндэс угсаа ижил сонгогчид харьяалагддаг, түүнийг дагаад намуудын авах дэмжлэг газар зүйн хувьд төвлөрсөн байсан нь олон тойргоор санал хураах сонгуульд ҮН, ИЭЧН хоёр арай цөөн суудал авах байсан гэсэн үг юм. ХОТ-оор АҮК намд ямар ч байсан “бонус суудал” ногдож, улмаар Үндэсний Ассамблейд авах суудал нь нийт хүчинтэй саналд уг намын эзлэх саналын хувиас (62 хувь байсан) нь давах байв. Ингэснээр тус нам бусад намтай зөвшилцөлгүй шинэ үндсэн хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай гуравны хоёр хувийн олонхийн суудлаа дангаар авч болохоор байжээ.

Түүнчлэн сонгуулийн саналын хуудсан дээр Үндэсний Ассамблейд зориулсан нэг, орон нутгийн парламентад зориулсан нэг санал өгөх практик нэвтрүүлсэн нь сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтад гарсан нэг чухал шинэ санаачилга байлаа. Сонгууль болоход хэдхэн сар үлдэх хүртэл АҮК-оос үндэсний болон орон нутгийн сонгуульд хоёуланд нь тоологдох ганц саналын хуудсаар санал хураах асуудлыг тавьсаар байлаа. Энэ нь томоохон, үндэсний хэмжээний намуудад ашигтай арга мэх болох нь нэлээд тодорхой байсан бөгөөд үүнийг бизнесийн лидерүүд, Ардчилсан Нам, олон улсын зөвлөхүүдийн хамтарсан шахалтын үр дүнд арайхийж өөрчилсөн юм. Эцсийн дүндээ асар олон сонгогч үндэсний болон орон нутгийн саналын хуудсаа үнэхээр хоёр намын хооронд хувааж өгсөн нь харагдаж байв. Гэсэн хэдий ч саналын хуудсыг тусад нь салгасны үр шимийг гол хүртэгчид нь Ардчилсан Нам, Эрх Чөлөөний Фронт зэрэг жижиг нам байлаа. Орон нутгийн сонгуульд энэ хоёр нам хоёулаа 200,000 гаруй санал авсан нь үндэсний хэмжээний үр дүнгээс нь дээгүүр байсан бөгөөд ҮН-ын орон нутгийн хэмжээнд авсан саналын тоо үндэсний хэмжээнд авсан саналаасаа 490,000 саналаар буурсныг үүгээр тайлбарлаж байв.

Дээрхээс гадна, сонгуулийн тогтолцоо нь парламентын бүрэлдэхүүний үндэс угсаа болон хүйсийн бүтэцэд нөлөө үзүүлсэн байдаг. Өмнөд Африкийн Үндэсний Ассамблей 1994 оны тавдугаар сард тангараг өргөсний дотор цагаан арьстнууд олонхи байсан хуучин парламентын 80 гишүүн улиран сонгогдсон байв. Гэвч хуучин ба шинэ парламентын хооронд үүнээс өөр ижилсэх зүйл байхгүй байсан ба хар арьстан цагаан арьстантай, коммунист үзэлтэн консерватив үзэлтэнтэй, Зулу үндэстэн Кшоса үндэстэнтэй, Лалын шашинтан Христийн шашинтантай мөр зэрэгцэн суух болсон нь Өмнөд Африкийн урьдны гашуун туршлагаас эрс өөр шинэчлэл болжээ. Шинэ Үндэсний Ассамблей ийм бүтэц бүрэлдэхүүнтэй болсон нь ЖХТТ ашигласны нэг үр дүн гэж үзэж болно. Намын жагсаалтаар санал хурааснаар сонгуульд өрсөлдсөн намууд аль болох олон санал авахаар эрмэлзэн олон янзын үндэс угсааны хүмүүсийг нэр дэвшүүлэх нөхцөлийг хангасан байна. Үр дүнд нь Үндэсний Ассамблейн гишүүдийн 52 хувь нь хар арьст (түүний дотор Кшоса, Зулу, Сото, Венда, Цвана, Педи, Швази, Шэнгаан, Ндебеле хэлтэн), 32 хувь нь цагаан арьст (англи ба африк хэлтэн), найман хувь нь Энэтхэг гаралтай, долоон хувь нь өнгөт арьст гишүүдээс бүрдэх болжээ. Үүнийг сонгогчдын үзүүлэлттэй харьцуулвал, нийт сонгогчдын 73 хувь нь хар арьстан, 15 хувь нь цагаан арьстан, есөн хувь нь өнгөт арьстан, гурван хувь нь Энэтхэг гаралтай сонгогчид байсан байна. Түүнчлэн, шинээр байгуулагдсан парламентын гишүүдийн 27 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

1999 онд хар арьст парламентын гишүүдийн эзлэх хувь 58, өнгөт арьст гишүүдийнх 10 хувь хүртэл тус тус өсч, цагаан арьстнууд 26 хувь, Энэтхэг гаралтай гишүүд таван хувийг эзлэх болсон байна. 2004 онд хар арьст гишүүдийн парламентад эзлэх хувь (65 хувь) хар арьстнуудын хүн амд эзлэх хувьтай ойртож очсон байх ба цагаан арьст гишүүд парламентын суудлын 22 хувийг эзэлж байв. Харин өнгөт арьст болон Энэтхэг угсаатай гишүүдийн тоо бараг тогтвортой байж иржээ. Парламентын гишүүдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1999 онд 30 хувь, 2004 онд 33 хувь болж өссөн байна. Хэрвээ олонхийн тогтолцоог хэвээр үлдээсэн бол парламент дахь эмэгтэй, Энэтхэг угсаатан, цагаан арьст гишүүдийн тоо хамаагүй цөөхөн, харин хар арьст, эрэгтэй гишүүдийн тоо олон байх байсан гэж Өмнөд Африкт олон хүн хүлээн зөвшөөрдөг.

Түүнчлэн олонхийн тогтолцоогоор явсан бол парламент туйлширч хуваагдах байсан гэж үзэх үндэстэй ба цагаан арьст тойргуудын ихэнхийг цагаан арьстнууд (янз бүрийн намын), Кшосачуудыг Кшосачууд, Зулуучуудыг Зулучууд гэх мэтээр төлөөлөх байв. Өмнөд Африкийн одоогийн ЖХТТ-нд парламентын гишүүд тойргийн сонгогчдын өмнө хүлээх хариуцлага үгүйлэгдэж, сонгогчдоос алслагдах асуудал үүсч байна

гэж үздэг боловч үнэн хэрэгтээ сонгогч нэг биш, нэлээд олон гишүүнд асуудлаа тавьж шийдвэрлүүлэх боломжтой тогтолцоо юм.

Гэсэн хэдий ч Парламентын гишүүдийн хариуцлага хүлээх байдал, төлөөлөх чадварыг хэрхэн дээшлүүлэх асуудлаар Өмнөд Африкт маргаан үргэлжилсээр байна. Анхны сонгууль нь үндсэн хуулийг хэн боловсруулах вэ гэдгийг тогтоох зорилготой бүх нийтийн санал асуулгын өнгө аястай байсан гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг. Үүнээс хойших сонгуулиуд ард түмнийг төлөөлөх Парламент бүрдүүлэхэд голлон чиглэж ирсэн бөгөөд дээрх нөхцөл байдлыг харгалзан сонгуулийн тогтолцоог өөрчлөх нь зүйтэй гэж улс төрийн олон зүтгэлтэн, сонгогч иргэд үзэх болжээ.

Өнөөдөр томоохон улс төрийн намууд бүгд хувь тэнцүүлэх зарчмыг дэмжсэн хэвээр байна. Энэ бүх нөхцөл байдлыг харгалзан сонгогч намд төдийгүй нэр дэвшигчид санал өгөх боломжтой, дээрээс нь саналын хуудас ойлгомжтой, санал тэмдэглэхэд түвэггүй байх өөрчлөлтийг парламент дахь төлөөллийн хувь тэнцсэн чанарт нөлөөлөхгүйгээр хийх боломжтой юм. Тухайлбал, парламентын гишүүдийг арай жижиг олон мандаттай тойргуудаас сонгох нэг гарц байна. Одоогийн тогтолцоонд бүс нутгуудаараа тойрог болж, маш том газар нутгийг хамарсан эдгээр тойргийн хэмжээнд гаргасан намын жагсаалтаар санал хурааж байгаа нь орон нутгийн төлөөлөл, нөлөөллийг бүрхэг болгох гол шалтгаан болж байна. Хоёр дахь боломж бол нийт гишүүдийн тал хувийг нэг мандаттай тойргоос, бусдыг нь жагсаалтаас сонгох холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо авч хэрэглэх явдал юм. Энэ хоёр хувилбарын хоёуланг Ардчилсан Намын дарга асан Фредерик ван Зыл Слаббертээр удирдуулсан ажлыг хэсэг нягтлан үзсэн бөгөөд 2002 онд амжин шинэчлэл хийх санал дэвшүүлж байжээ. Дээрх ажлын хэсгийг ЖХТТ газар зүйн төлөөллийг хангалттай тусгаж чадахгүй байна гэсэн гомдлын дагуу Ерөнхийлөгчөөс санаачилга гарган сонгуулийн тогтолцоонд үнэлэлт дүгнэлт хийх үүрэгтэйгээр байгуулсан аж. Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтэд Өмнөд Африк Улс ЖХТТ-оо хэвээр үлдээх, гэхдээ дор бүрнээ 3-7 мандаттай 69 тойрог байгуулж санал хураах, 100 суудлыг үндэсний хэмжээнд санал тоолж хуваарилах өөрчлөлт хийхийг зөвлөмж болгосон байна. Гэвч эрх баригч АУК нам 2004 оны сонгуульд энэ шинэчлэлийг хийхээс татгалзсан бөгөөд 2009 оны сонгуульд ч шинэ тогтолцоо хэрэглэх хүсэлгүй байгаа нь илт харагдаж байна.



BALLOT PAPER

SAMPLE ONLY

Make your mark next to the party you choose.
 Эсвэл илэрхийлж өгөхөөсөө өмнө таны сонголт.
 Таны сонголт өөрийн сонголтотой байхыг хангах.
 Эсвэл илэрхийлж өгөхөөсөө өмнө таны сонголт.
 Бүх сонголтуудыг гүйцэтгэхийн тулд таны сонголт.
 Таны сонголтотой байхыг хангахыг хангах.

Place a mark next to the party you choose.
 Өөрийн сонголтотой байхыг хангахыг хангах.
 Таны сонголт өөрийн сонголтотой байхыг хангах.
 Эсвэл илэрхийлж өгөхөөсөө өмнө таны сонголт.
 Бүх сонголтуудыг гүйцэтгэхийн тулд таны сонголт.
 Таны сонголтотой байхыг хангахыг хангах.

PAN AFRICANIST CONGRESS OF AZANIA		PAC		
SPORTS ORGANISATION FOR COLLECTIVE CONTRIBUTIONS AND EQUAL RIGHTS		SOCCER		
THE KEEP IT STRAIGHT AND SIMPLE PARTY		KISS		
VRYHEIDFRONT - FREEDOM FRONT		VF-FF		
WOMEN'S RIGHTS PEACE PARTY		WRPP		
WORKERS' LIST PARTY		WLP		
XIMOKO PROGRESSIVE PARTY		XPP		
AFRICA MUSLIM PARTY		AMP		
AFRICAN CHRISTIAN DEMOCRATIC PARTY		ACDP		
AFRICAN DEMOCRATIC MOVEMENT		ADM		
AFRICAN MODERATES CONGRESS PARTY		AMCP		
AFRICAN NATIONAL CONGRESS		ANC		
DEMOCRATIC PARTY - DEMOKRATIESE PARTY		DP		
DIKWANKWETLA PARTY OF SOUTH AFRICA		DPSA		
FEDERAL PARTY		FP		
LUSO - SOUTH AFRICAN PARTY		LUSAP		
MINORITY FRONT		MF		
NATIONAL PARTY - NASIONALE PARTY		NP		

Presented by the Voter Education Programme of the Independent Electoral Commission.

*Өмнөд Африк Улсын хаалттай
 жагсаалтаар санал хураах ХТТ-нд
 хэрэглэдэг саналын хуудас*

ИНДОНЕЗИ УЛС: Залгамж холбоо, тохиролцоо ба ЗӨВШИЛЦӨЛ

Эндрю Эллис

Тогтвортой, үр нөлөөтэй төрд түшиг болж чадахуйц улс төрийн институци хөгжүүлэх асуудал Индонези Улсын хувьд амаргүй хүнд сорилт байсаар ирсэн. 20,000 орчим арал бүхий асар том газар нутаг, маш олон үндэстэн угсаатнаас бүрдсэн энэ улсад эв нэгдлийн цорын ганц тулгуур нь нийтээрээ колончлолыг эсэргүүцсэн тэмцэл байв. Улс төрийн харъяалал тогтооно гэдэг Индонезид хүнд асуудлын нэг байдаг. Өмнө нь энэ харъяалал Исламын шашны янз бүрийн урсгал, шашны бус үндсэрхэг үзэл, эсвэл Христийн шашны зарим чиглэлд суурилдаг байсан бол 2004 оны байдлаар манлайлах чанар, авилгын асуудлуудыг нэмэн үзэж болмоор мэт харагдаж байна. Индонезийг нэгдмэл нэг улс гэдэг үүднээс бүх нийтийг хамарсан, үр нөлөөтэй сонгуулийн тогтолцоо сонгон авах асуудал хэзээ ч амар хялбар байсангүй.

1945 онд тусгаар тогтносноос хойших анхны бүх нийтийн сонгуулиа Индонези 1955 онд явуулсан. Энэ сонгуулийг 15 бүсээр хуваасан тойрогт хувь тэнцүүлсэн тогтолцоо хэрэглэн зохион байгуулах шийдвэрт санал нэгтэй хүрчээ. Тойргуудад ногдох мандатыг хүн амын тоотой нь хувь тэнцүүлэн хуваарилсан бөгөөд зах хязгаарын арлыг хамарсан бүс нутгуудад цөөн тооны нэмэлт төлөөлөлтэй байх боломж олгосон байна. Харегийн квот ашиглан Хамгийн их үлдэгдлийн зарчмаар суудал хуваарилжээ. Намууд нэр дэвшигчдийн жагсаалтаас гадна хувь хүний нэрийг ч дэвшүүлж болохоор байв. Сонгогч аль нэг намд санал өгөх юмуу эсвэл тодорхой нэг нэр дэвшигчийн нэрийг саналын хуудсанд бичих дүрмээр санал хураах ажиллагаа явагдав.

Сонгуулийн үр дүнд бий болсон хууль тогтоох байгууллага нь 27 намыг төлөөлөх жагсаалтаас сонгогдсон хүмүүс, дээр нь нэг бие даасан гишүүнээс бүрдэж байв. Хамгийн том дөрвөн нам бүгд 16-23 хувийн

санал авсан байлаа. Эндээс үүдэлтэй нэг нам байтугай, хоёр нам нийлээд ч хууль тогтоох байгууллагад олонхи болж чадахгүй нөхцөл үүсчээ. Засгийн газрын танхим бүрдүүлэхэд хүндрэлтэй байсан төдийгүй аль ч засгийн газрын хувьд хууль тогтоох байгууллагын итгэлийг хүлээх чадвар хязгаарлагдмал байлаа. Үүний дараахан Үндсэн хуулийг шинээр боловсруулах үүрэгтэй сонгогдсон Ассамблей ч улс төрийн тэнцвэрийн хувьд дээрхтэй төстэй бүтэцтэй байсан бөгөөд өөр хоорондоо тохиролцоонд хүрч чадаагүй байна.

Улс төрийн институцид итгэх итгэл ерөнхийдөө алдагдаж, нэгдмэл төр улсын эсрэг бослого тэмцэл гарсан нь эцэстээ 1959 онд ерөнхийлөгч Сукарно авторитар дэглэм тогтооход хүргэжээ. Энэ дэглэм 1960-аад оны дундуур ерөнхийлөгч Сухартогийн шинэ зарлигаар солигдох хүртэл үргэлжилсэн бөгөөд уг зарлигаар гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглалын эрх мэдлийг зааглан тодорхойлж өгсөн байна. Үүний дараа холбогдох сонгуулиуд явагдсан боловч сонгуулийн кампанит ажлууд ихээхэн хязгаарлагдмал байж, олон нэрдэвшигч хасагдсанаас гадна дүрэм журам нь засгийн газрын бодлогыг эсэргүүцэгчдийн эсрэг тэнцвэртэй бусаар үйлчилж байв. Нэрдэвшигчдээ намын хяналтанд байлгах эрмэлзэл нь хаалттай жагсаалтаар санал авах хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгууль явуулах шийдвэрт хүргэжээ. Ерөнхийлөгч Сухарто Явачуудын улс төрийн ноёрхлыг сулруулахыг эрмэлзэж байсан бөгөөд Явагийнхан 1955 онд бүртгэлтэй сонгогчдын 70 гаруй хувийг эзэлж байсан хэдий ч нийт суудлын дөнгөж талаас дээш хувийг авсан байна. Хэдийгээр энэ тоо багассан боловч 2004 онд мөн л 61 хувьтай хэвээр байлаа.

Ардчилсан шилжилт: 1999 оны сонгууль

1998 онд Сухартогийн дэглэм нуран унасны дараа 1999 оны нэгдүгээр сарын сүүлээр сонгуулийн шинэ хуулийг эцэслэн боловсруулж дуусав. “Тойргийн онцлогтой хувь тэнцүүлсэн тогтолцоо” гэж тодорхойлсон сонгуулийн энэ өвөрмөц тогтолцоо цаг хугацаанд баригдаж бага багаар урагшилсан улс төрийн яриа хэлэлцээрийн үр дүнд төрөн гарсан юм.

Тухайн үед хууль тогтоох байгууллагад суудалтай байсан Сухартогийн үеийн улс төрийн намууд энэ тохиролцоонд хүрэхдээ нэг талаас намаасаа ирж буй дарамт шахалтыг дагаж өөрсдийн байр суурийг хамгаалах, нөгөө талаар уг хэлэлцээрийн гадна байгаа шинэ намууд, бусад бүлгийн шахалт шаардлагад нийцүүлэх гэсэн давхар дарамтын дор ажилласан ба хэлэлцээрийн эцсийн үр дүн дээрхээс өөрөөр гарах үндэсгүй байлаа.

1999 оны зургадугаар сарын сонгуулиар сонгогч бүрүлс төрийн намын төлөө нэг санал өгөв. Засаг захиргааны 27 нэгжийг үндэслэн сонгуулийн тойрог байгуулж, нэг тойрогт 4-82 хүртэл тооны мандат хуваарилсан

байна. Тойргоос намын авах суудлын тоог хувь тэнцүүлэх зарчмаар тодорхойлжээ. Улс орны нэгдмэл байдлыг хадгалах асуудалд ихээхэн санаа зовж байсан учраас ямар нэг бүс нутгийн нам сонгуульд бүртгүүлэх боломжгүй гэсэн заалт тусгайлан оруулсан байв. Улс төрийн намын тухай хуульд сонгуульд өрсөлдөх нам бүр наад зах нь засаг захиргааны есөн нэгжид зохион байгуулагдсан байх шаардлагыг тусгасан байв.

Уг хуульд зарим нэг чухал нарийн ширийн зүйлс тодорхойгүй байлаа. Сонгогчдын өгсөн саналыг суудлын тоонд хөрвүүлэх аргыг зааж өгсөнгүй. Түүнчлэн тухайн намын авсан суудлыг намын жагсаалтад буй аль нэр дэвшигч авахыг заасан дүрэм байсангүй. Эдгээр асуудлыг бүр сүүлийн шатанд л шийдсэн байна.

Суудал хуваарилах эцсийн зохицуулалтад Харегийн квот болон хамгийн их үлдэгдлийн зарчмыг тусгажээ. Намын авсан суудлыг нэр дэвшигчдэд хуваарилах арга бүр ч ярвигтай байлаа. Бодит байдал дээр цөөн хэдэн намын удирдлага л энэ журмыг баримталсан бөгөөд намынхаа авсан суудалд аль нэр дэвшигчийг сонгож суулгах эсэхээ Сонгуулийн комисст мэдэгдэх эрх мэдлийг намын удирдлагууд эдэлж байлаа.

Гэсэн хэдий ч зарим нэг орон нутгийн чанартай асуудлыг эс тооцвол 1999 оны сонгуулийг 1955 оноос хойших анхны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн сонгууль гэж дүгнэсэн байна. Уг сонгуулиар таван нам хоёроос дээш хувийн санал авчээ. Намуудын харьцангуй нөлөө нь Индонезийн нутаг дэвсгэрийн хэмжээгээр газар бүрт харилцан адилгүй байлаа. Эдгээрээс гадна бусад 16 нам төлөөлөлтэй болсон байна.

1999 оны сонгуулийн үр дүнгээс үүдэн 1945 оны Үндсэн хуульд иж бүрэн үнэлэлт дүгнэлт өгөх ажиллагаа явагдав. 2002 онд энэ ажил дуусч томоохон өөрчлөлтүүд биелэлээ олсны дотор төрийн эрх мэдлийг салгаж хуваарилах, харилцан хяналт тавих зарчим нэвтрүүлэх, ерөнхийлөгч ба дэд ерөнхийлөгчийг шууд сонгуулиар сонгох, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтцэд маш хязгаарлагдмал эрх бүхий хоёр дахь танхимыг нэмэх өөрчлөлтийг нэвтрүүлсэн байна. Үндсэн хуульд хоёр багц нэмэлт өөрчлөлт орж цаашид төрийн байгууллагуудын ажиллах арга хэлбэрийг үндсээр нь өөрчилснөөс гадна Сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай, Сонгуульд байгууллагын бүтцийн тухай, Үндсэн хуулийн цэц байгуулах тухай гэсэн таван хууль батлан гаргасан байна. Ингэснээр Индонези Улс ерөнхийлөгчийн ардчилсан засаглалтай орнуудын тоонд зүй ёсоор орох болов.

Хууль тогтоох байгууллагыг нэг мандаттай тойргуудаас харьцангуй олонхийн тогтолцоогоор сонгох санал дэмжлэг авч чадсангүй

1999 оноос хойш нэг мандаттай тойрог (НМТ) бүхий олонхийн тогтолцоо хэрэглэхийг нэн ялангуяа хэвлэл мэдээлэл, судлаачдын хүрээнд ихээр ярих болсон нь 1999 онд сонгогдсон хууль тогтоох байгууллагад гишүүдийн хариуцлага хүлээх асуудал дутагдаж байна гэж үзэх болсонтой холбоотой. Хэдийгээр 1999 оны сонгуулийн тогтолцоог улс төрийн тохиролцоо биш, харин ЖХТТ-ны зарчмыг тойргийн сонгогчдын өмнө хариуцлага хүлээх зарчимтай хослуулах гэсэн зоригтой оролдлого гэж үзэж байсан ч бодит байдал дээр тойрог ба гишүүний хооронд тийм харилцаа холбоо огт бүрдээгүй байна.

Гэхдээ 1999 оны сонгуулийн дараа хийж үзсэн загварчлалаас Индонезийн хувьд НМТ бүхий олонхийн тогтолцоо нь дэлхийн бараг хаана ч байгаагүй хэмжээний тэнцвэргүй үр дүн үзүүлэх магадлалтай байсан нь тодорхой харагджээ. Мөн 1999 онд сонгогдсон хууль тогтоох байгууллага болон эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн оролцогчдын хоорондын харилцаа аажмаар муудсантай холбоотой нэг мандаттай тойргоор сонгууль явуулдаг болох санал дэмжигдэх магадлал муутай болж эхэлжээ. Түүнчлэн Индонезийн нийгэм дэх олон ургальч үзлийг харьцангуй олонхийн тогтолцоо тусгаж чадахгүй нь бараг тодорхой байлаа. Үүнээс гадна 2004 оны сонгуульд тойргоор санал хураах үйл явцыг нэвтрүүлэхэд багагүй цаг хугацаа шаардагдаж, хүндрэл бэрхшээл тулгарахаас гадна олонхийн тогтолцоо эмэгтэйчүүд сонгогдоход тааламжтай бус гэдэг нь илэрхий байв.

2004 оны сонгуулийн тогтолцоо

2002 онд шинэчлэн баталсан Үндсэн хуульд Үндэсний Ассамблейн доод танхимын сонгуульд зөвхөн улс төрийн намууд оролцоно гэж зааснаар сонгуулийн хуулиар дамжуулан тогтолцоог өөрчлөх боломжийг зарим талаар хязгаарлаж өгсөн юм. Дээрх заалтад үндэслэн боловсруулсан Сонгуулийн хуулийн шинэ төсөлд олон мандаттай тойргууд бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгууль явуулах, ингэхдээ нээлттэй жагсаалтаар санал хураан, томоохон тойргуудыг хувааж задлах зохицуулалтыг тусгасан нь сонгогдсон гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагад нийцүүлсэн хэрэг байв. Сонгуулийн хороо нь 3-аас 12 мандаттай тойргуудыг дээрх шаардлагад үндэслэн тогтоосон байна. Үүний дараа өрнөсөн маргаан хэлэлцүүлгийн эцэст тойргийн мандатын тоо Сонгуулийн хорооны гаргасан хязгаарын хүрээнд аль болох өндөр байх нь зүйтэй гэсэн зөвшилцөлд хүрчээ. Эцэст нь хагас нээлттэй жагсаалтаар санал хураах, чингэхдээ сонгогч зөвхөн нэг намын төлөө

саналаа өгөх, хүсвэл тухайн намын нэг нэр дэвшигчийг сонгож саналаа өгч болох дүрэмтэй байхаар тогтжээ. Гэхдээ тухайн нэр дэвшигч хувийн саналын тоогоор Харегийн квотыг давсан тохиолдолд намын жагсаалтад орсон нэрсийн дарааллыг үл харгалзан сонгогдох зохицуулалт хийсэн нь нэр дэвшигчдэд очих саналын нөлөөг багасгах далд зорилготой байв. Энэ нь 2004 оны хууль тогтоох байгууллагын сонгуулиар нотлогдсон.

Хууль тогтоох байгууллагын бүтцэд бүс нутгийг төлөөлөх танхим нэмж байгуулсантай холбоотой зарим нам “нэг хүн, нэг санал, нэг ижил үнэ цэнэ” гэсэн зарчмаар хүн амын тоонд үндэслэн мандатыг тогтоох хэрэгтэй гэж үзэж байсан бол бусад нь зах хязгаарын арлуудыг дэмжсэн төлөөллийн онцлогийг хэвээр үлдээхийг дэмжиж байв. Үүний эцэст талууд харилцан буулт хийж засаг захиргааны нэгж бүрт ногдох мандатын тоог тодорхойлох нарийн томъёо боловсруулснаар жижиг газруудад доод тал нь 325,000 хүн тутамд нэг мандат, арай томд нь дээд тал нь 425,000 хүн тутамд нэг мандат, нэг нэгжид доод тал нь гурван мандат оногдох зохицуулалт хийжээ.

Намын төв удирдлагууд нам доторх байр сууриа сулруулах сонирхол багатай байгаагаа харуулав. Томоохон намуудын зүгээс 2004 оны болон түүний дараагийн сонгуулиудад оролцох намуудад тавигдах шаардлагуудыг чангатгасан байна.

Бүс нутгийн хэмжээний намыг сонгуульд оролцохыг хориглосон заалтаа чуламбатжуулсан байна. Нээлттэй буюухаалттай жагсаалт, “нэг хүн, нэг санал, нэг ижил үнэ цэнэ” зарчим, Ява болон Захын арлуудын асуудал, намын оролцооны холбогдолтой бүх асуудлыг нэг бүрчлэн хэлэлцэн тохирсон байна. Харин нэлээд өргөн хүрээтэй кампанит ажлын үр дүнд хүйсийн төлөөллийн хувьд “байж болох квот” гэдэг заалтыг оруулсан ба энэ дагуу намууд нэр дэвшигчдийн жагсаалтдаа дор хаяж 30 хувьд эмэгтэй нэр дэвшигч оруулах хүсэл эрмэлзэлтэй байх шаардлага тавьжээ. Энэ заалтын хэрэгжилтийг хангах зохицуулалт хуульд тусгагдаагүй ч дээрх заалт нь эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих чухал хэрэгсэл болох нь батлагдаж 2004 оны хууль тогтоох байгууллагад 12 эмэгтэй сонгогдсон нь 1999 оныхоос нэлээн сайжирсан үзүүлэлт байв.

2004 оны хууль тогтоох байгууллагын сонгуулийн үр дүн өөрчлөлт, залгамж чанарын аль алины илэрхийлэл болсон гэж үзэж болно. 1999 онд гурваас дээш хувийн санал авсан таван нам энэ амжилтаа давтсан бөгөөд хоёр нам шинээр нэгдэн орсон байна. Нийтдээ 17 нам төлөөлөлтэй болжээ.

Бүс нутгийг төлөөлөх танхимын сонгууль: СҮШТ гайхал төрүүлэв

Тус улсын Үндсэн хуульд шинээр байгуулагдах бүс нутгийг төлөөлөх танхимын сонгуульд (Бүс нутгийн төлөөлөгчдийн зөвлөл) нэр дэвшигчид нь нам бус, хувь хүмүүс байна гэж заасан байдаг. Засаг захиргааны нэгж бүрээс дөрвөн хүн сонгогдох ёстой байв. Хуулийн төсөлд багц саналын тогтолцоог санал болгосон нь Ява арлаас гаднах жижиг газруудад ялах бололцоотой намуудад ашигтай тусч буй нь тодорхой байв. Харин Явад хамгийн хүчтэй байсан нэгэн нам СҮШТ-оор сонгууль явуулах санал дэвшүүлсэн нь эцсийн тохиролцоо болж батлагджээ.

2004 онд явагдсан Бүс нутгийн танхимын анхны сонгууль СҮШТ-ны нийтлэг сул талыг харуулсан байна. Тухайлбал, аймаг бүрд ногдсон дөрвөн суудлын төлөө дунджаар 30 орчим нэр дэвшигч өрсөлдсөнөөс олон хүн 10 хүрэхгүй хувийн саналаар сонгогдсон байна. Харин эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлаа хүчтэй явуулсан нь санаандгүй үр дүнд хүргэж, шинэ танхимын гишүүдийн 21 хувь нь эмэгтэйчүүд байсан нь урьд өмнө Индонезид явагдсан аль ч чөлөөт сонгуульд гарч байгаагүй өндөр амжилт байв.

Ерөнхийлөгчийн шууд сонгууль

Тус улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг шууд сонгуулиар сонгодог бөгөөд эдгээр суудалд нам бүр хоёр хүний нэр дэвшүүлдэг байна. Сонгууль нь хоёр шаттай явагдах ба хоёр дахь шатанд олонхийн тогтолцоогоор халз өрсөлдүүлэн ялагчийг тодруулдаг. Ингэхдээ сонгуульд ялах хүмүүс улсын хэмжээнд хангалттай өргөн хүрээтэй, олон талын дэмжлэг авсан байх нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон байна. Тухайлбал, хоёр нэр дэвшигчдийн хувьд эхний үед шууд ялахын тулд нийт саналын үнэмлэхүй олонхийг аваад зогсохгүй засаг захиргааны нэгжүүдийн дор хаяж талд нь 20-иос дээш хувийн санал авах шаардлагыг хангах ёстой. Ихэнх ялагч энэ шаардлагыг хангах боломжтой ч Явад дэмжлэг сайтай, бусад газар нутагт дэмжлэг багатай нэр дэвшигчдэд эхний шатанд ялалт байгуулахад нь бэрхшээл учирч болох талтай. 2004 оны долдугаар сард явагдсан ерөнхийлөгчийн анхны шууд сонгуулийн эхний шатанд таван нэр дэвшигч өрсөлдсөнөөс хэн нь ч 35-аас дээш хувийн санал авч чадаагүй байна. Харин мөн оны есдүгээр сард болсон хоёр дахь шатны сонгуульд нэр дэвшигч Сусило Бамбанг Юдхоёно 61 хувийн саналаар ялалт байгуулсан ажээ.

Улс төрийн бодит байдал: Зөвшилцөл, тохиролцоо

1999 онд хэлэлцэн тохирсон сонгуулийн тогтолцоо нь эрх мэдлийн хөшүүргийг гартаа атгаж байсан Шинэ дэглэмийн намууд ба гудамжинд буй шинэ намуудын аль алинд нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байх ёстой байв. 1999 оны сонгуулийн дараа Үндсэн хуульд хийсэн үнэлгээний дүгнэлт ч улс төрийн өргөн хүрээнд зөвшилцөлд хүрэхийг шаардаж байв. 2004 оны сонгуулийн хууль зарчмын хувьд 1999 оныхтой төстэй өөр нэг тохиролцоо байсан боловч нарийн ширийн зарим асуудлыг аваад үзэхэд ихээхэн ялгаатай байсан билээ. Түүнчлэн, 1999, 2004 онуудад аль алинд нь улс төрийн түүхэн уламжлал, оролцогч талуудын улс төрийн мэдлэг туршлага, байр сууриас хамааран практик шийдлийн хувилбар хязгаарлагдмал байсан. Гэсэн хэдий ч шинэ Индонези улсын төрийн институцийн хүрээнд ардчиллын нааштай шинж тэмдэг илэрч байна. Өөрчлөлт шинэчлэлд чухал үүрэгтэй оролцсон улс төрийн нам, хувь хүмүүс богино хугацааны улс төрийн ашиг сонирхлын зэрэгцээ урт хугацааны алсын хараатай ажилласан нь эцэстээ сайн нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Санал шилжүүлэх тогтолцоо (СШТ)

109. СШТ бол хамгийн сонирхол татам сонгуулийн тогтолцооны нэг гэж улс төр судлаачид удаан хугацааны турш үзэж ирсэн боловч түүнийг хууль тогтоох байгууллагын сонгуульд хэрэглэж байсан туршлага маш цөөн. Энэ тогтолцоог БН Ирланд Улсад 1921 оноос хойш, Мальтад 1947 оноос хойш, Эстонид 1990 онд нэг удаа хэрэглэж байжээ. Мөн Австралид Холбооны Сенатыг сонгоход болон хэд хэдэн мужийн сонгуульд, Хойд Ирландад орон нутгийн сонгуульд хэрэглэдэг байна. Тэрчлэн, Шотландын орон нутгийн сонгууль, Шинэ Зеландын зарим эрх бүхий байгууллагын сонгуульд хэрэглэдэг. Мөн энэ тогтолцоо Канадын Бритиш Колумбия мужийн Иргэдийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжид тусгалаа олсон байжээ.

Санал шилжүүлэх тогтолцоог заримдаа эрэмбэт саналын тогтолцоо ч гэх нь бий. Сонгогч сонголтоо эрэмбэлэх буюу хамгийн их дэмжиж буй нэр дэвшигчийг '1', дараагийнх нь '2', '3'... гэх мэт эрэмбэлэн тэмдэглэнэ. Нэгдүгээр сонголтоор тогтоосон квотыг давж чадсан нэр дэвшигчид шууд сонгогддог. Дараагийн тооллогод эхний тооллогоор хамгийн бага амжилт үзүүлсэн нэр дэвшигчийг хасч, түүний авсан саналыг дахин хуваарилах бөгөөд мөн ялсан нэр дэвшигчийн квотоос илүү гарсан саналыг бусад нэр дэвшигчид хуваарилдаг. Энэ ажиллагааг мандатыг хуваарилж дуустал үргэлжлүүлдэг. Сонгогчид ихэвчлэн улс төрийн намын төлөө бус нэр дэвшигчийн төлөө саналаа өгдөг боловч намын жагсаалт гаргах боломж ч байна.

Энэ тогтолцооны үндсэн зарчмыг 19 дүгээр зууны үед Британийн Томас Харе, Данийн Карл Андре нар тус тусдаа нээж олсон байдаг. СШТ-нд олон мандаттай тойргоор сонгуулийг явуулах бөгөөд сонгогчид саналын хуудсыг бөглөхдөө альтернатив саналын тогтолцооных шиг нэр дэвшигчдийг сонголтын дарааллаар нь дугаарлаж тэмдэглэдэг. Ихэнх тохиолдолд энэ нь сонгогч дур сонирхлоороо шийдэж болох, заавал бүх нэр дэвшигчийг дугаарлах албагүй, хүсвэл ганцхан хүнийг ч тэмдэглэж болдог байна.

Саналын хуудаснаас эхний буюу нэгдүгээр сонголт бүхий саналуудыг тоолж дүнг гаргасны дараа суудалд хүрэхийн тулд нэр дэвшигчдийн авах шаардлагатай саналын квотыг тооцно. Үүнд ихэвчлэн Дрүүпийн квотыг ашигладаг бөгөөд дараах энгийн томъёогоор тооцдог. Үүнд:

$$\text{Квот} = \frac{\text{саналын тоо}}{\text{суудлын тоо}} + 1$$

БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛС: Санал шилжүүлэх тогтолцоог хэрэгжүүлсэн туршлага

Майкл Галлагер

Ирландын Парламентын доод танхимыг (*Dail Eireann*) СШТ-оор сонгодог. Энэхүү харьцангуй ховор тогтолцооны гарал үүсэл 1922 онд Бүгд Найрамдах Ирланд Улс тусгаар тогтнолоо олсон цаг үетэй холбоотой. Хуучин эрх баригчид Британичуудын хувьд протестант шашинтүндэсний цөөнхийн эрх ашгийг хамгаалах үүднээс ХТТ-ны ямар нэг хэлбэрийг хэрэглэхийг эрмэлзэж байсан ба шинэ төрийн улс төрийн элитүүд ч ерөнхийдөө хувь тэнцүүлэх зарчмыг дэмжиж байжээ. Тэдгээрийн аль аль нь намын жагсаалтаар санал хураах ХТТ-ны талаар сайн мэдэхгүй байснаас СШТ-г сонгуулийн тогтолцоогоо болгохоор тохиролцож авч хэрэглэсэн нь өнөөг хүртэл хэрэглэгдсэн хэвээр байгаа юм.

Парламентын доод танхим Дэйл нь Ирландын Улс төрийн тогтолцоонд чухал ач холбогдолтой байдаг. Учир нь эндээс засгийн газраа сонгодог бөгөөд засгийн газар бүрэн эрхээ хадгалж үлдэхийн тулд Дэйлийн олонхийн дэмжлэгийг авсан байх шаардлагатай. Тус улсын ерөнхийлөгч нь харьцангуй ач холбогдол багатай институци боловч парламентын тогтолцоонд ховорхон тохиолддог нэг онцлог байдаг нь Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар шууд сонгодог явдал юм. Энэ сонгууль нь альтернатив саналын тогтолцоо (АСТ)-оор явагддаг.

Дэйлийн 166 гишүүнийг нийт 40 орчим сонгуулийн тойргоос сонгодог бөгөөд нэг тойрог нь гурваас таван мандаттай байна. Санал өгөх ажиллагаа энгийн хялбар. Сонгогчид ердөө л дэмждэг нэр дэвшигчийнхээ нэрний хажууд '1' гэж тэмдэглэх бөгөөд бас хоёрдугаар, гуравдугаар гэх мэт сонголтоо дээрх байдлаар дугаарлан тэмдэглэж болно. Сонгогчид дан ганц нэг намын бус, өөр өөр намын нэр дэвшигчдийг ч оролцуулан дугаарлаж болно. Хэдийгээр ихэнх сонголт намын харъяаллын дагуу хийгддэг боловч заавал ингэх албагүй, зарим сонгогч газар зүйн харъяаллыг

харгалзан санал өгдөг. Өөрөөр хэлбэл нэр дэвшигчид аль намын гишүүн байхаас үл хамааран нутгийнхаа нэр дэвшигчдийг нэгдүгээрт эрэмбэлэн санал өгнө гэсэн үг. Саналын хуудас тоолох ажиллагаа, ялангуяа илүүдэл саналыг хуваарилах ажиллагаа нь түүнийг санаачлаагүй хүмүүсийн хувьд ойлгоход хэцүү харагддаг боловч сонгогчдын хувьд энэ бүх нарийн ширийн ажиллагааг сайн мэддэг байх шаардлагагүй гэдгийг дурдах нь зүйтэй. Тэд зөвхөн саналаа яаж өгөхөө мэддэг байж, тооллогын ажиллагааны “тэгш шударга”, ил тод байдалд сэтгэл ханамжтай байхад хангалттай.

Энэхүү сонгуулийн тогтолцоог тус улсын Үндсэн хуульд суулгаж өгсөн байдаг учраас бүх нийтийн санал асуулга явуулахгүйгээр өөрчлөх боломжгүй. Хоёр тохиолдолд (1959, 1968 онд) тус улсын хамгийн том нам Фианна Фэйлээс сонгуулийн СШТ-г Британийн харьцангуй олонхийн тогтолцоогоор солих санал асуулга явуулжүзжээ. Ингэхдээ хувь тэнцүүлэх тогтолцооны аль ч хэлбэр засгийн газрын үйл ажиллагааны тогтвортой, шуурхай байдалд асуудал үүсгэх магадлалтай гэсэн үзлийг иш үндэс болгож тавьсан байна. Дээрх тохиолдол бүрт сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулах саналыг сонгогчид эсэргүүцсэн бөгөөд 1959 онд 52:48 хувийн саналаар, 1961 онд 61:39 хувийн саналаар татгалзсан байна.

Тогтвортой засгийн газар бүрдүүлэх шалгуурын хувьд, БН Ирланд Улсын СШТ-нд үнэлгээ хийсэн хүмүүсийн хэн нь ч үнэн хэрэгтээ засгийн газрын ажиллагаанд асуудал байна гэж үзсэнгүй. 1940-өөд оны дунд үеэс хойш төрсөн засгийн газрууд (эвслийн болон нэг намын засгийн газрын аль аль нь) гурав, дөрөв юмуу таван жилийн хугацаатай эрх барьж байсан бөгөөд богино насалсан цорын ганц онцгой тохиолдол нь 1980-аад оны эхэнд гарч байв. Мөн сонгогчид өөр намын нэр дэвшигчдийг оролцуулан дугаарлах замаар дэмждэг намтайгаа эвсэл болж хамтран зүтгэх түншийг тодорхойлох хүслээ ч илэрхийлж чаддаг байна.

Ерөнхийдөө СШТ нь ихээхэн хувь тэнцүүлсэн үр дүн үзүүлж ирсэн бөгөөд зөвхөн Фианна Фэйл нам бага хэмжээний “бонус” суудал авч байсан байна (1945-1992 онд сонгогчдын 45 хувийн дэмжлэгтэйгээр нийт суудлын 48 орчим хувийг авч байжээ). Гэхдээ сонгуулийн тойргийн хэмжээ жижиг байх нь (нэг тойрог дунджаар дөрвөн мандаттай) том намын хувьд хэрэв бусад намын дэмжигчдийн хоёр, гуравдугаар сонголтод орж чадвал үр шимийг нь илүү хүртэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд энэ явдал хамгийн сүүлд явагдсан хоёр сонгуульд тохиолдсон байна. Энэ хоёр сонгууль урьд хожид байгаагүй хамгийн пропорциональ бус үр дүн гаргасны дотор 2002 онд Фианна Фэйл нам сонгогчдын 41 хувийн дэмжлэгтэйгээр нийт суудлын 49 хувийг авчээ.

БН Ирланд Улсын СШТ-ны талаарх магтаал, шүүмжлэлийн нэлээд нь нэг ижил хүчин зүйлсээс үүдэлтэй буюу сонгогчид нэг намын нэр

дэвшигчдийн дотроос сонголт хийх боломж олгодогтой холбоотой үүсдэг. Энэ нь нам доторх өрсөлдөөнийг эрчимжүүлдэг бөгөөд ялангуяа нэг тойрогт хоёроос дөрвөн нэр дэвшигч дэвшүүлдэг Фианна Фэйл намынхны хувьд илүүтэй мэдрэгддэг. Статистик үзүүлэлтээс үзэхэд Фианна Фэйлээс сонгогдон ажиллаж буй парламентын гишүүд өөр намын нэр дэвшигчид бус өөрийн намын нэр дэвшигчид ялагдах тохиолдол их байдаг байна.

Үүнээс үүдэн парламентын гишүүд сонгогчдынхоо итгэлийг хүлээхийн тулд тойргийнхоо түвшинд илүү идэвхтэй ажиллахад хүрч, улмаар үндэсний түвшинд тавигдаж буй улс төрийн бодлогод, тухайлбал засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, байнгын хороодоор хууль тогтоомж хэлэлцэх зэрэгт хангалттай цаг зав гаргаж чаддаггүй гэж энэ тогтолцоог шүүмжлэгчид үздэг. Энэ нь Ирландын парламентчдын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг (тойрогт хийх ажлын ачааллаас болж үндэсний хэмжээнд хувь нэмрээ оруулах чадвартай хүмүүс сонгуульд оролцох сонирхолгүй болдог утгаараа), төр нь ойрыг харсан бодлого явуулах, нутгархах зүй бус хандлага гарахад хүргэдэг гэж буруушаадаг ажээ. Мөн шүүмжлэгчдийн зүгээс саналын төлөөх намын дотоод өрсөлдөөн нь улс төрийн намуудын хуваагдал, эв нэгдэлгүй байдалд хүргэж болох эрсдэлтэй гэсэн сэрэмжлүүлэг байнга сонсогддог байна.

Харин энэ тогтолцоог дэмжигчдийн хувьд сонгогчид нэг намын гишүүдийн дотроос сонголт хийх боломжтой нь харин ч сайн хэрэг гэж үздэг байна. Энэ нь сонгогчид чадвар муутай хүмүүсийг илүү чадварлаг, идэвх зүтгэлтэй шинэ нэр дэвшигчээр солих боломж олгохын зэрэгцээ ер нь иргэд улс төрийг сонирхох нь багасч байгаа өнөө үед парламентын гишүүд сонгогчидтойгоо илүү ойр дотно холбоотой байж, тэднийг улс төрийн тогтолцоотой холбох үүргээ биелүүлэх сонирхлыг нэмэгдүүлж байгаа юм гэсэн үндэслэлийг сөргүүлэн тавьдаг байна. Түүнчлэн Ирландын парламентын гишүүд өөр бусад улс орныхтой харьцуулахад мэдлэг чадвар султай гэсэн нотолгоо байхгүй, мөн сүүлийн жилүүдэд Ирланд Улсын эдийн засаг анхаарал татахуйц өндөр өсөлттэй байгаа учраас засгийн газар муу ажиллаж байна гэж үзэх аргагүй гэсэн байр суурь илэрхийлэх нь олонтаа. Дээр нь Ирландын Улс төрийн намуудын Парламент дахь үйл ажиллагаа эв нэгдэлтэй, сахилга бат сайтай явагддаг, ямар нэг жигүүр, ялгарч харагдахаар дэд бүлэг байхгүй гэдгийг цохон тэмдэглэж иржээ.

2002 онд бүх намын оролцоотой парламентын хороо байгуулагдаж сонгуулийн тогтолцоог өөрчлөх саналтай болон өөрчлөхийг эсэргүүцэгчдийн дэвшүүлж буй үндэслэлийг авч үзсэн байна. Тус хорооноос иргэд СШТ-нд ихээхэн дасал болсон, өөр тогтолцоогоор солих нь сонгогчдын хувьд ашиггүй бөгөөд СШТ-г шүүмжилж буй улс төрийн

тогтолцооны зарим доголдол нь өөр бусад хүчин зүйлсээс хамаарсан байна гэсэн дүгнэлт гаргажээ. Энэхүү дүгнэлтэд зааснаас үзэхэд, одоогийн сонгуулийн тогтолцоонд нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл өөр тогтолцоогоор солихыг дэмжих хангалттай үндэслэл байхгүй байна.

БН Ирланд Улсын СШТ-нд ямар нэг үнэлэлт дүгнэлт өгөхдөө тухайн орны өвөрмөц онцлогийг харгалзаж үзэх хэрэгтэй. Энэ бол газар нутгийн хувьд ч, хүн амын хувьд ч жижигхэн улс бөгөөд тус улсын Парламентын гишүүний хүн амын тоонд ногдох харьцаа (1:20,000) олон улсын стандартаас харьцангуй өндөр байдаг. Энэ нь том улс орнуудыг бодвол парламентын гишүүн ба сонгогчдын хэлхээ холбоо, сонгуулийн ямар тогтолцоо хэрэглэснээс үл хамааран, илүү ойр дотно байхад хүргэдэг байж болно. Түүнчлэн, БН Ирланд Улс бол баян чинээлэг, хүн ам нь боловсролтой, улс төрийн тогтолцоо нь бүхэлдээ сайн, бүх нийтээр хууль ёсны гэж хүлээн зөвшөөрсөн улс билээ. Ирландын нийгэмд онцын ямар нэг хагарал зөрчил (тухайлбал, үндэс угсааны, хэлний, шашны гэх мэт) байдаггүй.

Энэ шалтгаанаас үүдэн СШТ бусад орчин нөхцөлд ямар үр дүн үзүүлэх талаар хатуу дүгнэлт хийхээс болгоомжлох нь зүйтэй. Харин Бүгд Найрамдах Ирланд Улсын сонгогчид энэ тогтолцоогоо солих шинжгүй байна гэж дүгнэх үндэс хангалттай байна.



BALLOT PAPER HOUSE OF REPRESENTATIVES

WESTERN AUSTRALIA

ELECTORAL DIVISION OF

BRAND

**Number the boxes from 1 to 10
in the order of your choice.**

BEAZLEY, Kim
AUSTRALIAN LABOR PARTY

GENT, Alan
INDEPENDENT

McCARTHY, Brian
INDEPENDENT

GOODALE, Bob
THE GREENS (WA)

McKERCHER, Mal
AUSTRALIAN DEMOCRATS

ANDERSON, Leone L
INDEPENDENT

GALLETLY, Clive Philip Arthur
INDEPENDENT

REBE, Phil
AUSTRALIANS AGAINST FURTHER IMMIGRATION

WALTON, Malcolm
NATIONAL PARTY

HEARNE, Penny
LIBERAL

**Remember...number every box
to make your vote count**

Australian Electoral Commission

AEC

110. Сонгуулийн үр дүнг хэд хэдэн цуврал үе шатаар тоолж тогтоодог. Эхний тооллогоор нэр дэвшигч бүрт өгсөн нэгдүгээр сонголтын дүнг тоолж баталгаажуулна. Ингээд нэгдүгээр сонголтоор авсан саналынх тоо нь тогтоосон квотоос их буюу тэнцүү байгаа нэр дэвшигч шууд сонгогддог.

Хоёр дахь болон түүний дараагийн тооллогуудад сонгогдсон нэр дэвшигчийн илүүдэл саналыг (өөрөөр хэлбэл, квотоос дээш гарсан саналыг) саналын хуудсанд тэмдэглэсэн хоёр дахь сонголтын дагуу бусад нэр дэвшигчдэд хуваарилна. Адил тэгш хуваарилах үүднээс тухайн нэр дэвшигчийн илүүдэл саналын хуудсыг бүгдийг дахин хуваарилалтад оруулдаг. Гэхдээ хүн бүрт нэг саналын бутархай хувь ногдохоор хуваарилах бөгөөд ингэснээр нийт дахин хуваарилсан саналын тоо нь ялсан нэр дэвшигчийн илүүдэл саналын тоотой тэнцүү байдаг (харин БН Ирланд Улсын хувьд жигнэсэн дунджийн аргаар хуваарилдаг онцлогтой). Жишээлбэл, нэг нэр дэвшигч 100 санал авсан нь тогтоосон квотоос таван саналаар илүү байжээ. Тэгвэл саналын хуудас бүрийг нэг саналын 5/100 буюу 1/20 хувиар тооцож дахин хуваарилах юм.

Тооллого хийж дуусах бүрт аль нэг нэр дэвшигч тогтоосон квотоос дээш санал авч чадахгүй бол нийт саналын тоогоор хамгийн бага санал авсан нэр дэвшигчийг хасдаг. Дараагийн тооллогоор түүний авсан саналыг үлдэж байгаа бусад нэр дэвшигчдэд хоёрдахь ба удаах сонголтын дагуу дахин хуваарилна. Дараа дараагийн тоологын үйл ажиллагааг илүүдэл саналыг дахин хуваарилж, эсвэл нэг дэр дэвшигчийг хассаны дараа тухайн сонгуулийн тойрогт хуваарилсан бүх суудлыг квотоос дээш санал авсан нэр дэвшигчид эзэлж дуусах хүртэл буюу тооллогод үлдсэн нэр дэвшигчийн тоо авах ёстой суудлын тооноос нэгээс илүү болох хүртэл үргэлжлүүлнэ. Сүүлийн тохиолдолд үлдэж байгаа нэр дэвшигчдийн нэгээс бусад нь бүгд бүтэн квот авалгүйгээр сонгогдож болдог.

111. *Давуу талууд*: СШТ-нд ХТТ-ны бүх давуу тал ерөнхийдөө ажиглагдана. Дээр нь төлөөлөгчдийг сонгох механизмын хувьд СШТ нь намууд болон нэр дэвшигчдийн хооронд сонголт хийх боломж олгодог учраас хамгийн боловсронгуй тогтолцоо гэгдэх нь бий. Сонгуулийн үр дүн хувь тэнцүүлсэн байдлын хувьд шударга байхын зэрэгцээ СШТ-ны ихэнх бодит жишээнд олон мандаттай тойргийн хэмжээ харьцангуй жижиг байдаг нь сонгогчид ба сонгогдсон төлөөлөгчдийн хооронд харилцаа холбоо хүчтэй байх нөхцөл болдог. Цаашилбал, сонгуулийн дараа байгуулагдах эвслийн бүрэлдэхүүнд сонгогчид нөлөөлж болно.

БН Ирланд Улсын жишээнээс харахад намууд хоорондоо сонголтын дарааллаа харилцан тохирч сурталчлах ба хамтран ажиллах сонирхолтой байна. Мөн СШТ нь нэр хүндтэй бие даан нэр дэвшигчийг сонгох боломж олгодог ороо ЖХТТ-оос илүү байдаг. Энэ нь сонгогчид намуудын хооронд бус нэр дэвшигчдийн хооронд сонголт хийж байгаатай холбоотой (гэхдээ СШТ-нд намын жагсаалтаар санал өгөх нь бий бөгөөд нэг жишээ нь Австралийн Сенатийн сонгууль байна).

112. *Сул талууд*: Ерөнхийдөө ХТТ-ны бүх сул тал СШТ-нд байна. Дээрээс нь дараах зарим онцлог сул талыг дурдаж болно:

а. Эрэмбэт саналын тогтолцоо нь олон улс оронд танил бус, түүнчлэн сонгогчид тодорхой хэмжээгээр бичиг үсэг тайлагдсан, тооны зохих мэдлэгтэй байхыг шаарддаг гэдэг үүднээс заримдаа СШТ-г шүүмжлэх явдал гардаг.

б. СШТ-ны санал тоолох ажиллагаа нэлээд будлиантай, ярвигтай байдаг нь бас нэг дутагдалтай тал гэж үздэг. Эстони Улс энэ тогтолцоог анхны сонгуульдаа авч хэрэглэсний дараа халах болсон нь дээрх шалтгаанаас үүдэлтэй. СШТ нь илүүдэл саналуудыг шилжүүлээд дахин дахин тоолохыг шаарддаг. Ийм учраас энэ тогтолцоогоор хураасан саналыг санал хураах байранд шууд тоолох биш, тусгай тоологын төв дээр аваачиж тоолох шаардлага гардаг. Тооллогын явцад будлиан гардаг, сонгуулийн дүн шударга байх асуудал чухлаар тавигддаг оронд сонгуулийн дүнгийн хууль ёсны байдлыг хангахын тулд тооллогыг санал авсан байранд явуулах, улмаар түүнд тохирсон сонгуулийн тогтолцоо сонгож авах шаардлагатай байж болно.

в. ЖХТТ-оос ялгаатай өөр нэг онцлог бол СШТ-нд нэр дэвшигч саналын төлөө өрсөлдөгч намын гишүүдтэй төдийгүй өөрийн намын хүмүүстэй өрсөлдөх учраас улс төрийн нам дотооддоо хагарах нөлөө үзүүлж болох талтай. Үүнтэй холбоотой улстөрчид сонгогчдын саналыг хахуульдаж авах үзэгдэлд хүргэх явдал бас гардаг.

г. СШТ нь аливаа нам нийт сонгогчдын олонхийн санал авсан хэдий ч өрсөлдөгчдөөсөө цөөн суудал авахад хүргэж болно. Мальта Улс 1980-аад оны дундуур энэ тогтолцоондоо нэмэлт өөрчлөлт оруулж, ийм тохиолдол гарвал тухайн намд зарим нэмэлт суудлыг урамшуулал болгон олгохоор заажээ.

Гэхдээ энэ тогтолцоотой холбоотой олон шүүмжлэл бодит байдалд нэг их асуудал үүсгээд байдаггүй нь нотлогдсон байна. БН Ирланд Улс, Мальта Улсад СШТ-оор явуулсан сонгуулиуд нь нэг, хоёрхон том намаас бүрдсэн харьцангуй тогтвортой, хууль ёсны төр бүрэлдэн, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах нөхцөл болсоор иржээ.

Хувь тэнцүүлэх зарчимтай холбоотой асуудлууд

Тойргийн хэмжээ

113. Сонгуулийн тойргоос сонгогдох гишүүний тоо буюу тойргийн мандатын тоо хэмжээ нь сонгогчдын саналын тоог суудлын тоонд хувь тэнцүүлэн шилжүүлэхэд шийдвэрлэх нөлөөтэй хүчин зүйл гэдэгтэй сонгуулийн мэргэжилтнүүд бараг бүгд санал нэгтэй байдаг. ХОТ, АСТ, ХШТ гэх мэт тогтолцоонд тойргийн мандат нэг байдаг буюу тухайн тойргоос нэг төлөөлөгч сонгогддог. ХТТ-ны бүх хувилбар, түүнчлэн багц саналын болон намын багц саналын зэрэг олонхийн тогтолцооны зарим хувилбар, хязгаарлагдмал саналын болон санал үл шилжүүлэх гэх мэт бусад зарим нэг тогтолцоонд сонгуулийг заавал олон мандаттай тойргоор зохион байгуулах шаардлагатай байна. Аль ч хувь тэнцүүлсэн тогтолцооны хувьд сонгуулийн тойрог бүрээс сонгох гишүүний тоо хэд байхаас сонгуулийн үр дүн хэр хувь тэнцүүлсэн байх нь нэлээд хэмжээгээр хамаардаг.

ЧИЛИ УЛС: Элитийн эрх ашигт баригдсан тогтолцоо

Карлос Хьюнеус

Чилийн сонгуулийн тогтолцоог генерал Августо Пиночетийн (1973-1990) авторитар дэглэм ноёрхож байсан үетэй холбож үзэхгүйгээр ойлгох аргагүй. Тэрбээр тогтвортой, хагас ардчилсан авторитар дэглэм (authoritarian democracy) байгуулах зорилготой байсны нэг бүрэлдэхүүн хэсэг нь сонгуулийн тогтолцоо байлаа. Өмнө нь байсан хувь тэнцүүлсэн тогтолцоо нь 1973 оны есдүгээр сарын 11-ний цэргийн эргэлтээр дуусгавар болсон юм. Энэ тогтолцоо нь 19 дүгээр зууны үеийн Чилийн нийгмийн байгуулал дахь хагарал бутралын эсрэг арга хэмжээ байсан бөгөөд олон намын тогтолцоо бий болоход гол нөлөө үзүүлсэн байв. 1960-аад онд энэ тогтолцоог хэрэглэж байх хугацаанд зургаан том нам төрөн гараад байсны хоёр нь зүүний (Социалистууд ба Коммунистууд), хоёр нь төвийн (Христийн Ардчилсан үзэлтэн ба Радикал үзэлтэний нам), хоёр нь барууны (Либералиуд ба Консервативууд, тэд 1966 онд нэгдэж Үндэсний нам байгуулсан) намууд байлаа.

Бином тогтолцоо: Авторитар дэглэмийн өв уламжлал

Чилийн Үндсэн хуульд парламентыг хоёр танхимтай байхаар заасан. Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим нь дөрвөн жил тутамд сонгогддог 120 гишүүнээс бүрдэх бөгөөд нийт 60 тойргоос тус бүр хоёр гишүүн сонгогддог байна. Сенат нь 19 тойргоос хоёр хоёроор найман жилийн хугацаатай сонгогддог 38 гишүүнтэй. Эдний тэн хагасыг дөрвөн жил тутамд нөхөн сонгож, Төлөөлөгчдийн танхимын сонгуультай нэгэн зэрэг сонгууль явуулдаг. Түүнээс гадна, сонгуулийн бус гишүүд, шууд томилогддог сенаторууд гэж байдгийн дөрвийг нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, гурвыг нь Дээд шүүх, хоёрыг нь Ерөнхийлөгч томилдог. Мөн өмнөх албан тушаалын дагуу насан турш гишүүн байх

нэг хүн байсан нь хуучин ерөнхийлөгч Эдуардо Фрай Руйз-Тагел байв (1980 оны Үндсэн хуульд анх сенатын 13 тойрог байсныг 1989 оны Үндсэн хуулийн шинэчлэлээр 19 болгож өргөтгөсөн нь сонгуулиар томилогдоогүй сенаторуудын эрх мэдлийг багасгахад чиглэсэн байна). Эдгээр зохицуулалтыг Пиночет болон түүний дэмжигчидтэй хэлэлцэн тохирсны үндсэн дээр хийсэн бөгөөд ардчилалд шилжих явцад тэднийг засгийн эрхнээс буулгасан юм.

Төлөөлөгчдийн болон Сенатын танхимын аль алиных нь сонгуульд нам, эвсэл, бие даагчдын зүгээс тойрог бүрт дээд тал нь хоёр хүний нэр дэвшүүлсэн жагсаалтыг гаргаж өгдөг байна. Сонгогчид өөрсдийн шилж сонгосон нэр дэвшигчийнхээ төлөө санал өгдөг. Эхний суудлыг нийт дүнгээр хамгийн олон санал авсан жагсаалтад багтсан нэр дэвшигчдэд өгдөг. Нэг тойргийн хоёр суудлын хоёуланг авахын тулд хамгийн амжилттай өрсөлдөгчдийн санал нь хоёр дахь жагсаалтад өгсөн саналаас хоёр дахин их байх ёстой. Энэ тогтолцоонд тавьдаг босго маш өндөр учраас намууд сонгуульд эвсэл болон оролцох шаардлагатай болдог байна. Тухайн жагсаалтаар нэг суудал авахын тулд нийт саналын 33,4 хувийн санал авсан байх шаардлагатай. Харин хоёр суудлын хоёуланг баталгаатай авахын тулд нийт саналын 66,7 хувийг авсан байх хэрэгтэй.

Тусулсад сонгуулийн хоёр том эвсэл байдаг нь 2001 онд Төлөөлөгчдийн танхимын нийт суудлын нэгээс бусдыг авсан байдаг. Зүүн-төвийн эвсэл болох Концертацион пор ла Демокрациаг Пиночетийн дэглэмийг эсэргүүцэгч дөрвөн нам бүрдүүлдэг (Социалистууд, Ардчилсан нам, Христийн Ардчилсан үзэлтэн ба Радикал үзэлтэний нам) бөгөөд тэд 1990 оны гуравдугаар сард ардчилалд эргэж орсноос хойш эрх барьж байна. Баруун жигүүрийн сөрөг хүчин болох Чилийн Альянс эвсэл (Бие даасан ардчилсан эвсэл, UDI, Үндэсний шинэчлэл, RN) Пиночетийн дэглэмийг дэмждэг байжээ. Амьдрал дээр Концертационы жагсаалтад хоёр бүлэглэл тус бүрээс нэг нэр дэвшигч ордог бөгөөд Христийн ардчилсан намаас нэг, Социалистууд, Ардчилсан нам, Радикалуудаас нэг нэр дэвшигч ордог гэсэн үг. Социалистууд ба Ардчилсан намын хооронд өрсөлдөөн болдог тойрог гэж байхгүй. Сөрөг хүчний жагсаалтын хувьд UDI, Үндэсний шинэчлэл намууд гол төлөв тойрог бүрт нэг нэр дэвшигч дэвшүүлдэг байна.

Сонгуулийн энэ тогтолцооны үр дүнд бараг бүх дүүргээс Концертационы нэг төлөөлөгч, Чилийн Альянсаас нэг төлөөлөгч сонгогддог байна. Энэ тогтолцоонд нэг жагсаалтаас нэг суудлын төлөө өрсөлдөж байгаа хоёр нэр дэвшигчийн хооронд өрсөлдөөн явагдах боломжтой ч практик дээр аль аль эвсэлд байгаа элитүүдийн байр сууриас болж энэ байдал ихээхэн хязгаарлагддаг.

Энэ тогтолцооны давтагдашгүй онцлог бол практик дээр хамгийн том олонхийг бус хамгийн том цөөнхийг дэмждэг явдал юм. Энэ бол мажоритар буюу олонхийн тогтолцоо биш. Харин нийт саналын 34 хувийг авсан сонгуулийн жагсаалт нийт суудлын тал хувийг авах боломж олгодог учраас хувь тэнцүүлэх механизм ашигладаг боловч пропорциональ бус үр дүн гаргадаг тогтолцоо юм. Яагаад ийм гажуудал гараад байгаагийн гол шалтгаан нь сонгуулийн өрсөлдөөнд тавьдаг хязгаарлалтуудтай холбоотой.

Сонгуулийн энэ тогтолцоог 1988 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн бүх нийтийн санал асуулгын дараа тухайн үеийн цэргийн дэглэмийнхэн бий болгожээ. Уг санал асуулга 1980 оны Үндсэн хуулийг батлах, генерал Пиночетийг тус улсын ерөнхийлөгчөөр дахин найман жилийн хугацаатайгаар сонгох гэсэн хоёр зорилготой байлаа. Энэхүү сонгуулиар Пиночет Концертационд ялагдсан нь тус улсад ардчилсан шилжилт өрнөхөд хүргэж 1989 онд дахин конгрессийн болон ерөнхийлөгчийн сонгууль явуулсан юм. Улмаар ерөнхийлөгчийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигч Патрицио Эйлвин (Христийн ардчилсан нам) ялалт байгуулжээ. Угтаа сөрөг хүчний намууд сонгуульд ялалт байгуулах магадлал өндөр байсан учир, тийм үр дүн гарахаас сэргийлж сонгуулийн энэхүү тогтолцоог Пиночетийн нэрийг дэвшүүлэхийг дэмжиж байсан баруун жигүүрийн хоёр намд ашигтай байхаар бодож боловсруулсан нь бүтэлгүйтжээ.

1990 оноос хойш явуулсан ерөнхийлөгчийн гурван сонгууль, конгрессийн дөрвөн сонгуульд Концертационы эвсэл ихэнх саналыг авч ялалт байгуулж ирсэн боловч шууд томилогдсон сенаторуудын дийлэнх нь сөрөг хүчнийг дэмжиж байсан учраас Сенатын танхимд хяналт тогтоосон удаа байхгүй байна.

Намууд ба ардчилалд бином тогтолцооны үзүүлэх зарим сөрөг нөлөө

Энэхүү сонгуулийн тогтолцоо нь хэд хэдэн үндэслэлээр шүүмжлэлд өртөж ирсэн. Нэгдүгээрт, намууд нэг суудал авахын тулд маш өндөр босго давах ёстой болдог учраас сонгуульд заавал эвсэж орохыг хүчээр шаарддаг. Хоёрдугаарт, тус улсын Коммунист нам 1973 он хүртэл улс төрд гол үүрэгтэй байсан, эдүгээ үндэсний хэмжээнд нийт саналын 5-7 хувийг авдаг ч Конгрессд төлөөлөлгүй байсаар өдийг хүрчээ. Гуравдугаарт, ихэвчлэн эвсэл бүр нэг суудал авдаг учраас жинхэнэ өрсөлдөөн хоёр сөргөлдөгч эвсэл ба тэдний намуудын хооронд явагдахын оронд нэг эвслийн гишүүн намуудын хооронд явагддаг байна. Энэхүү маргаан нь эвслийн эв нэгдэл, тогтвортой байдалд эрсдэл учруулж байдаг. Үүнээс үүдэлтэй 2001 онд болсон Сенатын сонгуульд UDI, RN намууд эвсэлд

оролгүйгээр хамтарсан нэг нэр дэвшигчийг есөн тойргийн долоод нь дэвшүүлсэн буюу гол нэр дэвшигчтэй олигтой өрсөлдөхөөргүй сулхан нэр дэвшигч өрсөлдүүлсэн байна. Дөрөвдүгээрт, энэ тогтолцоо нь намын удирдлагуудад асар их эрх мэдэл олгосноос тэд бараг жагсаалт хийж байх явцдаа л ялагчдыг сонгочихдог байна. Олон тойрогт жинхэнэ өрсөлдөөн явагддаггүй учраас сонгогчид сонгуульд оролцох сонирхол муутай байгаад зогсохгүй өөрийнх нь дэмждэг намаас нэр дэвшигч байхгүй бол бүр ч сонирхолгүй болдог ажээ.

Энэхүү учир дутагдалтай байдлыг харгалзан засгийн газар сонгуулийн шинэчлэл хийх хэрэгтэй гэсэн санал тавихад хүрсэн бөгөөд хоёр мандаттай тойргуудын оронд илүү хувь тэнцсэн үр дүн гарахуйц томсгосон тойргууд хэрэглэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн. Гэвч энэ санал төдий л амжилт олоогүй юм. Учир нь Концертацион үүсч болох тодорхойгүй байдлаас эмээж байгаа бол сөрөг хүчин өөрт нь давуу байдал олгож буй хуучин тогтолцоогоо хамгаалсаар байгаа билээ.

Ерөнхийлөгчийн сонгуулиуд

1980 оны Үндсэн хуульд ерөнхийлөгчийн сонгуульд хоёр үе шаттай тогтолцоо хэрэглэхээр заажээ. Нэр дэвшигч эхний шатанд ялахын тулд үнэмлэхүй олонхийн санал авах шаардлагатай, хэрэв ингэж чадахгүй бол дараагийн шатанд халз өрсөлддөг. Энэ нь эвслийг дэмжихэд чиглэсэн байдаг. 1989, 1993 оны ерөнхийлөгчийн сонгуулийн ялагчид болох Патрицио Эйлвин, Эдуардо Фрай нар тус бүр үнэмлэхүй олонхийн саналаар эхний үед ялалт байгуулж байсан бол 1999 оны сонгуульд Рикардо Лагос, түүний баруун жигүүрийн өрсөлдөгч Жокүин Лавин нар дөнгөж 30,000 саналын зөрүүтэй байв. Хоёр дахь үед Лагос 50,27 хувийн саналаар ялалт байгуулсан байна. (Өмнөх Үндсэн хуулиар (1925 оны) аль ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авахгүй бол хэн ерөнхийлөгч болохыг конгрессоос шийддэг байсан бөгөөд ийм явдал 1946, 1958, 1970 онуудад тохиолджээ. Эдгээр тохиолдол бүрт хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялагчаар тодруулж байсан байна).

Сонгогчдын бүртгэл ба санал хураалт: Сайн дураараа уу, албадлагаар уу?

Одоогийн сонгуулийн тогтолцоотой холбоотой өөр нэг асуудал бол сонгогчоор бүртгүүлэх эсэх нь сайн дурын боловч саналаа заавал өгөх шаардлага тавьдаг явдал юм. Цэргийн дэглэмийнхэн 1988 оны бүх нийтийн санал асуулгад бэлтгэж байх явцад буюу 1987 оны хоёрдугаар сард сонгогчдыг шинээр бүртгэж эхэлсэн бөгөөд хуучин бүртгэлийг нь цэргийнхэн 1973 онд шатаасан байв. Ардчилсан сөрөг хүчнийхэн сонгогчдыг бүртгэлд хамруулах хөдөлгөөн хүчтэй өрнүүлсэн нь ардчилалд

хүрэхийн тулд санал хураалтаар Пиночетийг ялах стратегитай холбоотой байсан бөгөөд энэ нь ч амжилт олж сонгуулийн эрх бүхий иргэдийн 92 хувийг бүртгэлд хамруулж чадсан байна. Харин тэр үеэс хойш санал өгөх насны хүн амын өсөлтийг дагаж бүртгэлтэй сонгогчдын тоо өсөөгүй нь залуучууд сонгуульд оролцох сонирхолгүй болсонтой холбоотой. 2001 оны конгрессийн сонгуульд нийт 10 сая орчим сонгогчдын 80 хувь нь нэрийн жагсаалтад бүртгүүлсэн бол 2004 оны хотын захиргааны сонгуульд энэ тоо 77 хувь байлаа.

Залуу сонгогчдын сонгуульд оролцох хувь доогуур байгаа нь засгийн газраас сонгуулийн насанд хүрсэн иргэдийг автоматаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэж, санал өгөх явдлыг сайн дурын болгох санал дэвшүүлэхэд хүргэжээ. Концертационы намууд автомат бүртгэлийг дэмжиж байсан боловч сайн дураар сонгуульд оролцох тал дээр зөвшилцөлд хүрээгүй байна. Ингэх болсон нэг шалтгаан нь сонгуулийн ерөнхий ирц буурна, сонгогчдыг идэвхжүүлж сонгуульд оролцуулах кампанит ажлын зардал улам бүр өсөх нь баруун жигүүрийн намуудад ашигтай гэж эмээснээс үүдэлтэй. Харин сөрөг хүчний UDI нам автомат бүртгэлийг эсэргүүцэж, санал хураалтад оролцохыг сайн дурын болгохыг дэмжиж байгаа ажээ.

Бином тогтолцоог дэмжигчид тус улсын хоёр том эвслийн нэг нь засгийн эрхэнд, нөгөө нь сөрөг хүчинд байгаа учраас энэ тогтолцоо засаглал үр дүнтэй хэрэгжихэд сайнаар нөлөөлж ирсэн гэж үздэг. Гэхдээ ингэж үзэх нь буруу юм. Концертацион эвсэл бином тогтолцоо нэвтрүүлэхээс өмнө байгуулагдсан. Энэ эвслийг байгуулсан улстөрчид өмнөх зөрчил мөргөлдөөнөөс (1973 оны хямралыг бий болгож ардчиллыг алдагдуулахад хүргэсэн) сургамж авч, улс төрийн тогтолцооны хүрээнд элитүүдийн хооронд хамтын ажиллагааг чухалчилж байсан бөгөөд үүнтэй холбоотой эвсэл нь өөрөө авторитар дэглэмийн эсрэг ажиллах, ардчилалд эргэж орохыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн байв. Тэгэхээр засаглал үр дүнтэй хэрэгжихэд сонгуулийн тогтолцоо гол нөхцөл болж байна гэж үзэх нь өрөөсгөл билээ.

Энэ тогтолцооны улс төрийн намууд, ардчилалд үзүүлж буй сөрөг нөлөөг аваад үзэхэд урт хугацаанд үргэлжлүүлэн хэрэглэх боломжгүй ч нөгөө талаар түүнийг өөрчлөх нь намуудын сонгуульд үзүүлэх амжилтад нөлөөлөх учир мөддөө шинэчлэгдэнэ гэж үзэхэд бэрх юм. Түүнчлэн одоогийн тогтолцооны зарчмыг Үндсэн хуульд заасантай холбоотой аливаа шинэчлэл хийхийн тулд заавал Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Харин сенатын гишүүдийг сонгуулийн бус аргаар томилох, түүний дотор хуучин ерөнхийлөгч нарыг сенатад насаар нь ажиллуулах явдлыг болиулах тал дээр Конгресс дахь Концертацион болон Чилийн Альянсийн хооронд зөвшилцөлд хүрсэн ажээ.

114. Хамгийн их хувь тэнцүүлсэн үр дүнд хүргэдэг тогтолцоо том тойрогтой байна. Учир нь том тойргоор санал хураахад маш жижигхэн намууд хүртэл хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болох нөхцөл бүрддэг. Харин жижиг тойргуудын хувьд тогтолцооны математик нөлөөллийн хүрээнд бодит босго нь арай өндөр байдаг (121 дүгээр хэсгээс үзнэ үү). Жишээлбэл, зөвхөн гурван мандаттай тойрог байлаа гэхэд аль нэг нам баттай суудал авахын тулд дор хаяж 25+1 хувийн санал авах ёстой. Энэ тохиолдолд нийт сонгогчдын арван хувийн санал авсан нам суудал авах магадлал багатай бөгөөд иймээс энэ намыг дэмжигчдийн саналыг хоосон үрэгдсэнд тооцож болно. Гэтэл есөн мандаттай тойрогт 10+1 хувийн санал авахад л дор хаяж нэг суудал авах баталгаатай болох юм.

Нөгөө талаар, тойргийн хэмжээ томрох тусам (мандатын тоо талаасаа ч, мөн хааяа үүнээс үүдэн газар зүйн хэмжээ нэмэгдэх талаасаа ч) сонгогдсон гишүүн ба түүнийг сонгосон тойргийн хоорондох уялдаа холбоо сулардаг байна. Улс төрийн амьдралд орон нутгийн хүчин зүйлс хүчтэй үүрэг гүйцэтгэдэг, сонгогчид нь сонгосон гишүүнээ тойрогтойгоо байнга хэлхээ холбоотой байж, хууль тогтоох байгууллагад тэдний “төлөөлөгч” болон ажиллана гэж хүлээдэг нийгэмд бол энэ байдал ноцтой үр дагавар учруулж болно.

115. Үүнээс үүдэн сонгуулийн тойргийн оновчтой хэмжээний талаар ширүүн мэтгэлцээн өрнөж байна. Ерөнхийдөө зарчмын хувьд тойргийн хэмжээ гурваас долоон мандаттай байх нь тохиромжтой гэдэгтэй ихэнх эрдэмтэд санал нийлдэг бөгөөд практик дээр суудлын тоо гурав, тав, долоо гэх мэт сондгой тоотой байх нь тэгш тоотой байснаас дээр байдаг. Ялангуяа хоёр намын тогтолцоотой үед энэ нь бүр ч чухал гэж үзэх нь бий. Гэхдээ энэ бол зөвхөн тойм төдий асуудал юм. Сонгуулийн үр дүн хувь тэнцүү, шударга байх, хууль тогтоох байгууллагад намууд тэгш төлөөлөлтэй болох нөхцөлийг бүрдүүлэхэд мандатын тоо аль болох олон байх нь зүйтэй төдийгүй ийм байх зайлшгүй шаардлагатай янз бүрийн нөхцөл байдал учирч болно. Нэлээд олон оронд сонгуулийн тойргийг засаг захиргааны хуваарийн дагуу, тухайлбал муж, аймгийн хилийн дагуу байгуулдаг нь тойргууд том, жижиг харилцан адилгүй хэмжээтэй байхад нөлөөлдөг. Нөгөөтэйгүүр энэ аргыг ашиглах нь сонгуулийн тойргийн хил хязгаарыг сонгууль болох бүр заавал шинээр тогтоох шаардлагагүй болох бөгөөд сонгогчид нь тойргуудаа мэддэг, танил дасал болсон байх нөхцөлийг хангаж өгдөг ажээ.

116. Тойргийн хэмжээний хувьд хэт том юмуу хэт жижиг хоёр туйлын аль аль нь туйлширсан үр дүнд хүргэх хандлагатай байдаг. Тухайлбал, улс орон даяараа нэг том сонгуулийн тойрог болох тохиолдолд суудал авахад шаардлагатай саналын тоо маш бага байна. Ийм нөхцөлд маш жижиг намууд хүртэл суудал авах боломжтой гэсэн үг. Жишээлбэл, Израиль Улс бүхэлдээ 120 мандаттай ганц тойргоор сонгуулиа зохион байгуулдаг. Энэ нөхцөлд сонгуулийн үр дүн дээд зэргээр хувь тэнцсэн байхын зэрэгцээ нийт саналын өчүүхэн хувийг авсан намууд төлөөлөлтэй болдог бол, нөгөөтэйгүүр, сонгогдсон гишүүн ба сонгогчдын хоорондын харилцаа холбоо маш сул байна. Эсрэгээрээ, тойрог нь хоёрхон мандаттай байх тохиолдол байна. Тухайлбал, ЖХТТ-той Чили Улсад сонгуулийг хоёр мандаттай тойргуудаар явуулдаг. Тодорхой жишээн дээр хийсэн судалгаанаас үзэхэд энэ нь нэлээд тэнцвэртэй бус үр дүн үзүүлдэг нь тойрог тус бүрээс зөвхөн хоёр нам л суудал авах боломжтой байдгаас үүдэлтэй. Энэ нь хууль тогтоох байгууллагад намуудын төлөөллийг авсан саналд нь үндэслэн тэгш хангах талаасаа ч, хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөх талаасаа ХТТ-ны сайн талыг алдагдуулах хандлагатай байдаг.

117. Эсрэг тэсрэг байдлыг харуулсан дээрх жишээ нь аливаа ХТТ-нд тойргийн хэмжээ, мандатын тоо шийдвэрлэх ач холбогдолтойг тодорхой харуулж байна. Ийм учраас тойргийн хэмжээний асуудал бол ХТТ-г боловсруулахад маш чухал цорын ганц хүчин зүйл төдийгүй бусад хэд хэдэн тогтолцооны хувьд ч маш чухал нөлөөтэй. Тухайлбал, санал үл шилжүүлэх тогтолцоо гэхэд хувь тэнцүүлэх томъёо ашигладаггүй боловч гол нь олон мандаттай тойргоор сонгуулийг зохион байгуулах тул нэлээд пропорциональ үр дүн үзүүлэх хандлагатай байдаг. Үүний нэг адил санал шилжүүлэх тогтолцоог нэг мандаттай тойрогт хэрэглэх үед АСТ болж хувирдаг бөгөөд СШТ-ны зарим давуу талыг хадгалах боловч пропорциональ чанар нь алдагдсан байдаг. Намын багц саналын болон багц саналын тогтолцооны үед тойргийн хэмжээ томрох тусам пропорциональ байдал нь багасах магадлалтай. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл аливаа сонгуулийн тогтолцоог бодож боловсруулах үед тухайн тогтолцоо практик дээр хэрхэн хэрэгжих, сонгогч болон сонгогдсон төлөөлөгчдийн хоорондын харилцаа холбоо ямар байх, сонгуулийн үр дүн ерөнхийдөө хэр хувь тэнцсэн байхыг олон талаар тодорхойлдог гол хүчин зүйл нь тойргийн хэмжээ юм.

118. Үүнтэй холбогдуулан тухайн намын хүч нөлөө (тойрогт нэг ижил намаас оролцоод амжилт үзүүлсэн нэр дэвшигчдийн дундаж тоо) нь парламент дахь төлөөллийн шинж чанарыг тодорхойлох чухал хүчин зүйл

байдаг. Хэрэв нэг тойрогт нэг намаас ганцхан нэр дэвшигч сонгогддог бол тэр нь голдуу эрэгтэй хүн байхаас гадна тухайн тойрогт зонхилох үндэс угсааны буюу нийгмийн бүлгийн гишүүн байх магадлал ихтэй байдаг. Хэрэв хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч сонгогддог бол төлөөллийн тэнцвэр нэмэгдэн, эмэгтэйчүүд, үндэсний цөөнхийн гишүүд сонгуульд амжилт гаргах магадлалтай болдог байна. Тойргийн хэмжээ том (долоо буюу түүнээс дээш мандаттай), харьцангуй цөөн тооны намуудтай байх тусам намын хүч нөлөө илүү байх хандлагатай байдаг.

Босго

119. Нам буюу намаас нэр дэвшигч парламентад суудалтай болохын тулд шаардагдах саналын доод хэмжээг босго гэх ба энэ нь бүх тогтолцоонд ил, далд хэлбэртэй байна. Тодруулбал, босго нь хуульд зааж тодорхойлсон (*албан ёсны босго*) эсвэл тухайн сонгуулийн тогтолцооны математик нөлөөнд бий болсон (*далд босго*) байж болно.

120. Албан ёсны босгыг Үндсэн хуульд юмуу сонгуулийн хууль тогтоомжид тусгаж өгсөн байдаг. Тухайлбал, Герман, Шинэ Зеланд, Орос гэх мэт холимог тогтолцоотой орнууд таван хувийн босго тавьсан байдаг. Өөрөөр хэлбэл, бүх нийтийн сонгуульд таваас доош хувийн санал авсан намууд суудал авах эрхгүйгэсэн үг. Энэ туршлага нь Герман Улсаас гаралтай агаад хэт даврагч тэрс үзэлт бүлгүүдийн сонгогдох боломжийг хязгаарлах, хэт жижиг намууд парламентад орж ирэхээс сэргийлэх зорилго агуулдаг ажээ. Гэхдээ Герман, Шинэ Зеландын аль алинд нь заавал босго давах шаардлагагүйгээр нам жагсаалтынхаа дагуу суудал авах боломжтой “арын хаалга” мөн байдаг. Шинэ Зеландын хувьд аливаа нам сонгуулийн тойргуудаас дор хаяж нэг суудал авсан байх ёстой бол Германд энэ тоо гурван суудал байдаг байна. Харин 1995 онд Орост арын хаалганы зам байхгүй байсан учраас намын жагсаалтаар өгсөн саналуудын бараг тал хувь нь дэмий үрэгдсэн байна.

Хуулиар тогтоосон саналын босго Нидерландад 0,67 хувь байхаас эхлээд Туркт 10 хувь байх хүртэл олон янз байдаг. Хуульд зааснаас бага санал авсан намууд тооллогоос хасагддаг байна. Үүний нэг онцгой жишээ бол Туркийн 2002 оны сонгууль бөгөөд нэлээд олон нам арван хувийн босго давж чадалгүй бүдэрснээр нийт сонгогчдын саналын 46 хувь нь хоосон үрэгдэхэд хүрчээ. Энэ жишээнээс үзэхэд албан ёсны босго тогтоох нь сонгуулийн дүнгийн пропорциональ бус байдлыг нэмэгдүүлэх ба босго тавиагүй бол суудал авах байсан намуудад өгсөн сонгогчдын санал дэмий үрэгдэж байна.

1993 онд Польшид харьцангуй нам буюу намуудад таван хувь, эвслүүдэд найман хувийн босго тогтоосон хэдий ч энэ босгыг давж чадаагүй намуудад өгсөн санал нийт саналын 34 гаруй хувьтай тэнцэж байжээ.

121. Далд босго нь сонгуулийн тогтолцооны математик нөлөөнд үүсдэг бөгөөд энд тойргийн хэмжээ хамгийн чухал байдаг. Жишээлбэл, дөрвөн мандаттай тойрогт ХТТ-оор сонгууль явуулахад 20-иос дээш хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдох магадлалтай байдаг бол, 10 –аас бага хувийн (энэ тоо яг хэд байх нь намууд, нэр дэвшигчид, саналын бүтцээс хамаарна) санал авсан нэр дэвшигч сонгогдох боломжгүй юм.

Нээлттэй, хаалттай болон чөлөөт жагсаалт

122. ЖХТТ нь нам, улс төрийн бүлэглэлүүд нэр дэвшигчээ танилцуулах зарчимд тулгуурласан байдаг ч сонгогчид санал болгосон нэр дэвшигчдийн хооронд эсвэл намуудын хооронд сонголт хийх боломж нь янз бүр байна. Энэ нь жагсаалтын гурван үндсэн хэлбэрээс буюу *нээлттэй*, *хаалттай*, *чөлөөт* жагсаалтын аль нь байгаагаас хамаарч байдаг.

123. ЖХТТ-ны дийлэнхэд нь хаалттай жагсаалт буюу жагсаалтаар сонгогдох нэр дэвшигчдийн дарааллыг нам нь тогтоох дүрэм үйлчилж байна. Энэ нөхцөлд сонгогч тодорхой нэг нэр дэвшигчийг сонгох хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэх боломжгүй гэсэн үг. Хаалттай жагсаалтын нэг тод жишээ бол Өмнөд Африкийн ЖХТТ юм. Тус улсын саналын хуудсанд намын нэрс, бэлэг тэмдэг, намын даргын фото зураг байх боловч нэр дэвшигчдийн нэр байдаггүй. Сонгогчид зөвхөн дэмждэг намаа сонгох ба сонгогдох нэр дэвшигчдийн нэрсийг намууд нь өөрсдөө урьдчилан тогтоосон байдаг. Энэ нь намууд жагсаалтдаа нэрээрээ шууд сонгогдоход бэрхшээлтэй байж болох зарим нэг нэр дэвшигчид (үндэсний цөөнх, эмэгтэйчүүд гэх мэт) сонгогдох боломж олгож байна гэсэн үг.

Хаалттай жагсаалтын сөрөг тал бол сонгогчид тухайн намаас сонгогдох төлөөлөгчид хэн байхыг тодорхойлох эрхгүй гэсэн үг. Хаалттай жагсаалт нь үйл явдлын гэнэтийн огцом өөрчлөлтөд уян хатан бус байдаг. Хоёр Герман нэгдэхийн өмнөх 1990 оны Зүүн Германы сонгуулийн үеэр нэгэн намын дээгүүр зэрэглэлийн нэр дэвшигч цагдаагийн нууц мэдээлэгч байсан нь санал хураалтаас дөрөвхөн хоногийн өмнө мэдэгдэж, тэр дор нь намаасаа хөөгдсөн ч тус намын жагсаалт хаалттай байсан учраас сонгогчид түүнийг нэр дэвшүүлсэн намд санал өгөхөөс өөр сонголтгүй байжээ.

124. Баруун Европын ЖХТТ бүхий орнууд нээлттэй жагсаалт хэрэглэдэг нь сонгогчид дан ганц намд төдийгүй тухайн намаас нэр дэвшсэн хүнд санал өгөх боломж олгодог. Нээлттэй жагсаалттай орнуудын ихэнхэд нь сонгогч нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх, эсвэл намын төлөө саналаа өгөх нь өөрийнх нь үзэмжийн асуудал байдаг бөгөөд сонгогчид намын төлөө санал өгөх нь түгээмэл байдаг. Үүнтэй холбоотой саналын хуудсан дээрх нэр дэвшигчийг сонгох боломж үр нөлөө муутай байх нь олонтаа. Харин Швед Улсад нийт сонгогчдын 25 гаруй хувь нь нэр дэвшигчийн болон намын аль алинд саналаа өгдөг бөгөөд хэрвээ хаалттай жагсаалттай байсан бол сонгогдохооргүй байсан цөөнгүй хүмүүс сонгогдсон байдаг.

125. Бразил (жишээг үзнэ үү) болон Финляндад сонгогч саналаа нэр дэвшигчдийн төлөө өгөх *ёстой* ба нэр дэвшигчдийн авсан нийт саналын тоогоор намын авах суудлын тоог тодорхойлдог. Нам нь нэр дэвшигчдийн сонгогдох дарааллыг хүн бүрийн хувиараа авсан саналын тоонд үндэслэн тогтооно. Энэ зохицуулалт нь сонгогчдын хувьд дэвшигчдийн дотроос сонголт хийх боломж нээх сайн талтай ч зарим нэг сөрөг нөлөө дагуулдаг. Тухайлбал, нэг намын нэр дэвшигчид саналын төлөө өөр хоорондоо эрчимтэй өрсөлддөгөөс болж нам дотор хагарал, зөрчил үүсэхэд хүргэж болох талтай. Түүнчлэн жагсаалт нээлттэй байх нь цөөнхийн төлөөллийг тэнцвэртэй хангасан нэр дэвшигчдийн жагсаалт намд ашиггүй байх сөрөг нөлөөтэй. Тухайлбал Шри-Ланкад нээлттэй жагсаалттай ХТТ-оор зохион байгуулсан сонгуульд Синьхал үндэстний томоохон намууд Тамил үндэстний цөөнхийн нэр дэвшигчдийг намын жагсаалтдаа суудал авахуйц байрлалд жагсаасан боловч үр дүнд хүрээгүй байна. Учир нь олон сонгогч зориуд жагсаалтын доод хэсэгт байрласан Синьхал үндэстний нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн байжээ. Косовод хаалттай жагсаалтаас нээлттэй жагсаалтад шилжсэн нь илүү туйлширсан үзэлтэй нэр дэвшигчдийн тоог нэмэгдүүлсэн байна. Үүний нэг адилаар нээлттэй жагсаалт нь эцгийн эрхт ёс угшсан нийгэмд эмэгтэй нэр дэвшигчдэд ашиггүй болох нь заримдаа нотлогддог. Харин Польшийн сонгогчид хаалттай жагсаалтын оронд нээлттэй жагсаалтаар илүү олон нэр дэвшигч эмэгтэйг сонгоход бэлэн гэдгээ нотлон харуулсан байдаг.

Нээлттэй жагсаалттай хувь
тэнцүүлсэн тогтолцоотой
Дани Улсын саналын хуудас

Sønderjyllands amts 2. kreds

Folketingsvalget 1994

A. Socialdemokratiet
Lis Greibe
Bent K. Andersen
Inger Bierbaum
Dorte Dinesen
Steen Jønsson
Poul Qvist Jørgensen
Karsten Meyer Olesen
B. Det Radikale Venstre
Jes P. Asmussen
Arne J. Carstensen
Birthe Clausen
Horst Gronwald
Kaj Smedemark
Niels Erik Tyge
Mikkel Wold
C. Det Konservative Folkeparti
Bente Witt
Bent Have
Kaj Ikast
Kirsten Lyck
Hans Chr. Madsen
Jens Rønholdt
Jakob Aakjær
D. Centrum-Demokraterne
Jan R. Arentoft
Flemming Hübschmann
Bent Olsen
Carl J. Tønder
F. Socialistisk Folkeparti
Jørn Ulrik Larsen
Helge C. Jacobsen
Karin Petersen
Kent Glumso
Jørgen Jørgensen

Хаалттай жагсаалттай хувь
тэнцүүлсэн тогтолцоотой
Никарагуа Улсын саналын хуудас

BOLETA ELECTORAL PARA REPRESENTANTES ANTE LA ASAMBLEA NACIONAL
CONSEJO SUPREMO ELECTORAL
REPUBLICA DE NICARAGUA

REGION 5

1	2	3	4	5	6	7	8	9	10
UNO	PSOC	PLIUN	PRT	FSLN	MAP-ML	PSC	PUCA	PCDN	MUR
UNION NACIONAL OPOSITORA	PARTIDO SOCIAL CONSERVATISMO	PARTIDO LIBERAL DE UNIDAD NACIONAL	PARTIDO REVOLUCIONARIO DE LOS TRABAJADORES	FRENTE SANDINISTA DE LIBERACION NACIONAL	PARTIDO MARXISTA LENINISTA	PARTIDO SOCIAL CRISTIANO	PARTIDO UNIONISTA CENTRO AMERICANO	PARTIDO CONSERVADOR DEMOCRATA DE NICARAGUA	MOVIMIENTO DE UNIDAD REVOLUCIONARIA
PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS	PROPIETARIOS
SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE	SUPLENTE

MUESTRA

Сонгуулийн тогтолцоо, түүний үр дагавар

БРАЗИЛ УЛС: Ерөнхийлөгчийн засаглал ба нэр дэвшигч төвтэй хувь тэнцүүлсэн тогтолцоо

Жозе Антонио Чейбаб

2002 онд Бразилчууд шинэ ерөнхийлөгчөө болон хоёр танхимт үндэсний хууль тогтоох байгууллага, холбооны бүрэлдэхүүнд орсон нэгжийн захирагчид (26 муж болон Бразилиа хот), түүнчлэн мужийн нэг танхимт хууль тогтоох хурлын гишүүдийг сонгох сонгуульд санал өгсөн юм. Энэ нь 1995 онд цэргийн дэглэм нуран унаснаас хойш ерөнхийлөгчөө болон төрийн бусад өндөр албан тушаалтнуудыг сонгосон дөрөв дэх шууд сонгууль байлаа.

Бразилд ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай олонхийн тогтолцоогоор явагддаг бөгөөд нэр дэвшигчид тус улсын 8,511,965 шоо дөрвөлжин километр өргөнүүдэд нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгогчдын саналын төлөө өрсөлддөг. 1997 оны зургадугаар сард батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ерөнхийлөгчийн албан тушаалд сонгогдсон хүн дахин нэг удаа сонгуульд өрсөлдөх боломжтой байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг батлах үед эрх барьж байсан ерөнхийлөгч Фернандо Генрих Кардосо 1998 оны сонгуульд дахин нэр дэвшиж, эхний шатанд 53,1 хувийн саналаар ялалт байгуулсан. Харин 2002 оны сонгуульд ерөнхийлөгч Луиз Инэсио Лула да Силва эхнийн шатанд 46 хувийн санал авч, хоёр дахь шатны халз өрсөлдөөнөөр ялалт байгуулсан байна.

Хууль тогтоох байгууллагыг сонгохтой холбоотой хууль, дүрэм журам анх 1946 онд батлагдан гарснаас хойш бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. Тус улсын Сенат нь Бразилийн бүх мужийн төлөөллөөс бүрдсэн танхим байдаг. Тухайлбал, холбооны гишүүн 27 муж тус бүр гурван нэр дэвшигчийг найман жилийн хугацаатайгаар олонхийн саналаар сонгодог байна. Дөрвөн жил тутамд сенатийн танхимын гуравны нэг юмуу гуравны хоёр нь сэлгэн сонгогдох бөгөөд нэг тойргоос хоёр сенатор сонгогдох

тохиолдолд сонгогчид багц саналын тогтолцоо (БСТ)-гоор хоёр санал өгдөг.

Төлөөлөгчдийн танхим 513 гишүүнтэй ба тэд 26 муж ба Бразилиа хотыг оруулаад нийт 27 олон мандаттай тойрогт өрсөлдөн сонгогддог. Тойргийн хэмжээг хүн амын тоог харгалзан тодорхойлох бөгөөд нэг тойрог доодтал нь найм, дээдтал нь 70 мандаттай байх хязгаарлалт тавьдаг. Сонгуулийг нээлттэй жагсаалт бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоогоор явуулдаг байна. Сонгогч бүр нэг санал өгөх ба намд юмуу эсвэл нэр дэвшигчийн аль нэгнийг дэмжиж саналаа илэрхийлэх боломжтой. Нэр дэвшигчдэд өгсөн саналыг нэгтгэн намд өгсөн нийт санал дээр нэмж, нийлбэр дүнгээр нь намын авах суудлын тоог тогтоодог. Намын жагсаалт дахь нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүмүүс тухайн намд хуваарилсан суудлыг авч сонгогддог байна. Суудлын хуваарилалтыг 1950 оноос хойш Д'Хондтын томъёогоор хийж иржээ. Тойргийн квотод хүрч чадаагүй намууд суудлын хуваарилалтаас хасагддаг. 1998 он хүртэл энэ квотын тооцоог нийт хүчинтэй ба хоосон саналын тоонд тулгуурлан хийж байсан нь санал босго нэлээд өндөрсгөх нөлөө үзүүлжээ.

Зориудын тэнцвэргүй хуваарилалт

Төлөөлөгчдийн танхимын сонгууль Бразилийн сонгуулийн тогтолцоонд магадгүй хамгийн маргаантайд тооцогдох элемент гэхэд болно. Сонгуулийн тойргийн хэмжээний дээд, доод хязгаараас үүдэлтэй төлөөлөгчдийн танхим дахь мужуудийн төлөөлөл хүн амын тоотой харьцуулахад тэгш бус. Тухайлбал, 25 сая хүн амтай, 70 гаруй суудалтай Сан Паулод нэг төлөөлөгчийг сонгоход шаардлагатай саналын тоо нь 290,000 орчим хүн амтай, найман суудалтай Амапэгийнхаас даруй арав дахин их байгаа учраас “нэг хүн, нэг санал, ижил үнэ цэнэ” гэсэн зарчмыг ноцтой зөрчиж байгаа хэрэг юм. Энэхүү тэнцвэргүй хуваарилалт нь хүн ам багатай ядуу дорой, хөдөө аж ахуйгаас хамааралтай мужуудад ашигтай байдаг бол илүү баян чинээлэг, аж үйлдвэржсэн томоохон мужуудад ашиг багатай. Улмаар үүнийг улс төр дэх уламжлалыг шүтэх үзэл хандлагыг бэхжүүлж, улс төрийн намуудыг сулруулах нөлөө үзүүлж ирсэн гэж шүүмжлэх нь олонтаа.

Гэхдээ үүнийг бас ялгаж салгаж, наана цаанатай нь ойлгох хэрэгтэй. Тэнцвэргүй хуваарилалтаас болж хамгийн их хохирч буй ганц муж бол Сан Пауло муж юм. Хэрэв эндэхийн хүн амын тоог нарийн тооцож зөв хуваарилах юм бол төлөөлөгчдийнх нь тоо 40 орчим хувиар нэмэгдэх боломжтой. Бусад зарим нэг мужийн хувьд нөхцөл байдал харьцангуй дээр буюу Сан Паулогийн дараа орох Минас Герайс муж гэхэд хүн амынх

нь тоотой харьцуулахад зөвхөн дөрөв орчим төлөөлөгч дутуу байна. Эндээс тэнцвэргүй хуваарилалт ерөнхийдөө нэг газар төвлөрсөн байгаа илэрхий харагдана. Үүнийг 1946 онд Үндсэн хуулийг боловсруулахад тодорхой зорилготой хийсэн ажээ. Тодруулбал, анхны Бүгд Найрамдах Улсын үед (1899-1930 он) холбооны хэмжээнд ноёрхож байсан Сан Пауло мужийн (Минас Герайсын хувьд арай бага хэмжээгээр) нөлөөг багасгах нь Үндсэн хуулийг батлахад нэг чухал асуудал болж тавигдаж байсантай холбоотой юм.

Мандатын тэнцвэргүй хуваарилалт нь харьцангуй ядуу буурай мужуудыг улс төрийн хувьд дэмжиж улмаар бүс нутагт баялгийн тэгш хуваарилалтыг хөхиүлэн дэмжих зорилго агуулдаг агаад Бразил шиг бүс нутгийн тэгш бус байдал өндөртэй орны хувьд энэ нь чухал үр дагавар бүхий зохицуулалт юм.

Түүнчлэн төлөөллөөр давуу мужууд үндэсний эрх ашгийг хөндсөн хууль тогтоомжид зохион байгуулалттайгаар хориг тавьж, саад учруулах боломжтой гэсэн таамаглал сонсогддог ч хараахан нотлогдоогүй хэвээр байна. Төлөөлөл ихтэй мужуудын улс төрийн онцлог хэв шинж дутуу төлөөлөлтэй мужуудынхаас заавал ялгаатай байх албагүй. Гэвч нутгархах үзэл бүх мужид байдаг төдийгүй сонгууль бол асар их өрсөлдөөн бий болгодог олныг хамарсан үзэгдэл байдаг. Хэрвээ Бразилийн улс төрийг нутгархах, тойрогтоо үйлчлэх сэтгэлгээ тодорхойлдог гэж үзэх юм бол Төлөөлөгчдийн танхимын суудлын тэнцвэргүй хуваарилалт түүний цорын ганц шалтгаан гэж үзэх нь өрөөсгөл юм.

Нам хоорондын болон нам доторх өрсөлдөөн

Төлөөлөгчдийн танхимын сонгуулийг явуулдаг нээлттэй жагсаалт бүхий ХТТ-ны гол онцлог нь нам хоорондын болон нам доторх өрсөлдөөний аль алиныг өдөөдөг явдал юм. Сонгууль нь олон оролцогчтой, нэлээд ширүүн өрсөлдөөнтэй явагддаг. Жишээлбэл, 2002 онд төлөөлөгчдийн танхимын 513 суудлын төлөө нийт 4,901 нэр дэвшигч өрсөлджээ. Нийт 27 тойргийн дөнгөж есөд нь 100 хүрэхгүй нэр дэвшигч оролцсоноос хамгийн бага нь Токатинс мужийн найман суудлын төлөө 66 нэр дэвшигч өрсөлдсөн байна. Харин Сан Паулогийн 70 суудалд 793 нэр дэвшигч, Риогийн 46 суудалд 602, Минас Герайсын 53 суудалд 554 нэр дэвшигч өрсөлдсөн ажээ. Намууд өөр хоорондоо өрсөлдөхийн сацуу намын нэрээр авсан суудалд сонгогдохыг хүсч буй нэр дэвшигчид өөр хоорондоо өрсөлддөг байна. Сонгогчид, төлөөлөгчдийн хооронд үйлчлэгч, хэрэглэгчийн хэлхээ холбоо тогтож, үндэсний хууль тогтоох байгууллага нь бодлогын чанартай үндэсний хэмжээний тоомоохон асуудалд бус харин орон нутгийн жижиг сажиг асуудалд голлон

анхаарахад хүргэдэг явдал Бразилийн Улс төрийн намуудын сул дорой байдлын уг үндэс болдог гэж үзэх нь бий.

Гэвч дээрх шүүмжлэлийг мөн л нухацтай, олон талаас нь авч үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, Бразилийн сонгогчдын шийдвэрт хувь хүний үйл ажиллагаа голлон нөлөөлдөг гэж үзэж бас болохгүй. Нийт саналын тоонд эрэмбэт саналын (сонгогчид зөвхөн намыг бус, тодорхой нэг нэр дэвшигчийг сонгодог) эзлэх хувь намын саналын эзлэх хувиас хамаагүй их байдаг боловч энэ тооноос сонгогчид яг яаж санал өгдөгийг тодорхойлох аргагүй байдаг. Сонгогчид нь хувь хүнд намаас илүү ач холбогдол өгдөг бол тодорхой нэг нэр дэвшигчийн төлөө санал өгч байгаа хүмүүс тухайн нэр дэвшигч намаа өөрчилсөн ч гэсэн түүний төлөө саналаа өгнө гэсэн үг. Энэ асуудлыг шууд авч үзсэн ямар нэг судалгаа байхгүй ч янз бүрийн нотлох баримтаас үзэхэд хууль тогтоох байгууллагад ажиллах сонгуульт хугацаанд намаа сольсон нэр дэвшигчид дахин сонгогдох магадлал багатай байдаг. Энэ нь анх өөрийг нь дэмжиж сонгосон сонгогчдын итгэлийг даах чадваргүй болохоо харуулж байна гэж ойлгогддог гэсэн үг юм.

Сонгогчид ба тэдний сонгосон төлөөлөгчдийн хоорондын холбоо

Сонгогчид ба тэдний төлөөлөгчдийн хороондын хэлхээ холбооны талаар бодитой судалгаа, мэдээлэл ховор. Гэвч тойрогтоо үйлчлэх сэтгэлгээ нь сонгуулийн кампанит ажлаа амжилттай явуулж хууль тогтоох байгууллагад удаа дараа сонгогдох үндэс суурь болдог гэдгийг нотлох гэж багагүй хүчин чармайлт тавьж ирсэн тохиолдлууд байна. Энэ үзлээр бол тойрогтоо хамгийн “буян болсон” нэр дэвшигч амжилт гаргадаг. Гэтэл Бразилийн олон мандаттай тойргийн тогтолцоонд сонгогдсон гишүүн бүр тухайн тойргийг төлөөлөх хэд хэдэн (доод тал нь найман) гишүүний нэг байдаг учраас тодорхой нэг гишүүнийг аль нэг шинэ төсөлд зарцуулах хөрөнгийг гаргах шийдвэртэй холбож үзэхэд хэцүү байдаг. Хэдийгээр зарим нэр дэвшигчид сонгуулийн тойргийг газар зүйн хувьд өөрсдөдөө тохируулан сонгож авах боломжтой, бас ингэхийг оролддог ч энэ нь Төлөөлөгчдийн танхимд орох цорын ганц арга биш болохын зэрэгцээ хамгийн үр дүнтэй арга ч биш юм. Амжилттай өрсөлдөж ялалт байгуулсан нэр дэвшигчдэд өгсөн нийт саналын газар зүйн тархалтын тухай нэгэн судалгаанаас үзэхэд, 1994, 1998 оны сонгуульд ялсан төлөөлөгчдийн дөнгөж 17 хувь нь ийм стратеги хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, 17 хувь нь л төвлөрсөн нэг газраас өндөр хувийн санал авч чадсан байна. Харин бусад нь тодорхой бүс нутгийг өрсөлдөгчидтэйгээ хуваалцах, бие биеэсээ алслагдмал нутгуудад давамгайлах, газар зүйн хувьд тархай бутархай хэсгээс нийт саналынхаа зарим хэсгийг цуглуулах гэх мэт янз бүрийн

стратеги хэрэглэсэн байна. Сонгууль нь өрсөлдөөнтэй явагддаг, хуулиар нэг мөр тогтоосон тойргууд гэж байхгүй учир аливаа төлөөлөгч тодорхой тойргийн дэмжлэгийг дахин авна гэж итгэлтэй байх үндэслэл хомс. Үнэн хэрэгтээ, дахин сонгогдох хувь тийм ч өндөр биш буюу сонгуульд дахин өрсөлдөхийг хүссэн хүмүүсийн 60 орчим хувь байдаг гэсэн тооцоо байдаг. Иймээс сонгогчид ба төлөөлөгчдийн хэлхээ холбоог нутгархах үзэл тодорхойлдоггүй, үгүйдээ л дангаар тодорхойлдоггүй нь харагдаж байна.

Сонгуулийн тогтолцоо намын хагарал бутралд нөлөөлдөг үү?

Бразилд байгаа нээлттэй жагсаалтаар томсгосон тойргуудад санал хураадаг хувь тэнцүүлсэн тогтолцооны талаар судалж мэдэх шаардлагатай зүйл олон хэвээр байна. Гэхдээ ийм тогтолцоонд сонгууль туйлын өрсөлдөөнтэй явагддаг, сонгогдоод ажиллаж байгаа гишүүдийн давуу тал харьцангуй бага байдаг, төлөөлөгчдийн сонгуулийн тойрогтойгоо тогтоосон харилцаа харилцан адилгүй байдаг, улмаар нэр дэвшигч сонгуульд амжилттай оролцоход зонхилох стратеги гэж байдаггүй болох нь илэрхий байна.

Төлөөлөгчдийн танхим дотор нутгархах, тойрогт үйлчлэх сэтгэлгээ, хувийн тоглолт бий болоход сонгуулийн тогтолцоо ямар нэг хэмжээгээр нөлөөлж байна гэдэг нь маргаантай асуудал юм. Сонгогдсон төлөөлөгчдийн хувийн зан байдлыг төлөвшүүлэхийн тулд ерөнхийлөгчөөс болон намын удирдлагуудаас авч хэрэглэдэг механизмуудын талаар ярих нь энэхүү тоймын хүрээнээс хальсан хэрэг хэдий ч төлөөлөгчдийн хувьд ч орон нутгийн чанартай, явцуу хүрээний шаардлагуудаас гадна бусад олон тооны дарамт шахалттай тулгарч байдаг. Эдгээр дарамт нь нам доторх хагарал бутралын эсрэг тэнцвэржүүлэгч байдлаар үйлчилдэг.

Бразилийн хууль тогтоох байгууллага дахь намуудын хагарал сүүлийн 15 жилд тус орны туулсан олон тооны хүндрэл бэрхшээлийн шалтгаан болсон гэж үзсээр ирсэн. Намын тогтолцоонд хагарал бутрал их байгааг гол төлөв хэд хэдэн хүчин зүйл хавсран нийлснээр тайлбарладаг. Үүнд сонгуулийн тогтолцоо, түүний нэр дэвшигчдийн өрсөлдөх чадварыг дөвийлгөх нөлөө, ерөнхийлөгчийн тогтолцооны онцлог шинж, 1988 оны үндсэн хуулиар батлагдсан холбооны улсын хүчтэй тогтолцоо зэргийг оролцуулан тооцож болно.

Харин Төлөөлөгчдийн танхим дахь хагарал ерөнхийдөө савнаасаа халилгүй, нөлөө бүхий намын тоо 1990 оноос хойш найм орчимд эргэлдэж байна. Сонгуулийн хуулийн зарим заалт томоохон намуудыг дэмжих хандлагатай байж, хагарал бутралын эсрэг тэнцвэр бий болгодог. Тухайлбал, сонгуулийн квот тооцоходоо хоосон саналын хуудсуудыг нэмэх

(энэ квотыг улам өндөр, давахад хэцүү болгодог), аль нэг тойргоос квотод хүрэх санал аваагүй намуудыг үлдэх суудлын хуваарилалтаас хасах гэх мэт заалтуудыг хэлж болно.

Ерөнхийлөгчийн засаглал ба намын тогтолцооны хоорондын уялдаа холбоо тийм ч тодорхой ойлгомжтой биш. Үүнтэй холбоотой холбооны улсын зарчим нь намын тогтолцооны хагарал бутралын нэг шалтгаан болж байна уу гэх асуулт урган гарна. Бразилийн үндэсний зарим нам бодит байдал дээр бүс нутгийн жижиг намуудын эвсэл байдаг. Эдгээр эвслээс цэвэр орон нутгийн чанартай жижиг намууд төрөн гарч улмаар үндэсний хэмжээнд олон нам бий болоход хүргэдэг. Гэвч энэ нь шинэ намууд яагаад олноор төрөн гарсаар байгаагийн бодит, цорын ганц шалтгаан мөн үү? Түүнчлэн холбооны улсын тогтолцоо нь намууд хагарч бутраад байгаагийн нэг шалтгаан мөн эсэх, аль эсвэл дээрх үзэгдэл ердөө л Бразил шиг том улсад ардчилсан байдлаар зохицон орших ёстой бүс нутгийн олон янзын ашиг сонирхлын тусгал эсэх нь тодорхойгүй хэвээр үлдэж байна.

126. Нээлттэй жагсаалтын тогтолцоонд нэмэлт уян хатан байдал бий болгоход чиглэсэн бусад арга хэрэгслийг цөөн тооны улсад ашигладаг. Люксембург, Швейцар улсуудад сонгогчид мандатын тоогоор санал өгдөг бөгөөд саналаа нэг намын жагсаалтад байгаа нэр дэвшигчдэд хуваан өгөх эсвэл хэд хэдэн намын нэр дэвшигчид өгөх боломжтой. Янз бүрийн намын жагсаалтаас сонгон нэгээс дээш нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх (*panachage*), эсвэл маш их дэмждэг нэг нэр дэвшигчийнхээ төлөө нэгээс дээш тооны санал өгөх (*cumulation*) нь сонгогчдын саналаа илэрхийлэх боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд эдгээрийг энэ номд чөлөөт жагсаалтын тогтолцоо гэж ангилсан байгаа.

Холбоотны журмаар ажиллах нь

127. Хуулиар тогтоосон босго өндөр байх нь жижиг намуудыг ялгаварлан гадуурхах нөлөө үзүүлдэг бөгөөд зарим тохиолдолд угаасаа ийм далд зорилготой байдаг. Гэвч ерөнхийдөө жижиг намуудыг зориуд ялгаварлан гадуурхах нь сайн зүйлд тооцогддоггүй. Ялангуяа, дэмжигчид нэгтэй жижиг намууд сонгуульд тус тусдаа өрсөлдөхөд нийт авах ёстой саналаа “хувааж”, улмаар бүгд босго давж чадахгүй үлдэх нь бий. Энэ асуудлыг тойрч гарах үүднээс ЖХТТ ашигладаг зарим оронд жижиг намууд сонгуульд нэгдэж орохыг зөвшөөрдөг бөгөөд улмаар тэд сонгуульд өрсөлдөхийн тулд ямар нэг бүлэглэл (*apparentement, stembusaccoord*) үүсгэдэг. Ийнхүү нэгдсэн намууд тус тусдаа хуулийн этгээд хэвээр үлдэх ба саналын хуудсан дээр ч нэр нь тус тусдаа бичигдэнэ, гагцхүү тус бүрийнх нь авсан саналыг нэг бүлэглэлд хамааруулан нэгтгэж тоолдог. Ингэснээр нийт саналын дүн нь тогтоосон босгод хүрэх боломж бүрдэж, улмаар хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болох бололцоо нээгдэнэ. Энэ аргыг нь Европ, Латин Америк (ийм намуудыг *лема* гэж нэрлэдэг) болон Израильд хэрэглэдэг. Африк, Ази тивд ховор тохиолдох бөгөөд Индонезид 1999 оноос дээрх аргыг хэрэглэхээ больсон нь тус улсын зарим жижиг нам бүлэглэлийн хэмжээнд суудалтай болсон боловч үнэн хэрэгтээ намууд өөрт ногдох суудлаа алдаж байна гэж үзсэнтэй холбоотой.

Холимог тогтолцоо

128. Сонгуулийн холимог тогтолцоо нь олонхийн (эсвэл “бусад”) болон ХТТ-ны аль алиных нь эерэг шинжийг нэгтгэн тусгах зорилго агуулна. Холимог тогтолцоонд хоёр өөр томъёо бүхий тогтолцоогоор сонгуулийг явуулах ба суудал хуваарилахад аль аль тогтолцоо нь нөлөөтэй байна. Ийм тогтолцооны бүтцэд ихэвчлэн нэг мандаттай тойргоор санал хураадаг олонхийн тогтолцоо (хааяа өөр бусад тогтолцоо) болон ЖХТТ байдаг. Холимог тогтолцоо хоёр хэлбэртэй. Хувь тэнцүүлсэн суудлын хуваарилалт

нь олонхийн тогтолцоогоор (эсвэл бусад) сонгууль явуулсан тойргийн суудал яаж хуваарилагдсанаас хамаарч, тэнд үүссэн пропорциональ бус байдлыг нөхөж өгөх байдлаар хоёр төрлийн сонгуулийн үр дүн харилцан уялдаатай гардаг тогтолцоог холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо гэж нэрлэдэг. Харин хоёр төрлийн сонгууль тусдаа явагдаж, үр дүн нь өөр хоорондоо ялгаатай байдаг, суудлын хуваарилалтын хувьд бие биеэсээ хамааралгүй явагддаг тогтолцоог параллель тогтолцоо гэж нэрлэдэг. ХХТТ нь ерөнхийдөө пропорциональ үр дүн гаргадаг бол, параллель тогтолцооны пропорциональ байдал нь мажоритар тогтолцоо ба хувь тэнцүүлсэн тогтолцоо хоёрын хаа нэгтээ дунд хавьд нь оршдог.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ)

129. ХХТТ-ны хувьд тойргуудад суудал хуваарилахад үүссэн пропорциональ бус үр дүнг нөхөх байдлаар хувь тэнцүүлэх зарчмыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, аль нэг нам үндэсний хэмжээнд 10 хувийн санал авсан боловч сонгуулийн аль ч тойрогт суудал авч чадаагүй бол хувь тэнцүүлэх зарчмаар хууль тогтоох байгууллагад 10 хүртэл хувийн суудалтай болох боломжтой гэсэн үг юм. Сонгогчид Герман, Шинэ Зеландад байдаг шиг хоёр тусдаа сонголт хийж болно. Нөгөөтэйгүүр сонгогчид зөвхөн ганцхан сонголт хийж болох бөгөөд тойрог бүрт нэр дэвшигчдийн хувиараа авсан саналын дүнгээр тухайн намын авсан нийт саналын тоог гаргаж болно.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо бол сонгогчдын саналыг хоёр өөр тогтолцоогоор буюу нэг нь ихэвчлэн намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ), нөгөө нь ихэвчлэн олонхийн тогтолцоогоор дамжуулан суудалд шилжүүлэх тогтолцоо бөгөөд ЖХТТ нь олонхийн тогтолцооноос үүссэн пропорциональ бус байдлыг нөхдөг.

Хүснэгт 4. ХХТТ-г ашиглаж буй орнууд

Улс	Хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилах суудлын тоо	Олонхийн/мажоритар (эсвэл бусад) зарчмаар хуваарилах суудлын тоо	Олонхийн тогтолцооны (эсвэл бусад) хувилбар	Нийт суудлын тоо
Албани	40 (29%)	100 (71%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	140
Болив	62 (48%)	68 (52%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	130
Герман	299 (50%)	299 (50%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	598
Унгар	210 (54%)	176 (46%)	Хоёр шатлалт тогтолцоо	386
Итали	155 (25%)	475 (75%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	630
Лесото	40 (33%)	80 (67%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	120
Мексик	200 (40%)	300 (60%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	500
Шинэ Зеланд	55 (46%)	65 (54%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	120
Венесуэл	65 (39%)	100 (61%)	Харьцангуй олонхийн тогтолцоо	165

130. ХХТТ-г Албани, Болив, Герман, Унгар, Итали, Лесото, Мексик, Шинэ Зеланд, Венесуэл улсуудад хэрэглэдэг. Эдгээрийн нэгээс бусдад нь тойргийн суудалд сонгогдох гишүүдийг харьцангуй олонхийн тогтолцоогоор сонгодог. Харин Унгар Улс хоёр шаттай тогтолцоо ашигладаг бөгөөд Италийн тогтолцоо нэлээд нарийн түвэгтэй байдаг. Үүнд доод танхимын суудлуудын дөрөвний нэгийг нэг мандаттай тойргийн сонгуульд үрэгдсэн саналуудыг нөхөх үүднээс хадгалж үлддэг. Венесуэлд ХОТ-оор сонгогдох 100 суудал байдаг, үлдэх суудлыг үндэсний хэмжээнд ЖХТТ зарчмаар хуваарилах болон нэмэлт урамшууллын суудлууд эзэлдэг. Мексикт (жишээ судалгаанаас үзнэ үү) ХОТ-ны 300 суудлын хуваарилалтад гарсан тэнцвэргүй байдлыг (ихэвчлэн өндөр гардаг) ЖХТТ-ны зарчмаар хуваарилдаг 200 суудлаар нөхдөг байна. Зөрчил мөргөлдөөний дараах үеийн Лесотогийн сонгуулийн тогтолцоо гэхэд ХОТ-ны 80 суудал, нэмэлт 40 суудалтай байв.

ЛЕСОТО УЛС: Африк тивийн анхны холимог хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоо

Юрген Элклит

1998 оны тавдугаар сард болсон Үндэсний Ассамблейн ээлжит сонгуулийн үр дүн маш тодорхой байлаа. Эрх баригч Лесотогийн Ардчиллын Конгресс (ЛАК) сонгуульд илт давуу ялалт байгуулж, Үндэсний Ассамблейн 80 суудлын 79-г нь авсан байна.

Цорын ганц асуудал нь ЛАК нийт сонгогчдын 60 гаруйхан хувийн дэмжлэг авсан явдал байв. Авсан суудлын тооны хувьд ийм үр дүн гарсан нь харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ) улс төрийн намуудын авсан саналын эзлэх хувь ба авсан суудлын эзлэх хувийн хооронд ямар их зөрүүтэй үр дүнд хүргэдгийг харуулах нэг тод жишээ болсон юм. Энэ төрлийн зөрүүтэй байдал урьд нь ч бас гарч байсан учраас гэнэтийн явдал биш байлаа. Гэвч үүний дараа ялагдсан намууд, ялангуяа сөрөг хүчний гол нам болох Басотогийн Үндэсний Нам (БҮН) сонгууль “бохир аргаар” явагдлаа хэмээн орь дуу тавьж эхэлсэн юм. Энэ нь шинэ зүйл байсангүй, харин 1998 оны сонгуулийн үр дүн ерөнхийдөө зөв байсан эсэхийг янз бүрээр буруутгасан шүүмжлэл сонин хэвлэлээр нийтлэгдсний дараа нийслэл хот Масеругийн гудамжинд олон нийтийн эсэргүүцэл тэмцэл өрнөж, улсын болон амины барилга байшинг галдан шатааж дэлбэлэх хүртэл ширүүссэн нь гунигтай бөгөөд гэнэтийн явдал байлаа.

Тус улсын засгийн газар Өмнөд Африкийн Хөгжлийн Хамтын Нийгэмлэгээс тусламж хүсч, ӨАХХН ч гол төлөв Өмнөд Африк Улсын зэвсэгт хүчнээс бүрэлдсэн цэрэг оруулсан байна. Дэг журмыг сэргээн тогтоож 1998 оны 10 дугаар сарын 2-нд тохиролцоонд хүрснийг хожим ӨАХХН-ээс баталгаажуулсан байна. Энэ тохиролцоогоор Улс төрийн түр зөвлөл (УТТЗ) байгуулж, тус байгууллагын сонгуульд нэр дэвшүүлсэн 12 намд сонгуулиар их бага дэмжлэг авснаас нь үл хамааран тус бүр хоёр

суудал олгох болсон байна. УТТЗ-ийн зорилго бол шинэ сонгуулийн тогтолцоо боловсруулах, Лесотогийн ардчилсан хөгжлийг энхийн замаар бэхжүүлэхэд чиглэсэн улс төр, захиргааны бусад арга хэмжээг санал болгох явдал байв. Гэхдээ бүх санал зөвлөмжийг засгийн газарт илгээж, түүнийг нь тогтсон ёсоор Парламентаар хэлэлцэж батлах ёстой байлаа.

УТТЗ байгуулах санааг Өмнөд Африк Улс ардчилсан шилжилтийн үйл явцын эхний үе шатанд яриа хэлэлцээ явуулах институци өргөн хэрэглэж байснаас авсан нь тодорхой байв. Гэвч энэ хоёр үйл явц тэс өөр бөгөөд институцийн шийдэл нь ч өөр байх шаардлагатайг тооцоогүй байлаа. Үүний дараа Лесотод өрнөсөн улс төрийн үйл явц амар хялбар байсангүй. УТТЗ-д сөрөг хүч үнэмлэхүй олонхийн буюу 22 суудалтай байсан бол тухайн үеийн засгийн газар хоёр суудалтай байсан учраас яриа хэлэлцээ явуулах бүтээлч уур амьсгал бүрдэхгүй байсанд гайхах зүйлгүй юм.

Үндэсний Ассамблейд үүний өмнө нэг ч суудал авч үзээгүй байсан УТТЗ-ийн төлөөлөгчид нэг гишүүнт тойргуудыг хэвээр хадгалахын зэрэгцээ дараагийн сонгуульд 1998 оныхоос илүү пропорциональ үр дүнг гаргахуйц сонгуулийн тогтолцоо санал болгох эрмэлзэлтэй байлаа. Мэдээж хэрэг нэг бол ХХТТ, эсвэл параллель тогтолцоо хэрэглэх шийдэл үлдэж байлаа. Германаас сонгуулийн тогтолцооны мэргэжилтэн урьж ирүүлэн илтгэл тавиулсны дараа УТТЗ-ийн гишүүдийн олонхи нь ХХТТ сонгох шийдлийг дэмжиж, зарим суудлыг нэг мандаттай тойргоор, бусад суудлыг намын жагсаалтаар хуваарилах нь зүйтэй гэж үзэх болжээ. Харин хууль тогтоох байгууллагыг бүрэн хяналтдаа авсан ЛАК нөгөө хувилбар болох параллель тогтолцоог дэмжихээр шийдсэн нь нэг мандаттай тойргийн суудлын ихэнх хувийг авахаас гадна үлдэх суудлаас авсан саналынхаа эзлэх хувьтай тэнцэх суудал нэмж авахаар тооцсон байна.

Удалгүй УТТЗ нь ХХТТ-г сонгохоор шийдэхдээ суудал хуваарилах томъёо, албан ёсны сонгуулийн босгын асуудал, нөөц мандатууд, нэг эсвэл хоёр саналын хуудас хэрэглэх эсэх гэх мэт нарийн ширийн практик асуудлуудыг анзаараагүй болох нь тодорхой болсон байна. Хэдийгээр УТТЗ-ийн гишүүд нэг мандаттай 80 тойргийг хэвээр хадгалах нь зүйтэй, тэгэхээр 50 нэмэлт суудалтай байхаас аргагүй гэдэгтэй санал нэг мэт байсан боловч хоёр ангилалд хэд хэдэн суудалтай байх асуудал маргаантай хэвээр байлаа. Сүүлийн санал нь бага зэрэг үндэслэл муутай буюу Лесото Улс өмнө нь 65 нэг мандаттай тойрогтой байсантай холбоотой байв. Хэрэв энэ тоондоо эргэж ороод түүнтэй адил тооны нэмэлт суудалтай болох юм бол (Германых шиг) Үндэсний Ассамблей нийтдээ 130 суудалтай болох байв. Хэрвээ Ассамблейн суудлын хэмжээ 130 байна гээд тухайн үед нэг гишүүнт тойргийн тоо 80 байсан, энэ тоо ойрын ирээдүйд өөрчлөгдөнө гэж үзэхэд хэцүүгэх юм бол үлдэх нэмэлт суудлын тоо 50 байх ёстой байлаа.

Засгийн газар энэ тоог олон шалтгаанаар эсэргүүцсний дотор Лесото Улс жижиг, ядуу буурай орон учраас парламентдаа зохих хэмжээний цөөн тооны суудалтай байх хэрэгтэй гэсэн үндэслэл дэвшүүлж байлаа.

Энэхүү улс төрийн зөрчлийг ойлгоход хялбар байлаа. Улс төрийн гацааны эсрэг институцийн шийдэл олох үүрэгтэй УТТЗ нэг мандаттай 80 тойрогтой, 50 нэмэлт суудалтай ХХТТ-г хүчтэй дэмжиж байхад, УТТЗ-өөс гаргасан бүх саналыг хэлэлцэн батлах үүрэгтэй хууль тогтоох байгууллагыг бүрэн хяналтдаа авсан эрх баригч засгийн газрын зүгээс нэг мандаттай 80 тойргийг хэвээр үлдээж, тусад нь 40 орчим суудал нэмж хуваарилж болох параллель тогтолцоог хамгийн оновчтой шийдэл гэж үзэж байв. Параллель тогтолцооны хувьд хоёр дахь саналын хуудас хэрэглэх боломжтой ч нэг мандаттай тойрогт санал хураасан хуудсаа давхар ашиглах нь зүйтэй гэж үзэж байв.

Сонгуулийн тогтолцооны талаар улс төрийн буулт хийх явц нэлээд цаг авсан нь гол төлөв хоёр талын хоорондын үл итгэлцэл, харилцан буулт хийхийн цаад утга агуулгад зарим талаар эргэлзэж байсантай холбоотой. Яваандаа сонгуулийн тогтолцоо нь ХХТТ байх ёстой (энэ нь сөрөг хүчний гол зорилго байв), суудлын тоо 120 (80+40) байх ёстой (засгийн газрын талын хувьд маш чухал байв) гэдэг дээр тохиролцоонд хүрсэн байна. Засгийн газар парламент дахь олонхийн байр сууриараа дамжуулж бүх хөзрийг гартаа атгаж байсан ч асуудлыг өргөн олноор хүлээн зөвшөөрүүлэх, улмаар нэмэлт өөрчлөлтийн хууль ёсны байдлыг хангахын тулд зарим нэг буулт хийх шаардлагатай нь тодорхой байлаа. Үндсэн хуульд дагалдах нэмэлт өөрчлөлтийг оруулахын тулд дан ганц Үндэсний Ассамблейгаар зогсохгүй, Сенатаас хүчтэй дэмжлэг авах шаардлагатай байсан нь харилцан буулт хийх бас нэг шалтгаан байв. Үүний цаад шалтгаан нь хэрвээ Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт дээр парламентын хоёр танхим тохиролцож чадахгүй бол бүх нийтийн санал асуулга явуулах ёстойг оршиж байв. Сонгогчдын бүртгэлийн асуудлаар санал зөрөлдөж байсан учраас үнэндээ ингэх боломжгүй байлаа. Эцэст нь 2001 оны тавдугаар сард Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг албан ёсоор баталсан байна. Үүний дараа л сонгуулийн хуульд зайлшгүй хийгдэх өөрчлөлтийг авч үзэх боломжтой болов.

1998 оны олон улсаар баталгаажсан гэрээгээр сонгуулийг 2000 оны тавдугаар сард буюу эрт явуулахаар заасан байв. Энэ тов бодитой бус байсан нь засгийн газар, сөрөг хүчин (УТТЗ) хоёр харилцан тохиролцож чадахгүй байснаас төдийгүй шинэ бие даасан Сонгуулийн Хороог дөнгөж дөрөвдүгээр сард томилсонтой холбоотой байв. Тохиролцоонд хүрэх гэсээр байтал нэг жил өнгөрснөөс гадна сонгуулийн тогтолцоо, сонгогчдын бүртгэлийн зүй зохистой тогтолцооны асуудлаар тохиролцох

гэсээр яриа хэлэлцээ дахин сунжирч шинэ сонгуулийг 2002 оны тавдугаар сард сая нэг явуулах боломжтой болсон байна.

Сонгууль ч боломжийн сайхан явагдаж өнгөрөв. Бүхэлдээ гэнэтийн биш ч гэсэн намын нэрээр авах хувь тэнцүүлсэн саналын 55 хувийг авсан ЛАК нийт уудлын 65 хувийг авсан байна. Үүний гол шалтгаан бол тус нам сонгуулийн өдөр явагдсан нэг мандаттай 78 сонгуулийн тойргийн 77-д (үлдэх хоёр тойргийн сонгуулийг нэр дэвшигч нь нас барсан шалтгаанаар хүчингүй болгосон боловч эцэстээ ЛАК ялсан байна) ялалт байгуулсан явдал юм. Энэ тогтолцоонд өлгөөстэй мандат гэж байгаагүй учраас сөрөг хүчин үлдэж байгаа 40 суудлыг бүгдийг нь авсан байна.

Сөрөг хүчний найман намын долоо нь хууль тогтоох байгууллагад суудал авсан нь авсан саналын эзлэх хувь ба суудлын эзлэх хувийн харьцаа талаасаа дутуу төлөөлөлтэй үлдсэн байна. Гэхдээ энэхүү дутуу төлөөлөл нь 1998 оныхтой харьцуулахад хамаагүй бага байсан бөгөөд Лесотогийн Үндэсний Ассамблей одоо улс төрийн төлөөлөл талаасаа нэлээд тэнцүү төлөөлөлтэй болоод байна. Иймээс 1998 оны хямралын дараа тавьсан хүчин чармайлтын үрээр дэвшүүлсэн гол зорилтыг биелүүлж чадсан юм.

Мөн энэ сонгуулиар а) нэг нам нэг мандаттай тойргуудын суудлыг бараг бүгдийг авсан, б) нийт суудлын дөнгөж 33 хувь нь нэмэлт суудал байсан, в) илүүдэл суудал байгаагүй зэрэг хүчин зүйлс нийлээд дараа дараагийн сонгуулиудад тодорхой хэмжээний пропорциональ бус байдал үүсгэсээр байх нь мэдээж юм. Гэхдээ жижиг, ядуу буурай орны хувьд хэтэрхий олон парламентын гишүүнтэй байх хэрэггүй гэж үзэж байсан 1999-2001 оны үеийн улс төрийн харилцан буулт хийх сунжирсан үйл явцын үр дүнд сонгуулийн тогтолцоогоо нэлээд сайжруулж чадсан учраас энэ нь түүнтэй харьцуулахад тийм ч чухал асуудал биш юм.

131. Хэдийгээр ХХТТ пропорциональ үр дүн гаргахад чиглэдэг боловч нэг мандаттай тойргоор явуулсан сонгуулийн үр дүнгийн пропорциональ бус байдал хэт их байснаас жагсаалтаар хуваарилсан суудал түүнийг бүрэн нөхөж хүрэлцэхгүй байх боломжтой. Ялангуяа хувь тэнцүүлэх зарчмаар суудал хуваарилах сонгуулийн тойргуудыг үндэсний түвшинд бус, бүс нутгийн юмуу аймгийн түвшинд тодорхойлсон тохиолдолд ингэх магадлал ихтэй. Аливаа намын хувьд аль нэг муж эсвэл аймгаас намын нэрээр авах ёстой суудлаасаа илүү олон суудлыг олонхийн тогтолцоогоор явуулсан сонгуульд авчихсан байж болно. Энэ асуудлыг шийдэхийн тулд хууль тогтоох байгууллага дахь суудлын тоог бага зэрэг нэмэгдүүлэх замаар пропорциональ байдалд ойртуулж болно. Эдгээр нэмэлт суудлыг нөөц мандатууд буюу *Überhangmandaten* гэж нэрлэдэг. Ийм явдал Германы ихэнх сонгуульд тохиолдсон бөгөөд Шинэ Зеландад ч ингэх боломжтой байдаг. Харин Лесотод бол хууль тогтоох байгууллагын суудлын тоо тогтмол бөгөөд 2002 онд ХХТТ-оор явуулсан анхны сонгуулийн үр дүн бүрэн пропорциональ байж чадаагүй байна (жишээг үзнэ үү).

132. *Давуу ба сул талууд*. ХХТТ нь ХТТ-ны пропорциональ чанарыг хадгалж үлдэхийн зэрэгцээ сонгогдсон төлөөлөгчид тойргийн сонгогчидтой холбоотой байх нөхцөлийг бүрдүүлдэг. Харин сонгогчид хоёр санал өгдөг тохиолдолд (нэгийг нь намд, нөгөөг нь орон нутгаас сонгогдох төлөөлөгчдөө) хууль тогтоох байгууллага дахь суудлын ерөнхий хуваарилалтыг хийх үед орон нутгийн төлөөлөгчдөө өгсөн санал нь намд өгсөн саналаас нь ач холбогдол багатай байдгийг тэр бүр ойлгодоггүй. Цаашилбал, ХХТТ нь хууль тогтоогчдын хоёр бүлгийг бий болгодог. Нэг нь голчлон тойрогтоо хариуцлага хүлээдэг, тойрогтоо уягдсан бүлэг, нөгөө нь үндэсний хэмжээний намын жагсаалтаар сонгогдсон, газар зүйн ямар нэг хэлхээ холбоогүй, зөвхөн намдаа үнэнч бүлэг байдаг. Энэ байдал нь тухайн намаас сонгогдсон хоёр бүлгийн төлөөлөгчдийн эв нэгдэлд нөлөөлж болно.

133. ХХТТ нь сонгогчдын саналыг суудал болгон хувиргахдаа цэвэр ЖХТТ мэт сонгуулийн тогтолцооны нэг адил пропорциональ үр дүн гаргаж болох учраас өмнө дурдсан ХТТ-ны олон давуу болон сул талыг давхар агуулдаг. Гэхдээ зарим үед ЖХТТ-г ХХТТ-оос илүүд үздэгийн нэг шалтгаан бол ХХТТ-оор сонгууль явуулахад “стратегийн санал өгөх” гэдэг гаж үзэгдэл үүсч болдогтой холбоотой. 1996 онд Шинэ Зеландын Уэллингтон Централ тойрогт явагдсан кампанит ажлын үеэр Үндэсний Намын стратегичид өөрийн намын нэрдэвшигчийн төлөө саналаа өгөхгүй байхыг сонгогчдод уриалж байв. Учир нь, ХХТТ-оор бол түүнийг сонгосон

ч Үндэсний Намд нэг ч суудал нэмэгдэхгүй, харин намын жагсаалтаар тэртэй тэргүй авах суудлыг нь орлох төдий гэж тооцсон байна. Иймээс Үндэсний Намын хувьд өөрийнх нь нэр дэвшигчийг дэмжсэн санал “дэмий үрэгдэж” байснаас Үндэсний Намын үзэл баримтлал, бодлогыг хүндэтгэн үздэг өөр нэг намын нэр дэвшигч сонгогдсон нь дээр гэж үзжээ.

МЕКСИК УЛС: Сонгуулийн шинэчлэл дагасан ардчилал

Жеффри А. Уэлдон

Мексик бол хүчтэй, хараат бус хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал бүхий ерөнхийлөгчийн тогтолцоотой улс. Гүйцэтгэх засаглал ба Конгрессийн хоёуланг нь цорын ганц албан ёсны нам болох Институцийн Хувьсгалт Нам (ИХН) гартаа атгаж байсан 1929-1999 оны хугацаанд үлгэр төдий байсан засаглалын эрх мэдлийг хуваах номлол өнөөдөр дахин сэргэж, улс төрийн зонхилох онцлог болсон байна.

Тус улсын ерөнхийлөгчийг харьцангуй олонхийн тогтолцоогоор сонгодог. 1988, 1994 оны сонгуульд ялагчид нийт саналын тал орчим хувийг авч байсан бол 2000 оны сонгуульд ялагч Виценте Фокс дөнгөж 42,5 хувийн саналаар ялалт байгуулсан байна. Хэрвээ эхний үед шатанд аль ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авч чадахгүй бол хамгийн өндөр санал авсан хоёр нэр дэвшигч хоорондоо халз өрсөлдөх сонгууль явуулах талаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай яригдаж байгаа ч биелэлээ олох эсэх нь томоохон намуудын сонгуулийн ирээдүй болон хоёр дахь үеийг зохион байгуулахад гарах зардлын асуудлаас голлон хамаарах нь дамжиггүй.

Ерөнхийлөгчийг зургаан жилийн хугацаатай сонгодог бөгөөд тэрээр дахин хэзээ ч сонгогдох буюу томилогдох ёсгүй. Энэ заалт нь ерөнхийлөгч эрх мэдлээ бэхжүүлэхээс сэргийлдэг боловч нэг удаа сонгогдсон эрхэм эргээд сонгогчидтой нүүр тулан уулзах шаардлагагүй болох учраас хариуцлага хүлээх байдлыг нь бууруулдаг. Ерөнхийлөгчөөр дахин сонгогдохыг хориглосны цаадах үзэл суртлын болон бэлэгдлийн чанартай үндэс суурийг (энэ нь Мексикийн хувьсгалын гол утга санаа байв) авч үзэх юм бол энэ заалтыг ойрын үед хүчингүй болгох магадлал бага юм.

Мексикийн Конгресс хоёр танхимтай. Төлөөлөгчдийн танхим нь гурван жилийн хугацаагаар сонгогддог бол Сенат нь зургаан жилийн хугацаатай сонгогддог (ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаатай давхцуулсан байдаг). Хоёр танхимын сонгуулиуд нь ХОТ болон ЖХТТ-ны бүрэлдэхүүн бүхий холимог тогтолцоогоор явагддаг.

Төлөөлөгчдийн танхим 500 гишүүнтэйгээс 300-г нь нэг мандаттай тойргуудаас (НМТ-ууд) ХОТ-оор, 200-г нь тус бүр 40 мандаттай бүс нутгийн таван тойргоос ЖХТТ-оор сонгодог. ХОТ-ны 300 суудлыг мужуудад хүн амынх нь тоотой хувь тэнцүүлэн хуваарилж, нэг ч муж хоёроос доош төлөөлөлтэй байх ёсгүй гэсэн хязгаарлалт тавьдаг. Сонгуулийн бие даасан байгууллага болох Холбооны Сонгуулийн Институт (ХСИ) мужуудад суудал хуваарилахдаа цэвэр Сэйнт-Лэгүегийн аргыг хэрэглэдэг ажээ. Дараа нь ХСИ-ээс муж бүрт хүн амын тоогоороо бараг тэнцүү НМТ-ууд байгуулдаг бөгөөд хүн амын тоогоор ойролцоо болгохын тулд ерөнхийдөө хот суурин газруудын тогтоосон хилийн заагийг баримталж байгуулахыг илүүтэйд үздэг. Түүнчлэн ЖХТТ-ны зарчмаар хуваарилдаг суудлын эздийг тодруулах 40 мандат бүхий таван том тойрогтой байна. Нам бүр НМТ бүрт нэг нэр дэвшигч дэвшүүлэх ба бүс нутгийн таван тойрог тус бүрт 40 нэр дэвшигчийг эрэмбэлсэн жагсаалт гаргаж танилцуулдаг.

Намууд сонгуульд оролцохын тулд бүтэн юмуу хэсэгчилсэн эвсэл байгуулж, зарим дүүрэгт нэг ижил нэр дэвшигч дэвшүүлж, эсвэл нэр дэвшигчдийн жагсаалтаа хамтран гаргаж болдог. Хэрэв тэд ингэж эвсэхээр болсон тохиолдолд эвслийнхээ дотор сонгогчдын саналыг хэрхэн хуваарилахаа тохирсон гэрээг ХСИ-д ирүүлсэн байх ёстой. Хэрэв намууд ерөнхийлөгчийн сонгуульд эвсэл болж орохоор болсон бол Төлөөлөгчдийн танхим ба Сенатийн сонгуульд ч бас эвсэл байгуулж орох ёстой. 2000 оны ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон гурван нэр дэвшигчийн хоёр нь эвслүүдээс нэр дэвшиж байжээ. 2003 оны хууль тогтоох байгууллагын сонгуульд ИХН ба Ногоон намын хооронд хэсэгчилсэн эвсэл байгуулж оролцохдоо 97 нэг мандаттай тойрогт хамтдаа, 203 тойрогт тус тусдаа нэр дэвшүүлснээс гадна хоёр тусдаа жагсаалт гарган оролцож байв (Эдгээр нам жагсаалтаас сонгогдох нэр дэвшигчиддээ суудал хуваарилахын тулд хамтран нэр дэвшүүлсэн 97 тойрогтоо авсан саналыг яаж хуваахаа урьдаас тохирсон байв.).

Сонгогчид төлөөлөгчдийг сонгохын тулд тус бүр нэг санал өгнө. ХОТ-оор тухайн тойргоос авсан бүх саналын нийлбэр дүнг ашиглаж нам бүрт хувь тэнцүүлэн хуваарилах суудлын тоог тооцдог. Ингэхдээ хамгийн их үлдэгдлийн арга буюу Харегийн квот ашиглах бөгөөд үндэсний хэмжээний нийт саналын хоёр хувьтай тэнцэх босгыг хуульчилсан байна. Аль нэг намд хувь тэнцүүлэн хуваарилах суудлын тоо ХОТ-оор ялалт

байгуулсан тойргийн тооноос үл хамаарах бөгөөд хоёр чухал онцлогтой байдаг. Үүнд аль ч нам 300-гаас дээш суудал авч болохгүй, аль нэг намын авах суудлын тооны бүх 500 суудалд эзлэх хувь нь тухайн намын авсан саналын нийт хүчинтэй саналын дүнд эзлэх хувиас найман пунктээс илүү байж болохгүй. Иймээс аливаа нам доод танхимд олонхи болж 251 суудал авахын тулд нийт хүчинтэй саналын дор хаяж 42,2 хувийг авахаас гадна ядаж 167 тойрогт ялалт байгуулсан байх ёстой. 1997, 2003 оны сонгуулиудад ИХН-ын авсан суудлын эзлэх хувийг найман пунктийн дүрмээр хязгаарласан байна. 2000 оны сонгуульд энэхүү найман пунктийн дүрэм ИХН-д ч, Үндэсний Хөдөлгөөний Нам (ҮХН)-д ч нөлөөлөөгүй байна.

40 мандаттай бүс нутгийн таван тойрогт намын жагсаалтын дагуу төлөөлөгчдөд суудал хуваарилахдаа мөн л хамгийн их үлдэгдлийн арга буюу Харегийн квот хэрэглэдэг. Уг жагсаалт нь нэр дэвшигчдийг эрэмбэлсэн хаалттай жагсаалт байдаг учраас жагсаалтад дээгүүр бичигдсэн нэр дэвшигчид эхэлж сонгогдох бөгөөд сонгогчдын санал уг жагсаалтын дарааллыг нь өөрчилөхөд нөлөөлөхгүй.

Мексикийн хувьд олон ургальч үзэл, олон намын өрсөлдөөнд суурилсан улс төр нь удаан хугацааны хувьсал хөгжлийн үр дүн байлаа. 1973 оноос хойш Төлөөлөгчдийн танхимын сонгуульд ашигладаг томъёог янз бүрээр шинэчилж иржээ. 1979, 1982, 1985 оны сонгуульд ашигласан томъёо нь 300 НМТ-той, 100 намын жагсаалтаас хуваарилах суудалтай байсан бөгөөд 60-аас дээш тойрогт ялалт байгуулаагүй намууд намын жагсаалтаар суудал авах боломжгүй байв. 1988 онд ашигласан томъёонд намын жагсаалтаар хуваарилах суудлын тоог 200 болгож нэмэгдүүлсэн бөгөөд хамгийн олон тойрогт ялалт байгуулсан нам нийт саналын хэдэн хувийг авснаас үл хамааран олонхийн суудал авах баталгаатай болгожээ. Нэг намын авч болох суудлын дээд хязгаарыг 350 болгож тогтоосон байна. 1991 оны сонгуульд энэхүү дээд хязгаар болон олонхийг баталгаажуулах заалтыг хэвээр ашигласан боловч ялсан нам нийт саналын дор хаяж 30 хувийг авсан байх шаардлага тавьсан байна. Түүнчлэн ялсан намд зориулсан шагналын суудлууд бий болгосноор тухайн нам Төлөөлөгчдийн танхимд яльгүй олонхийн байдлаар ажиллах шаардлагагүй болгожээ. Үүний хариуд засгийн газраас сонгуулийн үйл явцад тавих зарим хяналтаа хагас бие даасан эрх бүхий сонгууль удирдах байгууллагад (ХСИ) болон холбооны сонгуулийн шүүхэд шилжүүлж өгсөн байна. 1994 оны шинэчлэлээр олонхийг баталгаажуулах заалтыг хүчингүй болгож, параллель систем бий болгосон бөгөөд ЖХТТ-ны зарчмаар хуваарилдаг суудалд сонгох ажиллагааг олонхийн тогтолцоогоор явагдах сонгуулиас бүрэн салгасан байна. Ихэнх тохиолдолд аль ч нам нийт суудлын 60-аас

дээш хувийг (500-аас 300) авч чадахгүй юм. Гэвч энэ нь Мексикт холимог систем хэрэглэснээс хойш огт гарч байгаагүй хамгийн пропорциональ бус үр дүнд хүргэж, нийт саналын 50 орчим хувийг авсан ИХН төлөөлөгчдийн танхимын суудлын 60 хувийг авсан байна. Ингээд 1996 онд сонгуулийн хуульд дахин өөрчлөлт оруулж, нэг намын авч болох суудлын дээд хэмжээг 300-гаар хязгаарлан, илүүдэл төлөөллийн дээд хэмжээг дээр дурдсан ёсоор найман пунктээр тогтоосон байна. Сонгуулийн энэ дүрэм 1964 онд олон намын систем тогтсноос хойш тогтвортой явж ирсэн бөгөөд 1997, 2000, 2003 оны сонгуулиудад хэрэглэгдэж байсан юм. Энэ дүрмээр нэг ч нам үнэмлэхүй олонхийн суудал авч байгаагүй ажээ. Түүнчлэн 1996 оны шинэчлэлээр ХСИ-ийг бүрэн бие даасан эрхтэй болгож, холбооны сонгуулийн шүүхийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн байна. Одоогоор Төлөөлөгчдийн танхимын сонгуулийг илүү пропорциональ эсвэл пропорциональ бус болгох, жагсаалтаар сонгогдох төлөөлөгчдийн эзлэх хувийг багасгах эсвэл нэмэгдүүлэх, илүүдэл төлөөллийн түвшинг багасгах юмуу огт байхгүй болгох тухай саналууд явж байна. Гэвч ижил зорилготой хоёр нам байхгүй учраас ийм шинэчлэл мөд хийгдэхгүй ч байх магадлалтай.

Тус улсын Сенат 1994 оноос өмнө 64 гишүүнтэй байсан бөгөөд 31 муж тус бүрээс хоёр гишүүн, дээр нь Холбооны тойргоос хоёр гишүүн сонгогддог байв. Сенаторуудыг олонхийн тогтолцооны янз бүрийн дүрмээр сонгож байжээ. Үүний үр дүнд 1988 он хүртэл сонгогдсон бүх сенатор ИХН-ын гишүүд байв. ИХН Сенатад монополь эрх тогтоосон учраас засгийн газраас сөрөг хүчинд буулт хийж, Төлөөлөгчдийн танхимыг илүү пропорциональ төлөөлөлтэй болгосон байна.

1994 он гэхэд Сенатын төлөөллийг ч бас илүү өргөн хүрээтэй болгох уриалга гарах болов. Ингээд гишүүдийнхээ тоог 128 болгож, нийт суудлын дор хаяж дөрөвний нэг хувь нь сөрөг хүчинд очих баталгаатай болгожээ. 1997 оны Сенатын сонгуульд холимог тогтолцоо нэвтрүүлсэн байна. Муж бүр гурван сенатор сонгохоос гадна үлдэж байгаа 32 гишүүнийг жагсаалтаар санал хурааж хувь тэнцүүлэх зарчмаар сонгох болов. Намууд муж бүрт Сенатын гишүүнд нэр дэвшигч хоёр хүний нэрийг эрэмбэлэн дэвшүүлнэ. Хамгийн олон санал авсан намын хоёр нэр дэвшигч хоёулаа сенатороор сонгогдох бөгөөд хоёрдугаар байр эзэлсэн намын жагсаалтын нэгдүгээрт бичигдсэн нэр дэвшигч гуравдахь сенатын суудалд сонгогдоно. Сонгогчдын санал жагсаалтад буй нэр дэвшигчдийн дарааллыг өөрчлөхөд ямарваа нөлөө үзүүлэхгүй. Мөн нам бүр үндэсний хэмжээний санал хураалтад зориулж 32 нэр дэвшигчийг эрэмбэлсэн, хаалттай жагсаалт гаргадаг. Сенатын сонгуульд муж бүрт хураасан нийт саналыг үндэсний хэмжээнд нэгтгэж дүнг гаргана. Ингээд хамгийн их үлдэгдлийн арга

буюу Харегийн квот болон хоёр хувийн босгыг томъёогоор суудлын хуваарилалтыг хийнэ. Төлөөлөгчдийн танхимаас ялгаатай нь олонхийн ба хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилах суудлуудын хооронд ямар нэг уялдаа холбоо байхгүй, харин хоёр тогтолцоо параллелиар ажиллах бөгөөд ХТ зарчмаар олгох суудлууд нь ямар нэг пропорциональ бус байдлыг нөхөх зорилгогүй ажээ. Энэхүү сонгуулийн томъёогоор үндэсний хэмжээний нийт саналын 40 орчим хувийг зохих хэмжээний тархалттайгаар авч хамгийн ойрхон өрсөлдөгчөөсөө гурав юмуу дөрвөн пунктээр илүү гарч чадсан хамгийн том нам олонхи болох боломжтой. Сенатын нийт суудлын гуравны хоёрыг авахын тулд (Үндсэн хуулийн шинэчлэл хийх, Дээд Шүүхийн шүүгчийг сонгох, дотоод дэгийн асуудлыг шийдэхэд энэ тоо чухал) үндэсний хэмжээнд нийт саналын гуравны хоёрыг авах шаардлагатай байдаг. 2000 оны Сенатын сонгуульд аль ч нам үнэмлэхүй олонхийн суудал авч чадаагүй байна.

Мужуудыг төлөөлдөг танхимын гишүүдийг сонгоход үндэсний хэмжээнд нэр дэвшигчдийн жагсаалт гарган санал хураах нь зохимжгүй гэсэн үндэслэлээр жагсаалтаас сонгогддог сенаторуудыг байхгүй болгох хэд хэдэн шийдвэрийн төсөл Конгресст өргөн баригдаад байна. Гэхдээ намын жагсаалтыг зүгээр нэг байхгүй болгох нь нэгээс бусад мужид нэг юмуу хоёрдугаар байрт бичигддэг ИХН-д ашигтай тусна, иймээс бусад нам дээрх хувилбарыг эсэргүүцэх магадлалтай. Өөр нэг хувилбар бол нэг мужаас гурав юмуу дөрвөн сенатор сонгох, ингэхдээ бүгдийг нь ХТ зарчим, Д'Хондтын томъёо ашиглан сонгох санал байдаг.

Холбооны бүх төлөөлөгч, сенаторуудыг бүрэн эрхийн хугацаа дараалан дахин сонгогдохыг хориглодог (мужийн захирагч нар, мужийн хурлын гишүүд, хотын дарга нар, хотын зөвлөлийн гишүүдийн хувьд ч мөн адил). Хууль тогтоогчдын хувьд бүрэн эрхийн хугацаа нь дууссаны дараа өөр танхимд сонгогдож болохоос гадна нэг бүрэн эрхийн хугацаа өнжсөний дараа өмнөх танхимдаа дахин сонгогдож болдог. Энэхүү “дахин сонгогдохгүй байх” шинэчлэлийг намын төв хороонд үнэнч байдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн намын тэргүүнүүдийн эрх мэдлийг багасгах замаар ИХН-д тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 1932 онд хийсэн байна. Тухайн үед энэ шинэчилэлийг Мексикийн хувьсгалын жам ёсны дүгнэлт, эрх мэдэл нэг хэсэг хүний гарт бэхжихээс сэргийлэх арга хэрэгсэл гэж тайлбарлаж байв. Гэтэл энэ нь үнэн хэрэгтээ хууль тогтоогчдын бие даасан байдлыг багасгах зорилгод үйлчилж иржээ. Учир нь тэдний бүрэн эрхийн хугацаа дууссаны дараах албан тушаалын ирээдүй намаас хамаардаг бөгөөд ерөнхийлөгч намынхаа аппаратад хяналт тавьдаг учраас олон жилийн турш ерөнхийлөгчийн эрх мэдлийг нэмэгдүүлж ирсэн байна. Ийм учраас намын сахилга бат маш өндөр

байдаг уламжлалтай бөгөөд үүнийг 2000 он хүртэл ИХН-аас сонгогдсон холбооны хууль тогтоогчид бараг 100 хувь мөрдөж ирсэн байна. Энэ нь гишүүдийн хариуцлагатай байдал, төлөөлөлд ч дам нөлөө үзүүлж байв. Сонгогчдын хувьд тэдний сайн ажилласныг урамшуулах, муу ажилласныг шийтгэх боломж байхгүй.

Бүх нам нэр дэвшигчдээ сонгохдоо элитийн томилгоо, хаалттай хуралдаан, хаалттай эсвэл өндөр хяналттай намын анхан шатны сонгууль гэх мэт харьцангуй хаалттай журмууд баримталдаг. Ерөнхийдөө нэр дэвшүүлэх ажиллагаа сүүлийн жилүүдэд нээлттэй болж байгаа боловч нэр дэвшигчид намаасаа ихээхэн хамааралтай хэвээр байна. Дээр нь намууд ихэнх кампанит ажлын зардлыг, тэр ч байтугай тойргийн болон мужийн түвшний өрсөлдөөнийг хянаж байдаг төдийгүй хаалттай жагсаалт нь нэр дэвшигчид кампанит ажил явуулах сонирхлыг бууруулдаг байна.

Мексик Улсад удаан үргэлжилж буй ардчиллын үйл явцад үүсч буй санал зөрөлдөөнийг сарниулах үүднээс эрх баригч намын зүгээс цуврал буулт хийж, сонгуулийн тогтолцоог олон удаа өөрчилсний үр дүнд маш хүчтэй намууд бүхий ерөнхийлөгчийн тогтолцоо тогтоод байна. Одоо бол янз бүрийн намууд өөр өөр ашиг сонирхолтой болж, ямар ч өөрчлөлтийг хэн хэндээ ашиггүй тоглоом гэж үзэх болсон учраас цаашид өөрчлөлт хийгдэх магадлал бага юм.

ШИНЭ ЗЕЛАНД УЛС: Хувь ТЭНЦҮҮЛСЭН ТОГТОЛЦООНД ДАСАН ЗОХИЦОЖ СУРЧ БАЙНА

Найжел С. Робертс

Шинэ Зеланд Улс сонгуулийн ХОТ бүхий орны гол жишээнд тооцогдож байсан үе бий. Харин 1990-өөд оны эхээр хоёр удаа бүх нийтийн санал асуулга явуулсны дараа тус улс 120 гишүүнтэй нэг танхимт парламентаа холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ)-гоор сонгох болсон юм. 2004 он хүртэл энэхүү шинэ тогтолцоог хэрэглэж гурван удаагийн сонгуулийг явуулаад байна.

Шинэ Зеланд Улс яагаад сонгуулийн тогтолцоогоо өөрчлөв? Аль эрт ардчилал тогтсон, тэр дундаа Англо-Саксоны өв уламжлалтай энэ орон ийм туйлын өвөрмөц алхам яагаад хийх болов?

Юуны өмнө ХОТ 1978, 1981 онд маш их гажуудалтай үр дүн гаргасан байна. Аль аль тохиолдолд нь тус улсын Үндэсний Нам улсын хэмжээгээр авсан саналынхаа дүнгээр өрсөлдөгч Хөдөлмөрийн Намаас цөөн санал авсан хэдий ч Төлөөлөгчдийн танхимд үнэмлэхүй олонхийн суудал авч засгийн эрхэнд хэвээр үлдсэн ажээ. Түүнчлэн энэ хоёр сонгуулийн хоёуланд нь тус улсын гуравдахь том нам болох Социал Кредит нам багагүй хэмжээний санал авсан боловч түүний үр дүн гараагүй байна (тус нам 1978 онд нийт саналын 16 хувь, 1981 онд 21 хувийг авсан боловч тэр үед 92 суудалтай байсан парламентад дөнгөж нэг, хоёрхон суудал тус тус авсан байна). Сэтгэл сэрдхийлгэсэн эдгээр үр дүн 1984 оны дунд үеэр сонгогдсон Хөдөлмөрийн намын засгийн газраас Сонгуулийн тогтолцооны асуудлаар Эзэн хааны комисс байгуулахад хүргэсэн байна. Энэ комиссоос 1986 онд гаргасан *Ардчиллыг сайжруулах нь* хэмээх тайланд Германыхтай төстэй санал хураалтын тогтолцоо авч хэрэглэхийг санал болгожээ. Сонгуулийн тогтолцоог үнэлэхэд зориулж бий болгосон 10 шалгуурт тулгуурлаж үнэлэхэд “бусад бүх тогтолцооноос илүү дээр” тогтолцоо нь ХХТТ мөн гэдэг үндэслэлийг тус комисс дэвшүүлсэн байв.

Шинэ Зеландын томоохон намуудын аль нь ч энэ саналыг дэмжээгүй бөгөөд хэрвээ үүнийг Үндэсний Нам 1990 оны сонгуулийн мөрийн хөтөлбөртөө сөхөн тавьж энэ асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулна гэж амлаагүйсан бол тэгээд л сураг тасрах байлаа. 1992 онд болсон эхний санал асуулгаар нийт сонгогчдын 85 орчим хувь нь “сонгуулийн тогтолцоонд ямар нэг өөрчлөлт оруулах”-ыг дэмжжээ. Хоёр дахь санал асуулгаар оролцогчдын 54 хувь нь ХХТТ-г дэмжсэнээр (46 хувь нь ХОТ-г хэвээр үлдээх санал өгчээ) эхний санал асуулгаас хойш 14 сарын дараа шинэ сонгуулийн тогтолцоог хэрэглэхээр баталсан байна.

Шинэ Зеландын парламентын сонгуульд сонгогчид Германых шиг хоёр санал өгдөг. Нэгийг нь улс нь нэг тойрог болж аль нэг улс төрийн намын төлөө (Шинэ Зеландад намын санал гэж нэрлэдэг), хоёр дахийг нь нэг мандаттай тойрогт өрсөлдөж буй аль нэг нэр дэвшигчийн төлөө өгдөг байна. Нэг мандаттай тойргийн (Шинэ Зеландад тойргийн гэдэг) төлөөлөгчид ХОТ-оор сонгогддог бол улс төрийн намуудад хуваарилах парламентын суудлын хувь хэмжээг тэдгээрийн авсан намын саналын тооноос шууд хамааруулан хувь тэнцүүлэн тогтоодог. Хэрэв аль нэг нам үндэсний хэмжээнд намд өгсөн саналын 25 хувийг авах юм бол 120 гишүүнтэй Парламент дахь бүх суудлын дөрөвний нэг орчим хувийг (ойролцоогоор) буюу 30 орчим суудал авах эрхтэй болно. Хэрвээ нийт 30 суудал авах эрхтэй нам тойргийн хэмжээнд 23 суудал авчихсан байх юм бол нэг мандаттай тойргоос хараахан сонгогдож чадаагүй, намын жагсаалтад дарааллын дагуу эрэмблэгдсэн нэр дэвшигчдэд үлдэх долоон суудлыг өгөх юм. Үүний нэгэн адилаар 30 суудал авах эрхтэй нам нэг мандаттай тойргуудаас 11-хэн суудал авсан бол намынхаа жагсаалтаар нэмж 19 суудал авах болно.

Шинэ Зеландын ХХТТ-нд хоёр босго байдаг. Аливаа нам улсын хэмжээнд намд өгсөн саналынхаа тоогоор парламентад тодорхой хувь хэмжээний суудал авахын тулд нэг бол нийт намын саналын дор хаяж таван хувийг авсан байх, эсвэл нэг мандаттай тойргуудаас ганц ч болов суудал авсан байх ёстой. 1996 оны бүх нийтийн сонгуульд таван нам таван хувийн босгыг давсан бөгөөд нэг нам уг босгыг давж чадаагүй боловч нэг мандаттай тойргуудаас ганц суудал авсан байжээ. Гурван жилийн дараа явуулсан сонгуульд мөн л таван нам таван хувийн босго давжээ. Бусад хоёр нам босго давж чадаагүй боловч нэг мандаттай тойргоос суудал авсан байв. Иймээс тэдний нэг нь парламентад нэмж дөрвөн суудал (сонгуульд өгсөн намын саналуудын 4,3 хувийг авсан байсан учраас) авах эрхтэй болсон юм. 2002 онд зургаан нам таван хувийн босго давсан бөгөөд долоо дахь нам нь нэг мандаттай тойргоос нэг суудал авсан учраас Парламентад намынхаа жагсаалтаас дахин нэг хүн оруулах эрхтэй болсон байна.

Эдгээр тоо нь ХХТТ нэвтрүүлсэнтэй холбоотой нэг томоохон өөрчлөлтийг харуулж байна. Юуны түрүүнд “улс төрийн намуудын адил тэгш байдал”-ыг хангах үүднээс бий болгосон санал хураалтын шинэ тогтолцоо нь пропорциональ бус байдлын индексийг бодитойгоор бууруулж чадсан бөгөөд тодруулбал, 1946-1993 онд ХОТ-оор явуулсан 17 сонгуульд энэ индекс дунджаар 11 хувь байсан бол ХХТТ-оор зохион байгуулсан эхний гурван сонгуулийн дундаж үзүүлэлт гурван хувь болж буурсан байна. Шинэ Зеландад 1935-1993 оны хугацаанд ХОТ-оор явуулсан сонгууль бүрт тус улсын хоёр том нам (Хөдөлмөрийн эсвэл Үндэсний нам) Төлөөлөгчдийн танхимд үнэмлэхүй олонхийн санал авч байсан байжээ. Харин өнөөг хүртэл явагдсан гурван сонгуульд ХХТТ-ны үзүүлсэн нөлөө бол нэг ч нам Парламентын нийт суудлын талаас илүү хувийг аваагүй явдал юм. 1996 оны сонгуульд хамгийн том нам нь нийт 120 суудлын 44 -ийг авсан бол, 1999 онд хамгийн их нь 49 суудал, 2002 оны сонгуульд хамгийн их нь 52 суудал авсан.

Шинэ Зеланд Улс нэг нам олонхиороо бүрдүүлдэг засгийн газарт дасаад байсан бол эвслийн засгийн газар эрх барьдаг орон болж хувирсанд гайхах зүйлгүй юм. ХХТТ-оор явуулсан анхны сонгуульд хоёр нам хамтран эвслийн засгийн газар байгуулж Парламентад ялихгүй олонхийг (120-оос 61 суудал) эзлэх болсон байна. Энэ эвсэл 1998 оны наймдугаар сард задарснаас хойш тус улс цөөнхийн эвслийн засгийн газартай болсон учраас хууль тогтоох хөтөлбөрөө Парламентаар батлуулахын тулд янз бүрийн албан ба албан бус дэмжлэгийн механизм (бусад намтай, хааяа парламентын гишүүдтэй нэг бүрчлэн хэлэлцэн тохирох замаар) ашиглахаас аргагүйд хүрч байлаа. Сонгуулийн тогтолцооны асуудлаарх Эзэн хааны комиссын ашигласан бусад шалгуурын нэг бол “үр

өгөөжтэй ажилладаг засгийн газар” гэсэн үзүүлэлт байлаа. Тус комиссын тэмдэглэсэнчлэн сонгуулийн тогтолцоо нь “засгийн газарт... үүрэг хариуцлагаа биелүүлэх боломж олгох ёстой. Засгийн газар хэрэгтэй үед шийдэмгий арга хэмжээ авах чадвартай байх ёстой”. Энэ үүднээсээ Шинэ Зеландын ХХТТ-оос төрсөн засгийн газруудын хувьд засгийн эрх барихад хүндрэл багатай байсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тэд бүгд л төсвөө ямар нэг бодитой саадгүйгээр батлуулж байснаас гадна аль нь ч парламентад явуулдаг засгийн газарт үл итгэх санал хураалтад орж ялагдах асуудалтай тулгарч байсангүй. Үүний зэрэгцээ Шинэ Зеландын засгийн газар илүү үр өгөөжтэй ажиллаж Эзэн хааны комиссын өөр нэг шалгуурыг хангаад байна. Засгийн газрууд парламентын байнгын хороод дахь олонхидоо найдахаа (үнэндээ, хааяа ингэж найдлага тавих явдал тохиолддог) больсон төдийгүй ХХТТ-оор байгуулагдсан удаа дараагийн парламентуудад эрх баригч ба сөрөг хүчний намуудын хоорондын зөвшилцөл яриаг (өгч авах явдал) хавьгүй ихээр явуулах болсон байна.

Мөн Сонгуулийн тогтолцооны асуудлаарх Эзэн хааны комисс ХХТТ-г ашиглаж Парламентад Маоричууд (Шинэ Зеландын Полинези гаралтай уугуул иргэдийн цөөнх) болон эмэгтэйчүүд, Ази, Номхон далайн арлынхан гэх мэт бусад сонирхлын бүлгийн төлөөллийг оруулахаар тооцсон байна. Энэ нь ч хэрэгжиж байна. Хамгийн сүүлд ХОТ-оор явуулсан сонгуульд Маоричууд парламентын гишүүдийн долоон хувийг эзэлж байв. Харин одоо тэд хууль тогтоох байгууллагын гишүүдийн 16 хувийг бүрдүүлж байна. Эмэгтэй парламентын гишүүдийн эзлэх хувь 1993 онд 21 хувь байсан бол ХХТТ-оор сонгогдсон сүүлийн гурван парламентад дунджаар 29 хувьд хүрсэн байна. 1993-2002 онд Номхон далайн арлуудаас гаралтай парламентын гишүүдийн эзлэх хувь нэгээс гурван хувь хүртэл, Ази гаралтай парламентын гишүүдийн тоо тэгээс хоёр хувь болж өссөн байна.

Удаан хугацаанд хэрэглэсэн сонгуулийн тогтолцоогоо орхих нь улс төрийн хувьд амар хялбар үйл явц байгаагүй бөгөөд ашиг сонирхлоо бэхжүүлсэн, албан тушаал хашиж байгаа улстөрчдөд ч бүр ч амаргүй байсан. Сонгуулийн тогтолцоогоор мэргэшсэн тэргүүлэх эрдэмтдийн зүгээс сонгуулийн томоохон шинэчлэлийг хөнгөн хуумгай хийж болохгүй гэж ямагт анхааруулж ирсэн байдаг. Гэсэн хэдий ч Шинэ Зеландын парламентчид, олон нийтийн аль аль нь пропорциональ төлөөллийн тогтолцоондоо (заавал дуртай байх албагүй ч) дасан зохицож сурч байгаа нь улам бүр нотлогдож байна. Шинэ Зеландад 1990-өөд оны үед авч хэрэглэсэн, 1996 онд албан ёсны болгож баталгаажуулсан шинэчлэл нэлээд удаан хугацаанд оршин тогтнох төлөвтэй байна.

Параллель тогтолцоо

134. Параллель тогтолцоо нь ХТТ ба ОД тогтолцооны бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Гэхдээ ХХТТ-оос ялгаатай нь ХТТ-ны бүрэлдэхүүн хэсэг нь олонхийн зарчмаар сонгууль явуулж буй тойргуудад гарсан ямарваа пропорциональ бус байдлыг нөхдөггүй (Түүнчлэн Параллель тогтолцооны ХТТ бус бүрэлдэхүүн хэсэг нь заавал олонхийн бус Тайванийх шиг өөр хэлбэртэй байж болно). Параллель тогтолцоонд ХХТТ-ны нэг адил сонгогч нэг саналын хуудсаар нэр дэвшигч ба намд аль алинд нь саналаа өгч болох ба Өмнөд Солонгост энэ аргыг нэвтрүүлээд байна. Эсвэл Япон, Литва, Тайландын туршлагаар хоёр тусдаа саналын хуудасны нэгээр нь олонхийн тогтолцооны тойргуудад хуваарилсан суудлын төлөө өрсөлдөгчдөд, нөгөөгөөр нь хувь тэнцүүлэх саналын зарчмаар сонгогдох өрсөлдөгчдөд саналаа өгдөг байж болно (Япон, Тайландын тухай жишээг тус тус үзнэ үү).

Параллель тогтолцоо бол сонгогчдын саналыг хоёр өөр тогтолцооны зарчимд тулгуурлан хууль тогтоох байгууллагын суудалд шилжүүлэх зарчимд суурилсан холимог тогтолцоо юм. Ийм тогтолцооны бүрэлдэхүүнд ЖХТТ, нөгөө нь (ихэвчлэн) ОД тогтолцоо байдаг. Гэхдээ хоёр дахь тогтолцооны үр дүнг тооцоход эхний тогтолцоогоор хуваарилсан суудлыг харгалздаггүй байна.

Параллель тогтолцоог одоогоор 21 улсад хэрэглэж байгаа бөгөөд энэ тогтолцоо сүүлийн 15 жилийн турш сонгуулийн тогтолцооны зохион байгуулалтын өвөрмөц жишээ болж ирсэн юм. Магадгүй энэ нь ЖХТТ-ны ашигтай талыг олонхийн (буюу бусад) тогтолцооны ашигтай талуудтай хослуулах онцлогтой нь холбоотой буй заа. Армян, Гвиней (Конакри), Япон, Өмнөд Солонгос, Пакистан, Филиппин, Орос, Сейшел, Тайланд, Зүүн Тимор, Украин улсууд нэг мандаттай тойргуудад санал хураах ХОТ-г намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлэх саналын бүрэлдэхүүн хэсэгтэй хослуулж, Азарбайджан, Гүрж, Казахстан, Литва, Таджикистан улсууд нэг мандаттай тойргоор санал хураах бүрэлдэхүүн хэсэгтээ Хоёр шаттай тогтолцоог хэрэглэдэг байна.

Андорра, Сенегал (жишээ судалгааг үзнэ үү), Тунис улсууд парламентын гишүүдийн заримыг Намын багц саналын аргыг ашиглаж сонгодог. Харин Параллель тогтолцоондоо БСТ ашигладаг цорын ганц улс бол Монако бөгөөд мөн Тайвань ганцаараа СҮШТ-г хувь тэнцүүлэх саналын бүрэлдэхүүн хэсэгтэй хамт хэрэглэдэг байна.

135. Хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилах суудал ба олонхийн зарчмаар хуваарилах суудлын тооны харьцаа маш олон янз байдаг (Хүснэгт 5-ыг үзнэ үү). Зөвхөн Андорра, Орос, Украин улсууд яг 50:50 хувийн харьцаатай хуваадаг. Харин нөгөө түйл нь болох Өмнөд Солонгос Улс 299 суудлынхаа 81 хувийг ХОТ-оор, үлдсэн 56 гишүүнийг намын жагсаалтаар санал хурааж хувь тэнцүүлэх зарчмаар сонгодог байна. Үүний нөгөө эсрэг туйлд Зүүн Тимор улс 75 суудлаа хувь тэнцүүлэх замаар, 13-г нь ХОТ-оор сонгуулийн тойргуудаас санал хурааж хуваарилдаг байна. Ерөнхийдөө ихэнх тохиолдолд энэ харьцаа их ойрхон байдаг. Тухайлбал, Япон Улс төлөөлөгчдийнхөө 60 гаруй хувийг нэг мандаттай тойргуудаас үлдсэнийг нь жагсаалтаар санал хурааж сонгодог байна.

ТАЙЛАНД УЛС: Сонгуулийн шинэчлэлээр дамжуулан авлигатай тэмцэж байна

Аллен Хикен

1997 онд батлагдсан Тайландын Үндсэн хууль тус улсын улс төр, сонгуулийн талбарт өргөн цар хүрээтэй өөрчлөлт авчирсан юм. Эдгээр шинэчлэлийн дотор сонгуульд хяналт тавьж, удирдан зохион байгуулах эрхтэй бие даасан Сонгуулийн Хороо байгуулах, Парламентын гишүүд ба Засгийн газрын гишүүдийн харилцааг зохицуулах шинэ журмууд, Тайланд Улсад анх удаа сонгуульд Сенат бий болгох асуудал орсон байна. Мөн энэ Үндсэн хуулиар Тайландын сонгуулийн түүхийн ихэнх үед хэрэглэж байсан багц саналын тогтолцоо (БСТ)-г харьцангуй олонхийн (ХОТ) болон намын жагсаалтаар санал хурааж хувь тэнцүүлэх зарчмаар суудал хуваарилах тогтолцооны (ЖХТТ) элемент бүхий параллель тогтолцоогоор сольжээ.

1997 оноос өмнө Тайланд Улс Төлөөлөгчдийн танхимаа сонгохдоо БСТ хэрэглэдэг байв. Харин сенатын гишүүдийг бүхэлд нь сонгохгүйгээр шууд томилдог байлаа. Тус улсын сонгуулийн тойргууд нэгээс гурав хүртэл тооны мандаттай бөгөөд ихэнх тойргууд нь нэгээс дээш мандаттай байдаг. Мандатыг засаг захиргааны нэгжийн хүн амынх нь тоотой хувь тэнцүүлэн хуваарилна. Сонгогчид намд бус, нэр дэвшигчдийн төлөө саналаа өгч, ингэхдээ тухайн тойргын мандатын тоотой тэнцүү тооны санал өгөх боломжтой байлаа. Гэвч бүх саналаа нэг нэр дэвшигчийн төлөө өгч болохгүй, харин өөр өөр намын нэр дэвшигчдэд хуваан өгч болдог. Түүнчлэн заавал мандатын тоогоор санал өгөхгүй байх замаар зарим нэр дэвшигчийг сонгохоос хэсэгчлэн түдгэлзэж болдог. Намууд өрсөлдөхийг хүссэн тойрогтоо нэр дэвшигчдийн бүрэн баг дэвшүүлэх шаардлагатай байдаг (өөрөөр хэлбэл гурван мандаттай тойрогт гурван нэр дэвшигч дэвшүүлэх ёстой гэсэн үг). Суудлыг харьцангуй олонхийн зарчмаар хамгийн олон санал авсан нэг, хоёр юмуу гурван нэр дэвшигчид хуваарилдаг.

Тайландын БСТ нь намын тогтолцоондоо наанадаж хоёр гол нөлөө үзүүлж байв. Эдгээр олон мандаттай тойргууд нь нэг тойргоос олон нам төрүүлэх хандлагатай байдаг нь эргээд маш олон нам Төлөөлөгчдийн танхимд орж ирэхэд дөхөм үзүүлж байв. 1975-1996 оны хооронд үр дүнтэй ажилласан үндэсний намуудын дундаж тоо зургаагаас дээш байв. Аль ч нам олонхи болж үзээгүй учраас олон намаас бүрдсэн томоохон эвслийн засгийн газрууд байгуулах шаардлагатай байсанд гайхах зүйлгүй. Эвслийн засгийн газрууд ерөнхийдөө зоримог бус, богино настай байлаа. Шинэчлэгчдийн хувьд сонгуулийн тогтолцоог өөрчилснөөр намуудын тоог бууруулж, засгийн газрын ажиллах чадваргүй, тогтворгүй байдлыг багасгана гэдэгт итгэж байв.

Хоёрдугаарт, энэ тогтолцоо нь нэг намын нэр дэвшигчид нэг тойрогт өөр хоорондоо өрсөлдөх боломж бүрдүүлж байв. Хэдийгээр нам бүр нэр дэвшигчдийн баг дэвшүүлдэг боловч сонгогчид бүх саналаа тэдэнд өгч тэдний багийг бүгдийг нь дэмжихийг хамтарч уриалахын оронд голдуу нэг нэгийнхээ эсрэг кампанит ажил явуулах хандлагатай байдаг ажээ. Нам доторх энэхүү өрсөлдөөн нь нэр дэвшигчид ба сонгогчдын хувьд намын харъяаллын үнэ цэнийг алдагдуулж, намууд дотроо хэсэг бүлэгт хуваагдан, эв нэгдэлгүй болоход хүргэсэн байна. Үүний нэг тусгал бол сонгууль бүрийн өмнө намаа солих явдал газар авч, оролцогчдыг нь мөнгөний улс төрд буруутгадаг явдал юм. Нам доторхи өрсөлдөөн, намын харъяаллын сулралт, харьцангуй жижиг тойргууд зэрэг нь улстөрчид сонгогчдын харьцангуй явцуу хүрээ үүсгэж, тэдэндээ үйлчлэхийг дэмждэг байна. Сонгуулийн кампанит ажлын явцад нэр дэвшигчид санал худалдаж авах замаар өөрийн гэсэн тойрог бий болгодог байв. Алба хашиж буй улстөрчдийн хувьд тойрогтоо “буян үйлдэх”, тодорхой бараа, үйлчилгээ үзүүлэхэд голлон анхаарч, өргөн хүрээтэй бодлогын асуудлуудыг голдуу үл ойшоодог, улмаар төрийн бодлогын уялдаа холбоо, тууштай байдлыг алдагдуулдаг байна. 1997 оны Үндсэн хуулийг боловсруулагчдын зүгээс сонгуулийн шинэчлэлээр дамжуулан намын эв нэгдлийг бэхжүүлнэ, намын харъяаллыг учир утгатай болгоно, нэр дэвшигчид ба улстөрчдийн зүгээс өргөн хүрээтэй, үндэсний хэмжээний тойрогт үйлчлэх сонирхол төрүүлнэ гэдэгт найдаж байв.

Улс төрийн шинэчлэл хийхийн төлөө иргэний нийгмийн хүрээнд удаан хугацаагаар оргилон буцалж байсан шаардлагын хариуд 1996 онд Төлөөлөгчдийн танхимаас Үндсэн хууль боловсруулах ассамблейг (ҮХБА) байгуулсан байна. Үүнээс хойш жилийн дараа буюу олон нийттэй өргөн хүрээтэй зөвлөлдсөний дараа, мөн эдийн засгийн хүнд хямралаас улс төрийн хямралд асар хурдан шилжиж байх тэр мөчид ҮХБА-гаас шинэ Үндсэн хуулийн төслийг өргөн барьж, Төлөөлөгчдийн танхимаар

батлуулсан байна. Энэхүү шинэ Үндсэн хуулийн тулгын чулуу нь сонгуульт Сенат болон Төлөөлөгчдийн танхимыг сонгох цоо шинэ тогтолцоо хоёр байв. Төлөөлөгчдийн танхимд хэрэглэж байсан БСТ байхгүй болов. Үндсэн хуулийг боловсруулагчид сүүлийн үеийн чиг хандлагыг даган Тайланд Улсад Параллель сонгуулийн тогтолцоо бий болгосон юм. Тайландын олон мандаттай тойргуудыг 400 нэг мандаттай тойргоор солив. Эдгээр тойргийн хувьд сонгогчид дэмжиж байгаа нэр дэвшигчийнхээ төлөө нэг санал өгөх юм. Түүнчлэн улс даяар нэг тойрог болж хувь тэнцшүүлэх зарчмаар сонгох 100 гишүүн бүхий хоёр дахь давхаргыг бий болгожээ. Аливаа нам энэ давхаргын суудлаас авах эрхтэй байхын тулд намын жагсаалтын авсан саналаар дор хаяж таван хувийн босго давах ёстой юм. Нам бүр нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж сонгогчдод танилцуулах бөгөөд сонгогчид хоёр санал өгнө. Үүнд, нэгийг нь нэр дэвшигчид, нөгөөг нь намд өгдөг. Нэр дэвшигчдийн хувьд тойрогт өрсөлдөх эсвэл намын жагсаалтаар өрсөлдөх эсэхээ сонгох ёстой. Энэ хоёр давхаргын хооронд ямар нэг уялдаа холбоо байхгүй. Нэг давхаргад нь авсан намын суудал нөгөө давхаргад нь авсан тойргийн суудлын тооноос огт хамаардаггүй.

Мөн 1997 оны Үндсэн хуулиар, Тайландын түүхэнд анх удаа Сенатын танхимын гишүүдийг сонгохоор заажээ. Энд 200 сенаторыг СҮШТ ашиглан сонгодог байна. Сонгуулийн тойргийн хэмжээ янз бүр буюу нэгээс 18 хүртэл мандаттай байдаг. СҮШТ-ны Тай хувилбар ч бас нэмэлт онцлогтой. Үндсэн хуулийг шинэчлэгчид Сенатын танхимаа намаар талцсан эмх замбараагүй хэрүүл уруулаас дээгүүр тавихыг хүссэн байна. Иймээс сенаторууд аль нэг улс төрийн намд харъяалагдах, сонгуулийн кампанит ажил явуулахыг Үндсэн хуулиар хориглосон байна.

Үндсэн хуулийн эдгээр шинэчлэлээс ямар үр дүн гарав? Дээр дурдсанчлан Үндсэн хууль боловсруулагчдын нэг гол зорилго бол Тайланд дахь намуудын тоог цөөлөх явдал байсан учраас нэг мандаттай тойргуудад шилжиж, намын жагсаалтаас сонгогдох нөхцөл болгон таван хувийн босго тавьсан байна. Эл зорилго сайн биелсэн мэт харагдаж байна. 2001 оны Төлөөлөгчдийн танхимын сонгуулиар хууль тогтоох байгууллагад нөлөөтэй намуудын тоо эрс буурч, дундаж нь 1997 оноос өмнө 6,2 байснаа 3,1 болж буурсан. Энэ үзүүлэлт нь нэг мандаттай тойргуудад өрсөлдөх намын тоо цөөрсөн төдийгүй намуудын тойрог хоорондын зохицуулалт сайжирсантай холбоотой. 1957 оноос хойш анх удаагаа нэг нам буюу шинээр бүрэлдэн бий болсон Тай Рак Тай нам олонхийн суудлыг бараг авах шахав. Хожим нь арай жижиг нэг нам задарч гишүүд нь тус намын эгнээнд элссэнээр олонхи болж чадсан байна.

Үндсэн хууль боловсруулагчдын өөр нэг итгэж байсан зүйл бол намын жагсаалтаар санал хурааж, намын дотоод өрсөлдөөнийг арилгаснаар сонгогчид, нэр дэвшигчдийн аль аль нь үндэсний хэмжээний асуудлаарх намын бодлогын байр сууринд илүү анхаарал хандуулахыг дэмжих явдал байв. Энэ нь ч үнэхээр 2001 оны сонгуулиас эхлэн хэрэгжиж эхлэв. Сүүлийн үеийн Тайландын сонгуулийн түүхэнд анх удаа Тай Рак Тай нам тэргүүтэй улс төрийн намууд нам төвтэй сонгуулийн нэгдсэн стратеги боловсруулахад ихээхэн хүчин чармайлт тавих болсон. Намууд бодлогын мөрийн хөтөлбөрөөрөө, зарим тохиолдолд кампанит ажлын чухал асуудлаар ялгарч эхэлсэн байна.

Гэхдээ Тайландын намын тогтолцоонд гарч буй өөрчлөлтийг гүнэлэхэд зарим талаар болгоомжтой хандах шалтгаанууд бий. Нэгдүгээрт, нам төвтэй стратегид шилжих явдал гол төлөв намын жагсаалтаас сонгогдохын төлөөх кампанит ажлуудаар хязгаарлагдаж, нэг мандаттай 400 тойрогт явагдаж буй өрсөлдөөн нь нэр дэвшигч төвтэй асуудлуудад чиглэсэн хэвээр үлджээ. Мэдээж энэ нь сонгуулийн тогтолцоотой холбоотой ба нэг мандаттай тойргууд нь нэр дэвшигчдэд хувийн дэмжлэгийн сүлжээгээ бэхжүүлэх сонирхол (хэдийгээр энэ нь БСТ-нд байснаас арай багассан боловч) төрүүлдэг нь үүний шалтгаан болсон хэвээр байна. Хоёрдугаарт, сонгуулийн шинэ тогтолцоо нь нэг суудал авахад шаардлагатай саналын дундаж тоог эрс бууруулж өгсөн байна. Энэ нь хууль тогтоох байгууллагын суудлыг нэмсэн болон багц саналаас нэг мандаттай тойрогт шилжсэний давхар нөлөө юм. Ингэснээр хувийн стратегиа орхих сонирхлыг сулруулсан байна. Сонгогдоход хэдийчинээ цөөн санал хэрэгтэй байх тусам нэр дэвшигчид хувийн стратеги хэрэглэх магадлал төдийчинээ их байх талтай. Эцэст нь СҮШТ-оор сонгогддог нам бус Сенаттай болсон нь намын баримжаатай сонгогчидтой болгох оролдлогыг зарим талаар мохоож байна.

Мэдээж хэрэг 1997 оны шинэчлэлийн үр дагаварт ямар нэг үнэлэлт дүгнэлт өгөхийг түр харж хүлээнэх хэрэгтэй. Одоо байгаа хомсхон мэдээлэлд үндэслэн 2001 ба 2005 оны сонгуулийн үр дүн шинэ чиг хандлагын тусгал уу, эсвэл Тай Рак Тай намын тэргүүн, Ерөнхий сайд Таксин Шинаватрагийн хувийн ер бусын зан чанарын нөлөө байна уу гэдгийг тодорхойлох боломжгүй юм. Ямартай ч 2001 ба 2005 оны Төлөөлөгчдийн танхимын сонгуулиуд нь Тайланд Улсыг сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн үр дагавруудын (заримдаа хүсээгүй) нэг сонирхолтой жишээ болгоод байна.



REPUBLIKA E SHQIPERISE
KOMISIONI QENDROR I ZGJEDHJEVE

QARKU: TIRANE
B: TIRANE



FLETE VOTIMI
Zgjedhjet për organet e qeverisjes vendore 28 Dhjetor 2003

Nr.	Per Kryetarin e Bashkise	Shenimi i votuesit
1	AHMET SHAIPI TUSHA PARTIA SIGURIA KOMBETARE SHQIPTARE PSKSH	
2	ALBERT ESAT KARIQI PARTIA KONSERVATORE SHQIPTARE Pkons	
3	EDI KRISTAQ RAMA PARTIA SOCIALISTE E SHQIPERISE, PARTIA SOCIALDEMOKRATE E SHQIPERISE PSSH, PSD	
4	FATJON SHEFQET SOFTA PARTIA ALEANCA POPULLORE PAP	
5	GENCI SELMAN RAMAJ PARTIA DEMOKRISTIANE PDK	
6	JOLANDA FEKO HYSENBELLIU PARTIA KOMUNISTE E SHQIPERISE PKSH	
7	KRESHNIK SHABAN ÇOLLAKU PARTIA DEMOKRATE E RE PDR	
8	RASIM PESHK MULGECI PARTIA ALEANCA SOCIALISTE SHQIPTARE PASSH	
9	ROBERT SOTIR PAPA PARTIA LEVIZJA E LEGALITETIT PLL	
10	SINAN AHMET ISUFI I PAVARUR I PAVARUR	
11	SPARTAK KIÇO NJJELA PARTIA DEMOKRATIKE + PARTIA REPUBLIKANE + PARTIA BASHKIMI LIBERAL PD+PR+PBL	
12	VLADIMIR SINAN LULAJ PARTIA (C) MIREGJENES POPULLORE PMP	

Nr.	Per Keshillin e Bashkise	Shenimi i votuesit
1	ALEANCA DEMOKRATIKE (N.CEKA) AD	
2	PARTIA AGRARE AMBENTALISTE (L.XHUVELI) PAA	
3	PARTIA ALEANCA POPULLORE (F.SOFTA) PAP	
4	PARTIA BALLI KOMBETAR (SH.ROG) PBK	
5	PARTIA BALLI KOMBETAR DEMOKRAT (H.SELFO) PBKD	
6	PARTIA BASHKIMI LIBERAL SHQIPTAR (T.LAÇO) PBL	
7	PARTIA BASHKIMI PER TE DREJTAT E NJERJUT (V.DULE) PBDNJ	
8	PARTIA DEMOKRACIA SOCIALE (P.MILO) PDS	
9	PARTIA DEMOKRATE E RE (G.POLLO) PDR	
10	PARTIA DEMOKRATIKE (S.BERISHA) PD	
11	PARTIA DEMOKRATIKE E RINOVUAR (D.SHEH) PDRn	
12	PARTIA DEMOKRISTIANE (H.LESI) PDK	
13	PARTIA KOMUNISTE E SHQIPERISE (H.MILLOSHI) PKSH	
14	PARTIA KONSERVATORE SHQIPTARE (A.RUÇO) Pkons	
15	PARTIA LEVIZJA E LEGALITETIT (E.SPAHU) PLL	
16	PARTIA REPUBLIKANE SHQIPTARE (F.MEDRU) PR	
17	PARTIA SOCIALDEMOKRATE E SHQIPERISE (S.GJURUSHI) PSD	
18	PARTIA SOCIALISTE E SHQIPERISE (P.XIANO) PSSH	

Параллель тогтолоцо бүхий Албани Улсын саналын хуудас

СЕНЕГАЛ УЛС: Параллель тогтолцоо Африкт

Ричард Венгрофф

Сенегал бол эрх баригч ерөнхийлөгчөө халж жинхэнэ ардчилсан замаар төрийн эрх мэдлийг шилжүүлж авсан Африкийн цөөхөн хэдэн улсын нэг юм. Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо нь Францынхтай маш төстэй бөгөөд хоёр шаттай, сүүлийн шат нь халз өрсөлдөх дүрмээр явагддаг олонхийн тогтолцоо юм. Намууд эхний шатанд нэр дэвшигчээ өрсөлдүүлэх сонирхолтой байхаас гадна сонгогчид үнэхээр дэмждэг нэр дэвшигчийнхээ төлөө чөлөөтэй санал өгдөг бол хоёр дахь шатанд “стратегийн” сонголтоо хадгалж үлддэг байна. 2000 онд сөрөг хүчний намууд эхний шатанд ялсан ерөнхийлөгч Абдоу Дайоуфыг үгүйсгэж, урьдчилан тохиролцсон ёсоор сөрөг хүчний тэргүүлэх нэр дэвшигч Абдулай Уэйдийн төлөө нэгдэж оролцсоноор удаан хугацаанд ноёрхож байсан Социалист Намын (СН) удирдагчийг хоёр дахь шатанд буулгаж авсан байна.

Хууль тогтоох байгууллагын хувьд, намын жагсаалтаар санал хураадаг цэвэр ХТТ-оос 1978 онд холимог тогтолцоо рүү шилжиж, 1983 оноос хойш параллель тогтолцоо рүү орсон байна. Түүнээс хойш ч энэ тогтолцоондоо олон удаа өөрчлөлт оруулжээ. Ихэнх өөрчлөлт нь уг тогтолцоог сөрөг хүчний зарим төлөөлөлд нээлттэй болгохын зэрэгцээ эрх баригч намын олонхийн байр суурийг хадгалж үлдэх замаар ардчилсан хууль ёсыг бий болгоход чиглэгдэж ирсэн байна. Бусад олон холимог тогтолцооны нэг адилаар Сенегалын тогтолцоонд нийт суудлын заримыг үндэсний хэмжээнд намын жагсаалтаар санал хурааж хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилдаг байна. Харин бусад параллель тогтолцооноос ялгаатай нь харьцангуй олонхийн тогтолцооны бүрэлдэхүүн нь нэг мандаттай сонгуулийн тойргуудад санал хураах журмаар биш, олон мандаттай тойргууд бүхий намын багц саналын тогтолцоо (НБСТ) байна.

Хууль тогтоох байгууллагын нийт суудлын бараг тэн хагасыг нь намуудад жагсаалтаар авсан саналд нь тулгуурлан хувь тэнцүүлж хуваах ба ингэхдээ хамгийн их үлдэгдлийн арга буюу Харегийн томъёо ашигладаг. Бусад суудлыг олон мандаттай 30 сонгуулийн тойрогт олонхийн санал авсан нэр дэвшигчдэд хуваарилдаг бөгөөд тойргийн хэмжээг аваад үзэхэд дээд тал нь 5 хүртэл мандаттай байна. Жижиг намууд ба сөрөг хүчний зүгээс хувь тэнцүүлэн хуваарилах суудлын тоог нэмэгдүүлэхийг байнга шаардаж ирсэн бол, эрх баригч намын хувьд ямагт тэнцвэрт байдлыг илүүд үзэж байв (эрх баригч нам олонхийн тогтолцооны суудлуудад ноёрхлоо хадгалж үлдээд, дээр нь параллель тогтолцоогоор авах суудлаа нэмбэл засгийн эрхэнд хэвээр үлдэх боломжтой). 1998 онд эрх баригч Социалист нам (СН) суудлын хуваарилалтыг дахин өөрчилж олонхийн тогтолцоогоор сонгогдох 20 суудлыг шинээр нэмжээ. СН өөрөө эдгээр суудлын 18-ыг нь авсан бөгөөд үндэсний хэмжээний нийт саналын олонхид дөнгөж хүрэх төдий (50, 3 хувь) санал авсныг эс тооцвол хууль тогтоох байгууллагыг хяналтандаа байлгах чадвартай болсон байна.

Ерөнхийлөгч Уэйд сөрөг хүчний тэргүүн байхдаа сонгуулийн тогтолцоог илүү хувь тэнцүүлсэн шинжтэй болгох, эрх баригч намд ашигтай НБСТ-г халах байр суурьтай байв. 2001 онд Уэйд Ерөнхийлөгчийн суудалд сууж авчээ. Ийнхүү түүний хувьд нэг бол сонгогчдын хүсэл сонирхлыг илүүтэй илэрхийлсэн тогтолцоо сонгох, аль эсвэл өөрийн эвсэлд (Сенегалын Ардчилсан Нам (САН) тэргүүтэй SОPI эвсэл) ашигтай байх хувилбар нэвтрүүлэх боломж нээгдсэн байна. Эцэст нь намдаа бий болсон асар их нөөц бололцоо, Ерөнхийлөгчийн засаглалын эрх мэдлийг хослуулан аваад үзэхэд түүний урьд өмнө нь маш тэгш шударга бус гэж шүүмжилж байсан тогтолцоо нь гэнэт дур булаам болж хувирсан байна.

СН болон нөгөө нэг том нам болох Дэвшлийн Хүчнүүдийн Альянс (ДХА) хоёр ч хэд хэдэн тойрогт олонхийн санал авах боломжтой учраас НБСТ-г дэмжих нь ашигтай гэж үзэж байв. Тэд бас сонгуулийн тогтолцоонд олонхийн зарчим түлхүү үйлчлэх ёстой гэж шийдээд байв. Арай жижиг намуудын хувьд жагсаалтаар санал хураах цэвэр хувь тэнцүүлсэн тогтолцоо нэвтрүүлэх байр суурьтай байсан ба энэ нь боломжгүй гэвэл суудлын болоод саналын харьцаа арай тэнцвэртэй байх нь аль нэг хувилбар байж болох юм гэж үзэж байлаа. Эрх баригч САН-ын хувьд Үндэсний ассамблейн суудлыг 140-с 120 болгож цөөлөх, олонхийн зарчмаар ба хувь тэнцүүлэн хуваарилах суудлын тооны харьцаа 70:70 байсныг өөрчилж, харьцангуй олонхийн тогтолцооны суудлыг 65, ЖХТ зарчмаар хуваарилах суудлыг 55 болгохын төлөө байлаа. Тус нам эрх барьж буй шинэ намын хувьд олон тойрогт давуу санал авах боломжтой, улмаар сонгогчдын дэмжлэгтэй харьцуулахуйц түвшинд суудлынхаа тоог нэмэгдүүлнэ гэж тооцож байжээ.

Энэ тооцоонууд ч зөв болох нь батлагдав. Хэдийгээр SОPI эвсэл нийт саналын талаас арай бага хувийг (49,6 хувь) авсан боловч 2001 оны сонгуулиар 120 суудлын 89-ийг (74,2 хувь) авсан байна. Хуучин эрх баригч нам байсан Социалист Нам 17,4 хувийн санал авч, улмаар авсан саналынхаа эзлэх хувиар хоёрт орсон боловч дөнгөж арван суудал авсан нь бүгд жагсаалтаас хувь тэнцүүлэн хуваарилсан суудал байв. Нийт саналын тоонд эзлэх хувиар гуравдугаарт орсон Мустафа Ниассегийн ДХА нам (нийт саналын 16,1 хувийг авсан) 11 суудал авч суудлынхаа тоогоор СН-ын урд орсон бөгөөд хоёр суудлыг нь олонхийн тогтолцоогоор авсан бөгөөд нэг тойрогт нь тэргүүлсэн байна. Ардчилсан Шинэчлэлийн Холбоо (АШХ) нам 3,7 хувийн саналаар нийт гурван суудал авсны нэгийг нь олонхийн тогтолцооны нэг мандаттай тойргоос авсан бөгөөд энэхүү жижиг тойрог нь тус намын тэргүүний төрсөн нутаг байв. Ардчилал, Социализмын төлөө Африкийн Нам (АСТАН) дөнгөж дөрөв хувь гаруйхан саналаар хоёрхон суудал авсны хоёуланг нь жагсаалтаар авсан байна. Бусад таван нам саналын бүрэн квотод хүрч чадаагүй боловч хамгийн их үлдэгдлийн аргын ачаар тус бүр нэг нэг суудал жагсаалтаар авсан байна. Нийт 15 нам хуваарилалтаас хасагджээ.

2001 оны сонгуулийн дээрх дүн Сенегал Улс СН-ын удирдлагад байхад тохиолдсон сонгуулийн хамгийн тэнцвэргүй үр дүнгээс ч муу байна. Тухайлбал, 1993 оны сонгуулиар 70 суудлыг ЖХТ зарчмаар, 50-ыг нь НБС-ын дүрмээр тойргуудад санал хураан хуваарилж байсан бол 1998 онд 70:70-ийн харьцаатай болгосон нь пропорциональ бус байдлыг бага зэрэг нэмэгдүүлсэн байдаг. Харин 2001 онд пропорциональ бус байдал эрс өсч, үр дүн нь ХОТ-оор явуулсан ихэнх сонгуулийн үр дүнгээс ч илүү пропорциональ бус гарсан байна. Ингэснээр эрхууль тогтоох байгууллагын хууль ёсны байдал алдагдахад хүрчээ. Ийнхүү ардчилсан шинэчлэлийн төлөө үзэл баримтлалтайгаар 2001 онд засгийн эрхэнд гарсан SОPI эвсэл сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийг өөрт ашигтайгаар ашигласан нь нэг томоохон ухралт болсон юм.

Сенегаль Улсад дангаар ноёрхогч эрх баригч намын хувьд анхнаасаа параллель тогтолцоог дэмжих болсон учир нь бусад нам өөр хоорондоо зохицон эвсэхээс сэргийлж бутлах, сонгогч стратегийн хувьд санал өгөх боломжийг аль болох багасгах замаар хамгийн том намд ашигтай нөхцөл үүсгэх явдал байлаа. Цаашлаад эрх баригч намын зүгээс сонгогч саналын хуудсанд нэг л сонголт тэмдэглэх, улмаар түүнийг олонхийн саналаар болон жагсаалтаас хувь тэнцүүлэн хуваарилах суудлын аль альнийг нь шийдэхэд ашиглах дүрэм нэвтрүүлсэн нь дээрх зорилгыг баттай хангах далд санаа байв. Тодруулбал, хувь тэнцүүлэн хуваарилах суудлын тоо аливаа нам, эвслийн авсан нийт саналын тооноос хамаарах

учраас Сенегалын сөрөг хүчний намуудын хувьд аль болох олон тойрогт нэр дэвшигчээ өрсөлдүүлэн олонхийн санал авах сонирхол давамгайлж байлаа. Тойргийн түвшинд авсан бүх саналыг нэмж жагсаалтаас хуваарилах суудлыг шийдэхэд ашигладаг нь тойргуудын хэмжээнд намууд хоорондоо эвсэх боломжийг бууруулж, сонгогчид стратегийн тооцоогоор бус, саналаа хүсэл зоригоороо гаргах сонирхол төрүүлдэг байна. Ийм учраас эрх баригч нам харьцангуй олонхийн тогтолцоотой ихэнх тойрогт өөрөө ялалт байгуулж чаджээ.

Тус улс мөн холимог параллель тогтолцоог орон нутгийн (Орон нутгийн зөвлөл) болон хотын түвшний сонгуулиуддаа хэрэглэдэг. Ялсан нам орон нутгийн хурлын бүрэлдэхүүнд дийлэнх олонхи байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт суудлын талыг нь багц саналын тогтолцоогоор сонгууль явуулж хуваарилдаг байна. Харин үлдэж байгаа тал хувийг нь тухайн орон нутаг буюу хотыг бүхэлд нь нэг тойрог болгон ЖХТТ-оор хуваарилдаг ажээ.

Сонгуулийн тогтолцоог өөрчлөх тухай маргаан мэтгэлцээнд гол нөлөө үзүүлэх хүчин зүйл нь богино хугацааны улс төрийн ашиг хонжоо олох эрмэлзэл байдгийг Сенегалын жишээ харуулж байгаа юм. Өөрчлөлт хийхийг шаардаж байсан сөрөг хүчин засгийн эрхэнд гармагц гэнэт өөрт нь ашигтайгаар эргэсэн хуучин тогтолцоог хамгаалж эхэлсэн байна. Үүний нэг дутагдалтай тал нь хэрвээ сонгогчдын санал савалж Социалист намд эрх мэдэл шилжвэл параллель тогтолцоонд НБСТ-ны бүрэлдэхүүн давамгайлж байгаа нь сөрөг хүчин жагсаалтаар илүү олон суудал авахад хүргэж, улмаар SОPI эвсэл 2001 оноос өмнөх байсан байр сууриндаа эргэж очихоос аргагүй болох юм. Нөгөө талаар энэ арга нь яваандаа хоёр том намын тогтолцоонд чиглэсэн шилжилт болон хувирч, үүний үр шимийг хүртэгч намуудын хувьд ямар нэг гуравдагч улс төрийн хүчин нэвтэрч орж ирэхэд бэрхшээлтэй нөхцөлийг бүрэлдүүлж болох талтай.

Хүснэгт 5. Параллель тогтолцоо ашиглаж буй орнууд

Улс	ХТТ зарчмаар хуваарилах суудлын тоо	Олонхийн (эсвэл бусад) зарчмаар олгох суудлын тоо	Олонхийн/ (эсвэл бусад) тогтолцоо	Нийт суудлын тоо
Андорра	14 (50%)	14 (50%)	НБСТ	28
Армян	56 (43%)	75 (57%)	ХОТ	131
Азербайжан	25 (20%)	100 (80%)	ХШТ	125
Гүрж	150 (64%)	85 (36%)	ХШТ	235
Гвиней	76 (67%)	38 (33%)	ХОТ	114
Япон	180 (37,5%)	300 (62,5%)	ХОТ	480
Казахстан	10 (13%)	67 (87%)	ХШТ	77
БН Солонгос Улс	56 (19%)	243 (81%)	ХОТ	299
Литви	70 (50%)	71 (50%)	ХШТ	131
Монако	8 (33%)	16 (67%)	БСТ	24
Пакистан	70 (20%)	272 (80%)	ХОТ	342
Филиппин	52 (20%)	208 (80%)	ХОТ	260
Орос	225 (50%)	225 (50%)	ХОТ	450
Сенегал	55 (46%)	65 (54%)	НБСТ	120
Сейшел	9 (36%)	25 (74%)	ХОТ	34
Тайвань	49 (22%)	176 (78%)	СҮШТ	225
Таджикистан	22 (35%)	41 (65%)	ХШТ	63
Тайланд	100 (20%)	400 (80%)	ХОТ	500
Зүүн Тимор	75 (85%)	13 (15%)	ХОТ	88
Тунис	52 (80%)	37 (20%)	НБСТ	189
Украин	225 (50%)	225 (50%)	ХОТ	450

136. *Давуу талууд.* Сонгуулийн үр дүнгийн хувь тэнцвэртэй байдал нь параллель тогтолцооны хувьд ихэвчлэн цэвэр олонхийн/мажоритар тогтолцоо, ХТТ-ны дунд хавьцаа байна. Энэ тогтолцооны нэг давуу тал нь ХТТ зарчмаар хуваарилах суудал хангалттай байгаа нөхцөлд олонхийн/мажоритар тогтолцоогоор өрсөлдөөд амжилт үзүүлээгүй цөөнхийн жижиг намууд авсан саналынхаа хэмжээтэй хувь тэнцэх суудал авах боломжтой байдаг. Түүнчлэн онолын хувьд параллель тогтолцоо нь цэвэр ХТТ-г бодвол намын тогтолцоог задлан бутаргах нөлөө нь бага байдаг.

137. *Сул талууд.* ХХТТ-ны нэг адилаар хоёр ангиллын төлөөлөгчид бий болох боломжтой. Мөн параллель тогтолцоо нь ерөнхийдөө төлөөллийн хувь тэнцсэн байдлыг баталгаатай хангаж чаддаггүй бөгөөд зарим нам тодорхой хэмжээний санал авсан ч төлөөлөлгүй хоцорч болох талтай. Түүнчлэн параллель тогтолцоо өөрөө харьцангуй нарийн түвэгтэй бөгөөд энэ тогтолцооны мөн чанар, ажиллагаа нь сонгогчдыг төөрөгдүүлж болох талтай байдаг.

Бусад тогтолцоо

138. Олонхийн тогтолцоо, хувь тэнцүүлэх тогтолцоо, холимог тогтолцоо гурваас гадна тодорхой нэг ангилалд тохирдоггүй хэд хэдэн тогтолцоо байдаг. Тэдний дотор санал үл шилжүүлэх, хязгаарлагдмал саналын тогтолцоо, Борда тооллогын тогтолцоо ордог. Эдгээр тогтолцоо сонгогчдын саналыг суудалд шилжүүлэхдээ ХТТ-ны хувилбаруудын пропорциональ байдал, олонхийн тогтолцоонуудын пропорциональ бус үр дүн хоёрын завсрын дундаж үр дүн үзүүлэх хандлагатай байдаг.

Санал үл шилжүүлэх тогтолцоо (СҮШТ)

139. СҮШТ-нд сонгогч бүр нэг нэр дэвшигчийн төлөө нэг санал өгөх боловч (ХОТ-оос ялгаатай нь) сонгуулийн тойргууд нэгээс дээш мандаттай байдаг. Нийт дүнгээрээ хамгийн их санал авсан нэр дэвшигчид тухайн суудлыг эзэн болно.

Санал үл шилжүүлэх тогтолцоонд сонгогчид олон мандаттай тойрогт нэг санал өгдөг. Нийт дүнгээр хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдогчоор зарладаг. Сонгогчид улс төрийн нам гэхээсээ илүү нэр дэвшигчдэд санал өгдөг.

СҮШТ хэрэглэх үед улс төрийн намуудад нэг сорилт тулгардаг. Тухайлбал дөрвөн мандаттай тойрогт нэг нэр дэвшигч 20 хувийн санал авахад л сонгогдох баталгаатай болно гэсэн үг. Иймээс дөрвөн мандаттай тойргоос 50 хувийн санал авсан нам дор хаяж хоёр суудал авна гэж тооцож болно. Гэхдээ нэр дэвшигч бүр 25 хувийн санал авсан тохиолдолд л ийм зүйл тохиолддог. Харин нэг нэр дэвшигч нь 40 хувийн санал, нөгөө нэг нь 10 хувийн санал авсан бол хоёр дахь нэр дэвшигч сонгогдохгүй байж болно. Тухайн нам энэ тойрогт гурван нэр дэвшигч дэвшүүлсэн бол “санал хуваагдах” аюулаас болж хоёр суудал авах магадлал нь бүр ч буурах талтай.

Өнөөдөр СҮШТ-г Афганистан, Иордан, Питкэйрний Арлууд, Вануату зэрэг улсын хууль тогтоох байгууллагын сонгууль, Индонези, Тайландын хоёр дахь танхимын сонгууль, мөн Тайваны параллель тогтолцоонд хууль тогтоох байгууллагын нийт 225 суудлын 176-г нь хуваарилахад хэрэглэж байна. Харин хүмүүсийн хамгийн сайн мэдэх жишээ бол 1948-1993 онд Японы парламентын доод танхимын сонгуульд энэ тогтолцоог хэрэглэсэн явдал юм.

140. *Давууталууд*

а. Өмнө дурдсанчлан СҮШТ, олонхийн тогтолцоо хоёрын хамгийн чухал ялгаа бол СҮШТ нь цөөнхийн намууд, бие даагчдын төлөөлөлд сонгогдох боломж илүүтэй олгодог явдал юм. Тойргийн мандатын тоо олон байх тусам илүү пропорциональ үр дүн үзүүлдэг. Иорданд СҮШТ нам бус, сүм хийдийг дэмждэг, олны танил цөөнгүй нэр дэвшигчдэд сонгогдох боломж олгосон, үүнийг тухайн үр хөврөлийнхөө шатанд яваа намын тогтолцооны хувьд нэг давуутай тал нь гэж үздэг.

б. СҮШТ нь намууд өндөр зохион байгуулалтад орж, тухайн намын нэр дэвшигчдэд саналаа хэрхэн хувааж өгөхийг сонгогчдод зааж өгөх замаар намынхаа суудал авах чадавхийг аль болох дээшлүүлэхийг дэмждэг. Хэдийгээр СҮШТ сонгогчид намын жагсаалтад буй нэр дэвшигчдийн дотроос сонголт хийх боломж олгодог боловч цэвэр ХТТ-г бодвол намын тогтолцоог задлан бутаргах нь бага байдаг гэж үздэг. СҮШТ-г 45 жил гаруй хэрэглэж буй Япон Улс чамгүй хүчирхэг “нэг намын ноёрхол”-той тогтолцоо байж болохыг харуулсан юм.

в. Эцэст нь тэмдэглэхэд энэ тогтолцоог хэрэглэх, ойлгоход хялбар тогтолцоо гэж сайшаадаг.

ЯПОН УЛС: Сонгуулийн шинэ ТОГТОЛЦООНД дасан зохицох ҮЙЛ ЯВЦ

Карен Кокс

Япон Улсад урт удаан хугацаанд засгийн эрх барьсан Либераль Ардчилсан Нам (ЛАН) 1993 онд задарч, дараахан нь болсон сонгуульд парламентын гол танхимыг хяналтаасаа алдсан юм. Түүний оронд бүрэлдэн бий болсон шинэ эвслийн нэг ололт амжилт бол авилгын эх сурвалж, ЛАН-ын удаан хугацааны ноёрхлын үндэс гэж нийтээрээ үзэж байсан сонгуулийн тогтолцоог шинэчилсэн явдал байв.

Сонгуулийн хуучин тогтолцоогоор (СҮШТ) парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн танхимын 511 гишүүнийг нэгээс зургаан мандатай 129 тойргоос сонгодог байв. 1947 оноос хойш хэрэглэж ирсэн энэ тогтолцоо томоохон намуудын дотор ялангуяа ЛАН-ын хувьд сонгуульд хандах онцгой өвөрмөц хандлагыг бий болгосон юм. Энэ тогтолцооны дагуу аливаа нам парламентын олонхи болоход хангалттай суудал авах эсвэл багагүй хэмжээний цөөнхийн суудал авах найдлага тавьж буй бол сонгуулийн тойрогт аль болох олон нэр дэвшигч дэвшүүлэх шаардлагатай байв. Иймээс намууд суудлын тоогоо нэмэгдүүлэхийн тулд, нэр дэвшигч бүр төрөлх зөнгөөрөө аль болох олон санал авахыг оролдох биш, харин найдвартай сонгогдоход шаардлагатай *хамгийн бага* саналыг авсан байх шаардлага тавьж байв. Үүний цаадах учир нь өөрийн “авах ёстой” хэмжээнээс илүү санал авсан нэр дэвшигч арай цөөн санал авсан хамтран зүтгэгч нараа гомдоож болох байлаа. Өөрөөр хэлбэл, нэр дэвшигч А-гийн илүү авсан буюу “авах албагүй байсан” саналын тоо нь түүнтэй нэг намаас нэр дэвшсэн Б-г суудал авахад хангалттай хүрэхээр байсан байж болно.

Сонгуулиар эрх мэдлээ хадгалж үлдэхийн тулд ЛАН намынхаа дэмжигчдийг онцгойлон харж үзэх бодлого баримталж сонгогчдын

тодорхой бүлэгт хандсан “буян үйлдэх”, халамжлах, бусад дэмжлэг туслалцаа үзүүлэхэд анхаардаг байв. СҮШТ-оор ялалт байгуулсан анхны нам болох ЛАН-ын гарт засгийн эрх байсан учраас сөрөг хүчний намууд түүнтэй үр нөлөөтэй өрсөлдөхөд хэцүү байлаа. Энэ тогтолцоо авлига, хээл хахууль газар авахад нөлөөлсөн гэдэгт гайхах зүйлгүй. Цаашилбал, хувь хүн рүү чиглэсэн, дэмжигчдээ онцгойлон харж үзэх иймэрхүү тогтолцооны улмаас бодлогын чанартай томоохон асуудлаар улс төрийн шийдвэр гаргах, хэлэлцүүлэг өрнүүлэх нь байнга хойш тавигдаж байв.

1990-ээд оны эхэн үед энэ тогтолцоонд бухимдсан иргэдийн зүгээс сонгуулийн шинэчлэл хийх шахалт асар их болов. Энэхүү шинэчлэлийг тусгасан хуулийг тохиролцон баталж чадаагүй нь ЛАН-ыг задрахад хүргэсэн бөгөөд улмаар 1993 онд засгийн эрхээ сөрөг хүчинд (түүний дотор ЛАН-аас гарсан хүмүүст) шилжүүлсэн юм. АНУ маягийн хоёр намын тогтолцоо, засгийн эрхэнд байгаа намуудыг тогтмол сэлгэн солих тухай үзэл баримтлал улстөрчид, эрдэмтэд, хэвлэл мэдээллийнхний дунд түгж, түүнийг Японы улс төрийн тогтолцооны эмгэгийг шийдвэрлэх “шидэт эм” мэтээр үздэг болоод байв. Ингээд олон хүн нэг мандаттай тойргуудтай (НМТ) тогтолцоо хэрэглэхийг уриалах болжээ. Гэхдээ жижиг намууд үүний улмаас улс төрийн тавцангаас шахагдана гэж эмээн энэ алхамыг эсэргүүцэх хандлагатай байлаа. Ингээд харилцан буулт хийсний үр дүнд өнөөдөр хэрэглэж байгаа хоёр давхаргат тогтолцоо бий болсон байна.

Шинэчлэгдсэн сонгуулийн тогтолцоо нь ЖХТТ ба нэг мандаттай тойргууд бүхий ХОТ гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй параллель тогтолцоо болно. Сонгогч энэ хоёр бүрэлдэхүүнд тус бүрд нь нэг нэг санал гаргаж оролцдог. 1996 онд анх энэ тогтолцоогоор явуулсан сонгуулийн ХТ шатанд нийт 200 суудал буюу долоогоос 33 хүртэл мандаттай 11 тойрог, харин хоёр дахь шатанд 300 НМТ байв. Суудлын тоог оновчтой болгох хүчин чармайлт тавьсны үр дүнд 2000 онд болсон хоёр дахь сонгуулийн өмнө хувь тэнцүүлж хуваарилах суудлын тоог 180 болгож багасгасан байна. Ингэснээр ХТ зарчмаар суудал хуваарилах 11 тойрог нь хэмжээний хувьд зургаагаас 29 мандаттай болжээ.

Параллель тогтолцоонд нам бүрийн бодитойгоор авсан саналын хувийг хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүнд илүүтэй тусгах үүднээс нийт суудлын тоог өөрчлөн тохируулдаг нэмэлт механизм байдаггүй. НМТ-ийн суудал ХТ зарчмаар хуваарилах суудлаас илүү байх нь НМТ-уудад суудал авч чадах томоохон намуудад ашигтай байдаг. Гэхдээ Японы сонгуулийн тогтолцооны хоёр үе шат өөр нэг өвөрмөц арга замаар холбоотой байдаг. Японы сонгуулийн хуулиар нэр дэвшигч намын жагсаалтаар болон НМТ-ийн суудалд давхар өрсөлдөх боломжтой.

ХТ бүрэлдэхүүн нь хаалттай жагсаалттай боловч сонгогчид тухайн жагсаалтад байгаа нэр дэвшигчдийн дараалалд тодорхой хэмжээгээр нөлөөлөх боломжийг олгосон заалт ч байдаг. Намын жагсаалтад болон НМТ-т аль алинд нь дэвшиж буй нэр дэвшигчдийнхээ заримд эсвэл бүгдэд нь адил зэрэглэл тогтоосон жагсаалт ирүүлэхийг намуудад зөвшөөрдөг. Ингээд НМТ-уудад ялсан нэр дэвшигчдийг тооцооноос хассаны дараа, намын жагсаалтад орсон боловч НМТ-уудад ялагдсан нэр дэвшигчдийн эцсийн дарааллыг тогтоохдоо тухайн тойрогт ялсан хүнтэй харьцуулахад хэр сайн санал авч чадсан эсэхийг нь харгалздаг.

Энэ заалт нь намуудад хэд хэдэн талаараа ашигтай байдаг. Нэгдүгээрт, энэ нь нэр дэвшигчдийн дарааллыг тогтоох улстөрийн хувьд таагүй ажлаас татгалзах боломж олгодог. Хоёрдугаарт, намаас гаргах нэр дэвшигчдийн жагсаалтад адилхан дараалалд бичигдсэн нэр дэвшигчид өөрийн тойрогт аль болох олон санал авахын тулд кампанит ажлаа эрчимтэй явуулдаг. Намууд нэр дэвшигчдэдээ адилхан дараалал тогтоох аргыг хэрэглэж болохоос гадна зарим нэр дэвшигчээ хатуу тогтсон дараалалд байлгах боломжтой. Энэ ч бас ашигтай. Учир нь намын жагсаалтад харьцангуй өндөр буюу “аюулгүй” дараалалд бичигдэх гэсэн нэр дэвшигчийн сонирхлыг түүнийг ялах магадлал багатай НМТ-т өрсөлдүүлэхээр ятгах түлхэц болгон ашиглаж болох юм.

Энэ тогтолцооны анхны туршилт 1996 онд явагдсан бөгөөд үр дүнд нь олон хүн сэтгэлдундуур үлджээ. Сонгуулийн шинэ хууль гарснаас хойших жилүүдэд ЛАН хүчээ дахин зузаатгаж, сөрөг хүчний намууд хэд хэдэн удаа хүчний хуваарилалтад орсон байна. Энэхүү тогтворгүй байдал нь ЛАН ерөнхийдөө ялалт байгуулж өмнөх хэв маяг үргэлжлэхэд хүргэснээр найдлага тавьж байсан хоёр намын тогтолцоонд чиглэсэн олигтой өөрчлөлт гарсангүй. Мөн энэ тогтолцооны зарим нэг түвэгтэй шинж чанар сонгогчдын дунд ч сэтгэл ханамжгүй байдал үүсгэсэн нь ялангуяа НМТ-т ялагдсан нэр дэвшигчид “дахин амилж” жагсаалтаас сонгогдон гарч ирдэг үзэгдэлтэй холбоотой байлаа. Тэр тусмаа нэг мандаттай тойргуудад санал хураахад нэгдүгээр, гуравдугаар (хааяа дөрөвдүгээр) байр эзэлсэн нэр дэвшигчид суудал авчихаад байхад, хоёрдугаар байр эзэлсэн нэр дэвшигч (ихэвчлэн сөрөг хүчний намуудын хамгийн өрсөлдөх чадвартай нь) суудал авч чадахгүй байгаа тохиолдол олон гарч байв. Мөн авлига, мөнгөний улс төртэй холбоотой асуудал ямар нэг хэмжээгээр багассан эсэх нь тодорхойгүй байлаа.

2000 онд шинэ тогтолцоогоор явуулсан хоёр дахь сонгуульд НМТ-ийн суудлын төлөө идэвхтэй өрсөлдөх чадвартай нэр дэвшигчдийн тоо буурсан байлаа. Харин хоёр намын тогтолцоонд шилжихэд бага зэрэг ахиц гарсан нь коммунист бус сөрөг хүчний намууд хагаран бутарч,

төвийн үзэл баримтлалтай Комейто нам хамтрагч талаа сольж, ЛАН тэргүүтэй эвсэлд нэгдсэнтэй холбоотой.

Шинэ тогтолцооны гуравдахь сорилт 2003 оны 11 дүгээр сард болов. Есдүгээр сард жижиг намуудын нэг Либераль нам сөрөг хүчний гол нам Ардчилсан Нам (ЯАН)-тай нэгдсэн байна. Уг нэгдсэн нам (ЯАН-ын нэрийг хэвээр авсан) сонгуулиар 40 суудал авч гайхалтай амжилт үзүүлсэн ба анх удаагаа намын тунхаг бичиг ашигласнаараа онцлог байв. Сөрөг хүчний бусад чухал нам цөөн хэдэн суудал авч бусдыг нь алдсан байна. Засгийн газрын талаас ЛАН болон түүний эвслийн жижгэвтэр хоёр намын аль аль нь суудлаа алдсан бөгөөд улмаар нэг нь ЛАН-д ууссан байна. Ингэснээр ихэнх суудал хоёр том намын гарт орж, Комейто ганцаараа нөлөө бүхий жижиг нам болж үлджээ. ЛАН-ын хувьд Комейтотой эвссэн хэвээр байгаа нь нэг талаас дээд танхимд Комейтогийн дэмжлэг хэрэгтэй байсантай холбоотойгоос гадна зохион байгуулалт сайтай Комейтоогоос дэмжлэг авсан нь НМТ-т олон нэр дэвшигчид нь ялалт байгуулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна.

2003 оны сонгуулийн үр дүнгээс үзэхэд сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн үр нөлөө тэр дороо мэдрэгдэхгүй, тогтсон зуршил, үйл ажиллагааг өөрчлөхөд хугацаа шаардагдана гэсэн үзлийг нотолсон үр дүн гарсан байна. Түүнчлэн хувь тэнцүүлэх бүрэлдэхүүн нь гуравдагч нам оршин тогтнох боломж олгодог учраас холимог тогтолцооноос АНУ маягийн хоёр намын тогтолцоо бий болох магадлал бага болох нь тодорхой байна.

141. *Сул талууд*

а. Дэмжигчид нь нэг дор төвлөрөөгүй тархсан жижиг намууд суудал авч чадахгүй байж болох бөгөөд томоохон намууд багагүй хэмжээний нэмэлт шагналын суудал авч, улмаар үндэсний хэмжээнд авсан олонхийн санал нь хууль тогтоох байгууллага дахь үнэмлэхүй олонхийн суудал болон хувирч болно. Хэдийгээр олон мандаттай тойргууд дахь суудлын тоог нэмэх замаар тухайн тогтолцооны пропорциональ байдлыг нэмэгдүүлэх боломжтой ч энэ нь сонгогч, сонгогдсон төлөөлөгчдийн хоорондын холбоог сулруулдаг байна. Тухайлбал, Тайландад 18 хүртэл мандаттай том тойргууд байдаг нь одоогоор байж болох хамгийн дээд хязгаар гэж тооцогдож байна.

б. Саналын төлөө нэг намын олон нэр дэвшигч өрсөлддөг бусад тогтолцоотой төстэй нь намын дотор зөрчил, хагарал гарахад нөлөөлж болно. Түүнчлэн улстөрчид сонгогчдын тодорхой бүлэгт хахууль өгч, явцуу хүрээнд үйлчлэх үзэгдэл энэ тогтолцоонд ажиглагддаг.

в. Намууд сонгуульд нэр дэвшүүлэх болон сонгогчдын саналыг татах стратегийн асуудлуудыг цогцоор авч үзэх шаардлагатай. Хэтэрхий олон нэр дэвшигч дэвшүүлэх нь цөөн нэр дэвшигч дэвшүүлснээс үр дүн муутай байж болно. Аливаа нам сонгогчдын саналыг намынхаа бүх нэр дэвшигчдэд адил тэгш хуваарилагдахаар зохион байгуулах нь хамгийн чухал.

г. СҮШТ-нд сонгогчид зөвхөн нэг санал өгдөг учраас улс төрийн намууд сонгогчдын өргөн хүрээг хамарсан сурталчилгаа явуулах сонирхол бага байдаг. Тэд өөрсдийн үндсэн дэмжигчдээс тодорхой хэмжээний санал авах боломжтой учраас бусад сонгогчдын саналыг авсан аваагүй суудал авч болдог.

д. СҮШТ сонгогчдын санал олноор дэмий үрэгдэхэд хүргэдэг. Ялангуяа нэр дэвшихэд тавих шаардлага, шалгуур бага, олон хүн өрсөлдөх боломжтой нөхцөлд ийм байдал түлхүү ажиглагддаг.

Хязгаарлагдмал саналын тогтолцоо (ХЯСТ)

142. СҮШТ-оос нэгэн адилаар хязгаарлагдмал саналын тогтолцоо нь олон мандаттай тойрогт санал хураадаг олонхийн тогтолцоо юм. СҮШТ-с ялгаатай нь сонгогчид нэгээс дээш, гэхдээ мандатын тооноос цөөн санал өгдөг. Тоолох ажиллагаа нь СҮШТ-той адилхан буюу нийт дүнгээр хамгийн олон санал авсан нэр дэвшигч суудал авдаг.

Энэ тогтолцоог орон нутгийн түвшний янз бүрийн сонгуулиудад ашигладаг боловч үндэсний түвшинд хэрэглэж байгаа орнууд гэвээс Гибралтар, Испани хоёр л байна. Испани Улс энэ тогтолцоог 1977 оноос хойш дээд танхим буюу Сенатынхаа сонгуульд ашиглаж байна. Сонгуулийн санал хураалт олон мандаттай том тойргуудад явагдах ба сонгогч мандатын тооноос нэгээр бага санал өгдөг.

Хязгаарлагдмал саналын тогтолцоо бол олон мандаттай тойргуудад хэрэглэдэг нэр дэвшигч төвтэй сонгуулийн тогтолцоо бөгөөд сонгогчид нэгээс дээш, гэхдээ мандатын тооноос цөөн санал өгөх боломжтой байдаг. Нийт дүнгээр хамгийн олон санал авсан нэр дэвшигчид суудал авдаг.

143. *Давуу ба сул талууд*. ХЯСТ нь СҮШТ шиг сонгогчдод энгийн ойлгомжтой, тоолоход харьцангуй хялбар байдаг. Гэхдээ энэ нь СҮШТ-оос илүү пропорциональ бус үр дүн үзүүлдэг. СҮШТ-нд байдаг шиг намын дотоод өрсөлдөөн, намын удирдлага, сонгогчдын явцуу хүрээнд үйлчлэхтэй холбоотой асуудлууд ХЯСТ-нд ч бас байдаг.

Борда тооллого (БТ)

144. Сонгуулийн тогтолцооны нэн өвөрмөц жишээ бол Номхон далайн жижигхэн улс Науруд хэрэглэдэг сайжруулсан Борда тооллого юм. Борда тооллого бол сонгогч хувилбарт саналын тогтолцоонд байдаг шиг дэмжих нэр дэвшигчдээ эрэмбэлэн дугаарладаг эрэмбэт саналын тогтолцоо юм. Тойргууд нь нэг болон олон мандаттай байж болдог. Энд ганц удаа тооллого хийх бөгөөд нэр дэвшигчийг хасах хасалт гэж байхгүй. Тооллогыг хийхдээ нэр дэвшигчдийг эрэмбэлсэн дугаарт оноо өгч тэдгээрийн нийлбэрээр дүнг тооцдог. Науручуудын сайжруулсан Борда тооллогод эхний сонголтод нэг бүтэн оноо, хоёр дахь сонголтод хагас оноо, гурав дахь сонголтод гуравны нэг оноо гэх мэтээр оноо өгдөг. Эдгээр оноог нэгтгэж, нийт дүнгээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчид ялагчаар тодордог.

Борда тооллого нь нэг эсвэл олон мандаттай тойрогт сонгуулийг зохион байгуулдаг нэр дэвшигч төвтэй эрэмбэт саналын тогтолцоо юм. Сонгогчид саналын хуудсан дээр сонголтоо тэмдэглэхдээ тоогоор дугаарлах бөгөөд тооллогын явцад тэмдэглэсэн сонголт бүрт адил тэгш хуваариар оноо өгдөг. Эдгээр оноог нэгтгэж, нийт дүнгээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг (эсвэл нэр дэвшигчдийг) сонгодог.

Сонгуулийн тогтолцооны давхарга ба эрлийз тогтолцоо

145. Сонгуулийн олон тогтолцоо, түүний дотор олонхийн тогтолцоо, хувь тэнцүүлсэн тогтолцооны аль аль нь төлөөллийн нэг давхаргатай байдаг. Өөрөөр хэлбэл, сонгогч нэг удаа санал өгөх бөгөөд нэг л төрлийн сонгогдсон төлөөлөгчид хууль тогтоох байгууллагад ажиллана. Нэг давхаргат ЖХТТ-нд намын нэр дэвшигчдийн жагсаалтыг Намиби, Нидерланд улсуудынх шиг үндэсний хэмжээний, эсвэл Финлянд, Швейцари улсуудынх шиг бүс нутгийн түвшинд гаргаж санал хурааж болдог.

Харин холимог тогтолцоонд гол төлөв төлөөлөгчдийн хоёр давхарга байдаг нь олонхийн тогтолцоогоор сонгогдсон ба хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгогдсон төлөөлөгчид байна. Зарим оронд, тухайлбал, Унгарт тогтолцоо нь гурван ч давхаргатай байдаг. Энд ХШТ хэрэглэдэг бөгөөд нэг мандаттай тойргуудад олонхийн тогтолцоогоор явуулсан сонгуульд ялсан төлөөлөгчид, ЖХТТ ашиглан үндэсний ба бүс нутгийн түвшний жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид хууль тогтоох байгууллагад ажилладаг.

Мөн аливаа сонгуулийн тогтолцоо нь шинж чанарын хувьд харилцан уялдаатай бус хоёр давхаргатай байж болно. Хоёр давхаргат хувь тэнцүүлсэн тогтолцоо нь үндэсний ба бүс нутгийн гэсэн хоёр жагсаалттай (Өмнөд Африкийнх шиг), эсвэл дан ганц бүс нутгийн жагсаалттай (Дани Улсынх шиг) байж болно. Британийн Виржинийн арлууд дахь хоёр давхаргат олонхийн тогтолцоонд ХОТ-оор нэг мандаттай тойргоос сонгогдсон төлөөлөгчид, багц саналын тогтолцоо ашиглан арлуудын хэмжээнд сонгогдсон төлөөлөгчид гэж байдаг.

Хүснэгт 6. Хувь тэнцүүлсэн тогтолцооны хувилбарууд

Сонгогчийн сонголт			
Давхарга	Хаалттай жагсаалт	Нээлтэй жагсаалт	Чөлөөт жагсаалт
Нэг: бүс нутгийн	Испани, Македон гэх мэт	Латви, Индонези гэх мэт	Швейцари, Люксембург
Нэг: үндэсний	Намиби, Молдав гэх мэт	Нидерланд	-
Олон	Өмнөд Африк, Эль Сальвадор гэх мэт	Швед, Исланд гэх зэрэг	-

146. Хоёр буюу түүнээс дээш давхаргатай сонгуулийн тогтолцоог, улс орных нь нэг хэсэгт нэг сонгуулийн тогтолцоо, нөгөө нэг онцлог хэсэгт нь өөр сонгуулийн тогтолцоо ашиглан төлөөлөгчдөө сонгодог эрлийз тогтолцооноос ялгаж авч үзэх нь зүйтэй. Тухайлбал, Панам Улсад нийт төлөөлөгчдийнхөө гуравны хоёрыг олон мандаттай тойргуудаас ЖХТТ-оор, үлдэж байгаа гуравны нэгийг нь нэг мандаттай тойргуудаас ХОТ-оор сонгодог байна.

147. Хүснэгт 6-д сонгуулийн гол тогтолцоонуудын давуу ба сул талыг нэгтгэн харуулж байна. Энд танилцуулсан давуу ба сул талууд олон тооны хүчин зүйлээс хамаарч янз бүрийн газар харилцан адилгүй байж болохыг анхаарах нь зүйтэй. Жишээлбэл, ХОТ-нд сонгогчдын ирц өндөр байх явдал тохиолдох бөгөөд ЖХТТ-нд ерөнхийлөгч хууль тогтоох байгууллагаас хүчтэй дэмжлэг авах нь байна. Мөн тодорхой нэг орчин нөхцөлд нэг намын хувьд давуу тал болон харагдаж байсан зүйлс өөр орчин нөхцөлд өөр намын хувьд сөрөг үр дагавартай байж ч болно. Энэ хүснэгтэд сонгуулийн тогтолцооны зарим болзошгүй үр нөлөөг тоймлон харуулсан ба үүнд сонгуулийн тогтолцооны тодорхой хувилбарын улс төрийн институцид үзүүлэх нөлөөг ерөнхийд нь харуулахыг хичээлээ.

Хүснэгт 7. Сонгуулийн тогтолцооны таван хувилбар: давуу ба сул талууд

	Давуу тал	Сул тал
Жагсаалтаар санал хураадаг хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ)	<p>Пропорциональ байдал</p> <p>Оролцогчдыг өргөнөөр хамруулдаг</p> <p>Цөөнхийн төлөөлөл</p> <p>Цөөн санал дэмий үрэгддэг</p> <p>Эмэгтэй төлөөлөгчид хялбар сонгогддог</p> <p>Тойргын хил тогтоох шаардлагагүй (буюу шаардлага бага)</p> <p>Нөхөн сонгууль явуулах шаардлагагүй</p> <p>Сонгогч заавал эх орондоо байж санал хураах байранд ирэлгүйгээр санал өгөхөд хялбар дөхөм</p> <p>Нэг нам тодорхой нутаг дэвсгэрт ноёрхох үзэгдлийг хязгаарладаг</p> <p>Сонгогчдын ирц өндөр байх магадлалтай</p>	<p>Сонгогч, сонгогдсон төлөөлөгчдийн хоорондын харилцаа сул</p> <p>Хариуцлага тооцохтой холбоотой бэрхшээл үүсдэг</p> <p>Ерөнхийлөгчийн засаглалтай бол хууль тогтоох байгууллагаас ерөнхийлөгчид үзүүлэх дэмжлэг сул байх магадлалтай</p> <p>Парламентын засаглалтай бол эвслийн эсвэл цөөнхийн засгийн газрууд байгуулагдах магадлалтай</p> <p>Улс төрийн намуудад илүү их эрх мэдэл олгодог</p> <p>Хууль тогтоох байгууллагад хэт туйлшрагч үзэлтэй намууд ороход хүргэж болно</p> <p>Аливаа намыг эрх мэдлээс буулгах амаргүй болдог</p>

	Давуу тал	Сул тал
Харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ)	Сонгогч, сонгогдсон төлөөлөгчдийн хоорондын харилцаа ойр, сайн Хариуцлага тооцоход хялбар дөхөмтэй Ойлгоход энгийн хялбар Иргэдийн хувьд сонголтууд нь тодорхой Сөрөг хүчний эв нэгдлийг дэмждэг Хэт туйлширсан үзэлтэй намуудыг оруулдаггүй Сонгогчид нэр дэвшигчдийн хооронд сонголт хийх боломжтой Ерөнхийлөгчийн засаглалтай үед хууль тогтоох байгууллагаас ерөнхийлөгчийг дэмжих магадлал ихтэй Парламентын засаглалтай бол олонхийн засгийн газрууд байгуулагдах магадлалтай	Жижиг намууд төлөөлөлтэй болох боломж бага Үндэсний цөөнх төлөөлөлтэй болох боломж бага Эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй Олон санал дэмий үрэгддэг Нөхөн сонгууль явуулах шаардлага олонтаа гардаг Тойргийн хил тогтоох шаардлагатай Жерримандеринг буюу тойргыг өөртөө ашигтай байдлаар байгуулах заль мэх гардаг Гадаадад байгаа болон эзгүй байгаа сонгогчдоос санал авах ажлыг зохион байгуулахад хэцүү
Хоёр шаттай тогтолцоо (ХШТ)	Сонгогчдод хоёр дахь удаагаа сонголт хийх боломж олгодог Бусад олонхийн болон мажоритар тогтолцоог бодвол санал хуваагдалт бага Ойлгоход энгийн хялбар Сонгогч, сонгогдсон төлөөлөгчдийн хоорондын харилцаа ойр, сайн	Тойргийн хил тогтоох шаардлагатай Зардал ихтэй, хоёр дахь шатыг зохион байгуулахад хүндрэлтэй Нөхөн сонгууль явуулах шаардлага олонтаа гардаг Сонгууль явуулах, үр дүнг зарлах хооронд урт хугацаа шаарддаг Пропорциональ бус байдал Намын тогтолцоог задлан бутаргаж болно Гүнзгий хуваагдсан нийгмийн хувьд тогтворгүйжүүлэх нөлөө үзүүлэх магадлалтай
Параллель тогтолцоо	Оролцогчдыг өргөнөөр хамруулдаг Цөөнхийн төлөөллийг сайтар хангана Цэвэр хувь тэнцүүлсэн тогтолцоог бодвол намын задрал бутралд хүргэхгүй Бусад хувилбаруудыг бодвол харилцан тохиролцоход хялбар байж болно Хариуцлага тооцоход дөхөм Цөөн санал дэмий үрэгддэг	Нарийн түвэгтэй тогтолцоо Тойргийн хил тогтоох шаардлагатай Нөхөн сонгууль явуулах шаардлага олонтаа гардаг Хоёр янзын аргаар сонгогдсон төлөөлөгчидтэй болно Санал дэмий үрэгдэхээс айж сонгогч саналаа өөрийн дэмжиж буй нэр дэвшигчид өгөхгүй байх сэтгэл зүйн нөлөөтэй ЖХТТ-г бодвол гадаадад байгаа болон эзгүй байгаа сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулахад хэцүү Ерөнхийдөө сонгуулийн эцсийн үр дүн пропорциональ байх баталгаа болж чаддаггүй

	Давуу тал	Сул тал
Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ)	Пропорциональ байдал Оролцогчдыг өргөнөөр хамруулдаг Газар зүйн төлөөлөл Хариуцлагатай байдал Цөөн санал дэмий үрэгддэг Бусад хувилбарыг бодвол харилцан тохиролцоход хялбар байж болно	Нарийн түвэгтэй тогтолцоо Тойргийн хил тогтоох шаардлагатай Нөхөн сонгууль явуулах шаардлага олонтаа гардаг Хоёр төрлийн аргаар сонгогдсон төлөөлөгчидтэй болно Стратегийн хувьд санал өгдөг ЖХТТ-г бодвол гадаадаас буюу эзгүйгээр санал авах ажлыг зохион байгуулахад хэцүү

Төлөөллийн тухай асуудлууд

Эмэгтэйчүүдийн төлөөлөл

148. Эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх олон арга зам байдаг. 107 дугаар хэсэгт авч үзсэнчлэн хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгууль явуулахад эмэгтэйчүүд сонгогдох боломж илүү байна. Ерөнхийдөө том тойрогтой сонгуулийн тогтолцоонд намууд тэнцвэртэй төлөөлөл бүхий жагсаалтаар өрсөлдөх нөхцөл бүрддэг нь эмэгтэйчүүд сонгогдох боломжийг нэмэгдүүлдэг ажээ. ЖХТТ-той орнуудад нэр дэвшигчдийн жагсаалтын тодорхой хувийг эмэгтэйчүүдээр бүрдүүлэхийг сонгуульд өрсөлдөгч намуудаас шаарддаг.

149. Сонгуулийн тогтолцооноос гадна парламентад эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэхэд ашиглаж болох дараах хэд хэдэн арга зам байна.

а. Нэгд, хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдэд зориулсан тодорхой тооны суудал байх ба эдгээрийг нөөц суудал гэж нэрийдэх нь бий. Эдгээр суудлыг нэг бол бүс нутгаас сонгогдсон төлөөлөгчдөд, аль эсвэл улс төрийн намуудад үндэсний хэмжээнд авсан саналтай нь шууд хувь тэнцүүлэн хуваарилдаг. Нөөц суудлууд ихэвчлэн олонхийн сонгуулийн тогтолцоонд байх бөгөөд энэ тухай Үндсэн хуульдаа зааж тусгасан орон хэд хэд байна. Тухайлбал, Афганистан (32 аймаг тус бүрт хоёр эмэгтэй буюу нийт суудлын ойролцоогоор 25 хувь орчим), Уганда (56 тойрогт тус бүрт нэг эмэгтэй буюу нийт суудлын 18 орчим хувь), Руанда (зөвхөн эмэгтэй нэр дэвшигч бүхий саналын хуудсаар 24 эмэгтэйг сонгодог нь нийт суудлын 30 орчим хувь байдаг). Энэтхэг Улсад зарим мужийн орон нутгийн хурлын суудлыг гурван бүлэгт хуваадаг. Сонгууль бүрт аль нэг бүлгийн суудалд зөвхөн эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх ёстой,

ингэснээрээ төлөөлөгчдийн дор хаяж гуравны нэг нь эмэгтэйчүүд байх баталгаа бий болдог. Тэрчлэн эрэгтэйчүүдийн хувьд сонгогдох эрх нь хоёр удаагийн бүрэн эрхийн хугацаагаар хязгаарлагддаг ажээ.

б. Хоёрт, улс төрийн намууд тодорхой тооны эмэгтэй нэр дэвшигчийг сонгуульд нэр дэвшүүлэхийг хуулиар шаарддаг туршлага байна. Энэ нь гол төлөв ХТТ-нд тохиолдох бөгөөд тухайлбал Намиби (орон нутгийн түвшинд нэр дэвшигчдийн 30 хувь), Перуд (нэр дэвшигчдийн 30 хувь) ийм туршлага байдаг. Мөн Болив Улсын ХХТТ-ны ЖХТ бүрэлдэхүүнд нь ийм механизм (нэр дэвшигчдийн 30 хувь) байна. Гэхдээ намын жагсаалтын сонгогдох боломжтой суудлуудад эмэгтэйчүүдийн нэрийг дэвшүүлэх хатуу шаардлага хэрэгжүүлэх механизм байхгүй л бол дан ганц хуулийн заалт энэ зорилтыг хангах баталгаа болдоггүй. Ийм шаардлага тавьдаг жишээ Аргентин (сонгуульд ялах боломжтой суудлын 30 хувь), Бельги (жагсаалтын эхний хоёр нэр дэвшигч өөр өөр хүйсийн хүмүүс байх ёстой), Коста Рикад (ялах боломжтой суудлын 40 хувьд) байдаг.

в. Гуравт, улс төрийн намууд өөрсдөө хууль тогтоох байгууллагад нэр дэвшүүлэх эмэгтэйчүүдийн квот тогтоодог туршлага байна. Энэ нь эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралд татан оролцуулах хамгийн түгээмэл механизм бөгөөд дэлхий даяар харилцан адилгүй үр дүнтэйгээр хэрэгжүүлж байна. Өмнөд Африк Улсын АҮК, Аргентиний Перонист Нам (ПН), Радикал Иргэний Холбоо (РИХ), Боливиын КОНДЕПА (Эх орны ухамсар) нам, Мексикийн Ардчилсан Хувьсгалын Нам (АХН), Австралийн болон Их Британийн Хөдөлмөрийн намууд, Скандинавын хойгийн орнуудад квотыг хэрэглэж байна. Их Британид болсон 1997 оны сонгуульд Хөдөлмөрийн намаас зөвхөн эмэгтэй нэр дэвшигчдээс бүрдсэн богино жагсаалт ашигласан нь Парламентын эмэгтэй гишүүдийн тоог бараг хоёр дахин буюу 60-аас 119 болгож нэмэгдүүлсэн байна.

2004 оны байдлаар 14 орон эмэгтэйчүүдийн квотыг Үндсэн хуульдаа заасан (хамгийн сүүлд Афганистан), 32 улс холбогдох хууль тогтоомждоо квотын талаар заалттай, доод тал нь 61 орны 125 нам сайн дурын намын квот тогтоосон байв. Сонгуулийн тогтолцооны төрлийн хувьд олонхийн тогтолцоотой 17 улс квоттой, холимог сонгуулийн тогтолцоотой 15, ХТТ-той 45 улс тус тус квоттой байна. “Бусад” гэх ангилалд багтах тогтолцоотой Афганистан, Иордан гэсэн хоёр улс мөн ийм квоттой байна.

150. Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг баталгаажуулсан тогтолцоонууд ололт амжилт, үр дагавар талаасаа

харилцан адилгүй байдаг. Тухайлбал, нөөц суудлууд нь нэг талаас эмэгтэйчүүд сонгуулыг албан тушаалд ажиллах баталгаа болдог ч, нөгөөтэйгүүр нэг хэсэгтээ эмэгтэйчүүдийг аргалж тайвшруулах, эцсийн дүндээ тэднийг гол тоглолтод оруулахгүй байх арга зам болон хувирч байна гэж эмэгтэйчүүд шүүмжилж байна. Хууль тогтоох байгууллагад сонгогдоно гэдэг нь шийдвэр гаргах бодитой эрх мэдэл олж авна гэсэн үг биш юм. Зарим оронд эмэгтэй хууль тогтоогчдод, ялангуяа нөөц буюу тусгай суудалд сонгогдсон гишүүдэд, шийдвэр гаргахад бодитой нөлөө үзүүлж оролцох эрх нь хязгаартай байна. Гэсэн ч зарим оронд эмэгтэйчүүд өөрсдөд нь квотоор олгосон албан тушаалаа ашиглан бодлого боловсруулах үйл явцад бодитой хувь нэмэр оруулж, “уламжлал”-ыг өөрчлөхөд нөлөөлсөөр байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл, тоо баримтыг Эмэгтэйчүүдийн сонгуулийн квотын тухай АСТОУХ (IDEA) болон Стокхольмийн Их Сургуулийн Дэлхийн дахины мэдээллийн сангийн www.quotaproject.org хаягаар орж үзнэ үү.

Үндэсний цөөнхийн төлөөлөл

151. Хууль тогтоох байгууллагад үндэсний цөөнхийн болон нутгийн ард иргэдийн бүлгийн төлөөллийг нэмэгдүүлэх олон арга байдаг. Сонгуулийн тойрог том байх тусам намаас нэр дэвшүүлэхдээ тэнцвэртэй төлөөллийг хангахад анхаарах нь илүүтэй байх ба тэр хэмжээгээр цөөнхийн сонгогдох боломж нэмэгддэг байна. ХТТ-нд саналын босго маш намхан байх эсвэл албан ёсны босго огт байхгүй байх нь төлөөлөл муутай юмуу огт төлөөлөлгүй явж ирсэн бүлгүүд парламентад орж ирэх нэг нөхцөл болно. Түүнчлэн олонхийн тогтолцоонд үндэсний цөөнхөд зориулж суудал зааж нөөцлөх туршлага зарим газар байна.

152. Хууль тогтоох байгууллагад үндэсний цөөнхийн тодорхой бүлгийн төлөөллийг хангахын тулд тэдэнд зориулсан нөөц суудал ашиглаж болно. Үндэсний цөөнхийн болон шашны цөөнхийн тодорхой бүлэгт суудал зааж хуваарилдаг олон орон байдгийн дотор Колумби (“хар арьст иргэд”), Хорват (Унгар, Итали, Чех, Словак, Рутенчууд, Украин, Герман, Австри гаралтай үндэсний цөөнх), Энэтхэг (тусгай бүртгэлд орсон овог аймаг, анги давхаргууд), Иордан (Христийн шашинтнууд болон Черкессүүд), Негр (Туарегууд), Шинэ Зеланд (Маоричууд), Пакистан (лалын бус шашинт үндэсний цөөнх), Палестин (Христийн шашинтнууд ба Самаританчууд), Самоа (нутгийн уугуул бус цөөнх), Словен (Унгар, Италичууд), Тайвань (нутгийн уугуул иргэд) улсуудыг нэрлэж болно.

Эдгээр суудалд сонгогдох хүмүүсийг ихэвчлэн бусад төлөөлөгчдийн нэг адилаар сонгодог боловч зарим тохиолдолд зөвхөн үндэсний цөөнхөөс санал хурааж сонгох нь бий. Үүний тулд тусдаа нэрсийн жагсаалт гаргах шаардлагатай (155-157 дугаар хэсгийг үзнэ үү). Энэ нь цөөнхийн эрх ашгийг хамгаалах норматив арга гэж үзэх нь олонтаа ч заавал сонгуулийн хууль эсвэл бусад хуулиар албадахгүйгээр хууль тогтоох байгууллагын төлөөллийг нэмэгдүүлж чадахуйц бүтэц боловсруулж хэрэглэх нь зүйтэй гэж маргах хүмүүс бас байна. Нөөц суудлын квот тогтоож өгөх нь хүн амын олонхийн дургүйцлийг төрүүлэхээс гадна янз бүрийн соёл, ёс заншилтай бүлгийн хооронд үл итгэлцэл үүсгэх талтай.

153. Нөөц суудал заахын оронд бүс нутгын төлөөллийг нэмэгдүүлэх замаар газар зүйн хувьд төвлөрөн суурьшсан бүлгүүдийн төлөөллийг хангах бололцоотой. Их Британийн Төлөөлөгчдийн танхимд сонгогдсон Шотланд, Уэйлс гаралтай парламентын гишүүдийн тоо нь дан ганц хүн амын тооны шалгуураар хуваарилсан бол ногдох байсан суудлаас илүү гардаг. Балбын уулархаг бүсийн төлөөлөл ч ийм байна. Өөр нэг боломжтой арга бол одоогоор Маврикийд хэрэглэж байгаа “шилдэг ялагдагчийн” тогтолцоо юм. Энэ тогтолцоо нь тодорхой үндэстэн угсаатны бүлгээс нэр дэвшээд хамгийн өндөр саналаар ялагдсан нэр дэвшигчдийн заримд нэмэлт суудал олгож, үндэс угсаатны бүлгүүдийн ерөнхий төлөөллийг тэнцвэржүүлдэг байна.

154. Түүнчлэн тодорхой бүлгийн төлөөлөл сонгогдоход дөхөмтэй байдлаар сонгуулийн тойргийн хил хязгаарыг тогтоож болно. АНУ-д Сонгуулийн эрхийн тухай актаар дан ганц хар арьст, латин америк, ази гаралтай америкчууд олонхи байх, хэлбэр дүрсийн хувьд хачин чигтэй тойргууд байгуулахыг зөвшөөрч байв. Үүнийг “зөвшөөрөгдсөн жерримандеринг” ч гэж үзэж болох юм. Ер нь цөөнхийн төлөөллийг хангах, дэмжих зорилгоор сонгуулийн тогтолцоог өөрчлөх асуудал яригдахад маргаан гарахгүй байх тохиолдол ховор байна.

Нийгмийн бүлгийн төлөөлөл

155. Нийгэм нь олон үндэстэн угсаатнаас бүрдсэн зарим оронд нөөц суудлын механизмын логик утгыг лавшруулж нийгмийн бүх бүлгийг хамруулан хэрэглэх нь байдаг. Өөрөөр хэлбэл, нөөц суудлыг нийгмийн доторх тодорхой нэг бүлгийн төлөөлөлд хуваарилах биш, хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүн бүхэлдээ нийгмийн бүлгүүдийн тэнцвэртэй төлөөллөөс бүтсэн байх зарчим үйлчилнэ гэсэн үг. Бүлгүүд тус тусдаа сонгогчдын нэрийн жагсаалттай байж зөвхөн өөрийн хүмүүсийг хууль тогтоох байгууллагад сонгодог байна.

Ливанд олон мандаттай тойргуудад санал хурааж, тухайн тойрогт ногдох суудлыг шашны бүлэг хооронд хэрхэн хуваарилахыг хуулиар зааж өгсөн байдаг. Шашны бүлгүүдэд хуваарилах суудлаас гадна бусад цөөнхөд багц саналын тогтолцоогоор хуваарилах суудлыг тусад нь заадаг аж. Фижи Улсад сонгогчид өөрийн хамаарах нийгмийн бүлгээс сонгогдох нэр дэвшигчдэд санал өгөхийн хажуугаар “нээлттэй” тойргуудад өрсөлдөж буй бусад нэр дэвшигчдийн төлөө давхар санал өгч болдог.

156. Цөөнх болон бусад нийгмийн бүлэг тусдаа санал хурааж төлөөлөгчөө дундаасаа сонгох механизм нь хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүн тэнцвэртэй байх баталгаа болдог ч нөгөө талаар нийгмийн бүлгүүд өөр хоорондоо эвсэн зохицох замыг хаан боогдуулах сөрөг нөлөө үзүүлэх нь бий. Үүний улмаас урьд нь ийм зохицуулалттай байсан ихэнх орнууд түүнээсээ түтгэлзээд байна. Тодорхой нэг бүлэгт хэнбугай хамаарахыг зааглаж тодорхойлох, тэдний хооронд суудлыг адил тэгш хуваарилах асуудал өөрөө эргэлзээтэй асуултаар дүүрэн гэхэд болно. Жишээлбэл, Энэтхэг Улсад колонийн дэглэмийн үед байсан лалийн, христийн, сикх болон бусад бүлэгт зориулсан сонгуулийн тойргуудыг тус улс тусгаар тогтносны дараа байхгүй болгосон боловч албан ёсоор дорой буурай гэж бүртгэгдсэн овог аймаг, анги давхаргуудын төлөөллийг оруулах үүднээс зарим суудлыг нөөцөлдөг хэвээр байна (холбогдох жишээнээс үзнэ үү). Мөн Пакистан, Кипр, Зимбабве Улсад янз бүрийн цаг үед хэрэглэж байсан үүнтэй төстэй механизмыг хожим нь өөрчилсөн байна. Фижид дээрхтэй төстэй механизм ашиглах нь зөв эсэх талаар маргаан байнга гарсаар ирсэн ч бүх нийтийн сонгуулиас гадна хууль тогтоох байгууллагын зарим суудлыг нутгийн Фижи, Энэтхэг, Ротуман үндэстнийг багтаасан сонгогчдын нэрсийн тусгай жагсаалт гарган санал хурааж хуваарилсан хэвээр байна.

157. Нийгмийн бүлгээрээ санал өгөх зарим зохицуулалт нь бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагад хэн ямар ангилалд хамаарахыг тодорхойлохыг үүрэг болгосон байдаг бол зарим тохиолдолд хувь хүн өөрөө сонголт хийж санал өгөх боломж олгодог. Орчин үеийн ардчилсан улсуудад нутаг ус, омог аймгийн бүлгээр санал өгөх тогтолцоо байсаар байгаагийн нэг тод жишээ бол Шинэ Зеланд Улс Маори үндэстний сонгогчиддоо зориулж тусдаа санал хураалт явуулдаг явдал юм. 1996 оноос эхлэн ХТТ-оор явуулж буй Шинэ Зеландын сонгуулийн үр дүн ийнхүү овог аймгийн бүлэгт зориулсан тусгай тогтолцоо хэрэглэх үндэслэлийг сулруулсан гэж үзэж болно. Энэ сонгуулиар тусгай жагсаалт гарган санал хурааснаас хоёр дахин олон Маори үндэстний төлөөлөгч бүх нийтийн саналаар сонгогдсон байна.

Сонгууль явуулах тов

158. Бүх нийтийн, мужийн, орон нутгийн, гүйцэтгэх засаглалын, хууль тогтоох байгууллагын сонгуулиуд заавал зэрэг нэг өдөр болох албагүй бөгөөд хоорондоо зайтай явагдаж болно. Сонгуулиудын хоорондох хугацаа ямар байх нь практикийн болоод улс төрийн учир шалтгаантай байх нь бий. Ихэвчлэн сонгууль явуулахын тулд нүсэр бэлтгэл ажил хийх шаардлагатай үед (тухайлбал, Энэтхэгийн доод танхим Лок Сабхагийн сонгууль), эсвэл аюулгүй байдлын асуудлууд санаа зовоосны улмаас сонгуулийг давхцуулалгүй зохион байгуулах хэрэгцээ тулгарч мэднэ. Энэтхэгийн сонгуулийн комиссын хувьд захиргааны болон аюулгүй байдлын асуудлаас үүдэлтэй хууль тогтоох байгууллагыг байгуулах санал хураалтыг цаг хугацааны хувьд ч, мужийн хувьд ч тодорхой дараалалтайгаар явуулах нь хамаагүй хялбар байдаг ажээ. Нэг мужид явагдах хууль тогтоох байгууллагын сонгууль өөр нэг мужаас хэдэн долоо хоногийн зайтай ч байж болно. Сонгуулийг шат дараатай явуулахад тулгардаг нэг бэрхшээл бол саналын хуудасны аюулгүй байдал байдаг. Сүүлд санал хураалт явуулсан газруудын сонгуулийн үр дүн өмнө санал хураалт явуулсан газруудын үр дүнд нөлөөлөхгүй байхын тулд бүх санал хураалт явагдаж дуустал саналын хуудсуудыг нэг төвлөрсөн аюулгүй цэг дээр хадгалах шаардлагатай болно.

159. Ерөнхийлөгчийн, хууль тогтоох байгууллагын болон холбооны мужийн сонгуулиудыг цаг хугацааны хувьд салгаж явуулах нь илүү түгээмэл тохиолддог. Ерөнхийлөгчийн ба хууль тогтоох байгууллагын сонгуулийг нэг өдөр явуулах нь ерөнхийлөгчийн талын намд ашигтай байдаг бөгөөд гүйцэтгэх ба хууль тогтоох засаглалын хооронд хагарал бага гарч, төр, засаг илүү эвсэг нийцтэй ажилладаг болохыг ялангуяа шинэ тулгар ардчилсан орнуудын жишээ нотлон харуулж байна. Харин төр, засгийн эрх мэдлийн хуваарийг салгаж харуулах эрмэлзэлтэй, эсвэл бэлтгэл ажлын боломжийг харгалзан үзэх шаардлагатай тохиолдолд ерөнхийлөгчийн ба хууль тогтоох байгууллагын сонгуулиудыг тусад нь явуулах нь зүйтэй байж болно.

Зайнаас санал өгөх арга

160. Шинэ, хуучин ардчилсан орнууд ялгаагүй дэлхийн олон улс оронд сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сонгуулийн өдөр оршин суугаа хаяг дээрээ байхгүй хүмүүсийг зайнаас санал өгүүлэх аргыг ашиглаж байна. Зайнаас санал өгөх ажиллагаанд харъяа санал хураалтын байрнаас өөр газраас, эсвэл өөр хугацаанд биечлэн санал өгөх, саналаа

шуудангаар илгээх юмуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан өгөх хэлбэрүүд ордог. Зайнаас санал өгөх нөхцөл шаардлага хэр энгийн хялбар байгаагаас шалтгаалан нийт саналын багагүй хувийг зайнаас өгсөн саналууд эзлэх нь бий. Финляндад зайнаас өгсөн санал нийт саналын 37 хувьтай тэнцдэг бол 2003 онд Маршаллын арлууд дээр болсон хууль тогтоох байгууллагын сонгуульд 58 хувьд хүрсэн байна. Зайнаас өгсөн санал нийт саналын 30 орчим хувь байдаг Швед Улсад сонгогчид сонгуулийн өдөр харъяа санал хураах байрандаа ирж амжих юм бол өмнө урьдчилж өгсөн саналаа өөрчилж болдог байна. Харин үүнийг хэрэглэх явдал нь сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтад, тухайлбал сонгуулийн шударга байдалд нөлөөлж болох талтай.

161. Зайнаас санал өгүүлэх үйл явцыг нам бүр үндэсний хэмжээнд нэг жагсаалт гарган өрсөлдөх ЖХТТ-той тохиолдолд зохион байгуулахад хамгийн хялбар байдаг бол нэг мандаттай тойргуудтай тогтолцоонд хэрэглэхэд ихээхэн ярвигтай. Ялангуяа гадаадаас санал өгөх ажлыг зохион байгуулж байгаа бол сонгогч бүрт зөв саналын хуудас олгохтой холбоотой практик асуудлуудыг нарийн харгалзаж үзэх шаардлагатай. Сонгуулийн тойрог олонтой тогтолцоонд тухайн улсын элчин сайдын яамдаар дамжуулан саналын хуудас тараах хүндрэлтэй байж болно. Элчин сайдын яам бүр саналын зөв хуудсыг хүлээн авсан байх, тэгээд сонгогч нэг бүрт хуудсыг нь алдаагүй олгох ажлыг зохион байгуулах зэрэг сорилт тулгарна. Хэрвээ саналын хуудсыг шуудангаар хүргүүлнэ гэвэл сонгуулийн цагийн хуваарьт ч нөлөөлж болно.

162. Гадаадаас өгсөн саналыг тухайн сонгогчийн оршин суудаг тойрогт нь тооцох (Шинэ Зеланд), гадаадад байгаа сонгогчдыг нэг (буюу олон) тойрог болгожтоолох (Хорват), нэг буюутүүнээсдээш тодорхой тойрогтой холбож өгөх (Индонези), эсвэл зөвхөн үндэсний хэмжээний ЖХТТ-оор суудал хуваарилах үед нийт саналын дүнд нэмж тооцох (Нидерланд) боломжтой юм.

Ирцийн асуудлууд

163. Сонгуулийн ирцийн түвшин ба сонгуулийн тогтолцоо хоорондоо харилцан уялдаа холбоотой байдаг. ХТТ-нд ерөнхийдөө сонгогчдын ирц өндөр байна. Олонхийн тогтолцоогоор сонгууль явуулахад аль нам ялах нь тодорхой бус, сонгуулийн дүн их ойролцоо гарах төлөвтэй байхад ирц өндөр байх хандлага ажиглагдана. Түүнчлэн нэг тойрогт өрсөлдөгчдийн авах саналын дүн ойролцоо гарах төлөвтэй байгаа бол ирц илүү өндөр байдаг байна.

164. Сонгуулийн хууль ёсны байдлыг дээшлүүлэх арга хэмжээ болгож зарим орон, ялангуяа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан хэд хэдэн бүгд найрамдах улс сонгуулийг хүчинтэйд тооцох ирцийн доод хэмжээг зааж өгсөн байдаг. Хэрэв сонгуулийн тойрогт ирц хүрэхгүй, тухайлбал 50 хувиас доош байгаа бол тухайн сонгуулийг хүчингүйд тооцдог. Гэхдээ ийнхүү зайлшгүй хангагдсан байх ёстой ирцийн хэмжээг зааж өгсөн нөхцөлд сонгуулийг хэдэн удаа явуулаад ч ирц хүрэлцэхгүй байх тохиолдол гардаг ба энэ нь сонгуулийг зохион байгуулах үүрэг хүлээсэн байгууллагын хувьд нэг ёсны хар дарсан зүүд болж, ирц хүрэхгүй байгаа сонгуулийн тойргууд там болон хувирах талтай. Тухайлбал, Украин Улс хэд хэдэн удаа нөхөн сонгууль явуулаад шаардлагатай ирцийн түвшинд хүрч чадаагүйгээс болж 1998 онд сонгууль явуулахдаа сонгуулийн ирцийн тухай заалтыг хүчингүй болгосон байна.

165. Сонгуульд заавал оролцохыг шаардах замаар сонгогчдын оролцооны асуудлыг шийддэг цөөнгүй орон байдгийн дотор Австрали, Бельги, Грек, Латин Америкийн орнууд ордог. Харин бусад олон орон санал хураалтад сонгогчдыг албадан оролцуулахаас зарчмын хувьд татгалздаг. Ийм шаардлага тавих зохицуулалт аль ч сонгуулийн тогтолцоонд таарч тохирч болох ч энэ аргыг хэрэглэх асуудлыг сонгуулийн ирцтэй холбоотой бусад асуудалтай хамтад нь авч үзэж хэрэгтэй.

Зөрчил мөргөлдөөний дараах болон шилжилтийн үеийн сонгууль

166. Зөрчил мөргөлдөөний дараах нөхцөл байдалд болон шилжилтийн үед сонгуулийн тогтолцооны талаар хэлэлцүүлэг өрнүүлж, бодож эргэцүүлэх хугацаа бага байх нь олонтаа. Энхийн гэрээ байгуулсны дараа, эсвэл авторитар дэглэм нуран унасны дараах улс төрийн үйл явцын эрч хүч сонгуулийг аль болох хурдан явуулах дарамт шахалт үүсгэх нь бий. Шилжилтийн үеийн сонгуулиудыг тойрсон улс төрийн хүсэл эрмэлзлэл, хязгаарлалтуудын тухай ярих нь энэхүү гарын авлагын цар хүрээнээс хэтрэх боловч сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалттай холбоотой зарим нэг тодорхой асуудал, бэрхшээлийн талаар авч үзье.

167. Янз бүрийн сонгуулийн тогтолцооны дэд бүтцийг бүрэлдүүлэхэд шаардагдах хугацаа харилцан адилгүй. Жишээлбэл, сонгогчдын нэрийн жагсаалт гаргах, тойргийн хил тогтоох асуудлууд хоёулаа цаг их авах ажил ба үр дүн нь сонгуулийн хууль ёсны байдалд чухал нөлөөтэй байдаг. Гэвч, нэг талаас сонгогч биеэр санал хураах байранд ирж саналаа өгдөг, тогтолцоо нь хувь тэнцүүлсэн бөгөөд улс даяараа нэг тойрог болж намын

жагсаалтаар санал хурааж буй нөхцөлд дээрх хоёр асуудал төдийлэн ач холбогдолтой биш байх тал бий. Нөгөөтэйгүүр нэг мандаттай тойргуудад олонхийн тогтолцоогоор сонгууль явуулахад дээрх хоёр асуудлыг зөв зүйтэй шийдэх нь маш чухал юм. Тэрчлэн шилжилтийн үеийн анхны сонгуульд авч хэрэглэсэн тогтолцоо цаашид удаан хэрэглэхэд тохиромжгүй байх тал ажиглагддаг. Гэхдээ байн байн тогтолцоогоо өөрчлөх нь тогтолцооны үзүүлэх нөлөөнд сонгогчид, улс төрийн намууд аль аль нь дасан зохицож чадахгүй байх үр дагавар үзүүлэх ба үүнтэй холбоотой тогтолцоог өөрчлөх үйл явц үргэлжилсээр байх нь бас таатай зүйл биш юм.

168. Сонгуулийн хуулийг шинээр боловсруулахад оролцогч талууд аль болох оролцоог хангах институци бий болгохыг эрмэлзэж улмаар нэр дэвшүүлэх шалгууруудыг зөөллөх, албан ёсны болоод далд босго доогууртай сонгуулийн тогтолцоог авч хэрэглэх замаар сонгуульд оролцох боломжийг хялбарчлах нь бий. Нөгөөтэйгүүр хувь хүний болон үндэстэн угсаатны чанартай улс төрөөс үүдэн намын тогтолцоо задарч бутрахад санаа зовнин сонгуульд оролцох, сонгогдох шалгуурыг өндөрсгөх нь ч байна. Харин олон нам нэг зэрэг төрөн гарах явдал бол авторитар дэглэмээс салж байгаа орнуудын сонгуулийн онцлог байдаг бөгөөд амжилт муутай оролцсон намууд аяндаа алга болдог байна.

169. Хэврэг эсвэл хуваагдмал улс төрийн орчин нөхцөлд ардчиллыг бэхжүүлэх гэж байгаа бол Суданы туршлагаар эхлээд орон нутгийн сонгуулийг, яваандаа сонгуулийн дэд бүтэц, улс төрийн нөхцөл байдал бүрдээд ирмэгц бүс нутгийн болон үндэсний сонгуулийг явуулах нь улс төрийн үүднээс илүү оновчтой байж болох юм гэсэн санал үндэслэлийг заримдаа дэвшүүлэх нь байдаг. Хэрвээ ийм стратеги сонгосон бол сонгуулийн тогтолцоо нь орон нутгийн сонгуульд тавигдах улс төрийн шаардлагыг хангах төдийгүй товлосон цаг хугацаанд багтаан сонгуулийг зохион байгуулах боломжтой байдлаар зохиомжлогдсон байх нь чухал.

170. Зөрчил мөргөлдөөний дараах сонгуульд гадаад, дотоодод дүрвэгсэд болон шилжин суурьшсан иргэдийн саналыг авах асуудал онцгой ач холбогдолтой байх нь бий. Гадаадаас санал өгөх ажлын үр нөлөө, ач холбогдлыг харуулах нэг тоджигшээ бол Босни Герцоговен юм. 1998 онд тус улсын нийт хоёр сая орчим сонгогчдын 314,000 нь хилийн чанадаас санал өгөхөөр бүртгүүлсэн байсны талаас илүү хувь нь Хорват болон хуучин ХБН Югослав Улсын (одоогийн Серб Монтенегро) нутаг дэвсгэрээс, үлдсэн хэсэг нь янз бүрийн 51 улсаас хандсан байна. Эдгээрийн 66 хувь нь хүчинтэй саналын хуудаст тооцогдсон байдаг.

БҮЛЭГ 4

БҮЛЭГ 4

4. Сонгуулийн тогтолцоо, институцийн бүтэц ба засаглал

171. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО нь засаглал, бодлогын үйл явц, улс төрийн тогтвортой байдал зэрэгт онцгой нөлөө үзүүлсээр ирсэн. Ялангуяа, парламентын тогтолцоотой үед сонгуулийн янз бүрийн тогтолцоо нь засаглалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Тухайлбал, нэг нам дангаар засгийн эрх барих нөхцөлийг бүрдүүлдэг сонгуулийн тогтолцоо (тухайлбал, олонхийн тогтолцоо), олон намын эвслийн засгийн газар байгуулагдах боломжтой сонгуулийн тогтолцоо (тухайлбал, хувь тэнцүүлсэн тогтолцоо) хоёр хоорондоо зөрчилтэй шинжийг агуулж байдаг. Энэ хоёрын аль аль нь бодлогын үйл явцад ч тодорхой нөлөөтэй. Тухайлбал, нэг намын засгийн газар бодлого боловсруулахдаа шийдэмгий, хариуцлагыг хэн хүлээх вэ гэдэг нь илүү тодорхой байдаг бол эвслийн засгийн газруудын боловсруулсан бодлого олон нийтийн санал бодлыг тусгасан, илүү өргөн хүрээг хамарсан байх магадлал ихтэй байна. Үүний нэгэн адилаар нэг намын засгийн газартай үед төр, засгийн бодлогод томоохон өөрчлөлт хийхэд хялбар байдаг бол эвслийн засгийн газар нь аливаа өөрчлөлтийг хийхээс өмнө асуудлыг хэлэлцэж, маргаан өрнүүлж цаг авах ерөнхий хандлага ажиглагдана.

172. Ерөнхийлөгчийн ба хагас ерөнхийлөгчийн засаглалтай бараг бүх улс орон ерөнхийлөгчөө шууд сонгодог. Түүнчлэн зарим бүгд найрамдах улсууд парламентын тогтолцоотой боловч төрийн тэргүүнээ шууд сонгодог байна.

Ерөнхийлөгчийн тогтолцоотой үед тус институцийн хууль ёсны байдал, нийтээр хүлээн зөвшөөрсөн бүрэн эрх нь ерөнхийлөгч ямар арга замаар сонгогдсон вэ гэдгээс маш ихээр хамаардаг. Олонхийн дэмжлэгийг илтэд хүлээж сонгогдсон ерөнхийлөгч, ялигүй хэдэн саналын зөрүүгээр

албан тушаалд хүрсэн ерөнхийлөгчийг бодвол хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрөгдөх давуу тал хамаагүй илүүтэй, өөрийн бодлогыг хэрэгжүүлэхээр шахаж шаардах хүчтэй байр суурьтай байна. Энэ нь ерөнхийлөгч ба хууль тогтоох байгууллагын хоорондын харилцаанд чухал дам нөлөө үзүүлдэг. Үнэмлэхүй олонхийн саналаар сонгогдсон ерөнхийлөгч хууль тогтоох байгууллагатай ямар нэг байдлаар зөрчилдөхдөө хууль ёсны бүрэн эрх нь ард нийтийн дэмжлэгэд баттай суурилсан байх давуу талтай. 1970 онд Чили Улсад Сальвадор Алленде 36 хувийн саналаар сонгогдоход үүнээс тэс өөр нөхцөл байдал үүсч түүнийг Конгрессийн баруун жигүүр эсэргүүцэн улмаар 1973 оны цэргийн эргэлт гарах нэг шалтгаан нөхцөл болсон байдаг.

173. Парламентын болон хагас ерөнхийлөгчийн, ерөнхийлөгчийн тогтолцоонд хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын хоорондох харилцааны хэв шинж харилцан адилгүй байна. Ерөнхийлөгчийн буюу хагас ерөнхийлөгчийн тогтолцоонд ерөнхийлөгчийн байр суурь түүнд хууль тогтоох байгууллага итгэл хүлээлгэж буй эсэхээс үл хамаарна. Ийм нөхцөлд ерөнхийлөгчийг цэвэр бодлогын шинж чанартай үндэслэлээр албан тушаалаас нь огцруулах боломжгүй. Гэвч Латин Америкийн орнуудын туршлагаас харахад шууд сонгогдсон ерөнхийлөгч хууль тогтоох байгууллагын гишүүдийн нэлээдийн дэмжлэгийг авч чадахгүй бол амжилттай ажиллахад хэцүү байх талтай.

Иймээс ерөнхийлөгчийн ба хагас ерөнхийлөгчийн тогтолцоотой ардчилсан улсуудын ерөнхийлөгчийн ба хууль тогтоох байгууллагыг сонгох сонгуулийн тогтолцооны тухай асуудлыг хэдийгээр дээрх хоёр институци өөр өөрүүрэг гүйцэтгэдэг, сонгуулийн тогтолцооны сонголтыг хийхэд нөлөөлөх хүчин зүйлс ялгаатай байх ч хамтад нь авч үзэх шаардлагатай. Сонгуулиудыг нэгэн зэрэг, эсвэл салангид явуулах, түүнчлэн намуудын нэгдэл нягтрал, задрал бутралд нөлөөлөх зохицуулалтууд, сонгогдсон албан тушаалтнууд болон намын удирдлагынх нь хоорондын харилцааны асуудлыг бүгдийг цогцоор авч үзэх нь зүйтэй.

Ерөнхийлөгчийн сонгууль

173. Зарчмын хувьд ерөнхийлөгчийг шууд сонгоход нэг мандаттай тойргоор санал хураадаг тогтолцооны алийг нь ч хэрэглэж болно. Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын тэргүүнээр томилогддог тохиолдолд ялсан нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн саналаар гарч ирэх бололцоо онолын хувьд хамгийн дөхүү бүрдүүлдэг тогтолцоо авч хэрэглэх хүчтэй норматив, практик хандлага ажиглагддаг. Энэ шалтгаанаас үүдэлтэй

ерөнхийлөгчийн шууд сонгуультай дийлэнх улс орон хоёр шатлалтай тогтолцоог хэрэглэж байгаа тоо баримт байна.


174. Сонгуулийг хоёр шаттай явуулах үед эхний шатанд тэргүүлсэн нэр дэвшигчид энэ шатанд хасагдсан нэр дэвшигчийн дэмжлэг, туслалцааг хоёр дахь шатанд авахын тулд шаргуу ажиллахад хүрдэг. Заримдаа ийм тохиролцоо нь дан ганц ялалт байгуулах хүсэл эрмэлзэлд үндэслэсэн байх нь тохиолдоно. Өөрөө хэлбэл, тохиролцоо нь бодлого, хөтөлбөр нь хоорондоо хэр нийцтэй байгаагаас хамаарах бус, харин эрэмбэт саналын тогтолцоонд нэр дэвшигчид хоорондоо сонголтоо урьчилсан наймаалцаж тохиролцдогтой төстэй байдлаар хийгддэг ажээ. Түүнчлэн ерөнхийлөгчийн сонгуулийг ХШТ-оор явуулахад их хэмжээний зардал чирэгдэл, хөрөнгө хүч шаардагддаг бөгөөд эхний болон хоёр дахь шатны хооронд сонгогчдын ирц ноцтой буурах зэрэг сөрөг тал байдаг. Үүнээс болоод хувилбарт санал болон нэмэлт саналын тогтолцоог авч турших явдал газар авч байна.

Харьцангуй олонхийн тогтолцоо

176. Аль нэг ерөнхийлөгчийг сонгох хамгийн шулуухан арга бол үнэмлэхүй олонхийн санал аваагүй ч гэсэн харьцангуй олон санал авсан нэр дэвшигчийг албан тушаалд томилох явдал байдаг. Босни Герцоговен, Камерун, Коморын арлууд, Экваторын Гвиней, Гаяана, Гондурас, Исланд, Кирибати, Өмнөд Солонгос, Малави, Мексик, Палестин, Панам, Парагвай, Филиппин, Руадна, Сингапур, Тайвань, Тунис, Венесуэл, Замби Улсын ерөнхийлөгчийн сонгуульд үүнийг хэрэглэдэг. Ийм тогтолцоо энгийн хялбар, хямд төсөр, үр өгөөжтэй нь тодорхой боловч, олон нэр дэвшигч ширүүн өрсөлдөж буй тохиолдолд сонгогчдын дийлэнх олонхийн хийж буй сонголт гэж үзэхээргүй дэндүү цөөн санал авсан хүн сонгогдох боломжтой. Заримдаа сонгогчдын олонхийн эсэргүүцсэн хүн хэдхэн саналын илүүгээр ялалт байгуулах явдал тохиолддог. Ийм жишээнд ерөнхийлөгч Рафаель Калдера нийт сонгогчдын 30,5 хувийн саналаар сонгогдсон 1993 оны Венесуэлийн сонгууль, мөн ерөнхийлөгч Фидель Рамос нийт сонгогчдын 24 хувийн саналаар долоон нэр дэвшигчтэй тойргоос сонгогдсон Филиппиний 1992 оны сонгуулийг дурдаж болно. Тайваний 2000 оны ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгч Чен Шуибиан дөнгөж 39 хувийн саналаар буюу дараагийн өрсөлдөгчөөсөө гурав хүрэхгүй хувийн илүүгээр ерөнхийлөгчид сонгогдсон нь тус улсын хувьд томоохон улсын төрийн шилжилт болсон юм.

177. АНУ ерөнхийлөгчийнхөө сонгуулийг бүх мужуудын хэмжээнд ХОТ-оор явуулдаг өвөрмөц онцлогтой. Муж бүрт харьцангуй олонхийн санал авсан нэр дэвшигч сонгуулийн коллеж дахь тухайн мужийн бүх саналыг авдаг байна. Харин Майне, Небраска хоёр мужийн хувьд арай өөр онцлогтой бөгөөд мужийн хэмжээнд харьцангуй олонхийн санал авсан хүнд хоёр, тухайн муждахь конгрессийн тойргуудад харьцангуй олонхийн саналтай байгаа нэр дэвшигчид нэг санал өгдөг байна. Үүний дараа сонгуулийн коллежоос үнэмлэхүй олонхийн саналаар ерөнхийлөгчийг сонгодог. Энэ нь ялсан нэр дэвшигч өрсөлдөгчөөсөө цөөн саналаар ялах нөхцөл байдалд хүргэж болно. Тухайлбал 2000 онд Бүгд Найрамдах намын нэр дэвшигч Жорж Буш Ардчилсан намын нэр дэвшигч Аль Гороос хагас сая орчим санал дутуу авсан боловч ялалт байгуулж байжээ.

لجنة الانتخابات المركزية
انتخابات رئيس السلطة الوطنية الفلسطينية
١٩٩٦/١/٢٠



لا تقترع لصالح أكثر من مرشح واحد (ضع إشارة X بجانب المرشح الذي تختار)

إسم المرشح	الرقم	X
محمد ياسر عبد الرؤوف عرفات (أبو عمار)	١	
سميحة يوسف مصطفى القبيج خليل (أم خليل)	٢	

ХОТ бүхий Палестиний ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудас

**ELECTORAL
COMMISSION
OF
KENYA**

PRESIDENTIAL ELECTION, 1992

In the **NORTH MUGIRANGO BORABU** Constituency

**PRESIDENTIAL
ELECTION, 1992**

COUNTERFOIL









No.
000000

NORTH MUGIRANGO BORABU

188

Constituency No.

Elector's Serial No.
in register

Candidate's Name	Party Symbol	Voter's Mark
GEORGE ANYONA MOSETI		
DR. ANDERSON CHIBULE WA TSUMA		
DAVID MUKARU NG'ANG'A		
AJUMA OGINGA ODINGA		
KENNETH STANLEY NJINDO MATIBA		
DANIEL TOROITICH ARAP MOI		
MWAI KIBAKI		
JOHN HARON MWAU		

INSTRUCTIONS TO VOTER

1. Mark the paper by placing the mark X in the right-hand column above opposite the name of the candidate you wish to elect.
2. Do NOT place a mark opposite more than one candidate.

Хоёр шатлалт тогтолцоо (ХШТ)

178. Хууль тогтоох байгууллагын сонгуульд байдаг шиг нэр дэвшигчид нийт саналын өчүүхэн бага хувиар сонгогдохоос сэргийлэх нэг арга бол эхний шатанд хэн нь ч үнэмлэхүй олонхийн санал аваагүй бол хоёр дахь санал хураалт явуулах арга юм. Энэ нь дээр дурдсанчлан (᠑᠖ дугаар хэсэг) хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд (халз мажоритар) эсвэл хоёроос дээш нэр дэвшигчийн хооронд (олонхийн/мажоритар) явагдаж болдог. Франц Улс, Латин Америкийн ихэнх орнууд, хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан Төв Азийн таван бүгд найрамдах улс, Африкийн франц хэлтэй олон орон ерөнхийлөгчөө сонгохдоо ХШТ-г хэрэглэдэг. Африк тивд энэ тогтолцоог Ангол, Капе Верде, Гамби, Гана, Гвиней-Бисау, Кени, Мозамбик, Намиби, Нигери, Сан Томе Принцип, Сейшел, Сьерра Леоне, Судан, Танзани, Уганда, Зимбабве Улс, Европт Францаас гадна Армян, Азербайжан, Австри, Беларусь, Болгар, Хорват, Кипр, Финлянд, Гүрж, Литва, Македон, Польш, Португаль, Румын, Орос, Словак, Словен, Украин Улс, түүнчлэн Афганистан, Гайти, Индонези, Иран, Зүүн Тимор, Йемен зэрэг улс тус тус хэрэглэж байна.

179. Үнэмлэхүй олонхийн болон олонхийн тогтолцооны бусад хувилбаруудыг өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэглэсэн олон жишээ байдаг. Коста Рика Улсад нэр дэвшигч эхний шатаас 40-хөн хувийн саналаар шалгарах боломжтой байдаг бол Сьерра Леоне Улсад нэгдүгээр шатанд аль нэг нэр дэвшигч 55-аас дээш хувийн санал авсан тохиолдолд л хоёр дахь үеийг явуулдаггүй байна. Аргентин Улсад нэр дэвшигч эхний үед амжилт олохын тулд 45 хувийн санал авах, эсвэл дор хаяж 40 хувийн санал авсан байхын зэрэгцээ удаах өрсөлдөгчөөсөө санал нь 10 хувиар илүү байх ёстой байдаг. Үүнтэй төстэй 40 хувийн босго, 10 хувийн зөрүүний тухай заалт Эквадор Улсад бас байна.

180. Цөөнгүй улсад ерөнхийлөгчийн сонгуулийг хүчинтэйд тооцоход шаардлагатай сонгогчдын ирцийн доод хэмжээг хуулиар зааж өгсөн байх ажээ. Орос болон хуучин Зөвлөлт холбоот улсын бүрэлдэхүүнд байсан бүгд найрамдах улсуудад сонгуулийг хүчинтэйд тооцох ирц 50 хувь байх жишээтэй. Энэ нь сонгуулийн үр дүнгийн хууль ёсны байдлыг хангахад чиглэсэн нэмэлт механизм болдог.

کاندیدان ریاست جمهوری خود را شناسید دولسمشری خپل کاندیدان وپیرنی

د ۱۳۸۳ کال د ولسمشرۍ ټولټکنې
انتخابات ریاست جمهوری سال ۱۳۸۳
د انتخاباتو د تنظیم کونکي
شور مرکزک تنظیم انتخابات
د ولسمشرۍ د انتخاباتو د رایو جوړونه ورځ رایو یوای انتخابات ریاست جمهوری
یو رای د خپلې خوښې د یوه کاندید تر مخ جوړکول په نښه کړه.
دو مغفل جوړکول په یوه کاندید دخواه دان یک علامه پکار یو.

<input type="checkbox"/>	عبد التوفيق پيرام	حزب ګډه ښي افغانستان
<input type="checkbox"/>	محمد کرزي	کانديد مستقل
<input type="checkbox"/>	همايون شاه آصفی	کانديد مستقل
<input type="checkbox"/>	مير محمد محفوظ نيايي	کانديد مستقل
<input type="checkbox"/>	حاجي محمد محقق	کانديد مستقل
<input type="checkbox"/>	سيد اسحق گيلاني	نهضت هېمنتگي ملي افغانستان
<input type="checkbox"/>	عبد الستار سيرت	کانديد مستقل
<input type="checkbox"/>	عبد الحفيظ منصور	کانديد مستقل
<input type="checkbox"/>	غلام فاروق نجرابي	حزب استقلال افغان ښار
<input type="checkbox"/>	احمد شاه احمد زى	کانديد مستقل
<input type="checkbox"/>	عبد الحبيب اربین	کانديد مستقل
<input type="checkbox"/>	وکيل منگل	کانديد مستقل
<input type="checkbox"/>	عبد الهادی خليل زى	کانديد مستقل
<input type="checkbox"/>	محمد ابراهيم رشيد	کانديد مستقل
<input type="checkbox"/>	محمد بوټس قاتوټى	نهضت ملي افغان ښار
<input type="checkbox"/>	ممنوعه جلال	کانديد مستقل
<input type="checkbox"/>	سيد عبد الهادی ډبير	کانديد مستقل
<input type="checkbox"/>	عبد الرشيد دوستم	کانديد مستقل

Хоёр шатлалтай тогтолцоо бүхий Афганистаны ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудас

181. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг эхний шатанд ялуулахын тулд намууд сонгуулийн өмнө эвсэл байгуулж болдог орнуудыг (Бразил 1994 онд, Чили 1989, 1994 онуудад) эс тооцвол ХШТ-г хэрэглэх явдал Латин Америкийн орнуудад хүндрэлтэй байсаар иржээ. Жишээлбэл, Перугийн 1990 оны сонгуульд Альберто Фүжимори хоёр дахь шатанд 56 хувийн саналаар ялалт байгуулсан боловч түүний нам Сенатийн 60 суудлын дөнгөж 14-ийг, Төлөөлөгчдийн танхимын 180 суудлын 33-ыг авсан байна. 1989 оны Бразилийн ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Фернандо Коллор де Мело хоёр дахь шатанд нийт саналын тал хүрэхгүй хувийг авч ялсан боловч дараа нь болсон хууль тогтоох байгууллагын сонгуульд түүний нам Сенатын 75 суудлын гуравханыг, Төлөөлөгчдийн танхимын 503 суудлын 40-хөнийг авсан байна. 1978 онд Эквадорын ерөнхийлөгчийн сонгуульд ХШТ-г хэрэглэснээс хойш нэг ч ерөнхийлөгчийн нам хууль тогтоох байгууллагад олонхийн суудал авч чадаагүй ажээ.

Үүнээс үүдсэн засаглалын хүндрэл бэрхшээл нь харилцан уялдаатай институцийн талаар зохицуулалтыг хамтад нь цогц байдлаар авч үзэхийн чухлыг харуулж байна. Хэдийгээр ХШТ-гоор явуулсан сонгуулийн хоёр дахь шатанд нийт сонгогчдын олонхийн санал авсан ерөнхийлөгч сонгогддог ч хууль тогтоох байгууллагыг сонгож буй тогтолцооноос үүдэлтэй парламентаасаа дэмжлэг авч чадахгүй байх явдал элбэг ажээ. Ялангуяа Бразилд ийм нөхцөл байдал намууд задарч бутрахад хүргэсэн байна. Ерөнхийлөгчид нэр дэвшигчид эхний ба хоёрдугаар шатны хооронд бусад намын дэмжлэгийг авч чадаж байсан ч тэдэнд энэ дэмжлэгээ сонгуулийн дараа хэвээр хадгалах боломж бага байж иржээ.







Эрэмбэт саналын тогтолцоо

182. ХШТ-ны сул талуудыг тойрч гарах нэг арга бол эхний ба хоёр дахь шатыг нэгтгэж нэг сонгууль болгон явуулах явдал юм. Үүнийг хийх хэд хэдэн арга байдаг. Нэг илэрхий шийдэл нь АСТ бөгөөд үүнийг Бүгд Найрамдах Ирланд Улсын ерөнхийлөгчийн сонгуульд хэрэглэдэг. Гэхдээ доогуур байр эзэлсэн нэр дэвшигч хоёр дахь сонголтын саналыг олноор нь авч дээгүүр байр эзэлсэн нэр дэвшигчээ ялах явдал энэ тохиолдолд гардаг. Ингэж санал шилжүүлэхэд ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж байсан хамгийн сүүлийн жишээ бол 1990 онд Ирландын ерөнхийлөгчөөр сонгогдсон Мэри Робинсоны сонгууль байлаа.

183. Хоёр дахь боломж бол Шри Ланкийн ерөнхийлөгчийн болон Лондон хотын захирагчийн сонгуульд хэрэглэдэг нэмэлт саналын тогтолцоо хэмээх эрэмбэт саналын тогтолцоо юм. Энэ тохиолдолд сонгогчид

зөвхөн эхний сонголтын нэр дэвшигчээ тэмдэглээд зогсохгүй хоёр дахь (Шри Ланкад бол мөн гурав дахь) сонголтоо тэмдэглэнэ. Харин саналын хуудас бага зэрэг ялгаатай байдаг. Шри Ланкад сонгогчид АСТ-ны болон СШТ-ных шиг нэр дэвшигчдийн нэрийн ард '1', '2', '3' гэсэн дугаар тавьж саналаа өгдөг. Лондонд бол ямар нэг дугаар тавих шаардлагагүй, саналын хуудас нь эхний сонголтод зориулсан ба хоёр дахь сонголтод зориулсан гэсэн хоёр баганатай байдаг. Сонгогчид эхэлж дэмжих болон удаад нь дэмжих нэр дэвшигчээ зохих багананд нь тэмдэглэх шаардлагатай. Энэ нь сонгогчид өөрсдөө ямар нэг дугаар тавих шаардлагагүй гэсэн үг.

184. Дээрх аргуудын аль алинд нь ижилхэн тооллого явагддаг. нэр дэвшигч эхний сонголтод орсон саналын тоогоор үнэмлэхүй олонхийн санал авсан тохиолдолд тэр даруйд нь ялагчаар зарладаг. Харин нэг ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авч чадаагүй бол тэргүүлэх хоёр нэр дэвшигчээс бусдыг нь хасч, тэдний хоёр дахь (Шри Ланкад бол хоёр болон гурав дахь) сонголтын саналуудыг сонголтын дарааллын дагуу үлдсэн хоёр тэргүүлэх нэр дэвшигчид хуваарилдаг. Энэ ажиллагаа дууссаны дараа хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог. Иймээс энэ тогтолцоо нь ХШТ-оор хоёр сонгуулиар шийддэг үр дүнд нэг удаагийн сонгуулиар хүрч ихээхэн зардал хэмнэдэг төдийгүй захиргааны хувьд илүү үр ашигтай байх талтай.

ජනාධිපතිවරණය 1994 சனாதிபதித் தேர்தல் 1994 Presidential Election 1994 උප පත්‍රිකාව அடிப்பித்தழ் Counterfoil අංකය } CM இல. No. ජනලේඛනයෙන් අංකය வாக்காளரின் இல. No. of Voter B 034001-ද. ඉ. 04-0606 ශ්‍රී ලංකා CM/1 B 034001-д. И. 04-0606 Шри ланка CM/1	වජිරිකා ඛණ්ඩාරනායක කුමාරතුංග சந்திரிகா பண்டாரநாயக குமாரதுங்க Chandrika Bandaranaike Kumaratunga ගලපපත්ති ආරච්චිගේ නිහල් கலப்பத்தி ஆரச்சிகே நிறூரால் Galappaththi Arachchige Nihal			
	ගාමිණී දිසානායක காமணி திசானாயக Gamini Dissanayake ඒ. ජේ. රණසිංහ ஏ. ஜ. ரணசிங்க A. J. Ranasinghe			
	හරිශ්චන්ද්‍ර විජයතුංග ஹரிசந்திர விஜயதுங்க Harischandra Wijayatunga			
	හඩ්සන් සමරසිංහ ஹட்சன் சமரசிங்க Hudson Samarasinghe			
				
				

Эрэмбэт тогтолцоо бүхий Шри Ланкийн ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудас

185. Нэмэлт саналын тогтолцооны сул тал нь сонгогчдын хувьд заримдаа ойлгоход бэрхтэй нарийн түвэгтэй байдал юм. Сонгогч саналаа дэмий үрэгдүүлэхгүйн тулд ямар хүмүүс эхний хоёрт жагсахыг таахаас өөр аргагүй болдог.

186. Хэдий ийм ялгаатай ч АСТ-ны болон Нэмэлт саналын тогтолцооны үндсэн зорилт нь адилхан буюу сонгуульд хэн нь ч ялсан нийт сонгогчдын үнэмлэхүй олонхийн санал авсан байх явдал юм. Сонгогч хоёр дахь сонголтоо илэрхийлснээр санал хураалтын хоёр дахь үе шат шаардлагагүй болох бөгөөд ихээхэн өртөг зардал хэмнэх төдийгүй зохион байгуулалт, аюулгүй байдал талаасаа ч ашигтай байдаг.

Газар зүйн хувьд саналын хуваарилалтад тавих нөхцөл

187. Индонези, Кени, Нигери гэсэн гурван улс ерөнхийлөгчийн сонгуульдаа “хуваарилалтын нөхцөл” гэгчийг мөн нэмж тавьдаг. Ийм тохиолдолд нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авсан ч түүнийг

зохих ёсоор сонгогдсонд тооцож зарлахын өмнө авсан саналынх нь тоо бүс нутгуудад хэрхэн хуваарилагдаж тархсан байгааг харгалзан үзэх шаардлагатай болдог. 2004 онд анхны ерөнхийлөгчийн шууд сонгуулиа явуулсан Индонези Улсад гэхэд ерөнхийлөгч ба дэд ерөнхийлөгчид нэр дэвшсэн баг хоёр дахь шатны санал хураалтад оролцохгүйгээр ялалт байгуулахын тулд үндэсний хэмжээнд нийт саналын үнэмлэхүй олонхийг аваад зогсохгүй бүх мужын талаас илүүд нь дор хаяж 20 хувийн санал авсан байх шаардлага тавьсан байдаг. Энэ шаардлагыг томоохон газар нутагтай, олон янзын бүс нутгаас бүрдсэн өөр нэг улс болох Нигери авч хэрэглэсэн бөгөөд нэр дэвшигч сонгогдохын тулд нийт саналын үнэмлэхүй олонхийг авах ёстой төдийгүй мужуудын дор хаяж гуравны хоёрт нь гуравны нэгээс дээш хувийн санал авсан байх ёстой ажээ.

188. Ийм шаардлага тавих нь нэр дэвшигч өөрийн нутгаас, эсвэл үндэс угсаа ижилтэй сонгогчдоос гадна бусад хүмүүсийн өргөн дэмжлэгийг олж авахаар хичээх сэдэл төрүүлдэг ач холбогдолтой бөгөөд зөв зохистой хэрэглэж чадвал маш сайн нөлөө үзүүлдэг. Гэхдээ дээрх хоёр шаардлагыг зэрэг тавих нь хоёуланг нь хангах нэр дэвшигч гарч ирэхгүй байх эрсдлийг ямагт дагуулдаг. Сонгуулийн тогтолцоо ялагчийг гаргадаггүй, эсвэл ялагч тодруулах аргачлал тодорхой биш нөхцөлд эрх мэдлийн хоосон орон зай үүсч улмаар тогтворгүй байдалд хүргэх аюул нүүрлэх учраас сонгуулийн тогтолцоо боловсруулагчид энэ болзошгүй тохиолдлыг анхаарч, хэрхэн шийдвэрлэх тухай заалтуудыг нь оруулж өгөх нь чухал.

Индонезид хоёр дахь шатанд энгийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог бол Нигерт ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь шатанд ч нэр дэвшигчийн авсан санал нь газар зүйн хувьд тодорхой хүрээг хамарсан байх нөхцөлийг тавьдаг нь дахин гурав дахь шатны сонгууль зохион байгуулахад ч хүргэж болзошгүй байдаг байна. Хэрвээ амьдрал дээр үнэхээр ийм нөхцөл байдал үүсэх юм бол сонгуулийн үргэлжлэх хугацаа сунжрах төдийгүй шаардагдах санхүүгийн болон захиргааны нөөц ч томоохон асуудал болж тавигдах нь дамжиггүй.

Ялагчийн авсан санал газар зүйн хувьд тархсан байх шаардлага нь зарим нэр дэвшигчдэд стратегийн хувьд давуу тал олгох тохиолдол байна. Тухайлбал, Кени улсын ерөнхийлөгчөөр сонгогдох нэр дэвшигч харьцангуй олонхийн санал авахаас гадна орон нутгийн найман мужийн дор хаяж тавд нь 25-аас дээш хувийн санал авах шаардлагатай байдаг. Гэсэн хэдий ч сөрөг хүчний хуваагдмал байдал нь ерөнхийлөгч Дэниел Арап Мой нийт саналын үнэмлэхүй олонхид хүрэхгүй саналаар 1990-ээд оноос хойш хэдэнтээ сонгогдон ажиллах боломж олгосон байна.

Дээд танхимын сонгууль

189. Хууль тогтоох байгууллагууд бүгд ганц танхимтай байдаггүй, ялангуяа томоохон улс орнуудад хоёр танхимтай парламент олон байдаг. Хоёр дахь танхим нь (гол төлөв дээд танхим буюу сенат гэж нэрлэдэг) дараах хоёр шалтгааны аль нэгээс, эсвэл хоёулангтай холбоотойгоор оршин тогтнож байдаг. Нэгдүгээрт, доод танхимынхаа гаргасан хөнгөн хуумгай шийдвэрт хориг тавих буюу хойшлуулах байдлаар хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Дээд танхимын эрх мэдэл гол төлөв доод танхимаасаа бага байх бөгөөд ялангуяа хяналтын үүрэг голлон гүйцэтгэдэг тохиолдолд ийм байдаг. Дэлхийн нийт улс орны гуравны хоёр орчим нь нэг танхим бүхий хууль тогтоох байгууллагатай, үлдсэн гуравны нэг нь хоёр дахь танхимтай байдаг.

190. Эдгээр танхимын бүтэц маш олон янз байдаг боловч ерөнхийдөө хоёр дахь танхимын хамгийн түгээмэл хэрэглэгддэг тогтолцоо бол холбооны улсын бүрэлдэхүүнийг төлөөлүүлэх байдаг. Жишээлбэл, АНУ, Австралийн муж улсууд, Герман, Өмнөд Африк Улсын мужууд бүгд дээд танхимдаа тусдаа төлөөлөлтэй. Холбооны мужуудын төлөөлөл адил тэгш байх ёстой гэдэг үзлээс үүдэн ихэвчлэн жижиг муж улс, аймгуудын төлөөллийг тэнцвэртэй оролцуулах зохицуулалт хийх нь олонтаа тохиолддог. Түүнчлэн хоёр дахь танхим сонгуулиа шат дараатай хэсэгчлэн явуулах туршлага түгээмэл байна. Жишээлбэл, Австрали, Япон Улс дээд танхимын гишүүдийнхээ тал хувийг гурван жил тутамд сэлгэн сонгодог, АНУ, Энэтхэг Улсад сенатын гишүүдийнхээ гуравны нэгийг хоёр жил тутамд шинээр сонгодог гэх мэт.

191. Дээд танхим нь хяналтын үүрэг голлон гүйцэтгэдэг зарим оронд сонгогдох гишүүдэд тусгай хязгаарлалт тавих нь байдаг. Жишээлбэл, Тайланд Улсад Сенатын танхимын гишүүдийг шууд томилохгүйгээр сонгодог боловч сенаторууд аль нэг улс төрийн намд харъяалагдах, сонгуулийн кампанит ажил явуулахыг хориглодог.

192. Хууль тогтоох байгууллагын хоёр дахь танхимын хувилбарын арай түгээмэл бүс нэг төрөлд тодорхой үндэс угсаа, хэл, соёл, шашны бүлгийн төлөөллийг хангах зорилго бүхий бүтэц багтдаг. Мөн хоёр дахь танхимд иргэний нийгмийн төлөөлөгчдийг зориуд оруулах нь байна. Тухайлбал, Малави Улсын Үндсэн хуулиар 80 сенаторын 32-ыг нь олон нийтийн “сонирхлын бүлгүүд”-ээс санал болгосон нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгох тухай заасан байдаг. Эдгээр бүлгийн тоонд эмэгтэйчүүдийн байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон эрүүл мэнд,

боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүлгүүд, бизнесийн болон хөдөө аж ахуйн салбарт ажилладаг байгууллагууд болон, үйлдвэрчний эвлэлүүд, нийгмийн нэрт зүтгэлтнүүд, шашны тэргүүнүүд багтдаг. Муу нэртэй Британийн Лордуудын танхимыг хааяа ерөнхий мэдлэгтэй улстөрчдийн боловсруулсан хууль тогтоомжид нарийн хяналт тавьж чадах тодорхой бодлогын чиглэлээр мэргэшсэн хүмүүс суудаг гэдэг үүднээс хамгаалах тохиолдол байдаг. Фижи, Ботсвани зэрэг улс хоёр дахь танхимаа уламжлалт омгийн ахлагч нарын төлөөлөлд зориулдаг ба тэднийг Фижид томилж, Ботсванид сонгодог байна.

193. Ийм олон янзын хувилбар байдаг учраас хоёр дахь танхимын нэлээд олон гишүүнийг хэсэгчлэн эсвэл шууд бусаар сонгох, бүр сонгохгүй байх тохиолдол ч байдаг. Сонгуулиар байгуулдаг дээд танхимуудын хувьд парламентын хоёр танхимын үүрэг өөр өөр гэдгийг илтгэн дээд, доод танхимын сонгуулийг хоёр өөр тогтолцоо ашиглан явуулах нь элбэг. Жишээлбэл, Австрали Улс доод танхимаа олонхийн тогтолцоогоор (АСТ), харин янз бүрийн мужийг төлөөлсөн дээд танхимаа хувь тэнцүүлсэн тогтолцоо (СШТ) ашиглан сонгодог байна. Энэ нь доод танхимын сонгуульд ердийнхөө ялж чадахааргүй цөөнхийн ашиг сонирхлын бүлгүүд мужийн төлөөллийн хүрээнд дээд танхимд сонгогдох боломжтой байна гэсэн үг. Индонезид парламентын доод танхимын гишүүдээ ЖХТТ-оор, дээд танхимдаа муж бүрээс дөрвөн төлөөлөгчийг СҮШТ ашиглан сонгодог. Колумбид хоёр танхимаа хоёуланг нь ХТТ-оор сонгодог боловч Сенатаа улс даяараа нэг тойрог болж сонгодог нь жижиг нам, цөөнхийн ашиг сонирхлын бүлэгт дээд танхимд төлөөлөлтэй болох илүү боломж олгож байна.

Засаглалын янз бүрийн шат давхарга

194. Дээр дурдсанчлан сонгуулийн тогтолцоог боловсруулахад тавигдах шаардлагууд нь тухайн сонгох гэж буй байгууллагын төрөл, түүний чиг үүрэг, эрх мэдлээс хамаарч харилцан адилгүй байдаг. Сонгуульт байгууллага нь улсуудын холбооны эсвэл, мужийн, орон нутгийн ямар ашиг сонирхолд үйлчлэхээр байгуулагдсанаас хамааран тэдгээрт зориулсан сонгуулийн тогтолцоог бодож боловсруулахад үндэсний хууль тогтоох байгууллагад зориулсан сонгуулийн тогтолцооноос өөр асуудлуудыг харгалзаж үзэх хэрэгтэй болно.

Улсуудын холбооны байгууллагын сонгууль

195. Европын Парламент зэрэг олон улс орныг хамарсан шийдвэр гаргах харьцангуй их эрх мэдэлтэй байгууллага одоохондоо ховор байгаа ч улс төрийн бодлогын даяарчлал, бүс нутгийн ашиг сонирхол нэгдэхийн хэрээр цаашид илүү түгээмэл болох нь дамжиггүй юм. ЕХ-ноос Европын Парламентын сонгуульд бүх гишүүн орон хувь тэнцүүлсэн тогтолцоо хэрэглэх шаардлагыг хуульчилсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна. Тодруулбал, одоогийн байдлаар нийт 23 улс ЖХТТ, хоёр улс (БН Ирланд Улс, Малт хоёр) СШТ ашиглаж байгаа ажээ. Гишүүн орнуудад суудал хуваарилахдаа цэвэр хүн амын тооны харьцаагаар бус, харин ойролцоо хэмжээтэй орнууд адил тооны төлөөлөгчтэй байх, харин жижиг орнууд харьцангуй илүү төлөөлөлтэй байх зарчмыг дагаж байна.

196. Ийм тогтолцоо боловсруулагчид орон нутгийн газар зүйн төлөөллөөс илүү бүс нутгийн болон намуудын тэнцвэрийг хадгалсан тогтолцоо сонгоход илүү ач холбогдол өгдөг. Европын парламент нь 500 гаруй сая хүнийг төлөөлсөн 732 ЕПГ (Европын парламентын гишүүн)-тэй байдаг нь сонгогч, төлөөлөгчдийн хооронд жижиг тойргийнх шиг хэлхээ холбоо үүсэх боломжгүй болгодог.

197. Европын Парламент нь улсуудын холбооны байгууллага ба нэг гишүүн улсын иргэд нөгөө нэг гишүүн улсдаа нэр дэвшигч байж болох эрхтэй хэдий ч сонгогчдын дунд ийм тусгай сонгууль гэдэг сэтгэлгээ хараахан бүрдээгүй нь харагддаг. Тус байгууллагын сонгууль нь ихэнхдээ гишүүн улс бүрийн үндэсний улс төрийн намуудын өрсөлдөөн мэт ойлгогдох ерөнхий хандлага байна. Улсуудын холбооны байгууллагын сонгуулийн тогтолцоог боловсруулахад үндэсний улс төрийн намууд гол үүрэг гүйцэтгэнэ, түүнчлэн тэнд зонхилж буй бүс нутгийн уламжлал заншлууд (Европын Парламентын жишээнд бол ХТТ) улсуудын холбооны түвшинд ч бас зонхилно гэдэг нь үнэн болоод байх шиг байна.

ЕВРОПЫН ПАРЛАМЕНТ: Улсуудын холбооны байгууллагын сонгууль

Эндрю Эллис, Стина Ларсеруд

2004 оны зургадугаар сард Европ тивийн 25 улсын иргэд Европын Парламентад суух төлөөлөгчдөө сонгохоор санал хураах байранд очжээ. Тэдний дотор олон хүн анх удаагаа саналаа өгсөн бол зарим нь тав дахь удаагийн сонгуульд оролцож буй туршлагатай хүмүүс байв. 2004 онд бүх гишүүн орон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгууль явуулсан байна.

1976 онд Ассамблейн төлөөлөгчдийг бүх нийтийн, шууд сонгуулиар сонгох тухай хуулийг баталснаар Европын Парламентын сонгуультай холбоотой анхны хууль тогтоомж төрөн гарсан байна. Хуулийн нэрнээс тодорхой байгаачлан уг хуулиар гишүүн улс бүрээс төлөөлөгчдийг шууд сонгох зарчмуудыг тодорхойлжээ. Европын Холбоо байгуулагдсан эхний жилүүдэд Европын Парламентын гишүүдийг гишүүн орон бүрийн үндэсний хууль тогтоох байгууллагаас нэр дэвшүүлдэг байсан бөгөөд сонгогчдын шууд оролцоо байгаагүй. 1976 оны хууль батлагдсан нь түүнээс хойш гишүүн улс бүр төлөөлөгчдөө бүх нийтийн шууд санал асуулгаар сонгоно гэсэн үг байв. Европын Парламентын анхны сонгууль 1979 онд Бельги, Дани, Франц, ХБНГУ, Итали, Люксембург, Нидерланд, БН Ирланд Улс, Их Британи гэсэн есөн гишүүн оронд явагдаж нийт 410 гишүүнийг сонгосон байна.

1976 оны хуульд парламентын бүрэн эрхийн хугацаа, нэр дэвшигчдэд тавих шаардлага гэх мэт сонгуультай холбоотой олон зүйлийг тодорхойлж өгсөн боловч сонгуульд яг ямар тогтолцоо хэрэглэх талаар заагаагүй байлаа. Харин сонгуулийн нэгдсэн журмын төсөл боловсруулах үүргийг Европын Парламентад өгчээ. Ийм журам гарч хүчин төгөлдөр үйлчлэх хүртэл сонгуулийн журмыг гишүүн орнуудын үндэсний хууль тогтоомжоор зохицуулахаар болсон байна.

Тухайн үед ихэнх гишүүн орон ХТТ-ны аль нэг хэлбэрийг дангаар нь эсвэл бусад тогтолцооны нэг хэсэг болгон ашиглаж парламентаа сонгож

байсан ба Европын Парламентын сонгуульд ч мөн танил дасал тогтолцоо хэрэглэх хандлагатай байлаа. Бельги, Дани, ХБНГУ, Итали, Люксембург, Нидерланд улсууд, тухайлбал, ЖХТТ-ны хувилбарууд ашиглаж байсан ба энэ тогтолцоогоор сонгууль явуулж бүх төлөөлөгчдөө сонгосон байна (Данийн төлөөллийн хүрээнд багтсан Гренландын нэг төлөөлөгчийн хувьд арай өөр онцлогтой бөгөөд 1985 онд Гренландыг Европын Хамтын Нийгэмлэгээс гарах хүртэл ХОТ-оор сонгож байсан байна). БН Ирланд Улс төлөөлөгчдөө эрэмбэт СШТ-оор сонгохоор болсон байна. Энд хоёрхон онцгой тохиолдол байлаа. Их Британи Улс ХОТ-той, Франц Улс ХШТ-той учраас хоёулаа ХТТ-той танил бус байв.

Их Британий хувьд Төлөөлөгчдийн танхимын сонгуульдаа хэрэглэдэг тогтолцоогоо хуулбарлан Европын Парламентын сонгуульд авч хэрэглэсэн байна. Энэ тогтолцоо нь тус улсын хоёр том нам болох Хөдөлмөрийн болон Консерватив намуудад маш сайн тохирсон бөгөөд аль нэг гуравдагч нам улс төрийн тавцанд гарч ирэх боломжийг хүндрэлтэй болгодог. Мөн нэг төлөөлөгч хоёр мандаттай байхыг эсэргүүцсэн нь Их Британи дахь Европын Парламентын сонгуульд ХОТ хэрэглэхэд түлхэц болсон байна. Британийн зарим улстөрчийн хүсч байсанчлан Европын Парламент, Британийн Парламентад зэрэг алба хашихыг хориглож, ХТТ-ны ямар нэг хэлбэрийг хэрэглэх болбол намын жагсаалт нь үндэсний юмуу орон нутгийн аль нэг байгууллагад сонгогдоогүй, олны танил бус төлөөлөгчдөөс бүрдэх болж, улмаар сонгуулийн хүлээгдэж буй ач холбогдлыг бууруулах эрсдэл дагуулах байлаа. Иймээс нэр дэвшигч төвтэй, нэг мандаттай тойрог бүхий, нэр дэвшигчид нь сонгогчидтойгоо илүү ойр байдаг тогтолцоо сонгох нь арай дээр гэсэн шийдэлд хүрсэн ажээ.

Умард Ирландын хувьд нөхцөл байдал арай өөр байв. Ард иргэдийн олонхи, цөөнхийн төлөөллийг хангах асуудал, түүнчлэн Англи, Шотланд, Уэйлсийн намууд эндэхийн сонгуульд гол төлөв өрсөлддөггүй гэсэн хоёр шалтгаанаар Умард Ирландад ногдсон гурван суудлыг хуваарилахад СШТ хэрэглэх болов. Үүнтэй зэрэгцэн 1976 оны хуулиар сонгуулийн нэгдсэн журам хэрэглэх тухай заасныг үндэслэл болгож Англи, Шотланд, Уэйлсд явуулж буй Европын Парламентын сонгуулийг ХОТ-оор явуулахыг эсэргүүцэн шүүхэд нэхэмжлэл гаргах оролдлого хийгдсэн боловч амжилтгүй болсон байна. Харин бүр хожим нь буюу 1999 онд Европын Парламентын сонгуулийн тухай хууль гарсны дараа Англи, Шотланд, Уэйлсд хэрэглэж байсан тогтолцоог сая өөрчилжээ. Их Британи Улс ч ийм өөрчлөлт албан ёсоор хийгдэнэ гэж урьдаас тооцож байсан ба 2002 онд энэ талаар Зөвлөлийн шийдвэр (дор үзнэ үү) ч гарсан байна. 1999 оноос хойш Их Британи Улс ХТТ хэрэглэдэг бусад гишүүн орны эгнээнд нэгдэн

орж, улмаар хаалттай жагсаалтаар бүс нутгийн сонгуулийн тойргуудад санал хураадаг ЖХТТ -г сонгож авсан.

Франц Улс үндэсний хууль тогтоох байгууллагын сонгуульдаа ХШТ хэрэглэдэг ч Европын Парламентын анхны сонгуульд улс нь нэг тойрог болж хаалттай жагсаалтаар санал хураах ХТТ-г авч хэрэглэх шийдвэрт 1977 оны эхээр хүрчээ. Энэ нь Европын парламентын анхны сонгууль явагдсан 1979 оноос бараг 2 жилийн өмнө болсон явдал бөгөөд цаанаа олон шалтгаантай байлаа. Юуны өмнө, олонхийн тогтолцооны гол давуу талын нэг болох тогтвортой засгийн газар бүрдүүлэх асуудал улсуудын холбооны байгууллагын сонгуульд хамаагүй нь тодорхой. Харин уг сонгуулийн тогтолцоог боловсруулахад хамаагүй илүү чухлаар тавигдсан шалгуур бол улс төрийн бүх намын тэнцвэртэй төлөөллийг хангахад оршиж байв. Улмаар, улсын хэмжээнд хүчинтэй саналын таван хувийн босго шалгуур тавих болсон нь нэг талаас пропорциональ байдлыг өндөр түвшинд барих, нөгөөтэй талаар дэмжлэг муутай намуудыг хасах сонирхол агуулж байлаа. Түүнчлэн нөхөн сонгууль явуулалгүйгээр эзэнгүй болсон суудлыг жагсаалтад байгаа дараагийн хүнээр нөхөх бололцоотой нь ЖХТТ-г авч хэрэглэхэд хүргэсэн өөр нэг давуу тал байлаа. Гэвч Европын Парламентын сонгуулийг таван удаа явуулсны дараа, сонгогч ба төлөөлөгчийн харилцаа холбоог бэхжүүлэх хүсэл, газар зүйн төлөөллийг нэмэгдүүлэх эрмэлзэл (сонгогдсон төлөөлөгчдийн нэлээд хэсэг нь Парис хотын оршин суугчид байлаа)-ээс үүдэн 2004 оны сонгуулиас өмнө нэг том тойргоо олон мандаттай найман тойргоор солиход хүрчээ.

Европын Парламентын сонгуультай холбоотой дараагийн нэг чухал хууль тогтоомж бол 2002 онд батлагдсан Зөвлөлийн 8964/02 дугаар шийдвэр байсан бөгөөд 1976 оны Ассамблейн төлөөлөгчдийг бүх нийтийн шууд сонгуулиар сонгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Шууд сонгуулийн заалтууд бий болгосноос хойш 26 жилийн дараа гаргасан энэ шийдвэрт Европын Парламентын сонгуулийг бүх гишүүн орон нийтлэг нэг тогтолцоогоор явуулах тухай заасан байна. Уг шийдвэрийн нэгдүгээр зүйлд, “Гишүүн орон бүрт Европын Парламентын гишүүдийг жагсаалтаар санал хураах, эсвэл саналын шилжүүлэх хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгох ёстой” гэж заажээ. Иймээс 2004 оны сонгуулиар бүх 25 гишүүн орон ХТТ ашигласан байна.

Ашигласан тогтолцоо нь нэг төрөл зүйлд хамаарах боловч зарим талаараа харилцан адилгүй. Эдгээрийн дотроос 23 улс (Австри, Бельги, Кипр, БН Чех Улс, Дани, Эстони, Финлянд, Франц, Герман, Грек, Унгар, Итали, Латва, Литва, Люксембург, Нидерланд, Польш, Португаль, Словак, Словени, Испани, Швед, Их Британи) ЖХТТ ашиглаж, Мальта, БН Ирланд хоёр улс эрэмбэт, санал шилжүүлэх тогтолцоо ашиглаж байна. Ийм ялгаа

гарна гэдгийг урьдаас төсөөлж болохоор байлаа. Учир нь, дээрх 23 улсын 21 нь (Франц, Их Британи улсуудаас бусад) үндэсний хууль тогтоох байгууллагын сонгуулиа бүхэлд нь буюу холимог байдлаар ЖХТТ-оор явуулдаг бол Мальта, БН Ирланд хоёр улс үндэсний сонгуульдаа СШТ-г ашигладаг.

ЖХТТ ашиглаж буй 23 улсын зарим нь хаалттай, бусад нь нээлттэй жагсаалт ашиглахаар сонгосон нь ихэнх тохиолдолд үндэсний сонгуулийнхаа онцлогийг дагасан байв. Ганцхан Грек Улс л энэ хандлагаас ялгарч байна. Тойргийн хэмжээгээр зарим гишүүн орон, ялангуяа арай жижиг орнууд нь улс даяараа нэг том тойрог болж санал хурааж буй бол зарим нь муж, орон нутгийн хил хязгаарыг дагасан хэд хэдэн тойрог байгуулдаг.

Мөн саналын босго гишүүн орон бүрт харилцан адилгүй байна. 2002 оны хуулиар улс орон бүр өөрийн гэсэн саналын босго тогтоож мөрдөхийг зөвшөөрсөн боловч албан ёсны босгын дээд хязгаар таван хувиас хэтрэхгүй байхаар зохицуулжээ. Ихэнхи орон тухайлбал, Кипр, Унгар, Швед мөн л үндэснийхээ сонгуульд тавьдагтай адилхан албан ёсны босго ашигласан байна (гэвч үндэсний сонгуульдаа албан ёсны босго ашигладаг Бельги Улс Европын Парламентын сонгуульд босго тавиагүй). Дан ганц албан ёсны босго ч биш, төлөөлөлтэй болоход заавал шаардлагатай дэмжлэг, далд босго ч гишүүн орон бүрт харилцан адилгүй. Босго ийнхүү янз бүрийн байгаа нь тухайн улсаас сонгогдох төлөөлөгчдийн тоо ба сонгуулийн тойргуудын хэмжээ (бүр тодорхой хэлбэл, нэг тойргоос сонгогдох төлөөлөгчдийн тоо)-нээс хамааралтай. Үндэсний хэмжээний нэг том тойргоос 78 төлөөлөгч сонгодог Итали Улс гэхэд нэг хувь ч хүрэхгүй маш доогуур босготой байхад, БН Ирланд Улс дөрвөн сонгуулийн тойрогтой, 13 төлөөлөгчтэй байна гэдэг бол тус улсын СШТ-оор сонгогдох нэр дэвшигч хамаагүй өндөр хувийн санал авах хэрэгтэй гэсэн үг. 2004 онд Ирландын сонгуульд ялалт байгуулсан төлөөлөгчид тойрогтоо нэгдүгээр сонголтын саналын 12,9-25,9 хувийн санал авч сонгогдсон байна.

Европын Парламентын сонгуульд нийтлэг нэг төрлийн сонгуулийн тогтолцоо хэрэглэхээр заасан ч энэ интеграцлал цаашид лавширч гүнзгийрэх эсэх нь эргэлзээтэй. Европын Парламент дотор намын бүлгүүд бий болсон хэдий ч үндэсний намууд өөрсдийн тэргүүлэх үүргээ ямар нэг хэмжээгээр пан-Европын намуудад олгох шинжгүй байна. Ийм учраас сонгуулийн тогтолцооны нарийн ширийн асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл үндэсний улстөрчдийн гарт хэвээр үлдэх төдийгүй тэдний тус тусын ашиг сонирхол, үндэсний уламжлалаас хамаарсан хэвээр байх өндөр магадлалтай юм.

Ойрын ирээдүйд Европын Парламентын сонгуультай холбоотой яриа мэтгэлцээн сонгогчдын ирц маш бага байгаа асуудалд голлон төвлөрөх нь тодорхой байгаа бөгөөд энэ нь ЕХ-ны гишүүн орнуудын санааг зовоосон гол асуудал болоод байна. Бүх гишүүн орон онолын хувьд сонгогчдын ирц харьцангуй өндөр байдаг ХТТ-г ашиглаж байгаа ч сонгогчдын ирц маш доогуур хэвээр байж иржээ. 2004 оны сонгуулиар ЕХ хүрээгээ тэлэхээс өмнө байсан 15 гишүүн оронд сонгуулийн ирц дунджаар 52,9 хувьтай байсан бол шинээр нэгдэн орсон 10 гишүүн орны хувьд үүнээс ч бага буюу 40,2 хувийн үзүүлэлттэй байв. Нэгэнт сонгогчид Европын Парламентын сонгуулийг хоёрдугаарт тавьж, тэдний хувьд сонгуулийн төлөөлөл өөрчлөгдөх нь ямар ач холбодолтой болох нь ойлгомжгүй байгаа нөхцөлд санал хураалтад оролцох сонирхол, ирц доогуур хэвээр байх төлөвтэй байна. Одоо ашиглаж байгаа сонгуулийн тогтолцоог маргаантай асуудал гэж үзэхгүйн зэрэгцээ тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах талаар нухацтай яриа мэтгэлцээн маш бага гарч байна. Иймээс ойрын ирээдүйд Европын Парламентын сонгуульд ашиглаж буй тогтолцоонууд нэлээд тогтвортой хэвээр байх нь тодорхой юм.

Холбооны болон мужийн сонгууль ба автономит нутаг дэвсгэр дээр явагдах сонгуулиуд

198. Холбооны улсын доторх бүс нутгууд болон муж улсууд үндэсний хууль тогтоох байгууллагатайгаа адилхан сонгуулийн тогтолцоо хэрэглэх (тэгш хэмт байдал), эсвэл өөр тогтолцоо ашиглах (тэгш бус хэмт байдал) нь байна. Тухайлбал, Өмнөд Африкт үндэсний болон бусад бүх сонгууль нь хаалттай жагсаалттай ХТТ-оор явагддаг бол Их Британид үндэсний хууль тогтоох байгууллагаа ХОТ-оор, харин Шотландын Парламент, Уэйлсийн Үндэсний Ассамблейн гишүүдийг ХХТТ-оор сонгодог. Мужийн хууль тогтоох байгууллагын тогтолцоо нь өөрийн хил хязгаарын хүрээнд байгаа цөөнхийн бүлгийн төлөөллийг оруулж ирэх юмуу хот, хөдөөгийн эрх ашгийн тэнцвэрийг хадгалахад гол ач холбогдол өгөх хандлагатай байна. Аливаа муж буюу бүс нутаг хэдийчинээ автономит (өөртөө засах) эрхтэй байна, бусад аймаг, мужтай адилхан сонгуулийн зохицуулалт хийх шаардлага төдийчинээ бага байдаг. Ийнхүү автономит хууль цаазтай байгаагийн цаад шалтгаан нь тухайн мужийн онцлог, хэрэгцээ шаардлага нь бусад газрынхаас нэлээд өвөрмөц ялгаатай байдагтай холбоотой.

Орон нутгийн байгууллагуудын сонгууль

199. Энэхүү гарын авлагад дурдсан аль ч сонгуулийн тогтолцоог орон нутгийн болон хотын захиргааны түвшинд хэрэглэж болох авч орон нутгийн сонгууль, төлөөллийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэгтэй холбоотой тусгайлан харгалзаж үзэх хэд хэдэн асуудал байдаг. Ялангуяа орон нутгийн өөрөө удирдах байгууллага ард иргэдийн өдөр тутмын амьдралын нарийн ширийн асуудлуудыг шийдвэрлэж байдаг учраас газар зүйн төлөөлөлд онцгой ач холбогдол өгөх нь олонтаа байдаг. Орон нутгийн сонгуулийг ардчилал руу дөхөх нэг алхам болгон ашиглаж байгаа нь үүний нэг жишээ юм (Хятадын тухай жишээг үзнэ үү).

200. Нэг мандаттай тойргуудад сонгуулийг зохион байгуулах нь, ялангуяа улс төрийн намууд нь сул, эсвэл огт байхгүй тохиолдолд, орон нутгийн иргэд аливаа ялгаваргүйгээр өөрсөддөө хамаатай асуудлаар шийдвэр гаргахад тэнцвэртэй оролцох нөхцөлийг бүрдүүлдэг. Тойрог жижиг байх тусам сонгогчдынх нь үзэл бодол, байр суурь ижилсэх хандлагатай байна. Үүнийг заримдаа сайн зүйл гэж үзэж болох ч заримдаа нэг тойрог дотор нийгмийн янз бүрийн төлөөллийг багтаах шаардлага ургах гарах нь бий. Ийм тохиолдолд тойргийг “дугуйны хэгээс”-ний зарчмаар байгуулах аргыг ашиглаж болдог. Үүнд тойргийн хил тогтоохдоо хөрш зэргэлдээх

суурин, дүүргийг тойруулан зурах биш төвөөс захад тэмүүлж гадагшилсан зураасаар тойргуудын хилийг тогтоож хуваадаг. Үр дүнд нь хот, хөдөөгийн сонгогчдыг аль алиныг багтаасан, эдийн засгийн анги давхарга, үндэс угсаатны хувьд холимог тойргууд үүснэ.

201. ХТТ ашигладаг зарим оронд хотын захиргааг сонгоход жагсаалтаар санал хураах дүрэмтэй ХТТ ашигладаг нь тухайн хотод буй улс төрийн янз бүрийн үзэл бодлыг бүгдийг тусгасан байгууллага бүрдэх нөхцөл болдог ажээ. Гэхдээ ийм үр дүнд бүрэн гүйцэд хүрэхийн тулд ямар нэг нам, улс төрийн үзэл бодолд хөтлөгдөөгүй орон нутгийн холбоодын төлөөлөгчдөд болон хувь хүмүүст бие даан нэр дэвших тодорхой орон зай үлдээх шаардлага гарна.

202. Орон нутгийн сонгуулийн тогтолцоог үндэсний хууль тогтоох байгууллагын тогтолцооны дутагдлыг нөхөх байдлаар бодож боловсруулсан байх нь тохиолддог. Тухайлбал, Конго (Браззавилле), Мали гэх мэтийн ардчилалд шинээр шилжсэн зарим оронд үндэсний хууль тогтоох байгууллагын сонгуулиа хоёр шаттай тогтолцоогоор явуулдаг нь Францын нөлөөнд өмнө тогтсон уламжлалаас үүдэлтэй байна. Гэвч орон нутгийн удирдлагын бүтцэд аль болох нийгмийн өргөн хүрээг хамруулах, үндэстэн угсаатнуудын төлөөллийг тэнцвэртэй хангах зорилгоор ХТТ-оор орон нутгийн сонгуулиа явуулдаг ажээ.

203. Үндсэн хуулийг боловсруулахад парламентын, эсвэл ерөнхийлөгчийн засаглалын алийг нь сонгох талаар мэтгэлцээн өрнөдөгтэй адил орон нутгийн захиргааны бүтцийг хэлэлцэх үед бас иймэрхүү мэтгэлцээн өрнөх явдал тохиолддог. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гадна орон нутгийн гүйцэтгэх байгууллагыг удирдах засаг дарга нар буюу хотын дарга нарыг иргэдээс шууд сонгох явдал дэлхий дахинд улам түгээмэл болж байна. Засаг дарга нар болон хотын дарга нарыг сонгох сонгуулийн тогтолцооны төрөл нь зарчмын хувьд ерөнхийлөгчийн шууд сонгуультай адил бөгөөд хууль тогтоох ба гүйцэтгэх байгууллага хоорондын харилцаа холбоог тойрсон асуудлууд орон нутгийн сонгуульд ч мөн сөхөгддөг.

Тосгоны хорооны сонгуулиуд: Урт замын эхлэл мөн үү?

Донг Лишенг, Юрген Элклит

1970-аад оны сүүлээр Хятадад “өрхийн гэрээний хариуцлагын тогтолцоо” гэгчийг нэвтрүүлснээр ардын аж ахуйтнууд гэр бүлийнхээ төлөө үйлдвэрлэл явуулж эхэлсэн байна. Үйлдвэрлэлийн төвлөрөл ийнхүү задарсан учраас Ардын нэгдэл, хамтралын зохион байгуулалт ч үеэ өнгөрөөжээ.

Анхны тосгоны зөвлөл (ТЗ) 1980-1981 онд Гуансигийн автономит бүсэд байгуулагдсан байна. Орон нутгийн эрх бүхий байгууллага нь огт мэдээгүй байхад бий болсон эдгээр хороодыг тосгоны ахмадууд, хуучин боловсон хүчнүүд, хамтач сэтгэлгээтэй тосгоны иргэд байгуулжээ. Зорилго нь үйлдвэрлэлийн бригад, багууд анхан шатанд ажиллахаа больсонтой холбоотой үүссэн эмх цэгцгүй байдал, өргөн хүрээтэй улс төрийн хямралыг шийдвэрлэхэд оршиж байв. Хэдэн сарын дараа орон нутгийн ажилтнууд энэхүү байгууллагын талаар олж мэдэн төв засгийн газартаа мэдэгдсэн байна. Улмаар Үндэсний Ардын Хурал (ҮАХ)-ын тэргүүлэгчид энэхүү шинэ хэлбэрийн байгууллагыг дэмжжээ.

1982 онд ТЗ-ийг нутгийн өөрөө удирдах сонгуулыг байгууллага болгож албан ёсоор үндсэн хуульдаа тусгаж өгсөн (111 дүгээр зүйл) байна. Өмнө байсан нэгдэл, бригад, баг хоорондын харилцаанаас ялгаатай нь, шинээр бий болсон хот суурингийн удирдлага нь (захиргааны хамгийн доод түвшин) ТЗ-ийг удирдахгүй зөвхөн заавар удирдамжаар хангадаг болж хувирчээ. Өөр нэг ялгаа нь сонгуулийн насны бүх иргэд оролцох шууд сонгуулийг нэвтрүүлсэн байна. 1987 онд Тосгоны зөвлөлийн тухай органик түр хууль гэгчийг баталж, ТЗ-ийн шууд сонгуулийн ерөнхий зарчмуудыг тогтоон, ТЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлжээ. Ингэхдээ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт

боловсруулж гаргах эрхийг мужийн болон доод түвшний эрх бүхий байгууллагуудад үлдээв. Энэ хуулийн ерөнхий хэрэгжилт, сонгуулийн чанар нь газар бүрт харилцан адилгүй байж ирсэн агаад 2002 оны сүүлээр авсан хамгийн сүүлийн тоог харахад хууль гарснаас хойш 10 жил өнгөрөөд байхад Хятадын 658,000 гаруй тосгонд оршин суугчдын дөнгөж 25 хувь нь уг хуульд бүрэн нийцсэн шууд сонгуулиудад оролцсон гэх статистик байна.

1998 онд ҮАХ-аас энэхүү органик хуулийг байнгын болгожээ. Уг хууль нь сонгууль явуулах журмуудыг тодорхой болгож, сайжруулахын зэрэгцээ ТЗ-ийн ил тод байдлын тухай болон олон нийтийн хяналтын тухай дүрмийг бэхжүүлж өгсөн байна. Энэхүү байнгын хууль бол тосгоны сонгуулийн үйл ажиллагааны улс төр, эрх зүйн нэгдмэл үндэс гэж олон хүн үздэг ч түүнийг бүрэн хэрэгжүүлэх асуудал томоохон сорилт хэвээр байна. Зарим шинэ стандартууд, тухайлбал, нууц санал хураалтын бүхээг, өрсөлдөгчдийг шууд нэр дэвшүүлэх зэрэг зохицуулалтыг нэвтрүүлсний дараа бүр ч олон асуудал тулгарах магадлалтай. Улсын хэмжээгээр явуулж байгаа ийм сонгуулиуд чанарын хувьд мөн л харилцан адилгүй хэвээр байна.

Тосгоны зөвлөлийн гишүүдийг гурван жилийн хугацаагаар сонгох ба нэг хүн хэдэн удаа дахин сонгогдож болох эсэхэд хязгаарлалт тавиагүй. ТЗ-үүд ихэвчлэн гурваас долоон гишүүнтэй, тэдний нэг нь дарга, хоёр юмуу нэг нь орлогч даргын үүрэг гүйцэтгэдэг. Хэдийгээр мужаас мужид харилцан адилгүй боловч ерөнхийдөө ТЗ-үүд нь тосгоныхоо бүхий л захиргааны асуудалд хяналт тавьдгийн дотор төсвийн удирдлага, нийтийн аж ахуй, маргаан таслах, нийтийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, эрүүл мэнд, орон нутгийн бизнесийн удирдлагын асуудлууд ордог байна. Томоохон тосгодын хувьд 10,000-аас дээш хүн амтай байхад жижиг тосгод дөнгөж хэдхэн зуун хүнтэй байх нь тохиолддог. Дунджаар авч үзвэл нэг тосгон 1,000-2,000 оршин суугчтай байх ажээ.

ТЗ-үүд тухайн Тосгоны Хурал буюу Тосгоны Төлөөлөгчдийн Хуралд ажлаа тайлагнадаг. ТЗ-ийнхөн нэг юм уу хоёр жилд нэг удаа хуралддаг байхад, Тосгоны Хурлыг 25-50 хүний бүрэлдэхүүнтэйгээр Тосгоны иргэдийн жижиг бүлгүүдээс сонгодог нь шийдвэр гаргалт болон ТЗ-д хяналт тавихад ихээхэн үүрэгтэй оролцдог. Тосгоны сонгуулиудыг Тосгоны сонгуулийн хороо удирдан зохион байгуулдаг байна.

Одоогоор нийт 31 муж, автономит бүс, хот, тосгоны сонгууль зохион байгуулж үзээд байна. 2003 оны байдлаар энэ талаар тэргүүлэгч хоёр муж Фужианд найм, Лайонингт долоон удаагийн сонгууль тус тус явагдсан бол бусад 19 мужид дөрвөөс зургаан сонгууль явагдсан байв. Улсын хэмжээгээрх нийт ТЗ-ийн сонгуулийн хувьд тогтсон нэг санал хураах

өдөр гэж байдаггүй. Аль нэг мужийн сонгууль явуулахаар товлосон жилд тухайн мужийн харьяа нутаг, жижиг суурингууд хамтран тосгодын сонгууль явуулах өдрийг товлодог.

Сонгууль нь нэг ижил ерөнхий журмаар явагддаг. Юуны өмнө сонгогчдыг бүртгэх ажиллагаа явагдах ба үүнийг Тосгоны сонгуулийн хороо хариуцан гүйцэтгэнэ. Бүртгэлтэй сонгогчдын жагсаалтыг сонгууль явуулахаас 20 хоногийн өмнө нэгтгэн гаргаж нийтэд танилцуулах ёстой. Сонгогчид нэрийн жагсаалттай холбоотой гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Улс төрийн эрхээ хасуулсан хүмүүсээс бусад 18 ба түүнээс дээш настай бүх иргэн үндэс угсаа, арьс өнгө, хүйс, ажил мэргэжил, гэр бүлийн гарал угсаа, шашин шүтлэг, боловсролын түвшин, өмч хөрөнгө, эсвэл тухайн газар оршин суусан хугацаагүл харгалзан сонгох, сонгогдох эрхтэй. Энэхүү эрхээ эдлэхэд тулгардаг нэг томоохон бэрхшээл бол “төрөлх тосгон”-доо оршин суугчийн бүртгэлтэй боловч алс зайдуу газар, гол төлөв хот суурин газруудад очиж ажиллаж амьдардаг сонгогчид асар олон байдагтай холбоотой. Тэдний хувьд сонгуулийн өдөр төрөлх тосгондоо ирж саналаа өгөх нь хүндрэлтэй буюу огт боломжгүй байх нь олонтаа ба ажиллаж, амьдарч байгаа хотынхоо сонгуульд оролцож боломж байхгүй. Үүнээс үүдэн сонгох эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг ажээ.

Сонгогчдын нэрийн жагсаалт гарсны дараа сонгуульд өрсөлдөх хүмүүсийг тосгоны иргэд шууд нэр дэвшүүлнэ. Ихэнх мужид, тосгоны зөвлөлийн дарга, орлогч дарга, жирийн гишүүний суудлыг тооноос зөвхөн нэгээр илүү нэр дэвшигч байж болно гэсэн шаардлага тавьдаг. Сүүлийн жилүүдэд зарим мужид тосгоны иргэдийг Тосгоны хуралд, эсвэл Тосгоны иргэдийн жижиг бүлгийн хуралд оролцуулах замаар нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн бол сүүлийн үед зарим мужид сонгуулийн өмнө нэр дэвшүүлэх ажиллагаа гэж байхгүй болжээ. Ийм газрын сонгогчдод нэг бол хоосон саналын хуудас эсвэл холбогдох баганы дээд талд сонгох албан тушаалыг бичсэн хоосон саналын хуудас өгдөг байна. Хэрэв тухайн сонгуулиар шинэ зөвлөл сонгож чадаагүй, эсвэл бүх албан тушаалд хүн сонгож чадаагүй бол энэ нь нэгдүгээр шатны сонгууль болж, түүний дараа дахин халз өрсөлдөөны журмаар сонгууль зохион байгуулдаг байна.

Эцсийн шатны сонгууль шууд явагдах ёстой. Ихэнх мужид саналын хуудас нууц байх, санал хураалтын бүхээг (буюу өрөө) ашиглах шаардлага тавьдаг. Саналаа өгөх гурван хэлбэр байдаг. Үүнд: а) бөөнөөр санал өгөх, энэ тохиолдолд бүх сонгогчид санал хураах төв байранд өглөө ирж, саналаа өгөөд, санал тоолж дуустал тэндээ хүлээдэг, б) ганцаарчилсан санал өгөх буюу сонгогч тухайн өдрийн хэдийд ч хамаагүй ирж саналаа өгөөд буцдаг, в) итгэмжлэгчээр, эзгүйгээр эсвэл, “зөөврийн саналын хайрцаг”-аар санал өгдөг. Ихэнх муж бөөнөөр санал өгөх аргыг ашигладаг.

Саналын хуудас нь албан тушаал бүрийн дор нэр дэвшигчийн нэрийг бичсэн хүснэгтээс бүрдэх бөгөөд сонгогч өөрийн сонгохыг хүссэн хүний нэрийг тэмдэглэнэ. Сонгогч саналаа өгөхдөө саналын хуудсанд бичигдсэн тосгоны албан тушаалын (нэг дарга, нэгээс хоёр орлогч дарга, жирийн гишүүд) тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг тэмдэглэж болно. Аливаа сонгууль хүчинтэйд тооцогдохын тулд сонгох эрх бүхий сонгогчдын үнэмлэхүй олонхи нь ирж саналаа өгсөн байх, сонгуульд ялах нэр дэвшигч 50+1 хувийн санал авсан байх шаардлагатай. Аль ч сонгогч олонхийн санал авч чадаагүй бол гурав хоногийн дотор халз сонгууль зохион байгуулдаг. Энэхүү халз сонгуульд ялах нэр дэвшигч сонгогчдын нийт саналын 33 хувийг авсан байх шаардлагатай. Ингээд сонгуульд ялсан хүмүүсийг нэн даруй албан тушаалд нь томилдог.

Сонгуулийн хууль нь нууц санал, шууд сонгууль, олон нэр дэвшигч (хэдийгээр тоо нь тун хязгаарлагдмал ч гэсэн) гэх мэт ардчилсан үйл явцын үндсэн хэм хэмжээг зааж өгч байгаагаараа тосгоны сонгуулиуд чухал ач холбогдолтой юм. Хятадын бусад сонгуульд эдгээр хэм хэмжээг хараахан нэвтрүүлээгүй байна. ТЗ-ийн сонгуулиас гарсан ахиц дэвшил нь тосгоноос хот суурин, цаашлаад нутаг дэвсгэрийн нэгж, засаг захиргааны арай өндөр түвшин хүртэл шууд сонгуулийн зарчим үйлчилж эхлэх эсэх, хэзээ үйлчлэх талаарх хүлээлтийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ. Түүнчлэн ТЗ-ийн сонгууль явагдах бүр сонгуулийн үйл явцыг удирдан зохион байгуулах орон нутгийн чадавхийг бэхжүүлж байна.

Хятадын тосгоны сонгуулиудын жинхэнэ ач холбогдол нь иймэрхүү “хязгаарлагдмал ардчилал” жинхэнэ ардчилалд хүргэх эхлэл мөн эсэх тухай асуултад ямар хариулт өгөхөөс ихээхэн хамаарах нь дамжиггүй. Сонгууль хэр ардчилсан байгаад үнэлэлт өгөх янз бүрийн арга зам байдаг. Сонгууль чөлөөт, тэгш шударга, учир утгатай байх гэсэн дэлхий дахинд түгээмэл хэрэглэгддэг гурван шалгуур үзүүлэлтийг энд авч үзвэл зохино. Хятад Улсад үндэсний парламент ба орон нутгийн зөвлөлийг сонгох үйл явц нь чөлөөт, тэгш шударга сонгуулийн стандартаас хол зөрдөг ба олон тохиолдолд сонгогдсон тосгоны удирдлагууд Хятадын Коммунист Намын (ХКН) нарийн бичгийн газрууд шиг эрх мэдэл эдэлдэггүй. Гэхдээ зөвхөн тосгоны сонгуулиуд бүрэн чөлөөт, шударга бус байна, зарим ТЗ эрх мэдэл султай байна гэдэг үндэслэлээр тэд бүхэлдээ огт чөлөөт бус, тэгш шударга бус, учир утгагүй гэж дүгнэж болохгүй. Сонгуулийг ямар нэг үнэмлэхүй стандарттай харьцуулж бус, тухайн орны ардчилсан хөгжлийн явцтай нь харьцуулж үнэлэх нь зүйд нийцнэ.

ТЗ-ийн сонгуулиуд зарим дам нөлөө үзүүлж эхлээд байгаагийн дотор Тосгоны ХКН-ын салбар зөвлөлийн сонгуульд заримдаа жирийн иргэдийг оролцуулж итгэл үзүүлэх санал өгүүлэх болсон, хот суурингийн дарга

нарыг сонгох зарим туршилт хийгдэж эхлээд байгааг дурдаж болно. Хятад дахь ардчилах үйл явцын өнөөгийн байдлаас үзэхэд дээд удирдагч нарын гаргасан улс төрийн шийдвэр анхан шатанд биелэлээ олохыг шаардах нь нэмэгдээд байна. Тосгоны шууд сонгуулийг хорь гаруй жилийн турш тасралтгүй сайжруулсны үр дүнд төр, засгийн дээд түвшний сонгуулийг явуулах асуудал техникийн хувьд боломжтой болох нь харагдаж байна. Харин ардчилах үйл явцад цаашид ямар нэг дорвитой өөрчлөлт гарах эсэх, хэрхэн өөрчлөгдөх вэ гэдэг асуултын хариу тодорхойгүй үлдэж байна.

大关庄村第五届村委会选举选票

职务	主任候选人		副主任候选人			委员候选人								
	姓	名	姓	名	姓	名	姓	名	姓	名	姓	名	姓	名
	关	李	李	关	勾	关	李	关	勾	李	关	刘	关	关
	利	少	少	利	井	真	桂	真	井	少	真	万	利	真
	泽	顺	顺	泽	仕	宝	芬	宝	仕	顺	奎	喜	泽	国

- 说明: 1. 主任候选人, 副主任候选人, 委员候选人, 超过候选人数的选项无效。
 2. 同意的在候选人姓名下方空格内划“○”; 不同意的划“×”另选他人在空格内写上另选人的姓名, 并在其姓名下方空格内划“○”, 未划符号的无效。
 3. 不许提同一候选人担任两种或两种以上职务, 否则该候选人的赞成票无效。

Хятадын тосгоны сонгуулийн саналын хуудас

Сонгуулийн тогтолцоо ба улс төрийн намууд

204. Сонгуулийн тогтолцооны хувилбарууд нь тус бүрдээ улс төрийн намын зохион байгуулалт, тогтолцооны тодорхой нэг загварт илүү таатай нөлөө үзүүлэх талтай байдаг. Намын тогтолцоо аль болох төлөөллийг хангах нь чухлаас гадна ихэнх мэргэжилтнүүдийн хувьд үндэс угсаа, арьс өнгө, бүс нутгийн явцуу эрх ашгаас илүү өргөн хүрээтэй улс төрийн үнэт зүйлс, үзэл суртал, бодлогын тодорхой хөтөлбөрт тулгуурласан намууд үүсч хөгжихийг хөхиүлэн дэмждэг тогтолцоог илүүд үздэг. Ийм өөр хоорондоо ялгаатай боловч харилцан хамаарал бүхий үзэл баримтлалд тулгуурласан намууд нь нийгмийн бүлгүүд хоорондоо зөрчилдөж мөргөлдөөн үүсэх эрсдлийг багасгахын зэрэгцээ тодорхой нэг сегментийн, эсвэл бүс нутгийн ашиг сонирхолд голлон тулгуурласан намуудыг бодвол үндэсний эрх ашгийг илүүтэй эрхэмлэх хандлагатай байна.

205. Хаалттай жагсаалттай ХТТ-той ихээхэн төвлөрсөн улс төрийн тогтолцоонд намын байгууллагууд хүчирхэгжих магадлал өндөр байдаг бол, тойрогт тулгуурласан ХОТ нь төвлөрлийг задлах буюу үүний эсрэг нөлөө үзүүлж болно. Гэхдээ намын тогтолцооны хөгжилд нөлөө үзүүлэх бусад олон сонгуулийн хувьсагч байдаг. Жишээлбэл, Орос, Индонези гэх мэт шинээр ардчилал тогтоосон орнууд бүс нутгийн улс төрийн намуудаас илүү үндэсний хэмжээний байгууллагууд бий болох сонирхол төрүүлэх замаар урьд тогтсон намын тогтолцооныхоо хөгжлийг төлөвшүүлэх оролдлогууд хийж байна (Индонезийн тухай жишээ судалгааг үзнэ үү). Эквадор, Папуа Шинэ Гвиней гэх мэт бусад орны хувьд иймэрхүү зорилгод хүрэхийн тулд улс төрийн намын бүртгэл, санхүүжилтийн шаардлагуудыг ашиглаж байна. Улсын, эсвэл хувийн санхүүжилт олж авах боломжийн асуудал бол бүхий л сонгуулийн тогтолцооны боловсруулалтад чухлаар тавигддаг гол асуудал байдаг төдийгүй амьдрах чадвартай шинэ намууд төрөн гарахад хамгийн их саад учруулдаг хязгаарлалт байх нь олонтаа.

Сонгуулийн тогтолцооны сонголт улс төрийн намын тогтолцооны хөгжилд нөлөөлдөг шиг тогтсон улс төрийн тогтолцоо ч сонгуулийн тогтолцооны сонголтод нөлөөлж байдаг. Одоо байгаа намуудын хувьд улс төрийн зайлшгүй шаардлага хүчтэй тавигдахгүй л бол өөрсдөд нь ноцтой хохирол учруулж болох, эсвэл шинэ, өрсөлдөгч намууд улс төрийн намын тогтолцоонд орж ирэх боломжийг нээж өгсөн өөрчлөлтийг дэмжихгүй нь ойлгомжтой. Иймээс сонгуулийн тогтолцоог өөрчлөх боломжууд нь практик дээр хязгаарлагдмал байх талтай.

206. Мөн сонгуулийн тогтолцооны олон төрөл нь нэр дэвшигч хувь хүмүүс ба тэдний дэмжигчдийн харилцаанд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг. Ерөнхийдөө олонхийн гэх мэт нэг мандаттай сонгуулийн тойрог ашигладаг тогтолцоо нь нэр дэвшигч хувь хүмүүс өөрсдийгөө тодорхой нэг газар нутгийг төлөөлж, нутгийн сонгогчдын ашиг сонирхолд үйлчлэх үүрэгтэй төлөөлөгч гэж үзэхэд хүргэдэг. Үүний эсрэгээр ихэнх ХТТ шиг томоохон олон мандаттай тойрог ашигладаг тогтолцоонд үндэсний асуудалд анхаарсан, гол төлөв намдаа үнэнч төлөөлөгчид сонгогдох хандлагатай. Аль аль арга нь өөрийн гэсэн давуу талтай байдаг нь орон нутгийн ба үндэсний хэмжээний төлөөлөгчдийг нэгтгэсэн холимог тогтолцоо улам бүр түгээмэл болох нэг шалтгаан болоод байна.

207. Улс төрийн намууд ба сонгуулийн тогтолцооны талаар ярихад байнга сөхөгддөг нэг асуудал бол хариуцлага тооцох тухай асуудал бөгөөд, үүнийг ялангуяа сонгогдсон нэр дэвшигчидтэй холбон авч үзэх нь түгээмэл. Сонгогчид, сонгогдсон гишүүд, улс төрийн намуудын харилцаанд дан ганц сонгуулийн тогтолцоо ч биш, бүрэн эрхийн хугацааны хязгаарлалт, намууд ба тэндээс сонгогдсон төлөөлөгчдийн харилцааг зохицуулах заалтууд, эсвэл сонгогдсон гишүүд хууль тогтоох байгууллагаас огцролгүйгээр намаа солихыг хориглох заалтууд гэх мэт улс төрийн эрх зүйн хүрээний бусад заалт ч нөлөө үзүүлж байдаг.

208. Сонгогчид намд бус, нэр дэвшигчдийн хооронд сонголт хийх эрх чөлөө бол хариуцлага тооцохтой холбоотой асуудлын өөр нэг чухал элемент юм. Иймээс сүүлийн жилүүдэд олон орон сонгуулийн тогтолцоондоо нэр дэвшигчид төвтэй санал хураалтын элементийг илүүтэй оруулах болсны нэг жишээ бол ХТТ-нд намын нээлттэй жагсаалт нэвтрүүлж байгаа явдал юм.

Шууд ардчиллын боломжууд

209. Энэхүү гарын авлагад бүх шатны төлөөлөгчдийг сонгоход зориулсан сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалтын асуудлыг авч үзэж байна. Харин хариуцлага тооцох тухай асуудлын хувьд илүү өргөн хүрээтэй авч үзэх шаардлагатай ба үүнд ялангуяа шууд ардчиллын институцийн үүргийг харгалзаж үзэх хэрэгтэй. Эдүгээ бүх нийтийн санал асуулгыг хэрэглэх явдал дэлхий дахинд улам түгээмэл болж байна. Иргэдийнхээ санал санаачилгыг хөхиүлэн дэмжиж ирсэн урт түүхтэй Швейцари улсад гэхэд иргэдийн бүлгүүд хууль тогтоомжийн төсөл санаачлан боловсруулж олон нийтээр санал хураалгадаг журам үйлчилдэг. Тэгвэл ард түмнээс шууд сонгогдсон ерөнхийлөгчийг

эргүүлэн татах асуудлаар санал хураалт явуулах боломжтой цорын ганц улс бол Венесуэл юм. Мөн ерөнхийлөгчийн тогтолцоотой зарим орон, АНУ-ын олон муж улсад хууль тогтоогчид, эсвэл муж, орон нутгийн албан тушаалтнуудын эсрэг ийм санал хураалтыг явуулахыг шаардаж болдог.

БҮЛЭГ 5

БҮЛЭГ 5

5. Сонгуулийн зохион байгуулалт ба өртөг зардал

210. СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧАДАВХИ, БОЛОВСОН ХҮЧНИЙ болон ТӨСВИЙН хүрэлцээ зэрэг нь зарим үед сонгуулийн тогтолцооны талаар гаргах шийдвэрт нөлөөлөх нь бий. Хандивлагчдын санхүүжилтээр богино хугацаанд төсвийн асуудлыг шийдэх бололцоотой байсан ч урт хугацаанд тогтвортой хэрэглэж болох сонгуулийн тогтолцоо сонгох нь алсаа харсан ухаалаг шийдэл юм.

Гэвч хамгийн энгийн хялбар бөгөөд хямд төсөр тогтолцоог зөв сонголт гэж ойлгох нь эндүүрэл болно. Тохиромжгүй сонгуулийн тогтолцоо нь улс орны улс төрийн тогтолцоонд төдийгүй ардчиллын тогтвортой байдалд бүхэлд нь сөрөг нөлөө үзүүлж болох учраас төсөв хэмнэх нь үүний дэргэд өчүүхэн асуудал болохыг анхаарах нь чухал.

Ямар тогтолцоо сонгосон байгаагаас шалтгаалаад сонгуулийн зохион байгуулалттай холбоотой дараах асуудал, харилцан адилгүй үр дагавар үүснэ.

211. *Сонгуулийн тойргуудын хилийг тогтоох.* Нэг мандаттай тойргуудад санал хураадаг тогтолцоонд тойргийн хилийг тогтоох нь цаг хугацаа их шаарддаг, өртөг өндөртэй үйл ажиллагаа байдаг. Тойргийн хилийг тогтооход хүн амын тоо, ялгарал, нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол, нэгдэл нягтрал зэрэг олон асуудлыг авч үзэх шаардлагатай болно. Цаашилбал, тойргийн хил хязгаар нь хүн амын тооны өөрчлөлтийг тогтмол тусгаж байх шаардлагатай учраас нэг удаа хийгээд орхих ажил биш юм. Энэ талаас авч үзэхэд хамгийн төвөгтэй тогтолцоонд ХОТ, АСТ, ХШТ-г тус тус нэрлэж болно. Мөн БСТ, НБСТ, СҮШТ, ХЯСТ, СШТ-нд сонгуулийн тойргийн хил тогтоох асуудал яригдах боловч олон

мандаттай том тойргуудаар сонгуулийг зохион байгуулдаг тул тойргийн тоо цөөхөн, шийдвэр гаргахад арай хялбар байна. Холимог тогтолцоонд ч мөн тойргийн хил хязгаар тогтоохтой холбоотой сорилт бэрхшээл тулгардаг.

212. Олон мандаттай тойргуудад санал хурааж буй нөхцөлд тойргийн мандатын тоог өөрчлөх замаар хилийг заавал шинээр тогтоохгүйгээр асуудлыг шийдэх боломжтой байдаг (аймаг, муж гэх мэт засаг захиргааны нэгжийг сонгуулийн тойрог болгон ашиглаж байгаа тохиолдолд энэ арга онцгой ач холбогдолтой). ЖХТТ-нд тойрогтой холбоотой асуудлыг шийдэх нь ерөнхийдөө хамгийн хялбар бөгөөд, хямд төсөр байна. Ийм тогтолцоонд нэг бол улс нь бүхэлдээ ганц тойрог болдог, өөрөөр хэлбэл тойргийн хил хязгаар тогтоох огт шаардагагүй, эсвэл мужийн юмуу бүсийн тогтсон хил хязгаартай давхцуулан тогтоосон том олон мандаттай тойргуудад сонгуулийг зохион байгуулдаг. НҮБ-аас ивээн тэтгэж 1996 онд Сьерра Леонед, 1997 онд Либерид, 2001 онд Косовод зохион байгуулсан сонгуулиуд бүгд ЖХТТ-оор явагдсан байна. Үүний цаадах нэг гол шалтгаан нь тойрог байгуулахад зайлшгүй шаардагдах хүн амын тооллогын үнэн зөв тоо баримт дутагдалтай, тухайлбал дүрвэгсэд, шилжин суурьшигчдын талаар мэдээлэл хомс байсантай холбоотой байна.

213. *Сонгогчдын бүртгэл (Нэрсийн жагсаалт)*. Сонгогчдын бүртгэл бол сонгуулийг удирдан зохион байгуулахад тулгардаг хамгийн хэцүү, маргаантай, голдуу хамгийн амжилт муутай байдаг ажил юм. Үүнд асар олон сонгогчдоос стандартчилсан загвараар тодорхой мэдээлэл цуглуулж авах, эдгээр тоон мэдээллээ сонгуулийн үеэр хэрэглэж болох хэлбэрт оруулж цэгцлэн тараах, тодруулбал зөвхөн эрх бүхий сонгогчид санал хураалтад оролцох нөхцөлийг бүрдүүлэх, нэг сонгогч олон удаа санал өгөх, эсвэл бусдын өмнөөс санал өгөх зэрэг үйлдлээс хамгаалах үйл ажиллагаа ордог. Эдгээр асуудлын улс төрийн хувьд эмзэг, мэдрэмтгий байдал, хүч хөдөлмөр шаардсан чанар нь сонгогчдын нэрийн жагсаалт гаргах нь сонгуулийн бүхий л үйл явц дотроос хамгийн их зардал, цаг хугацаа шаарддаг ажлын нэг байдаг гэсэн үг юм.

214. Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт нь сонгогчдын нэрийн жагсаалтыг нэгтгэн гаргах үйл явц ямар шаардлагын дагуу явагдахыг олон талаар тодорхойлно. Нэг мандаттай тойргуудад санал хураах бол ихэвчлэн сонгогч бүр тодорхой нэг тойрогт харъяалагдах ёстой болно. Үүнээс үүдэлтэй ХОТ, АСТ, ХШТ, БТ-ын тогтолцоо төдийгүй нэг мандаттай тойргуудаар санал хураах бүрэлдэхүүн агуулсан

Параллель, ХХТТ-нд сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах нь хамгийн өртөг зардал ихтэй, захиргааны хувьд цаг хүч их шаарддаг ажээ. Олон мандаттай тойргууд бүхий БСТ, НБСТ, СҮШТ, СШТ-нд сонгогчдын нэрийн жагсаалт гаргах нь арай хялбар, томоохон тойрог бүхий ЖХТТ-той бол энэ ажиллагаа хамгийн хялбар байдаг байна. Харин гадаадаас санал өгөх сонгогчдыг бүртгэх нь аль ч тохиолдолд онцгой бэрхшээл учруулах талтай.

Сонгогчдын нэрийн жагсаалт гаргах нь ЖХТТ-нд илүү энгийн хялбар байдаг нь 1994 онд Өмнөд Африкт болсон анхны ардчилсан сонгууль болон бусад шилжилтийн үеийн зарим чухал сонгуульд уг тогтолцоог авч хэрэглэхэд нөлөөлсөн хүчин зүйлийн нэг нь байсан. Гэвч ямар ч үед сонгогчдын нэрийн жагсаалт гаргах нь маш өндөр зардалтай ажил байх янз бүрийн тогтолцоонд энэ зардлын ялгаа ялихгүй бага байдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй.

215. *Саналын хуудсын загварыг боловсруулж, үйлдвэрлэх.* Сонгуульд оролцох оролцоог аль болох нэмэгдүүлэх, буруу буюу “хүчингүй” саналын тоог багасгахын тулд саналын хуудсыг бүх сонгогчдод хүртээмжтэй байдлаар боловсруулах ёстой. Энэ шаардлагыг хангахын тулд намууд, нэр дэвшигчдийг билэг тэмдэг, фото зураг, янз бүрийн өнгөтэй хуудсыг гол төлөв ашигладаг бөгөөд саналын хуудасны хэд хэдэн сонирхолтой загварыг энэхүү гарын авлагад оруулсан болно. ХОТ, АСТ-нд санал авах хуудсууд хэвлэхэд хялбар, ихэнх тохиолдолд харьцангуй цөөн нэр дэвшигчийн нэрийг жагсаасан байдаг. ХШТ-ны саналын хуудсууд мөн л хялбар боловч санал хураалтын хоёр дахь үе шатанд саналын хуудсуудыг шинээр хэвлэх шаардлага гардаг учраас үйлдвэрлэлийн зардлыг хоёр дахин нэмэгдүүлдэг. Мөн хоёр дахь шатны сонгуулийн саналын хуудсыг хэвлэхэд цаг хугацаа шахамдуу байх явдал гарна. Параллель ба ХХТТ-нд дор хаяж хоёр янзын саналын хуудас хэвлэх шаардлага гол төлөв тулгарах ба хоёр (буюу түүнээс дээш) тэс өөр сонгуулийн тогтолцоо ашиглах учраас сонгогчдод саналаа хэрхэн өгөх талаар зааж сургах нь сонгуулийн байгууллагын хувьд хамаагүй илүү төвөгтэй болж ирнэ. СҮШТ, БСТ, БТ, СШТ-ны саналын хуудсууд ХОТ-той харьцуулахад илүү түвэгтэй байдаг. Олон нэр дэвшигч өрсөлддөгтэй холбоотой саналын хуудсан дээр хэвлэх бэлэг тэмдэг, зурагны тоо (хэрэв ашигладаг бол) олширдог нь үүнд голлон нөлөөлнө. ЖХТТ-нд саналын хуудсууд нь намын жагсаалтын төрлөөс шалтгаалаад хаалттай бол маш энгийн, нээлттэй бол Швейцарийнх шиг бүр ч түвэгтэй байх ажээ.

216. *Сонгогчдын боловсрол.* Сонгогчдын боловсролын мөн чанар, эрэлт хэрэгцээ нийгмээс нийгэмд эрс ялгаатай байх боловч сонгогчдод саналын хуудсаа хэрхэн бөглөхийг зааж сургахын хувьд янз бүрийн сонгуулийн тогтолцооны хооронд илэрхий ялгаатай зүйлс байна. АСТ, СШТ, Борда тооллого зэрэг эрэмбэт саналын тогтолцоонд нэр дэвшигчдийг эрэмбэлэн санал өгөх нь нэлээд төвөгтэй байх бөгөөд ялангуяа Австрали гэх мэт зарим оронд тохиолддог шиг сонгогч бүх нэр дэвшигчийн нэрсийг дугаарлах ёстой тохиолдолд бүр ч хүндрэлтэй байдаг. Мөн сонгогчдод хоёр төрлийн саналын хуудас өгдөг холимог тогтолцоог өргөнөөр хэрэглэх болсон нь сонгогчдод нэмэлт бэрхшээл болж байна. Гэтэл эсрэгээр ХОТ, НБСТ, СҮШТ гэх зэрэг сонгогч нэг санал өгдөг тогтолцооны зарчмыг ойлгоход туйлын хялбар байдаг. Бусад тогтолцоо эдгээр хоёр туйлын хаа нэгтгээ дунд хавьд байдаг гэхэд болно (Хүснэгт 8-аас үзнэ үү).

217. *Санал хураалт үргэлжлэх хугацаа.* ХОТ, АСТ, БСТ, СҮШТ, ЖХТТ, Борда тооллого, СШТ болон Параллель, ХХТТ-нд ерөнхийдөө нэг өдөрт багтаан нэг л удаа санал хураалт явуулдаг. Харин хоёр шатлалт сонгуулийн тогтолцоонд эхний шатны санал хураалтаас хойш ихэнх тохиолдолд нэг юм уу хоёр долоо хоногийн дараа санал хураах процессыг бүхэлд нь ахин давтах шаардлагатай байх учир зардал ихтэй, зохион байгуулалтын хувьд ч түвэгтэй байна.

218. *Нөхөн сонгууль явуулах.* ЖХТТ-той үед сонгуулиудын хооронд суудал эзгүйрэх тохиолдолд голдуу намын жагсаалтад байгаа дараагийн нэр дэвшигчийг оронд нь суулгах бөгөөд улмаар дахин сонгууль явуулах шаардлагагүй. Харин олонхийн тогтолцоонд эзгүй суудлыг заавал нөхөн сонгуулиар бөглөх хуулийн заалттай байх нь олонтаа. Бусад тогтолцоо хэрэглэж байгаа тохиолдолд дээрх хоёр аргын аль нэгийг хэрэглэх боломжтой. СШТ-той БН Ирланд Улс хууль тогтоох байгууллагын суларсан суудалд нөхөн сонгууль явуулдаг бол, Австрали Улс Сенатийн танхимын эзгүй суудалдаа нөхөн сонгууль явуулдаггүй. Түүнчлэн гишүүнийг сонгохын хажуугаар орлогчийг нь нэгэн зэрэг сонгох замаар нөхөн сонгуулиас зайлсхийх боломжтой байдаг бөгөөд тухайлбал, Боливи Улсад ийм арга хэрэглэдэг байна.

Нөхөн сонгууль нь жирийн сонгуулийг бодвол цар хүрээ болоод зардал багатай байдаг. Гэсэн хэдий ч энэ нь зарим улсын төсөвт багагүй дарамт учруулдаг бөгөөд нөхөн сонгууль явуулах чадавхи дутсаны улмаас тухайн суудал удаан хугацаагаар эзгүй байх тохиолдол заримдаа гардаг. Ялангуяа ДОХ, ХДХВ-ын халдварын тархалт ихтэй Өмнөд Африкийн зарим оронд сонгууль хооронд олон тооны эзгүй суудал гардаг ба дээрх бэрхшээл байнга тохиолддог.

Зарим үед нөхөн сонгууль нь зөвхөн цөөн тооны суудлыг нөхөх төдий бус өргөн хүрээтэй улс төрийн ач холбогдолтой байх ба засгийн газрын үйл ажиллагаанд дүн тавих сорилт болох нь бий. Түүнчлэн хэрвээ парламентын бүрэн эрхийн хугацаанд олон тооны эзгүй суудлыг шинээр нөхөх бол хууль тогтоох байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, улмаар энэ нь засгийн газрын эрх мэдэл, байр суурьт жинтэй нөлөөлөх магадлалтай байна.

219. *Санал тооллого.* ХОТ, СҮШТ, энгийн хаалттай жагсаалттай ХТТ -ны хувьд сонгуулийн дүнг гаргахад зөвхөн нам, нэр дэвшигч бүрийн авсан саналын нийт дүн шаардлагатай учраас санал тоолоход хамгийн хялбар байдаг. БСТ ба ХЯСТ-той үед сонгуулийн ажилтнууд нэг саналын хуудаснаас хэд хэдэн санал тоолох шаардлагатай байдаг бол Параллель ба ХХТТ-оор сонгууль зохион байгуулсан бол гол төлөв хоёр саналын хуудас тоолох шаардлагатай болно. АСТ, БТ, СШТ гэх зэрэг эрэмбэт саналын тогтолцоонд саналын хуудсан дээр нэр дэвшигчдийг эрбэлэн дугаарлаж санал өгөх учир тоолох ажиллагаа нь бүр ч илүү нарийн чимхлүүр байна.

Хүснэгт 8. Сонгуулийн 12 тогтолцооны зардал ба зохион байгуулалтыг харьцуулсан нь

	Тойргийн хил тогтоох	Сонгогчдын бүртгэл	Саналын хуудасны загвар, хэвлэлт	Сонгогчдын боловсрол	Санал хураалтын хугацаа	Нөхөн сонгууль	Санал тооллого
ХОТ	☹	☹	☺	☺	☺	☹	☺
БСТ	☺	☺	☺	☺	☺	☹	☺
ХШТ	☹	☹	☹	☺	☹	☹	☺
АСТ	☹	☹	☺	☹	☺	☹	☺
НБСТ	☺	☺	☺	☺	☺	☺	☺
ЖХТТ	☺	☹	☺	☺	☺	☺	☺
СШТ	☺	☺	☺	☹	☺	☹	☹
Параллель	☺	☹	☺	☺	☺	☺	☹
ХХТТ	☺	☹	☺	☹	☺	☺	☹
БТ	☺	☹	☺	☹	☺	☹	☺
СҮШТ	☺	☺	☺	☺	☺	☹	☺
ХЯСТ	☺	☺	☺	☺	☺	☹	☺

Түлхүүр: ☺= Зардал бага, зохион байгуулалт хялбар

☺= Зардал, зохион байгуулалттай холбоотой бэрхшээл дунд зэрэг

☹= Зардал ихтэй, зохион байгуулахад түвэгтэй

220. *Тогтвортой байдал.* Тогтолцооны тодорхой хувилбараар сонгууль зохион байгуулахад учирч болзошгүй бэрхшээл нь тухайн орны түүх, ерөнхий хам нөхцөл байдал, өмнөх туршлага, хөрөнгө нөөц зэрэг олон хүчин зүйлээс хамаарах боловч Хүснэгт 8-д янз бүрийн тогтолцоонд гарч болзошгүй зарим бэрхшээлийг тоймлон харуулахыг хичээлээ. Хүснэгтээс үзэхэд ЖХТТ, ялангуяа хаалттай жагсаалтаар санал хураадаг тогтолцоонд сонгууль явуулах нь хямд төсөр бөгөөд захиргааны тал дээр бэрхшээл бага байдаг нь харагдаж байна. НБСТ ч мөн үүнтэй адил байх ажээ. Үүний дараа СҮШТ, ХЯСТ, дараа нь БСТ, ХОТ, тэдний араас АСТ, СШТ, Параллель, Борда тооллого, ХХТТ орж байна. Зохион байгуулалт болоод зардлын хувьд хамгийн их бэрхшээлтэй байх магадлалтай тогтолцоо бол хоёр шаттай тогтолцоо ажээ.

БҮЛЭГ 6

БҮЛЭГ 6

6. Бодлого боловсруулагчдад өгөх зөвлөгөө

221. Энэхүү гарын авлагын эцэст хийж болох тов тодорхой нэг дүгнэлт бол нь юуны өмнө сонгуулийн тогтолцооны маш олон тооны боломжит хувилбар байгаа явдал юм. Гэсэн хэдий ч ихэнх бодлого боловсруулагчдын гаргадаг нэг алдаа бол эдгээр хувилбаруудыг бүрэн судлахын оронд шуудхан хамгийн сайн мэддэг тогтолцоогоо (зарим ардчилалд шинээр шилжсэн орон хуучин колонийн дэглэмийн үед хэрэглэж байсан тогтолцоог) сонгодогт оршино. Зарим тохиолдолд энхийн гэрээ хэлэлцээрт туссан тодорхой элемент, эсвэл гадны дарамт шахалт нь тодорхой тогтолцоо сонгохоос өөр аргагүй байдалд хүргэх тал бас бий.

Энэхүү гарын авлага нь сонгуулийн тогтолцооны талаар гаргах аливаа шийдвэр мэдээлэлд үндэслэн байх нөхцөлийг хангах гол зорилготой юм. Түүнээс бус сонгууль явуулж буй тогтолцоогоо бүр мөсөн өөрчлөхийг уриалаагүй ба харин ч сонгуулийн шинэчлэл хийж ирсэн янз бүрийн орны туршлагыг харьцуулан харахад тухайн үеийн тогтолцооныхоо болж бүтэж буй бүрэлдэхүүнд нь тулгуурласан аядуу шинэчлэл хийх нь цоо шинэ тогтолцоонд шилжсэн үсрэлт хийхээс илүү дээр байна.

222. Бусдын туршлагаас суралцах зүйл олон бий. Жишээлбэл, ХОТ-оос ХТТ рүү шилжихдээ сонгогдсон төлөөлөгч тодорхой тойргийн сонгогчдын өмнө хариуцлага хүлээдэг уялдаа холбоог хэвээр хадгалахыг эрмэлзэж байгаа бол 1993 онд ХХТТ авч хэрэглэсэн Шинэ Зеланд, эсвэл 2002 онд мөн тогтолцоог авч хэрэглэсэн Лесотогийн туршлагаас суралцах зүйл байж магад. Цаашлаад нэг мандаттай тойргуудаа хэвээр үлдээхийн сацуу нийгмийн бүлэг хоорондын эвсэл зохицол, харилцан ойлголцлыг дэмжих хүсэлтэй байгаа бол Номхон далайн бүс

нутгийн орнуудын (ялангуяа Фижи юм уу Папуа Шинэ Гвиней Улсын) АСТ-оор сонгууль явуулж ирсэн туршлагыг судалж болох юм. Ардчилалд шилжихийг эрмэлзэж буй боловч нийгэм нь хуваагдмал зөрчилдөөнтэй байгаа улс ЖХТТ-оор олон талын оролцоо, төлөөллийг хангасан төр засаг бүрэлдүүлж чадсан Өмнөд Африк, эсвэл СШТ-оор сонгогддог Хойд Ирландын Ассамблейн ээдрээтэй түүх хоёрын аль алинаас нь суралцах нь зүйтэй. ХШ тогтолцооны нөлөөнд үүссэн тогтворгүй байдлыг засах, сонгуулийн өндөр зардлыг бууруулахаар хичээж байгаа бол БН Ирланд Улсад хэрэглэдэг АСТ-ны талаар судлан үзэж болох юм. Энд дурдсан бүх жишээнд нэг нийтлэг зүйл байгаа нь тухайн улсын улс төрд сонгуулийн тогтолцоо нь тодорхой нөлөө үзүүлж ирсэн онцлог байна.

223. Энэхүү гарын авлагын өмнөх бүлгүүдэд туссан зөвлөгөөг энд хураангуйлан авч үзвэл:

Энгийн бөгөөд тодорхой байх

224. Үр өгөөжтэй бөгөөд тогтвортой сонгуулийн тогтолцооны загвар, бүтэц нь ерөнхийдөө сонгогч, улстөрчдийн аль алинд нь хялбар ойлгогдохоор байдаг. Тогтолцоо хэтэрхий нарийн түвэгтэй байх нь буруу ойлголт, хүсээгүй үр дагаварт хүргэж болзошгүй ба тухайлбал, сонгогчид сонгуулийн үр дүнд үл итгэх байдалд хүргэх магадлалтай.

Шинийг сэдэхээс бүү эмээхтүн

225. Өнөөдөр дэлхий дахинд хамгийн үр дүнтэйд тооцогдож буй сонгуулийн тогтолцоонууд шинэлэг арга барилд тулгуурласан байх ба маш амжилттай хэрэгжиж байна. Шинийг сэдэхийн сацуу бусдын туршлага, хөрш зэргэлдээ орнууд төдийгүй илт ялгаатай тохиолдол жишээнээс ч сурах зүйл их бий.

Ерөнхий нөхцөл байдал болоод түр зуурын шинжтэй хүчин зүйлийг ч анхаар

226. Сонгуулийн тогтолцоо хий хоосон орон зайд хэрэгжихгүй. Хэр амжилттай байх нь улс төрийн институцийг болон уламжлалт ёс заншлыг хэрхэн сайн уялдуулснаас хамаарна. Сонгуулийн шинэ тогтолцоог боловсруулагчдын хамгийн эхлээд тавих ёстой асуулт, гарааны цэг бол нэгд, нийгэм, улс төрийн ямар орчин нөхцөлд тогтолцоог боловсруулж байна вэ? Хоёрт, байнга хэрэглэгдэх тогтолцоо боловсруулж байна уу, эсвэл зөвхөн шилжилтийн үеийг даван туулахад шаардлагатай тогтолцоо боловсруулж байна уу? гэсэн асуулт байж болох юм.

Сонгогчдыг дутуу үнэлэхгүй байх

227. Тогтолцоо энгийн хялбар байх нь чухал ч гэсэн сонгогчид сонгуулийн маш олон янзын тогтолцоог ойлгож, амжилттай хэрэглэх чадвартайг дутуу үнэлэхгүй байх нь чухал. Тухайлбал, Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж байгаа орнууд нарийн түвэгтэй эрэмбэт саналын тогтолцоог (нэрдэвшигчдийг эрэмбэлэн санал өгдөг) амжилттай хэрэглэж байхад ардчиллыг шинээр тогтоосон орнуудад сүүлийн үед явуулж байгаа олон сонгуулийн туршлага нь бичиг үсэгт тайлагдсан байх, “улс төрийн” боловсролын наад захын мэдлэгтэй байх хоёр нь хоорондоо ялгаатай гэдгийг тодорхой харуулсан. Туйлын ядуу буурай орнуудад хүртэл сонгогчид улс төрийн сонголтоо, хэнийг нь илүүд үзэж байгаагаа харьцангуй боловсронгуй байдлаар тэмдэглэх, илэрхийлэх хүсэлтэй байдаг.

Хүртээмжтэй байх зарчмыг баримжаа болгох

228. Хуваагдмал ч бай, харьцангуй нэгдмэл нийгэм ч бай, хаа ч гэсэн сонгуулийн тогтолцоо нь хууль тогтоох байгууллагад янз бүрийн ашиг сонирхлыг бүрэн төлөөлүүлэх чиг баримжаанд үндэслэх ёстой. Цөөнх нь үзэл суртал, үндэс угсаа, арьс өнгө, хэл, бүс нутаг, шашны хувьд ялгаатай байна уу гэдгээс үл хамааран, ялангуяа хөгжиж байгаа орнуудад нийгмийн тодорхой бүлгийн төлөөллийг хууль тогтоох байгууллагын гадна үлдээх нь нэн аюултай сөрөг үр дагаварт хүргэсэн тохиолдол олон удаа гарч байсан.

Шийдвэр гаргах үйл явц нь сонгуулийн тогтолцоонд чухал нөлөөтэй хүчин зүйл болохыг ойлгох

229. Сонгуулийн тогтолцоог ямарарга замаар нэвтрүүлэх нь түүний хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөхөд чухал нөлөөтэй байдаг. Шийдвэр гаргах үйл явцад аль болох олон бүлгийг, түүний дотор ялангуяа сонгогчдыг өргөнөөр оролцуулах нь намын ашиг сонирхлоор тогтолцоог өөрчиллөө гэх хардлагаас сэргийлж, эцсийн үр дүн буюу сонгосон тогтолцоо нь өргөн олны дэмжлэгийг хүлээх нэг нөхцөл болдог. Хэдийгээр сонгуулийн тогтолцооны талаар шийдвэрт хүрэхээр хэлэлцэх үед намын эрх ашгийг бодох нь зайлшгүй боловч аливаа институцийг хүлээн зөвшөөрүүлж, хүндлүүлэхийн тулд өргөн хүрээтэй олон нийтийн дэмжлэг шийдвэрлэх үүрэгтэй. Тухайлбал, Шинэ Зеландын сонгуулийн тогтолцоог ХОТ-оос ХХТТ-нд шилжүүлэхийн тулд хоёр удаа бүх нийтийн санал асуулга явуулсан нь эцсийн үр дүнг хууль ёсны болгох зорилготой байв.

Нөгөө талаар 1986 онд Францын Социалист засгийн газраас тухайн үед байсан хоёр шаттай тогтолцоог ХТТ-оор солих шийдвэр гаргасныг намын эрх ашгийн үүднээс гаргасан шийдвэр гэж олон нийт үзэж байсан бөгөөд 1988 онд тус засгийн газар засгийн эрхээс буусны дараахан буцаад хуучин тогтолцоогоо хэрэглэх болжээ.

Хууль ёсны байдлыг бэхжүүлж, түүнийг гол оролцогчдоор хүлээн зөвшөөрүүл

230. Тогтолцоо нь шударга, сонгуульд амжилт олох боломжийг бүгдэд адил тэгш олгож байна гэсэн итгэл үнэмшил ардчилсан үйл явцад оролцохыг хүсч байгаа бүх талуудад адил төрж байх ёстой. Сонгуульд “ялагдсан” хүмүүс сэтгэл гутралаа тухайн тогтолцоог үгүйсгэх байдлаар илэрхийлэхгүй байх, эсвэл ардчиллын замаар урагшлах үйл явцыг тогтворгүйжүүлэх шалтаг болгож ашиглахгүй байх явдал эн тэргүүний зорилт юм. 1990 онд Никарагуад явуулсан сонгуулиар Сандинистуудыг засгийн эрхээс буулгасан боловч тэд сонгуулийн тогтолцооны тэгш шударга байдлыг зөвшөөрч байсан учраас ялагдлаа хүлээн зөвшөөрсөн байдаг. Камбож, Мозамбик, Өмнөд Африк зэрэг улс бүх талын өргөнөөр хүлээн зөвшөөрсөн институцийн зохицуулалт хийх замаар иргэний цуст дайнаа эцэслэж чаджээ.

Сонгогчдын эдлэх учиртай эрх нөлөөг баталгаатай хангах

231. Төр засаг, түүний бодлогод нөлөөлөх арга замыг сонгууль өөрсдөд нь олгож байгааг сонгогчид мэдрэх ёстой. Үүнийг олон арга замаар гүйцэлдүүлж болно. Сонгогчид намуудаас шилж сонгох боломжтой байхын сацуу өөр өөр намын төдийгүй нэг намын нэр дэвшигчдийн дундаас сонголт хийх боломжтой байх нь нэг арга зам болно. Цаашлаад мөн ерөнхийлөгчийн, дээд танхимын, доод танхимын, мужийн болон орон нутгийн сонгуулиудад өөр өөр тогтолцоогоор саналаа өгөх боломжтой байх нь бас нэг арга зам болно. Хамгийн гол өөрсдийнх нь санал дан ганц хууль тогтоох байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд төдийгүй, төр засгийн үйл ажиллагаанд бодитойгоор нөлөөлсөн гэдэгт итгэлтэй байх ёстой.

Гэхдээ дээрхийг тогтвортой улс төрийн намуудын дэмжих зорилготой тэнцүүл

232. Сонгогчдын саналын нөлөөг хамгийн дээд зэргээр хангах хүсэл эрмэлзлийг эв нэгдэлтэй, чадвартай улс төрийн намуудыг дэмжих шаардлагатай тэнцвэртэй хослуулах нь зүйтэй. Саналын хуудсан дээрх нэрсээс сонгогчдын хийх сонголтыг нэмэгдүүлэх нь ихээхэн хуваагдмал

хууль тогтоох байгууллага бий болох нөхцөл болох магадлалтай ба энэ нь эргээд хэний ч хүсээгүй үр дүнд хүргэдэг талтай. Өргөн бааз суурьтай, эв нэгдэлтэй улс төрийн намууд нь үр өгөөжтэй, тогтвортой ардчиллыг хөгжүүлэх хамгийн чухал хүчин зүйл гэдгийг улс төр судлаачид нийтээрээ хүлээн зөвшөөрдөг билээ.

Урт хугацааны тогтвортой байдал, богино хугацааны давуу тал хоёр хоорондоо тэр бүр нийцдэггүй

233. Улс төрд оролцогчид сонгуулийн шинэ тогтолцооны талаар хэлэлцэн тохирох үедээ ирэх сонгуульд өөрийн намд ашигтай гэж үзсэн саналыг тулгах нь олонтаа тохиолдоно. Гэвч энэ нь ихэнхдээ ухаалаг стратеги биш байдаг. Ялангуяа хөгжиж байгаа орнуудын хувьд нэг намын богино хугацааны амжилт эсвэл ноёрхол нь урт хугацаанд улс төрийн тогтолцооны задрал, нийгмийн эмх замбараагүй байдалд хүргэж болно. Жишээлбэл, Өмнөд Африк Улсын 1994 оны шилжилтийн сонгуулиас өмнөх нөхцөлийг аваад үзэхэд АҮК нам өөрийн ашиг сонирхлыг бодолцон тухайн үеийн ХОТ-г хэвээр үлдээж болох байв. Тус улсын хамгийн том намын хувьд ХОТ-оор сонгууль явуулснаар хамгийн олон суудал авах бүрэн бололцоотой байлаа. Гэвч тэд ХТТ-ны аль нэг хэлбэрийг авах нь зүйтэй гэсэн саналыг тууштай дэмжсэн ба уг тогтолцоогоор явуулсан сонгуульд хамаагүй бага санал авсан нь сонгуулийн богино хугацааны ялалтаас урт хугацааны тогтвортой байдал хавьгүй чухал гэдгийг олж харсны нотолгоо байлаа.

234. Үүний нэг адил сонгуулийн тогтолцоо нь улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлтийг тусгаж, улс төрийн шинэ хөдөлгөөнд орон зай олдохоор уян хатан байх шаардлагатай. Ардчилал тогтсон орнуудад хүртэл томоохон намуудыг дэмжих дэмжлэг тогтвортой байх нь ховор байдаг. Харин ардчиллыг шинээр тогтоосон орнуудын улс төр ямагт эрчимтэй хувьсан өөрчлөгдөж байдаг учир нэг удаагийн сонгуулийн зохицуулалтаар түүний үр шимийг хүртсэн нам дараагийн сонгуулиар дахиад ижил үр дүн хүлээх магадлал бага байх ажээ.

Сонгуулийн тогтолцоогоор бүх асуудлыг шийдвэрлэх аргагүй

235. Хэрвээ улс төрийн өрсөлдөөний мөн чанарыг өөрчлөө гэвэл хамгийн үр нөлөөтэй арга хэрэгсэл нь сонгуулийн тогтолцоо болох нь гарцаагүй боловч энэ нь улс төрийн эмгэг согогыг бүгдийг нь анагаах жор болж чадахгүй. Ихэвчлэн бусад хүчин зүйлийн нөлөө, ялангуяа улс төрийн соёл нь сонгуулийн тогтолцоо болон бусад институцитэй харьцуулахад ардчиллын ирээдүйд хавьгүй ихээр нөлөөлдөг. Цаашилбал, Үндсэн хуульд

туссан оновчгүй зохицуулалт, дотооддоо эв түнжингүй хүчнүүдийн ноёрхол, эсвэл тухайн улсын бүрэн эрхт байдалд заналхийлэх гадны аюул зэрэг хүчин зүйлс сайн боловсруулсан сонгуулийн тогтолцооны бүхий л эерэг нөлөөг хялбархан үгүйсгэх нь байна.

Гэхдээ сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөөг бүү дутуу үнэл

236. Ардчилалд бэрхшээл учруулж болон олон хүчин зүйл байгаа ч, тэдгээрийн зай завсраар ардчиллын ололт амжилтыг гүнзгийрүүлэх, эсвэл эсрэгээрээ түүнд саад тотгор учруулж болох улс төрийн стратегийг зориуд ухамсартайгаар хэрэглэх орон зай ч мөн оршсоор байна. Сонгуулийн тогтолцоо нь бүх бэрхшээлийг шийдэх жор биш боловч улс төрийн тогтвортой байдлыг хангахад зонхилох үүрэг гүйцэтгэдэг институци юм. Сонгуулийн тогтолцоог чадварлагаар өөрчилж боловсронгуй болгосноор нийгмийн гүнзгий хагарлыг арилгах, сэргийлэх боломж бага ч, зохистой институцийг бүрэлдүүлэх замаар зөрчил мөргөлдөөнийг намжаах, төр засгийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд улс төрийн тогтолцоог хандуулах боломж байна. Сонгуулийн тогтолцоог сайжруулж өөрчлөх замаар хүрэх үр дүн ялигүй бага мэт байвч эдгээр ялигүй бага өөрчлөлт нь ардчилал бэхжих, эсвэл доройтох эсэхийг шийдвэрлэх нь олонтаа тохиолддог ажгуу.

Сонгогчид өөрчлөлтийг хүлээн авахад бэлэн байгаа эсэхийг харгалзах

237. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх нь хэрэглэж буй тогтолцооныхоо доголдолтой талыг сайн мэдэх улс төрийн хүрээнийхний хувьд оновчтой шийдэл мэт санагдаж болно. Гэвч шинэчлэл хийх шаардлагыг олон нийтэд зөв зохистой таниулаагүй нөхцөлд тогтолцоог өөрчлөхөөр завдах нь улс төрчид ашиг сонирхлоо гүйцэлдүүлж байгаагаас цаашгүй гэж ойлгогдох эрсдэлтэй ба үүнээс үүдэн олон нийт шинэчлэлийг эсэргүүцэж болох талтай. Тогтолцооны өөрчлөлтийг улс төрийн ашиг хонжоо олох илэрхий заль мэх гэж үзэх (1989 онд Чилид, 1993 онд Иорданд, Киргизстанд 1995 оноос хойш хэд хэдэн удаа) эсвэл сонгуулийн тогтолцоог байн байн өөрчилснөөс сонгогчид төөрөлдөх (Болив үүний нэг жишээ болно гэж зарим ажиглагч үздэг) нь хамгийн хор хохиролтой байдаг.

Дутагдлыг хожим засах боломжтой гэж бүү хойш суу

238. Бүх сонгууль ялагч, ялагдагчийг төрүүлэх ба үүнтэй холбоотой сонгуулийн тогтолцоо янз бүрийн сонирхлын бай болдог. Аливаа нэг тогтолцоог хэрэглээд эхэлсэн бол тэр нь улс төрийн орчны нэг

бүрэлдэхүүн хэсэг болдог. Харин өөрчлөлт хийж байх үедээ түүнийг амар хялбар хүлээн зөвшөөрөгдөнө гэж найдах болон хожим гарч болох хүндрэл бэрхшээлийг тухайн үед нь хялбар шийдэж, залруулж болно гэж төсөөлөх нь ухаалаг бүс хэрэг юм. Хэрэв тухайн тогтолцоог хожим дахин хянаж үзэх зорилт тавьж байгаа бол ийм бололцоог уг тогтолцоонд өөрчлөлт хийх заалт бүхий хууль эрхийн бармт бичигт эртхэн тусгаж өгөх нь зүйтэй.

Өмнөх тогтолцооны хэв маягт баригдахаас зайлсхий

239. Гэсэн хэдий ч улс төрийн бодит шинэ нөхцөлд яаж үйлчлэхийг нь бодож үзэлгүй ардчиллын шинэ эрэлт хэрэгцээнд үл тохирох сонгуулийн тогтолцоог колонийн үеэ суламжлан авсан буюу хэрэглэж ирсэн тохиолдол олон байдаг. Жишээлбэл, Британийн хуучин колони байсан Ази, Африк, Номхон далайн бараг бүх улс ХОТ-г авч хэрэглэсэн байдаг. Ардчилал шинээр тогтоосон ийм олон оронд, ялангуяа үндэс угсаатны хувьд хуваагдал орнуудад ийм тогтолцоо огт тохирохгүй болох нь нотлогдсон юм. Үүний нэгэн адилаар Баруун Африк дахь хуучин Францын колони байсан олон орон (Мали гэх мэт) ХШТ-г хадгалж үлдсэний уршгаар туйлширлын хор хөнөөлийг амсч байна гэж үзэх судлаачид олон байна. Мөн хуучин социалист орнууд сонгогчдын ирцийн доод түвшин болон олонхийн шаардлагуудыг Зөвлөлтийн үеэс өвлөж үлдсэн байна. Энэхүү гарын авлагад оруулсан газрын зургийн нэг анхаарал татам онцлог бол Британийн колони байсан олон орон ХОТ-г, Францын нөлөөнд байсан орнууд ХШТ-г, Нидерландын колони байсан орнууд эх газрын Европт хэрэглэж байсан ЖХТТ-ны аль нэг хувилбарыг голдуу хэрэглэдэг гэдэг утгаараа 100 жилийн өмнөх дэлхийн колониудын газрын зурагтай олон талаар төстэй байгаа явдал юм. Гэвч энэ байдал аажмаар өөрчлөгдөж байгаа нь үнэн.

Шинэ тогтолцооны нийгмийн зөрчилд үзүүлж болзошгүй нөлөөг үнэлэн цэгнэж үз

240. Энэхүү гарын авлагын бүр эхэнд дурдсан члан сонгуулийн тогтолцоо бол дан ганц хууль тогтоох байгууллага, ерөнхийлөгчийг сонгох механизм төдийгүй хагаралтай нийгэмд зөрчлийг зохицуулах хэрэгсэл болдог. Зарим тогтолцоо нь намууд өөрийн гишүүд, дэмжигчдээс гадна бусад сонгогчдын саналыг татах арга хэмжээ авах хөшүүрэг болдог. Харамсалтай нь өнөө үед дэлхий дахинаа сонгуулийн тохиромжгүй тогтолцоо хэрэглэж байгаа орнууд олон тохиолдох бөгөөд энэ нь улс төр дэх сөрөг үзэгдлийг улам даамжруулж, улмаар намууд сонгуулийг үр

дүн нь тодорхой тоглоом мэт үзэн өөрийн дэмжигчдээс өөр бүлгүүдэд дайсагнасан, хавчиж боосон байдлаар хандах байдал ажиглагддаж байна. Аливаа улс төрийн институцийг боловсруулж байгаа үед нийгэм дэх хурцадмал байдлыг намжаахгүй ч гэсэн наад зах нь асуудлыг дордуулахгүй байхыг хичээх зарчмыг баримтлах ёстой.

Болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үз

241. Урьд өмнө гаргасан, ялангуяа гаргаад удаагүй байгаа алдаанаасаа зайлсхийх байдлаар сонгуулийн тогтолцоог боловсруулах явдал олонтаа байдаг. Ингэхдээ өмнөх хүндрэл бэрхшээлийг засах тал дээр хэтэрхий их анхаарч, энэ тал руугаа хэлбийсэн тогтолцоо боловсруулахгүй байхад анхаарах хэрэгтэй. Цаашилбал, сонгуулийн тогтолцоо боловсруулагчид алс ирээдүйд гарч болзошгүй хүндрэл бэрхшээлээс зайлсхийхийн тулд зарим гарч болзошгүй нөхцөл байдлыг ч бодолцох хэрэгтэй. Тухайлбал, шинэ тогтолцоогоор санал хураахад хэн ч ялахгүй бол яах вэ? Нэг нам бүх суудлыг авч цэвэр ялалт байгуулах боломжтой юу? Сонгуулиар хууль тогтоох байгууллагад байгаа суудлын тооноос илүү суудал хуваарилахад хүрвэл яах вэ? Нэр дэвшигчдийн санал тэнцчихвэл яах вэ? Энэ тогтолцоог хэрэглэвэл аль нэг намын дэмжигчид өөрийн дэмждэг нам, эсвэл нэр дэвшигчийн төлөө санал өгөхгүй байх нь дээр гэж үзэх нөхцөл үүсэх үү? гэх мэт.

Сонгуулийн тогтолцоо боловсруулахад анхаарах асуудлын жагсаалт

- Тогтолцоо энгийн хялбар бөгөөд ойлгомжтой байна уу?
- Ерөнхий нөхцөл байдлыг харгалзаж үзсэн үү?
- Тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохиромжтой тогтолцоо мөн үү?
- Ирээдүйд шинэчлэл хийх тохиолдолд механизмууд нь тодорхой байна уу?
- Сонгогчдыг дутуу үнэлээгүй биз?
- Тогтолцоо төлөөллийг хангах тал дээр хүртээмжтэй байна уу?
- Боловсруулах үйл явц хууль ёсны бөгөөд хүлээн зөвшөөрөгдөхүйц байв уу?
- Сонгуулийн дүнг оролцогч талууд хүлээн зөвшөөрөх болов уу?

- Гэнэтийн болзошгүй нөхцөл байдлуудыг харгалзаж үзсэн үү?
- Тогтолцоо нь санхүүгийн болон зохион байгуулах процессын хувьд авч үзэхэд тогтвортой хэрэгжих боломжтой юу?
- Энэ тогтолцоонд сонгогч эрхээ бодитой эдлэх боломжтой юу?
- Өрсөлдөөнт намын тогтолцоонд сайн нөлөө үзүүлэх үү?
- Энэ тогтолцоо Үндсэн хуульд нийцэх үү?
- Нийгэм зөрчилтэй бол түүнийг тогтолцоо даамжруулах уу, намжаах уу?

Дэлхийн 213 тусгаар улс ба холбогдох нутаг дэвсгэрийн сонгуулийн тогтолцоо (2004 он)

Улс эсвэл нутаг дэвсгэрийн ¹ Нэр	Үндэсний хууль тогтоох байгууллагын ² сонгуулийн тогтолцоо	Сонгуулийн тогтолцооны төрөл зүйл	Хууль тогтоох байгууллагын хэмжээ- Шууд сонгогдох төлөөлөгчдийн нийт тоо	Хууль тогтоох байгууллагын хэмжээ- Санал хураалтаар сонгогдох гишүүдийн нийт тоо	Давхаргын тоо	Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо
АФГАНИСТАН	СҮШТ	Бусад	249	249	1	ХШТ
АЛБАНИ	ХХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	140ӨМ	140	2	-
АЛЖИР	ЖХТТ	ХТТ	389ХА	389	1	ХШТ
АНДОРРА	Параллель (ЖХТТ+НБСТ)	Холимог	28	28	2	-
АНГОЛ	ЖХТТ	ХТТ	220	220	2	ХШТ
АНГУИЛЬ	ХОТ	ОД	7	11	1	-
АНТИГУА БАРБУДА	ХОТ	ОД	17	17	1	-
АРГЕНТИН	ЖХТТ	ХТТ	257	257	1	ХШТ
АРМЯН	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	131	131	2	ХШТ
АРУБА	ЖХТТ	ХТТ	21	21	1	-
АВСТРАЛИ	АСТ	ОД	150	150	1	-
АВСТРИ	ЖХТТ	ХТТ	183	183	3	ХШТ
АЗЕРБАЙЖАН	Параллель (ХШТ+ЖХТТ)	Холимог	125	125	2	ХШТ ³
БАХАМА	ХОТ	ОД	40	40	1	-
БАХРЕЙН	ХШТ	ОД	40	40	1	-
БАНГЛАДЕШ	ХОТ	ОД	300	300	1	-
БАРБАДОС	ХОТ	ОД	30	30	1	-

¹ Нутаг дэвсгэр гэдэгт харьяа улсынхаа хууль тогтоох байгууллагад шууд төлөөлөлгүй газруудыг оруулав.

² Хоёр танхим бүхий хууль тогтоох байгууллагатай тохиолдолд доод танхимынх нь сонгуулийн тогтолцоог жишээ болгон авав.

³ Нэр дэвшигч эхний үед сонгогдохын тулд нийт саналын гуравны хоёрыг авах шаардлагатай.

БЕЛАРУСЬ	ХШТ	ОД	110	110	1	ХШТ
БЕЛЬГИ	ЖХТТ	ХТТ	150	150	1	-
БЕЛИЗ	ХОТ	ОД	29	29	1	-
БЕНИН	ЖХТТ	ХТТ	83	83	1	ХШТ
БЕРМУДА	ХОТ	ОД	36	36	1	-
БУТАН	БАЙХГҮЙ	-	-	-	-	-
БОЛИВ	ХХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	130	130	2	ХШТ ⁴
БОСНИ ГЕРЦЕГОВИН	ЖХТТ	ХТТ	42	42	1	ХОТ
БОТСВАНИ	ХОТ	ОД	57	62	1	-
БРАЗИЛ	ЖХТТ	ХТТ	513	513	1	ХШТ
БРИТАНИЙ ВИР- ЖИНИЙ АРЛУУД	ХОТ ба БСТ	ОД	13	13	2	-
БРУНЕЙ ДАРУССАЛАМ	БАЙХГҮЙ	-	-	-	-	-
БОЛГАР	ЖХТТ	ХТТ	240	240	1	ХШТ
БУРКИНА ФАСО	ЖХТТ	ХТТ	111	111	2	ХШТ
БИРМ ⁵	ХОТ	Харьцангуй олонхийн/ Мажоритар	485	485	1	-
БУРУНДИ	ЖХТТ	ХТТ	81	179 ⁶	1	-
КАМБОЖ	ЖХТТ	ХТТ	123	123	1	-
КАМЕРУН	НБСТ/ ЖХТТ+ХОТ ⁷	Харьцангуй олонхийн/ Мажоритар	180	180	'Э'	ХОТ
КАНАД	ХОТ	ОД	301	301	1	-
КАПЕ ВЕРДЕ	ЖХТТ	ХТТ	72	72	1	ХШТ
КЭЙМАНЫ АРЛУУД	БСТ	ОД	15	18	1	-
ТӨВ АФРИКИЙН БНУ	ХШТ	ОД	105	105	1	ХШТ
ЧАД	НБСТ/ ЖХТТ+ХШТ ⁸	ОД	155ХА	155	'Э'	ХШТ
ЧИЛИ	ЖХТТ	ХТТ	120	120	1	ХШТ
ХЯТАД	БАЙХГҮЙ	-	-	-	-	-
КОЛУМБИ	ЖХТТ	ХТТ	166 ХА	166	1	ХШТ
КОМОРОС	ХШТ	ОД	18	33	1	ХОТ ⁹
БН КОНГО УЛС (БРАЗЗАВИЛЛЕ)	ХШТ	ОД	137	137	1	ХШТ

⁴ Эхний үед аль ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авахгүй бол эхний хоёр нэр дэвшигчийг Үндэсний Ассамблейн санал хураалтад оруулж нэгийг нь сонгодог.

⁵ НҮБ-ын нэр нь Мьянмар.

⁶ Шилжилтийн үед 40 нэр дэвшигчийг томилсон.

⁷ Жагсаалтаар нийт саналын үнэмлэхүй олонхийг авсан бол олон мандаттай тойрогтой НБСТ, эсрэг тохиолдолд ЖХТТ.

⁸ Аль нэг жагсаалт нийт саналын үнэмлэхүй олонхийг авсан бол олон гишүүнт тойрогтой НБСТ, эсрэг тохиолдолд ЖПТ.

⁹ Холбооны ерөнхийлөгчийг гурван гол арлаас ээлжлэн сонгодог. Сонгуулийн эхний үеийг одоогийн ерөнхийлөгч сонгогдох арал дээр явуулаад эхний гурван нэр дэвшигчийг хоёр дахь үед оруулах ба энэ үед бүх арлын сонгогчид саналаа өгөх эрхтэй байдаг.

БН АРДЧИЛСАН КОНГО УЛС (КИНШАСА)	'Ш'	-	-	-	-	-
КҮҮКИЙН АРЛУУД	ХОТ	ОД	24	24	1	-
КОСТА РИКА	ЖХТТ	ХТТ	57	57	1	ХШТДО
КОТ Д'ИВУАР	ХОТ, НБСТ	ОД	225	225	'Э'	ХШТ
ХОРВАТ	ЖХТТ	ХТТ	151	151	1	ХШТ
КУБА	ХШТ	ОД	609	609	1	-
КИПР	ЖХТТ	ХТТ	56	56	1	ХШТ
КИПР (ХОЙД)	ЖХТТ	ХТТ	50	50	1	ХШТ
БН ЧЕХ УЛС	ЖХТТ	ХТТ	200	200	1	-
ДАНИ	ЖХТТ	ХТТ	173	173	2	-
ДЖИБУТИ	НБСТ	ОД	65	65	1	ХШТ
ДОМИНИК	ХОТ	ОД	21	30	1	-
БН ДОМНИКАН УЛС	ЖХТТ	ХТТ	150 ХА	150	2	ХШТ
ЭКВАДОР	ЖХТТ	ХТТ	100 ХА	100	1	ХШТ ДО
ЕГИПЕТ	ХШТ ¹⁰	ОД	444	454	1	- ¹¹
Эль САЛЬВАДОР	ЖХТТ	ХТТ	84	84	2	ХШТ
ЭКВАТОРЫН ГВИНЕЙ	ЖХТТ	ХТТ	100	100	1	ХОТ
ЭРИТЕР	'Ш'	-	-	-	-	-
ЭСТОНИ	ЖХТТ	ХТТ	101	101	2	-
ЭТИОП	ХОТ	ОД	547 ХА	547	1	-
ФОЛКЛЭНДЫН АРЛУУД	БСТ	ОД	8	8	1	-
ФИЖИ	АСТ	ОД	71	71	2	-
ФИНЛЯНД	ЖХТТ	ХТТ	200	200	1	ХШТ
ФРАНЦ	ХШТ	ОД	577	577	1	ХШТ
ГАБОН	ХШТ	ОД	120	120	1	ХШТ
ГАМБИ	ХОТ	ОД	48	53	1	ХШТ
ГҮРЖ	Параллель (ЖХТТ+ХШТ)	Холимог	235	235	2	ХШТ
ГЕРМАН	ХХТТ (ЖХТТ+ХОТ)	Холимог	598ӨМ	598	2	-
ГАНА	ХОТ	ОД	200	200	1	ХШТ
ГИБРАЛТАР	ХЯСТ	Бусад	15	17	1	-
ГРЕК	ЖХТТ	ХТТ	300	300	2	-
ГРЕНАДА	ХОТ	ОД	15	15	1	-
ГВАТЕМАЛ	ЖХТТ	ХТТ	158 ХА	158	2	ХШТ
ГВЕРНСИ	БСТ	ОД	45	47	1	-
ГВИНЕЙ КОНАКРИ	Параллель (ЖХТТ+ХОТ)	Холимог	114	114	2	ХШТ

¹⁰ Шаардлагатай бол хоёр үет Багц саналын системээр

¹¹ Ерөнхийлөгчийг хууль тогтоох байгууллагаас 5 жилийн хугацаатай сонгодог бөгөөд бүх ард түмний санал асуулгаар баталгаажуулдаг.

ГВИНЕЙ-БИСАУ	ЖХТТ	ХТТ	102	102	1	ХШТ
ГАЯНА	ЖХТТ	ХТТ	53	65	1	ХОТ
ГАЙТИ	ХШТ	ОД	83	83	1	ХШТ
ХОЛИ СИЙ (ВАТИКАН ХОТ)	БАЙХГҮЙ	-	-	-	-	-
ГОНДУРАС	ЖХТТ	ХТТ	128	128	1	ХОТ
УНГАР	ХХТТ (ЖХТТ+ХШТ)	Холимог	386	386	3	-
ИСЛАНД	ЖХТТ	ХТТ	63	63	2	ХОТ
ЭНЭТХЭГ	ХОТ	ОД	543	545	1	-
ИНДОНЕЗИ	ЖХТТ	ХТТ	550	550	1	ХШТ ¹²
ИСЛАМЫН БН ИРАН УЛС	ХШТ	ОД	290	290	1	ХШТ
ИРАК	ЖХТТ	ХТТ	275	275	1	-
БН ИРЛАНД УЛС	СШТ	ХТТ	166	166	1	АСТ
ИЗРАИЛЬ	ЖХТТ	ХТТ	120	120	1	-
ИТАЛИ	ХХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	630	630	2	-
ЯМАЙКА	ХОТ	ОД	60	60	1	-
ЯПОН	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	480	480	2	-
ЖЕРСИ	БСТ + ХОТ	ОД	53	53	3	-
ИОРДАН	СҮШТ	Бусад	104 ¹³	110	1	-
КАЗАХСТАН	Параллель (ХШТ+ЖХТТ)	Холимог	77	77	2	ХШТ
КЕНИ	ХОТ	ОД	210	222	1	ХШТ ¹⁴
КИРИБАТИ	ХШТ ¹⁵	ОД	40	42	1	ХОТ
БНАСАУ	ХШТ	ОД	687	687	1	-
БН СОЛОНГОС УЛС	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	299	299	2	ХОТ
КУВЕЙТ	БСТ	ОД	50	65	1	-
КИРГИЗСТАН	ХШТ	ОД	75	75	1	ХШТ
БНАЛАУ	БСТ	ОД	109	109	1	-
ЛАТВИ	ЖХТТ	ХТТ	100	100	1	-
ЛИВАН	БСТ	ОД	1хоёр8	1хоёр8	1	-
ЛЕСОТО	ХХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	1хоёр0	1хоёр0	хоёр	-
ЛИБЕРИ	'Ш'	-	-	-	-	-
ЛИВИЙН АРАБЫН ЖАМАХИРИЯ	БАЙХГҮЙ'	-	-	-	-	-
ЛЕЙХТЕНШТЕЙН	ЖХТТ	ХТТ	хоёр5	хоёр5	1	-
ЛИТВА	Параллель (ХШТ+ЖХТТ)	Холимог	141	141	хоёр	ХШТ

¹² Нэр дэвшигч эхний үеэс сонгогдохын тулд нийт саналын 50+1% дээр нийт аймгуудын талд нь хамгийн багадаа 20%-ийн санал авсан байх шаардлагатай.

¹³ Доод тал нь 6 эмэгтэй сонгогдсон тохиолдолд шууд сонгогдсон төлөөлөгч 110 байна, эсрэг тохиолдолд сонгуулийн зөвлөлөөс 6 хүртэлх эмэгтэйг шууд бусаар сонгодог.

¹⁴ Нэр дэвшигч эхний үеэс сонгогдохын тулд найман мужийн тавд нь дор хаяж 25%-ийн санал авсан байх шаардлагатай.

¹⁵ Нэг гишүүнт тойргуудад жирийн ХҮС-р, шаардлагатай бол хоёр дахь үеийг цөөн тооны олон гишүүнт тойрог бүхий Багц саналын системээр явуулдаг.

ЛЮКСЕМБУРГ	ЖХТТ	ХТТ	60	60	1	-
МАКЕДОН, ХУУЧИН БН ЮГОСЛАВ УЛС	ЖХТТ	ХТТ	1хоёр0	1хоёр0	1	ХШТ
МАДАГАСКАР	ХОТ, ЖХТТ	ОД	160 ХА	160	'Э'	ХШТ
МАЛАВИ	ХОТ	ОД	193	193	1	ХОТ
МАЛАЙЗ	ХОТ	ОД	219	219	1	-
МАЛЬДИВ	БСТ	ОД	42	50	1	- ¹⁶
МАЛИ	ХШТ ¹⁷	ОД	147 ХА	147	1	ХШТ
МАЛЫТ	СШТ	ХТТ	65	65	1	-
МЭН АРАЛ	БСТ, ХОТ	ОД	24	24	'Э'	-
МАРШАЛЛЫН АРЛУУД	ХОТ, БСТ	ОД	33	33	'Э'	-
МАВРИТАНИ	ХШТ	ОД	81 ХА	81	1	ХШТ
МАВРИКИЙ	БСТ ¹⁸	ОД	70	70	1	-
МЕКСИК	ХХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	500	500	2	ХОТ
МИКРОНЕЗИЙН ХОЛБООНЫ УЛС	ХОТ	ОД	14	14	2	-
БН МОЛДАВ УЛС	ЖХТТ	ХТТ	101	101	1	-
МОНАКО	Параллель (ХХТТ+БСТ)	Холимог	24	24	2	-
МОНГОЛ	ХОТ	ОД	76	76	1	ХОТ
МОНТСЕРАТ	ХШТ ¹⁹	ОД	9	11	1	-
МАРОККО	ЖХТТ	ХТТ	325	325	2	-
МОЗАМБИК	ЖХТТ	ХТТ	250	250	1	ХШТ
НАМИБИ	ЖХТТ	ХТТ	72	78	1	ХШТ ²⁰
НАУРУ	Сайжруулсан БТ	Бусад	18	18	1	-
НЕПАЛ	ХОТ	ОД	205	205	1	-
НИДЕРЛАНД	ЖХТТ	ХТТ	150	150	1	-
НИДЕРЛАНДЫН АНТИЛЛЕС	ЖХТТ	ХТТ	22	22	1	-
ШИНЭ ЗЕЛАНД	ХХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	120 ӨМ	120	2	-
НИКАРАГУА	ЖХТТ	ХТТ	90	92	2	ХШТ
НИГР	ЖХТТ, ХОТ ²¹	ХТТ	83	83	'Э'	ХШТ
НИГЕРИ	ХОТ	ОД	360	360	1	ХШТ ²²
НИЮЭ	ХОТ, БСТ	ОД	20	20	2	-
НОРВЕГ	ЖХТТ	ХТТ	165	165	1	-

¹⁶ Ерөнхийлөгчийг хууль тогтоох байгууллагаас 5 жилийн хугацаатай сонгодог бөгөөд бүх ард түмний санал асуулгаар баталгаажуулдаг.

¹⁷ Шаардлагатай бол хоёр дахь үед НБСТ.

¹⁸ Ялагдсан нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан, эсвэл эхний 62 суудлыг хуваарилсны дараа дутуу төлөөлөлтэй үлдсэн ард иргэдийн тодорхой бүлгийн "хамгийн шилдэг ялагдагч" нарт зориулж 8 суудал үлдээдэг.

¹⁹ Нэр дэвшигчид дор хаяж 6%-ийн дэмжлэг авах босгод хүрээгүй бол хоёр дахь үеийг Багц саналын системээр явуулдаг.

²⁰ Аль ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал аваагүй тохиолдолд дараа дараагийн үеийг давтан явуулах заалт байдаг.

²¹ Нэг мандаттай үндэсний цөөнхийн тойргуудаас найман төлөөлөгч сонгодог.

²² Нэр дэвшигч эхний үеэс сонгогдохын тулд үнэмлэхүй олонхийн санал буюу мужуудын гуравны хоёрт нь дор хаяж 25%-ийн санал авсан байх шаардлагатай.

ОМАН	ХОТ	ОД	83	83	1	-
ПАКИСТАН	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	342	342	2	-
ПАЛАУ	ХОТ	ОД	16	16	1	ХШТ ²³
ПАЛЕСТИН	БСТ	ОД	89	89	1	ХОТ
ПАНАМ	ЖХТТ, ХОТ	ХТТ	78 ХА	78	'Э'	ХОТ
ПАПУА ШИНЭ ГВИНЕЙ	АСТ	ОД	109	109	2	-
ПАРАГВАЙ	ЖХТТ	ХТТ	80	80	1	ХОТ
ПЕРУ	ЖХТТ	ХТТ	120	120	1	ХШТ
ФИЛИППИН	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	²⁴ 260	260	2	ХОТ
ПИТКЭЙРНИЙ АРЛУУД	СҮШТ	Бусад	4	8	1	-
ПОЛЬШ	ЖХТТ	ХТТ	460	460	1	ХШТ
ПОРТУГАЛЬ	ЖХТТ	ХТТ	230	230	1	ХШТ
КАТАР	БАЙХГИ	-	-	-	-	-
РУМЫН	ЖХТТ	ХТТ	345 ХА	345	1	ХШТ ²⁵
ОХУ	Параллель (ЖХТТ+ХОТ)	Холимог	450	450	2	ХШТ
РУАНДА	ЖХТТ	ХТТ	53	80	1	ХОТ
САНТ ХЕЛЕНА	БСТ, ХОТ	ОД	12	14	'Э'	-
САНТ КИТТС НЕВАЙС	ХОТ	ОД	10	15	1	-
САНТ ЛЮСИЯ	ХОТ	ОД	17	17	1	-
САНТ ВИНСЕНТ ГРЕНАДИН	ХОТ	ОД	15	21	1	-
САМОА	ХОТ, БСТ	ОД	49	49	'Э'	-
САН МАРИНО	ЖХТТ	ХТТ	60	60	1	-
САН ТОМЕ ПРИНЦИП	ЖХТТ	ХТТ	55	55	1	ХШТ
САУДЫН АРАБ	БАЙХГҮЙ	-	-	-	-	-
СЕНЕГАЛ	Параллель (НБСТ+ЖХТТ)	Холимог	120	120	2	ХШТ
СЕРБ МОНТЕНЕГРО	'Ш' ²⁶	-	126	126	-	-
СЕЙШЕЛ	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	34	34	2	ХШТ
СЬЕРРА ЛЕОНЕ	ЖХТТ	ХТТ	112	124	1	ХШТ ²⁷
СИНГАПУР	НБСТ, ХОТ	ОД	84 ²⁸	94	'Э'	ХОТ

²³ Эхний үеийг нь үндсэн сонгуульд тооцох бөгөөд эндээс эхний хоёр нэр дэвшигчийг хэдэн хувийн санал авснаас үл хамааран хоёрдугаар үед шилжүүлдэг.

²⁴ Сонгуулийн үр дүнгээс хамаарч суудлын тоо 208-260 хооронд байдаг. Хоёроос дээш хувийн санал авсан ямар нэг сонирхлын бүлэг, эсвэл жижиг бүлэг дээд тал нь гурван нэмэлт суудал авдаг. Тогтсон улс төрийн намуудын хувьд энэ заалтаас суудал хожихгүй. Бүх нэмэлт жагсаалтын суудлыг заавал эзэнтэй болгох албагүй.

²⁵ Нэр дэвшигч эхний үеэс сонгогдохын тулд сонгогчдын 50 хувийн дэмжлэг авах шаардлагатай.

²⁶ Үүнийг бичиж байх үед холбооны сонгуулийн ямар нэг хүчин төгөлдөр хууль байхгүй байсан боловч холбооны бүрэлдэхүүн улсуудад сонгууль явагдаж байна.

²⁷ Нэр дэвшигч эхний үеэс сонгогдохын тулд 55%-ийн олонхийн санал авсан байх шаардлагатай.

²⁸ Сөрөг хүчнээс томилогдох гишүүдийн тоо сонгуулиас сонгуульд харилцан адилгүй буюу сөрөг хүчний намуудын авсан суудлын тооноос хамаарч 0-3 суудал байж болно. Мөн ерөнхийлөгчөөс ес хүртэл тооны төлөөлөгчийг нэмж томилж болдог.

СЛОВАК	ЖХТТ	ХТТ	150	150	1	ХШТ
СЛОВЕН	ЖХТТ	ХТТ	90	90	2	ХШТ
СОЛОМОНЫ АРЛУУД	ХОТ	ОД	50	50	1	-
СОМАЛИ	'Ш'	-	-	-	-	-
ӨМНӨД АФРИК	ЖХТТ	ХТТ	400	400	2	-
ИСПАНИ	ЖХТТ	ХТТ	350	350	1	-
ШРИ ЛАНК	ЖХТТ	ХТТ	225	225	2	НС
СУДАН	ХОТ	ОД	270	360	1	ХШТ
СУРИНАМ	ЖХТТ	ХТТ	51	51	1	-
ШВАЗИЛАНД	ХОТ	ОД	55	65	1	-
ШВЕД	ЖХТТ	ХТТ	349	349	2	-
ШВЕЙЦАРИ	ЖХТТ	ХТТ	200	200	1	-
АРАБЫН БН СИРИ УЛС	БСТ	ОД	250	250	1	29
ТАЙВАНЬ	Параллель (СУШТ+ЖХТТ)	Холимог	225	225	2	ХОТ
ТАЖИКИСТАН	Параллель (ХШТ+ЖХТТ)	Холимог	63	63	1	ХШТ
ТАНЗАНИЙ НЭГДСЭН БНУ	ХОТ	ОД	231	295	1	ХШТ
ТАЙЛАНД	Параллель (ХОТ+ЖХТТ)	Холимог	500	500	2	-
ЗҮҮН ТИМОР	Параллель (ЖХТТ+ХОТ)	Холимог	88	88	2	ХШТ
ТОГО	ХШТ	ОД	81	81	1	ХШТ
ТОКЕЛАУ	'Ш'	-	-	-	-	-
ТОНГА	БСТ	ОД	9	30	1	-
ТРИНАДАД ТОБАГО	ХОТ	ОД	36	36	1	-
ТУНИС	Параллель (НБСТ+ЖХТТ)	Холимог	189 ХА	189	2	ХОТ
ТУРК	ЖХТТ	ХТТ	550	550	1	-
ТУРКМЕНИСТАН	ХШТ	ОД	50	50	1	ХШТ
ТУРКС КЭЙКОСЫН АРЛУУД	ХОТ	ОД	13	18	1	-
ТУВАЛУ	БСТ	ОД	15	15	1	-
УГАНДА	ХОТ	ОД	214	295	1	ХШТ
УКРАИН	Параллель (ЖХТТ+ХОТ)	Холимог	450	450	2	ХШТ
АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ	БАЙХГҮЙ	-	-	-	-	-
ИХ БРИТАНИ, ХОЙД ИРЛАНДЫН НВУ	ХОТ	ОД	659	659	1	-

²⁹ Ерөнхийлөгчийг хууль тогтоох байгууллагаас 5 жилийн хугацаатай сонгодог бөгөөд бүх ард түмний санал асуулгаар баталгаажуулдаг.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС	ХОТ	ОД	435	435	1	ХОТ ³⁰
УРУГВАЙ	ЖХТТ	ХТТ	99	99	1	ХШТ
УЗБЕКИСТАН	ХШТ	ОД	250	250	1	ХШТ
ВАНУАТУ	СҮШТ	Бусад	52	52	1	-
ВЕНЕСУЭЛ	ЖХТТ (ХОТ+ЖХТТ)	Холимог	165 ХА	165	3	ХОТ
ВЬЕТНАМ	ХШТ ³¹	ОД	498	498	1	-
ЙЕМЕН	ХОТ	ОД	301	301	1	ХШТ
ЗАМБИ	ХОТ	ОД	150	158	1	ХОТ
ЗИМБАБВЕ	ХОТ	ОД	120	150	1	ХШТ

ТҮЛХҮҮР ҮГС:

Т: Саналын тархалтын шаардлага тавигдана.

Э: Эрлийз тогтолцоо.

Д: Нэр дэвшигч эхний үеэс сонгогдохын тулд доод тал нь 50% +1 саналын дэмжлэг шаардлагатай.

БАЙХГҮЙ: Ямар нэг шууд сонгууль байхгүй.

ӨМ: Нөөц мандатын тооноос хамаарч хууль тогтоох байгууллагын суудлын тоо сонгууль бүрт харилцан адилгүй байж болно.

ХА: Хүн амын тооноос хамаарч хууль тогтоох байгууллагын хэмжээ өөрчлөгдөнө.

НС: Нэмэлт санал

Ш: Шижилтийн үед байгаа улс буюу нутаг дэвсгэр: гарын авлагыг хэвлэх үед сонгуулийн шинэ тогтолцоогоо хараахан шийдээгүй байсан.

ХОТ- Харьцангуй олонхийн тогтолцоо

ХШТ- Хоёр шатлалт тогтолцоо

АСТ- Альтернатив саналын тогтолцоо

БСТ- Багц саналын тогтолцоо

НБСТ- Намын багц саналын тогтолцоо

Параллель- Параллель тогтолцоо

ЖХТТ- Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо

ЖХТТ- Жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо

СШТ- Санал шилжүүлэх тогтолцоо

СҮШТ- Санал үл шилжүүлэх тогтолцоо

ХЯСТ- Хязгаарлагдмал саналын тогтолцоо

Сайжруулсан БТ- Сайжруулсан Борда тооллого

³⁰ Ерөнхийлөгчийг сонгуулийн коллежийн үнэмлэхүй олонхийн саналаар сонгодог. Сонгуулийн коллежийн гишүүдийг мужийн түвшинд сонгодог. Гол төлөв өгөгдсөн мужид хамгийн олон санал авсан нэр дэвшигч тухайн мужийн сонгуулийн коллежийн саналыг бүгдийг нь авдаг.

³¹ Шаардлагатай бол хоёр үетэй Багц саналын системээр.

Нэр томъёоны тайлбар

Эзгүйгээр санал өгөх (*absentee voting*)- Санал хураах байранд заавал биеэр ирэлгүйгээр зайнаас санал өгөх (*remote voting*)-ийг хэлнэ.

Нэмэлт мандамтай тогтолцоо (*Additional member system*)- Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог өөрөөр ингэж нэрлэнэ.

Альтернатив санал (*Alternative vote*)- Сонгогчид саналын хуудсан дээр нэр дэвшигчдийг сонгох дарааллын дагуу дугаарлаж саналаа өгдөг, нэг мандаттай тойрогт ашигладаг нэр дэвшигч төвтэй, олонхийн тогтолцоо юм. Хүчинтэй саналын хуудсуудыг тоолоход эхний буюу нэгдүгээр сонголтоор үнэмлэхүй олонхийн (50 хувь+1) санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно. Хэрэв аль ч нэр дэвшигч эхний сонголтоор үнэмлэхүй олонхийн санал авч чадахгүй бол хамгийн бага санал авсан нэр дэвшигчийг хасч, түүний авсан саналыг бусад нэр дэвшигчдэд дахин хуваарилаад, үлдэх саналаас аль нэг нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн саналд хүртэл энэхүү хуваарилалтыг хийдэг.

Аппарантмент (*Apparentement*)- Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоонд тусдаа кампанит ажил явуулан сонгуульд оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны нам, эсвэл бүлэглэлүүд суудал хуваарилалтад хамтарч орох зорилгоор авсан саналуудаа нэгтгэн тооцуулах тохиролцоонд хүрэхийг илэрхийлэх Франц гаралтай нэр томъёо болно.

Саналын хуудасны бүтэц (*ballot structure*)- Саналын хуудас дээр сонголт хийх хэлбэр. Тухайн сонгууль нэр дэвшигч төвтэй, эсвэл нам төвтэй эсэхийг илэрхийлнэ.

Багц санал (*Block vote*)- Багц саналын тогтолцоо нь олон мандаттай тойрогт хэрэглэдэг олонхийн тогтолцооны хувилбар бөгөөд сонгогч мандатын тоотой тэнцүү тооны санал өгдөг. Санал хураалт нь нэр дэвшигч төвтэй байна. Нийт саналын дүнгээр хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцно.

Борда тооллого (*Borda count*)- Борда тооллого нь нэг, эсвэл олон мандаттай тойрогт хэрэглэгддэг нэр дэвшигч төвтэй эрэмбэт саналын тогтолцоо бөгөөд сонгогчид саналын хуудсан дээр сонголтоо тоогоор дугаарлаж тэмдэглэдэг бөгөөд тэмдэглэсэн сонголт бүрт адил тэгш хувийн жингээр оноо өгдөг. Жишээлбэл, арван нэр дэвшигчтэй тойрогт эхний сонголтод нэг оноо , хоёрдахь сонголтод 0,9 гэх мэтчилэн хуваарилж хамгийн сүүлийн сонголтод 0,1 гэсэн оноо өгнө. Эдгээр оноог нэгтгэж, нийт дүнгээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг (эсвэл нэр дэвшигчдийг) сонгогдсонд тооцдог /Сайжруулсан Борда тооллого гэснийг үзнэ үү./

Хил тогтоох (*Boundary delimitation*)- Аливаа улс, орон нутгийн төлөөллийн байгууллагын харъяалах нутаг дэвсгэр, эсвэл олон үндэстний байгууллагын хамрах нутаг дэвсгэрийг сонгуулийн тойрогт хуваах үйл явц.

Хаалттай жагсаалт (*closed list*) - Сонгогчид зөвхөн аль нэг нам, эсвэл сонгуульд оролцож буй улс төрийн бүлгийн төлөө саналаа өгөх боломжоор хязгаарлагдсан, намын жагсаалтад байгаа нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх боломжгүй хувь тэнцүүлсэн тогтолцооны нэг хувилбар. /Нээлттэй ба чөлөөт жагсаалтуудтай харьцуулж үзнэ үү./

Нийгмийн тодорхой бүлгийн сонгогчдын тусгай нэрсийн жагсаалт (*communalroll*)- Шашин, үндэсугсаа, хэл, хүйсгэх мэт тодорхой шалгуураар сонгогчдыг бүртгэлд хамруулж гаргадаг нэрийн жагсаалт. Тухайн шалгуурыг хангасан бүх сонгогч энэхүү нэрийн жагсаалтад автоматаар орох, эсвэл сонгогч бүр тухайн жагсаалтад бүртгүүлэх эсэхээ өөрсдөө шийдэж болно. Энэхүү тусгай жагсаалтыг тухайн бүлгийг хууль тогтоох байгууллагад төлөөлөх хүнийг сонгох санал хураалтыг зохион байгуулахад хэрэглэдэг.

Нөхвөр суудал (*compensatory seats*)- Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд намын жагсаалтаар хуваарилах суудлууд. ХХТТ тогтолцоонд олонхийн бүрэлдэхүүнээр сонгууль явуулахад үүссэн пропорциональ бус байдлыг засах үүднээс нам буюу бүлэглэлд хуваарилдаг нэмэлт суудал юм.

Д'Хондтын томъёо (*D'Hondt formula*)- ЖХТТ тогтолцоонд суудал хуваарилахдаа хамгийн их дунджийн аргаар хэд хэдэн цуврал хуваагч ашигладаг томъёо. Аль нэг нам, бүлэгт өгсөн саналыг 1, 2, 3 ... гэх мэт тоонд дараалан хувааж суудлыг хуваарилдаг. Д'Хондтын томъёо томоохон намуудад илүү тааламжтай байх хандлагатай /Мөн Сэйнт-Лэгуёгийн томъёог үзнэ үү./.

Суудлын хуваарилалтад оролцох нөхцөл (*Distribution requirements*)- Нэр дэвшигч мандат авахын тулд үндэсний хэмжээнд нийт саналын тодорхой хувийг аваад зогсохгүй цөөнгүй тооны муж буюу бүсээс тодорхой хэмжээний дэмжлэг авсан байх шаардлагыг хэлнэ.

Дрүүгийн квот (*Droop quota*)- Хувь тэнцүүлсэн тогтолцоонд суудал хуваарилахдаа хамгийн их үлдэгдлийн арга ашигладаг квотын хувилбар. Нийт хүчинтэй саналын тоог тухайн сонгуулийн тойрогт ноогдсон суудлын тоон дээр нэгийг нэмсэн дүнд хувааж квотыг тодорхойлно. Үүнийг мөн Хагенбах-Бишоффийн квот (а) гэж нэрлэдэг /Түүнчлэн Харегийн квот болон Импералигийн квотыг үзнэ үү./.

Сонгогч (*Elector/Voter*)- Сонгуулийн эрх бүхий, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүн.

Сонгуулийн тойрог (*Electoral district*)- Аливаа улс, орон нутаг, улсуудын холбооны байгууллагын хамрах нутаг дэвсгэрийг сонгуулийн зорилгоор хуваасан газар зүйн бүсүүд. Нэг сонгуулийн тойргоос сонгуульд байгууллагад нэг буюу түүнээс дээш төлөөлөгч сонгож болно /Нэг мандаттай тойрог болон Олон мандаттай тойрог гэснийг үзнэ үү./.

Сонгуулийн томъёо (*Electoral formula*)- Сонгогчдын өгсөн саналын тоог суудлын тоо болгон хөрвүүлэх зарчим, арга зам.

Сонгуулийн төв байгууллага (*Electoral Management Body*)- Холбогдох хуулийн дагуу сонгуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг хүлээсэн байгууллага. Ихэнх орны СТБ дээрх зорилгоор байгуулагдсан хараат бус хороо, эсвэл тодорхой төрийн байгууллагын нэг хэсэг байна.

Сонгуулийн тогтолцоо (*Electoral system*)- Аливаа төлөөллийн байгууллагад нам, нэр дэвшигчид хэрхэн сонгогдохыг тодорхойлох зарчим, арга замыг хэлнэ. Түүний хамгийн гол гурван бүрэлдэхүүн хэсэг нь сонгуулийн томъёо, санал хураах зарчим, тойргийн хэмжээ гурав юм.

Гадаадаас санал өгөх (*External voting/absentee voting*)- Гадаадад байнга буюу түр оршин сууж байгаа санал өгөх эрхтэй сонгогчдын саналыг авах механизм.

Харьцангуй олонхийн тогтолцоо (*First past the post*)- Нэг мандаттай тойргуудаар сонгуулийг зохион байгуулдаг, нэр дэвшигч төвтэй олонхи/дийлэнхийн тогтолцооны хамгийн энгийн хэлбэр. Хэдийгээр нийт хүчинтэй саналын үнэмлэхүй олонхийг аваагүй ч гэсэн бусад нэр дэвшигчээс илүү олон санал авсан нэр дэвшигчийг ялагчаар тодруулдаг.

Чөлөөт жагсаалт (*Free list*) - Сонгогчид нам, бүлгийн төлөө санал өгөхөөс гадна нэг буюу түүнээс олон нэр дэвшигчийн төлөө санал өгч болдог хувь тэнцүүлсэн тогтолцооны нэг хувилбар /Хаалттай ба нээлттэй жагсаалтыг үзнэ үү./.

Жерримандеринг (*Gerrymandering*)- Сонгуулийн тойргийн хил хязгаарыг зориуд улс төрийн тодорхой ашиг сонирхолд ашигтай, эсвэл ашиггүй байдлаар тогтоохыг хэлнэ.

Хагенбах-Бишоффийн квот (*Hagenbach-Bischoff quota*)- Дрүүпийн квотыг өөрөөр ингэж нэрлэнэ.

Харегийн квот (*Hare quota*)- Хувь тэнцүүлсэн тогтолцоонд суудал хуваарилахад хамгийн их үлдэгдлийн арга ашиглах квотын хувилбар. Ингэхдээ нийт хүчинтэй саналын тоог тухайн сонгуулийн тойрогт ногдох мандатын тоонд хувааж тодорхойлдог. Үүнийг мөн Харе Ниймайерийн квот гэж нэрлэдэг /Түүнчлэн Дрүүпийн квот болон Импералигийн квот гэснийг үзнэ үү./.

Холимог тойрог (*Heterogeneous district*)- Тойргийн зохион байгуулалтын онцлогоос, эсвэл тойргийн хил хязгаар тогтооход тавигддаг бусад шалгуураас үүдэн сонгогчид нь нийгэм, үндэс угсаа, шашин, хэлний зэрэг олон бүлгийг төлөөлөх онцлогтой сонгуулийн тойргийг хэлнэ.

Хамгийн их дунджийн арга (*Highest average method*)- Хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын саналыг суудалд шилжүүлэх бас нэг зарчим. Намын авсан саналыг тодорхой цуврал хуваагчид хувааж авах суудлын тоог тогтооно. Эдгээр хуваагчаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь Д'Хондтын болон Сэинт Лэгуёгийн томъёо юм. Хамгийн их дунджийн арга нь түүний нөгөө нэг хувилбар болох Хамгийн их үлдэгдлийн аргыг бодвол том намуудад илүү ашигтай.

Нэгдмэл тойрог (*Homogeneous district*)- Тойргийн зохион байгуулалтын онцлогоос, эсвэл тойргийн хил хязгаар тогтооход тавих шалгуураас үүдэлтэй сонгогчид нь нийгэм, үндэс угсаа, шашин, эсвэл хэлний хувьд үл ялгарах онцлог бүхий сонгуулийн тойргийг хэлнэ.

Империалигийн квот (*Imperiali quota*)- Хувь тэнцүүлсэн тогтолцоонд суудал хуваарилахад ашигладаг хамгийн их үлдэгдэлийн арга. Нийт хүчинтэй саналын тоог тухайн сонгуулийн тойрогт ноогдох суудлын тоон дээр хоёрыг нэмсэн дүнд хувааж квотыг тодорхойлдог /Түүнчлэн Дрүүгийн квот болон Харегийн квот гэснийг үзнэ үү./

Пропорциоаналь бус байдлын индекс (*Index of disproportionality*)- Сонгуульд оролцсон нам, бүлгүүдэд суудал хуваарилахдаа пропорциональ байдлаас хазайж байгаа түвшнийг хэмжих зорилготой гаргасан тоог хэлнэ. Үүнийг тодорхойлохдоо нам, бүлэг бүрийн авсан саналын эзлэх хувь ба авсан суудлын эзлэх хувийн зөрүүг квадрат зэрэгт дэвшүүлж хооронд нь нэмээд, нийлбэрээс нь язгуур гаргах арга хамгийн түгээмэл байдаг.

Хүчингүй санал (*Invalid votes*)- Сонгогч саналаа тэмдэглэхдээ санамсаргүйгээр, эсвэл зориуд алдаа гаргасны улмаас хүчинтэйд тооцох аргагүй болсон саналыг хэлнэ.

Хамгийн их үлдэгдлийн арга (*Largest Remainder Method*)- Хувь тэнцүүлсэн тогтолцоонд саналын тоог суудлын тоо болгон хөрвүүлэх бас нэг зарчим. Тогтоосон квотод хүрсэн нам, бүлэгт суудал хуваарилсны дараа зарим мандат эзэнгүй үлдэх ба зарим намын авсан санал нь квотод хүрээгүй тул суудлын хуваарилалтын гадна үлддэг. Иймд эдгээр үлдэж байгаа мандатыг үлдэгдэл саналынх нь тооны дагуу нам, бүлгүүдэд олгодог. Хамгийн их үлдэгдлийн арга нь хамгийн их дунджийн аргыг бодвол жижиг намуудад илүү ашигтай байх талтай.

Хязгаарлагдмал саналын тогтолцоо (*Limited Vote*)- Олон мандаттай тойрогт, сонгогчид нэгээс дээш, гэхдээ мандатын тооноос цөөн санал өгдөг сонгуулийн тогтолцоо. Багц саналын болон СҮШТ-ны нэг адилаар нийлбэр дүнгээр хамгийн их санал авсан нэр дэвшигч ялна.

Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо (*List Proportional Representation*)- Сонгуульд оролцож буй нам, бүлгүүд тухайн сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж танилцуулах ба сонгогчид аль нэг намын төлөө санал өгч, намууд авсан

саналынхаа эзлэх хувьтай хувь тэнцүү хэмжээний суудал авдаг тогтолцоог хэлнэ. Суудал авах нэр дэвшигчдийг тухайн жагсаалтаас тодруулдаг /Хаалттай жагсаалт, Нээлттэй жагсаалт, Чөлөөт жагсаалт зэргийг үзнэ үү./

Үнэмлэхүй олонхийн дэмжлэг (*majority*)- Сонгуульд оролцсон нийт сонгогчдын талаас (50+1) илүү хувийн санал авахыг хэлдэг.

Зохиомол олонх (*manufactured majority*)- Сонгуулиар нийт хүчинтэй саналын 50 хүрэхгүй хувийг авсан нам, эвсэл хууль тогтоох байгууллагын суудлын үнэмлэхүй олонхийг авах тохиолдлыг хэлнэ. Энэ нь олонхийн тогтолцоонд түгээмэл тохиолддог сонгуулийн үр дүн.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (*Mixed member proportional*)- Хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдийг хоёр өөр тогтолцоо ашиглан сонгох хувилбар. Үүнд гол төлөв олонхийн тогтолцооны аль нэг хувилбараар суудлын тодорхой хэсгийг, үлдсэн суудлыг хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилна. Холимог тогтолцооны хувь тэнцүүлэн суудал хуваарилах бүрэлдэхүүн нь олонхийн зарчмаар суудал хуваарилахад үүссэн пропорциональ бус байдлыг нөхөх зорилго агуулдаг.

Сайжруулсан Борда тооллого (*Modified borda count*)- Нэг, эсвэл олон мандаттай тойрогт хэрэглэдэг нэр дэвшигч төвтэй эрэмбэт саналын тогтолцоо. Сонгогчид саналын хуудсанд сонголтоо тэмдэглэхдээ тоогоор дугаарлах бөгөөд тэмдэглэсэн сонголт бүрт 1, 2, 3 гэх мэт хуваагч ашиглан тооцсон оноо өгдөг. Жишээлбэл, арван нэр дэвшигчтэй тойрогт нэгдүгээр сонголтод 1; 2 дугаар сонголтод 0.5; гуравдугаар сонголтод 0.3333 гэх мэтээр оноо өгнө. Эдгээр оноог нэгтгэж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцож зарладаг /Борда тооллого гэснийг үзнэ үү./

Олон мандаттай тойрог (*Multi-member district*)- Хууль тогтоох байгууллагад нэгээс дээш төлөөлөгч сонгогдог тойргийг хэлнэ /Мөн нэг мандаттай тойрог гэснийг үзнэ үү./

Нээлттэй жагсаалт (*Open list*)- Сонгогчид сонгуульд өрсөлдөж буй аль нэг нам, бүлгийн төлөө саналаа өгөхийн зэрэгцээ тухайн нам, бүлгээс нэр дэвшүүлсэн нэг буюу заримдаа түүнээс дээш тооны нэр дэвшигчийн төлөө саналаа өгч болдог хувь тэнцүүлсэн тогтолцооны нэг хэлбэр /Мөн хаалттай жагсаалт ба чөлөөт жагсаалт гэснийг үзнэ үү./

Параллель тогтолцоо (*Parallel system*)- Хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдийг хоёр өөр тогтолцоо ашиглан сонгох холимог тогтолцооны

бас нэг хувилбар. Ихэвчлэн нэг бүрэлдэхүүн нь олонхийн тогтолцооны аль нэг хувилбар, нөгөөх нь хувь тэнцүүлсэн тогтолцооны аль нэг хувилбар байдаг. Ингэхдээ ХХТТ-оос ялгаатай нь суудлын хуваарилалт хийхэд хоёр бүрэлдэхүүн нь хоорондоо харилцан хамааралгүй, зэрэгцээ байдлаар үйлчилнэ.

Намын багц санал (*Party block vote*)- Олон мандаттай тойргууд бүхий олонхийн тогтолцооны хувилбар. Сонгогчид нэр дэвшигчид бус, намд саналаа өгөх учир нам төвтэй тогтолцоо болно. Хамгийн их санал авсан нам тухайн сонгуулийн тойргийн бүх суудлыг авдаг.

Олонх/дийлэнхийн тогтолцоо (*Plurality/majority systems*)- Харьцангуй олонхийн (буюу бусад нэр дэвшигчдээс олон), эсвэл үнэмлэхүй олонхийн (буюу 50+1%) санал авсан нэр дэвшигч(ид) буюу намыг ялагчаар зарлах зарчимд тулгуурладаг. Ийм тогтолцоог нэг бол нэг мандаттай тойрогт (тухайлбал, харьцангуй олонхийн тогтолцоо, альтернатив саналын тогтолцоо юм уу, хоёр үе шаттай тогтолцоо), эсвэл олон мандаттай тойрогт жишээлбэл Багц саналын болон намын багц саналын тогтолцоонд ашиглаж болно.

Эрэмбэт саналын тогтолцоо (*Preferential voting system*)- Сонгогч саналын хуудсанд нэр дэвшигчдийг, эсвэл намуудыг сонгох дарааллын дагуу эрэмбэлж саналаа өгдөг сонгуулийн тогтолцоо. Альтернатив саналын тогтолцоо, Борда тооллого, Санал шилжүүлэх болон Нэмэлт саналын тогтолцоо нь бүгд сонголтот саналын тогтолцооны жишээ юм.

Хувь тэнцүүлсэн тогтолцоо (*Proportional representation*)- Энэ тогтолцоо нь сонгуульд оролцсон нам, бүлгийн авсан нийт саналыг хууль тогтоох байгууллагад эзлэх суудлын тоонд зориуд ухамсартайгаар хувь тэнцүүлэн шилжүүлэх зарчимд тулгуурладаг. Жишээлбэл, сонгогчдын нийт саналын 30 хувийг авсан нам нийт суудлын 30 орчим хувийг авах болно. ХТТ тогтолцооны янз бүрийн хувилбараар сонгууль явуулахад заавал олон мандаттай тойргоор сонгуулийг зохион байгуулах шаардлагатай. Намын жагсаалтаар санал хураах ба санал шилжүүлэх тогтолцоо нь ХТТ тогтолцооны хоёр гол хувилбар юм.

Квот (*Quota*)- Энэ нь дараахь хоёр утгын аль нэгийг илэрхийлнэ.

a. Хувь тэнцүүлсэн тогтолцоонд нам, эсвэл нэр дэвшигч нэг суудал баталгаатай авахад шаардагдах саналын тоо. Нийтлэг хэрэглэгддэг гурван

төрлийн квот байдаг нь Харегийн, Дрүүпийн (буюу Хагенбах Бишофийн), Империалигийн квотууд юм.

б. Нийгмийн тодорхой нэг бүлгийн төлөөлөгчдөд олгохоор хуульд заасан суудлын тоо, эсвэл аливаа нам, эвслээс дэвшүүлэх нэр дэвшигчдийн тоонд тэдний эзлэх ёстой хувь байж болно. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь эмэгтэйчүүдийн квот байдаг.

Нөөц суудал (*Reserved seats*)- Шашин, үндэс угсаа, хэл соёл, хүйс гэх зэрэг тодорхой шалгуураар нэр дэвшигдэх буюу сонгогдох суудал.

Сэйнт-Лэгуёгийн томъёо (*Sainte-Laguë Formula*)- Хувь тэнцүүлсэн тогтолцоонд хамгийн их дунджийн аргаар хэд хэдэн цуврал хуваагч ашиглан суудал хуваарилах арга. Аль нэг нам, бүлэглэлд өгсөн саналыг 1, 3, 5 ... гэх мэт тоонд дараалуулан хувааж суудлыг хуваарилдаг /Д'Хондтын томъёог үзнэ үү./

Нэг мандаттай тойрог (*Single-member district*)- Сонгуульд ялалт байгуулсан нэг л нэр дэвшигч хууль тогтоох байгууллагад сонгогддог сонгуулийн тойрог.

Санал үл шилжүүлэх тогтолцоо (*Single nontransferable vote*)- Сонгогчид олон мандаттай тойрогт байгаа нэг нэр дэвшигчийн төлөө санал өгдөг тогтолцоо. Нийт дүнгээр хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

Санал шилжүүлэх тогтолцоо (*Single transferable vote*)- Олон мандаттай тойрогт санал хураалтыг зохион байгуулдаг нэр дэвшигч төвтэй, сонголтот, хувь тэнцүүлсэн тогтолцоо. Нэгдүгээр сонголтын саналын тоогоор тогтоосон квотыг давсан нэр дэвшигчид шууд сонгогддог. Дараагийн тооллогуудад эхний сонголтоор хамгийн бага амжилт үзүүлсэн нэр дэвшигчийг хасч, түүний саналыг бусад нэр дэвшигчдэд хуваарилахаас гадна квотоос илүү гарсан саналуудыг амжилттай яваа нэр дэвшигчдэд хуваарилах байдлаар тооллогыг хангалттай тооны нэр дэвшигч квотод хүрч сонгогдох хүртэл үргэлжлүүлдэг.

Нэмэлт санал (*Supplementary vote*)- Альтернатив саналын тогтолцоотой төстэй, нэр дэвшигч төвтэй, эрэмбэт саналын тогтолцоо. Хэрэв нэгдүгээр сонголтоор аль ч нэр дэвшигч үнэмлэхүй олонхийн санал авахгүй бол эхний хоёр нэр дэвшигчээс бусад бүх нэр дэвшигчийг хасч, тэдний саналыг хоёрдугаар, гуравдугаар гэх мэт сонголтын дагуу дахин

хуваарилдаг. Үүний дараа хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялагчаар тодруулдаг.

Босго (*Threshold*)- Аливаа нам хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болохын тулд авах шаардлагатай саналын доод хэмжээ. Босго нь тухайн улсын үндсэн хууль, эсвэл бусад хууль тогтоомжид ихэвчлэн нийт хүчинтэй саналын тоонд эзлэх хувь хэлбэрээр илэрхийлэгдсэн тоо буюу албан ёсны босго, эсвэл хэрэглэж байгаа сонгуулийн тогтолцооны математик онцлог байдлаар илэрхийлэгдэх босго байж болно.

Хоёр шаттай тогтолцоо (*Two-round systems*)- Сонгуулийн эхний шатанд нэр дэвшигчдийн аль нь ч суудал авахад шаардлагатай тооны санал буюу ихэвчлэн үнэмлэхүй олонхийн санал авч чадаагүй бол хоёр дахь шатны сонгууль зарлан явуулдаг олонхийн тогтолцооны нэг хувилбар.

Энэ тогтолцоонд ихэвчлэн эхний шатанд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч л хоёрдугаар шатанд өрсөлдөх боломжтой байна. Гэвч заримдаа хоёр дахь шатанд хоёроос дээш нэр дэвшигч өрсөлдөх боломжтой байж болно. Үүнийг нэгжишээ бол Францын тогтолцоо бөгөөд эхний шатанд нэрийн жагсаалтад бүртгэлтэй сонгогчдын 12,5-аас дээш хувийн санал авсан бүх нэр дэвшигч хоёрдугаар шатанд оролцож болдог. Хоёр дахь шатанд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг үнэмлэхүй олонхийн санал авсан эсэхээс үл хамааран сонгогдсонд тооцно.

НЭМЭЛТ УНШИХ МАТЕРИАЛУУД

Amy, Douglas, *Real Choices: New Voices: The Case for PR Elections in the United States* /Бодит сонголтууд: Шинэ дуу хоолой: АНУ-ын ХТТ-ийн сонгуулийн жишээ/, (New York: Columbia University Press, 1993)

Andrews, Josephine T. and Jackman, Robert, 'Strategic Fools: Electoral Rule Choice Under Extreme Uncertainty' /Стратегийн арга заль: Туйлын тодорхойгүй байдалд хийх сонгуулийн дүрмийн сонголт/, *Electoral Studies* /Сонгууль судлал сэтгүүл/, 24/1 (2005), хуудас 65-84

Barkan, Joel D., 'Elections in Agrarian Societies' /Хөдөөгийн нийгэм дэх сонгуулиуд/, *Journal of Democracy* /Ардчиллын сэтгүүл/, 6(1995), хуудас 106-116

Birch, Sarah, 'Single-Member District Electoral Systems and Democratic Transition' /Нэг гишүүнт тойрог бүхий сонгуулийн тогтолцоонууд ба ардчилсан шилжилт/, *Electoral Studies* /Сонгууль судлал сэтгүүл/, 24/2 (June 2005), хуудас 281-301

Bogdanor, Vernon, *What is Proportional Representation?* /Пропорциональ төлөөлөл гэж юу вэ?/ (Oxford: Martin Robertson, 1984)

-and David Butler (eds), *Democracy and Elections* /Ардчилал ба сонгууль/ (Cambridge: Cambridge University Press, 1983)

Colomer, Josep (ed.), *Handbook of Electoral System Choice* /Сонгуулийн тогтолцооны сонголтын тухай гарын авлага/ (Basingstoke: Palgrave, 2004)

-‘It’s Parties That Choose Electoral Systems’ /*Сонгуулийн тогтолцоог намууд сонгодог*/ (or Duverger’s Laws Upside Down – буюу Дүвергерийн Хуулийн толгойг уруу харуулах нь), *Political Studies* /*Улс төр судлал сэтгүүл*/, 53(2005), pp. 1-21

Dahl, Robert, *On Democracy* /*Ардчиллын тухай*/ (New Haven, Conn.: Yale University Press, 1998)

Downs, Anthony, *An Economic Theory of Democracy* /*Ардчиллын эдийн засгийн онол*/ (New York: Harper and Row, 1957)

Duverger, Maurice, *Political Parties: Their Organization and the Modern State* /*Улс төрийн намууд: Тэдгээрийн зохион байгуулалт ба орчин үеийн төр*/ (New York: John Wiley, 1954)

Elklit, Jorgen and Nigel S. Roberts, ‘A Category of its Own? Four PR Two-Tier Compensatory Member Electoral Systems in 1994’ /*Өөрийн гэсэн ангилал уу? ХТТ-ийн хоёр давхаргат нэмэлт нэмэлт гишүүн бүхий 1994 оны дөрвөн сонгуулийн тогтолцоо*/, *European Journal of Political Research* /*Улс төрийн судалгааны Европын сэтгүүл*/, 30 (1996), хуудас 217-240

Farrell, David M., *Electoral Systems: A Comparative Introduction* /*Сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан танилцуулга*/ (London and New York: Palgrave, 2001)

Finer, S.E. (ed.), *Adversary Politics and Electoral Reform* /*Сөргөлдөөнт улс төр ба сонгуулийн шинэтгэл* /, (London: Anthony Wigram, 1975)

Gallagher, Michael, ‘Comparing Proportional Representation Electoral System: Quotas, Thresholds, Paradoxes, and Majorities’ /*Пропорциональ төлөөллийн сонгуулийн тогтолцоо: Квот, босго, гаж үзэгдэл, олонхи* /, *British Journal of Political Science* /*Британийн улс төрийн ухааны сэтгүүл*/, дугаар 22 (1992), хуудас 469-496

Golder, Matt, ‘Democratic Electoral System Around the World 1946-2000’ /*Дэлхийн дахины ардчилсан сонгуулийн тогтолцоо*/, *Electoral Studies* /*Сонгууль судлал сэтгүүл*/, 24/1 (2005), хуудас 103-121

Grofman, Bernard and Arend Lijphart (eds), *Electoral Laws and their Political Consequences* /*Сонгуулийн хуулиуд ба тэдгээрийн улс төрийн үр дагавар*/ (New York: Agathon Press, 1986)

Grofman, Bernard and Arend Lijphart, Robert McKay and Howard Scarrow (eds), *Representation and Redistricting Issues /Төлөөлөл ба тойргийг шинэчлэн тогтоох асуудлууд/* (Lexington, Md.: Lexington Books, 1982)

Guiner, Lani, *The Tyranny of the Majority /Олонхийн дарангуйлал/* (New York: Free Press, 1994)

Hermens, Ferdinand, *Democracy or Anarchy? A Study of Proportional Representation /Ардчилал уу, Анархи уу? Пропорциональ төлөөллийн судалгаа/*, 2nd edition (New York: Johnson Reprint Corporation, 1972)

Horowitz, Donald L., 'Democracy in Divided Societies' /Хуваагдмал нийгмүүд дэх ардчилал/, *Journal of Democracy /Ардчиллын сэтгүүл/*, 4 (1993), хуудас 18-38

'Electoral System : A Primer for Decision Makers' /Сонгуулийн тогтолцоо: Шийдвэр гаргагчдын цагаан толгой/, *Journal of Democracy /Ардчиллын сэтгүүл/*, 14 (2003), хуудас 115-127

Jones, Mark P., *Electoral Laws and the Survival of Presidential Democracies /Сонгуулийн хуулиуд ба Ерөнхийлөгчийн ардчилал тэсэн үлдсэн нь/* (Notre Dame, Ind.: University of Notre Dame Press, 1995)

Lakeman, Enid, *How Democracies Vote /Ардчилсан орнууд саналаа яаж өгдөг вэ/* (London: Faber and faber, 1974)

Lardeyret, Guy, 'The Problem with PR' /ХТТ-ийн асуудлууд/, *Journal of Democracy /Ардчиллын сэтгүүл/*, 2 (1991), хуудас 30-35

LeDuc, Lawrence, Richard G. Niemi and Pippa Norris (eds), *Comparing Democracies 2: Elections and Voting in Global Perspective /Ардчилсан орнуудыг харьцуулахуй 2: Сонгууль ба санал хураалт дэлхий нийтийн төлөв/* (Thousand Oaks, Calif.: Sage, 2002)

Lijphart, Arend, 'Constitutional Design for Divided Societies' /Хуваагдмал нийгэм дэх үндсэн хууль боловсруулалт/, *Journal of Democracy /Ардчиллын сэтгүүл/*, 15/2(2004)

-*Patterns of Democracy /Ардчиллын хэв загвар/* (New Heaven, Conn.: Yale University Press, 1999)

-and Bernard Grofman (eds), *Gender and Party Politics /Жендэр ба намын бодлого/* (London: Sage, 1993)

Mackie, Thomas and Richard Rose, *The International Almanac of Electoral History* /*Сонгуулийн түүхийн олон улсын хуанли*/ (Washington, DC: Congressional Quarterly Press, 1991)

Mackie, Thokmas and Richard Rose, *A Decade of Election Results: Updating the International Almanac. Studies in Public Policy* /*Сонгуулийн үр дүнгүүдийн арван жил: Олон улсын хуанлийг шинэчлэх нь, Төрийн бодлогын судалгаанууд*/ (Glasgow: Centre for the Study of Public Policy, University of Strathclyde, 1997)

Mainwaring, Scott and Matthew Shugart, *Presidentialism and Democracy In Latin America* /*Латин Америк дахь ерөнхийлөгчийн засаглал ба ардчилал*/ (Cambridge: Cambridge University Press, 1997)

Miragliotta, Narelle L., 'Little Differences, Big Effects: An Example of the Importance of Choice of Method For Transferring Surplus Votes in PR-STV Voting System' /*Бага ялгаа ба их нөлөө: ХТТ-ийн СИТ тогтолцоонд илүүдэл санал шилжүүлэх арга сонгохын ач холбогдлын жишээ*/, *Representation* /*Төлөөлөл сэтгүүл*/, 41/1 (2004) [2005], хуудас 15-23

Moser, Robert G. and Ethan Scheiner, 'Mixed Electoral Systems and Electoral System Effects: Controlled Comparison and Cross – National Analysis' /*Сонгуулийн холимог тогтолцоо ба сонгуулийн тогтолцооны нөлөө: Хяналттай харьцуулалт ба үндэсний хэмжээнд хийсэн задлан шинжилгээ*/, *Electoral Studies: An International Journal* /*Сонгууль судлал: Олон улсын сэтгүүл*/, 23/4 (December 2004), хуудас 575-600

Nishikawa, Misa and Erik S.Herron, 'Mixed Electoral Rules' Impact on Party Systems' /*Холимог сонгуулийн дүрмээс намын тогтолцоонд үзүүлэх нөлөө*/, *Electoral Studies: An International Journal* /*Сонгууль судлал: Олон улсын сэтгүүл*/, 23/4 (December 2004), хуудас 753-768

Nohlen, Dieter, *Elections and Electoral Systems* /*Сонгууль ба сонгуулийн тогтолцоо*/, (Delhi: Macmillian, 1996)

-(ed.), *Enciclopedia Electoral Latinamericana y del Caribe* (San Jose, Costa Rica: Instituto Interamericano de Derechos Humanos (IIDH)/CAPEL8 1993)

-et al., *Elections in Africa* /*Африк дахь сонгууль*/, (Oxford and New York: Oxford University Press, 1999)

-et al., *Elections in the Asia-Pacific Region /Ази-Номхон далайн бүсийн сонгуулиуд/*, (Oxford and New York: Oxford University Press, 2001)

Norris, Pipa, *Electoral Engineering: Voting Rules and Political Behavior /Сонгуулийн инженерчлэл: Санал хураалтын дүрмүүд ба улс төрийн зан байдал/*, (Cambridge: Cambridge University Press, 2004)

Pitkin, Hanna F., *The Concept of Representation /Төлөөллийн тухай төсөөлөл/*, (Berkeley, Calif.: University of California Press, 1967)

Rae, Douglas W., *The Political Consequences of Electoral Laws /Сонгуулийн хуулийн улс төрийн үр дагаврууд/*, (New Haven, Conn.: Yale University Press, 1967)

Reilly, Ben, *Democracy in Divided Societies /Хуваагдмал нийгэм дэх ардчилал/*, (Cambridge: Cambridge University Press, 2001)

-‘Global Spread of Preferential Voting: Australian Institutional Imperialism?’
/Сонголтот саналын дэлхий нийтийн тархалт: Австралийн институцийн империализм/, *Australian Journal of Political Science / Австралийн улс төрийн ухааны сэтгүүл/*, 39/2 (July 2004), pp. 253-266

Reynolds, Andrew (ed.), *The Architecture of Democracy /Ардчиллын архитектур/*, (Oxford: Oxford University Press, 2001)

- *Electoral Systems and Democratization in South Africa /Өмнөд Африк дахь сонгуулийн тогтолцоо ба ардчилах үйл явц/*, (Oxford: Oxford University Press, 1999)

Rule, Wilma and Joseph Zimmerman (eds), *Electoral Systems in Comparative Perspective: Their Impact on Women and Minorities /Сонгуулийн тогтолцооны харьцуулсан судалгаа: Тэдгээрийн эмэгтэйчүүд ба цөөнхөд үзүүлэх нөлөө/*, (Westport, Conn.: Greenwood, 1994)

Sartori, Giovanni, *Comparative Constitutional Engineering: An Inquiry Into Structures, Incentives, and Outcomes /Үндсэн хуулийн бүтэц, зохион байгуулалтын харьцуулалт: Бүтэц, сонирхол, үр дүнгийн асуудлууд/*, (New York: Columbia University Press, 1994)

Shugart, Matthew S. and John Carey, *President and Assemblies: Constitutional design and Electoral Dynamics* /*Ерөнхийлөгч ба ассамблей: Үндсэн хуулийн бүтэц, зохион байгуулалт ба сонгуулийн динамик* /, (Cambridge: Cambridge University Press, 1992)

Shugart, Matthew S. and Martin P.Wattenberg, *Mixed-Member Electoral Systems: The Best of Both Worlds?* /*Холимог гишүүнт сонгуулийн тогтолцоо: Хоёр ертөнцийн хамгийн шилдэг нь үү?* /, (Oxford: Oxford University Press, 2004)

Sisk, Timothy D., *Power Sharing and International Mediation in Ethnic Conflicts* /*Үндэс угсаатны зөрчлийн үеийн эрх мэдлийн хуваарилалт ба олон улсын зуучлал* /, (Washington, DC: United States Institute of Peace and Press, 1996)

Taagepera, Rein and Matthew S. Shugart, *Seats and Votes: The Effects and Determinants of Electoral Systems* /*Суудал ба санал: Сонгуулийн тогтолцооны үр нөлөө ба тодорхойлогч хүчин зүйлс* /, (New Haven, Conn.: Yale University Press, 1989)

Сонгогчдын өгсөн саналд үндэслэн мандат хуваарилахад сонгуулийн тогтолцооны үзүүлэх нөлөө

Жишээ 1.

Нэг мандаттай таван тойрог бүхий харьцангуй олонхийн тогтолцоо (ХОТ), нэг том тойрог бүхий намын жагсаалтаар санал хураах тогтолцоонд (ЖХТТ) улс төрийн хоёр нам 25,000 саналын төлөө өрсөлдөж байна гэж бодъё.

	Сонгуулийн тойргууд							Авсан суудал	
	1	2	3	4	5	Нийт	%	ХОТ	ЖХТТ
А нам	3 000	2 600	2 551	2 551	100	10 802	43	5	2
Б нам	2 000	2 400	2 499	2 499	4 900	14 198	57	1	3
Дүн	5 000	5 000	5 000	5 000	5 000	25 000	100	5	5

Түлхүүр: ХОТ= Харьцангуй олонхийн тогтолцоо, ЖХТТ= намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо, суудлыг Харегийн квот буюу Хамгийн их үлдэгдлийн аргаар хуваарилна.

А нам Б намаас хамаагүй цөөн суудал авсан боловч ХОТ-оор суудал хуваарилахад нийт таван суудлын дөрвийг нь авсан байна. Харин ЖХТТ-оор бол Б нам гурван суудал, А нам хоёр суудал авч байна. Энэ жишээ хэтэрхий туйлширсан мэт харагдаж байгаа ч иймэрхүү үр дүн олонхийн тогтолцоонд нэлээд тохиолддог.

Жишээ 2.

Хоёрдахь жишээнд дээрх хоёр сонгуулийн тогтолцоо хэвээр байх боловч сонгуульд таван нам өрсөлджээ гэж төсөөлье. Ингэхэд дараахь үр дүн харагдаж байна.

	Сонгуулийн тойргууд							Авсан суудал	
	1	2	3	4	5	Нийт	%	ХОТ	ЖХТТ
А нам	2 000	2 000	2 000	2 00	50	6 250	25	3	1
Б нам	500	500	500	3 750	500	5 750	23	1	1
В нам	500	250	750	1 000	3 000	5 500	22	1	1
Г нам	1 000	500	1 700	25	1 025	4 250	17	0	1
Д нам	1 000	1 750	50	25	425	3 250	13	0	1
Дүн	5 000	5 000	5 000	5 000	5 000	25 000	100	5	5

Түлхүүр: ХОТ= Харьцангуй олонхийн тогтолцоо, ЖХТТ= намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо, суудлыг Харегийн квот буюу Хамгийн их үлдэгдлийн аргаар хуваарилна.

ЖХТТ-оор А нам Д намаас бараг хоёр дахин их суудал авсныг эс тооцвол бүх нам нэг суудал авсан байна. Харин ХОТ-оор хамгийн том нам (А) таван суудлын олонхийг авч, хамгийн олон санал авсан дараагийн хоёр нам (Б, В) тус бүр нэг суудал ногдож байна. Иймээс сонгуулийн тогтолцоо нь хууль тогтоох байгууллагын бүтцэд, цаашилбал парламентын тогтолцоонд засгийн газрын бүрэлдэхүүнд эрс нөлөө үзүүлэхээр байна.

Жишээ 3.

Гуравдахь жишээнд мөн л хоёр нам сонгуульд оролцох боловч, энэ удаад сонгогчдын тоо 50,000, мандатын тоо арав байна гэж бодъё. Харин сонгуулийн тогтолцоо нь Параллель тогтолцоо (таван суудлыг ЖХТТ-оор, үлдсэн тавыг нь ХОТ-оор хуваарилна), ХХТТ (тавыг ЖХТТ-оор, тавыг ХОТ-оор) байна.

	Сонгуулийн тойргууд								Авсан суудал	
	1	2	3	4	5	5 мандат	Нийт	%	Параллель	ХХТТ
А нам	2 600	2 600	2 600	2 600	3 100	13 500	27 000	54	Нийт 8: (ХОТ:5 + ЖХТТ: 3)	Нийт 5: (ХОТ:5 + ЖХТТ: 0)
Б нам	2 400	2 400	2 400	2 400	1 900	11 500	23 000	57	Нийт 2: (ХОТ:0 + ЖХТТ: 2)	Нийт 5: (ХОТ:0 + ЖХТТ: 5)
Дүн	5 000	5 000	5 000	5 000	5 000	25 000	50 000	100	10	10

Түлхүүр: Параллель= ЖХТТ ба ХОТ-оос бүрдсэн Параллель тогтолцоо, ХХТТ=ЖХТТ ба ХОТ-оос бүрдсэн Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ЖХТТ-нд суудлыг Харегийн квот буюу хамгийн их үлдэгдлийн аргаар хуваарилна).

Параллель тогтолцоогоор А нам найман суудал, Б нам үлдэх хоёр суудлыг авч байна. ХОТ-ны бүх таван суудал, ЖХТТ-ны гурван суудал бүгд А намд очиж байгаа нь нийт саналын 54 хувиар нийт суудлын 80 хувийг авч байна гэсэн үг. Харин ХХТТ-нд ЖХТТ-ийн элемент нь ХОТ-ны нөлөөнд бий болсон пропорциональ бус байдлыг нөхөж, нам тус бүр тав, таван суудал авсан байна. Тодруулбал, бидний авсан жишээнд, ХХТТ-оор А нам ХОТ-ны таван суудлыг бүгдийг нь, Б нам ЖХТТ-ны таван суудлыг бүгдийг нь авч байна.

ХХТТ-оор саналын эзлэх хувийн харьцаа 54:46 байхад суудлыг 50:50 харьцаагаар буюу параллель тогтолцооны үр дүнгээс хамаагүй илүү тэнцвэртэйгээр хуваарилсан байна. Энэ нь харьцангуй олонхийн тогтолцоотой зэрэгцүүлэн хэрэглэж байгаа ЖХТТ ба олонхийн тогтолцооноос үүссэн пропорциональ бус байдлыг нөхөх зорилготой ЖХТТ-ийн элемент хоёрын ялгааг тодорхой харуулж байна.

Тойргийн хил тогтоох

Энд үзүүлсэн хоёр зураг нь тойргийн хил тогтоох бие даасан тогтсон арга байхгүйгэсэн зарчмыг харуулахыг зорьж байна. Сонгуулийн тогтолцооны бүтэц, зохион байгуулалттай нэг адил сонгуулийн тойргийн хил тогтоох нь техникийн шинжтэй процесс мэт боловч эцсийн дүндээ улс төрийн үр дагавартай шийдвэр байдаг бөгөөд ашиг сонирхол бүхий талууд өөрт ашигтай улс төрийн шийдэлд хүрэх гэж зүтгэх нь ойлгомжтой.

Эдгээр зурагт төвдөө жижиг хот, эргэн тойрондоо хөдөө нутаг бүхий газар нутагт тойргийн хил тогтоох хоёр өөр арга хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна. Энэ нутгийн нийт хүн амын тоонд үндэслэн тогтоосон мандатын тоо нь хоёр байна. Хүн амын дөчин хувь нь хотод, жаран хувь нь хөдөө амьдардаг.

Асуудлыг хялбарчлах үүднээс хотод байгаа хүн бүр Ажилчдын намын төлөө, хөдөөгийн оршин суугч бүр Фермерүүдийн намын төлөө саналаа өгдөг гэж үзье. Мэдээж бодит амьдрал дээр илүү нарийн түвэгтэй байх боловч үүнээс болж математик зарчмууд нь өөрчлөгдөхгүй.

Загвар 1 буюу Цагирагын (*Doughnut*) зарчмаар хотын хүн амын бүтэц нь харьцангуй нэг янз нэг мандаттай тойрог (НМТ) бүхий нийгмийн нэг бүлэг гэж үзэн хоёр тойргийн сонгогчдын тоог тэнцүүлэхийн тулд ойролцоох хөдөө нутгаас багахан хэсгийг нэмж оруулсан байна. Хөдөө нутгийн ихэнх хэсэг нь хоёрдахь нэг янзын НМТ-ийг бүрдүүлж байна. Ингээд сонгууль явуулахад хотын тойрогт Ажилчдын нам, хөдөөгийн тойрогт Фермерүүдийн нам ялалт байгуулсан байна.



Загвар 2 буюу Хавчуургын (*Burger*) зарчмаар бол уг газар нутгийг түүний дундуур урсаж буй голын дагуу хоёр хуваасан байна. Ингэснээр сонгогчдын төлөөлийн хувьд холимог хоёр НМТ бий болох бөгөөд нэгэнд нь хотын хойд хэсэг ба түүнийг тойрсон хойд талын хөдөө нутаг, нөгөөд нь хотын урд хагас ба түүнийг тойрсон хөдөө нутаг багтана. Хоёр тойргийн аль алинд нь Фермерүүдийн нам 60 хувийн саналаар ялалт байгуулж хоёр суудлыг хоёуланг авсан байна.


Энэ тохиолдолд Ажилчдын нам хотын нэгдмэл тойргийн давуу талыг онцолж тойргийн хил тогтоох үүрэг бүхий байгууллагыг ятгахаар оролдох ба Фермерүүдийн нам нийгмийн янз бүрийн бүлэг оролцсон бүтэц бүхий холимог тойргийг чухалчилж үүний эсрэг дундаа “цоорхой” тойрог байх нь зохисгүй гэж маргахад гайхах зүйлгүй!

Хот ба хөдөө: Хоёр мандат

Загвар 1: Цагирагын зарчим

Хотынхон бүгд Ажилчдын намын төлөө санал өгнө. Хөдөөгийнхөн бүгд Фермерүүдийн намын төлөө санал өгнө.



	Тойрог А:	Ажилчид 80% Фермерүүд 20%
	Тойрог Б:	Фермерүүд 100%
	Үр дүн:	Ажилчид 1 суудал Фермерүүд 1 суудал




Хот ба хөдөө: Хоёр мандат

Загвар 1: Хавчуургын зарчим

Хотынхон бүгд Ажилчдын намын төлөө санал өгнө. Хөдөөгийнхөн бүгд Фермерүүдийн намын төлөө санал өгнө.

	Тойрог А:	Ажилчид 40% Фермерүүд 60%
	Тойрог Б:	Ажилчид 40% Фермерүүд 60%
	Үр дүн:	Фермерүүд 2 суудал



Зохиогчдын тухай

Эндрю Рейнольдс

Чэпел Хилл дэх Хойд Каролинагийн Их сургуулийн Улс төрийн ухааны дэд профессор Эндрю Рейнольдс Кэйп Тауны Их сургуулиас магистрийн зэрэг, Сан Диего дахь Калифорнийн Их сургуулиас PhD цол хүртжээ. Тэрээр ардчилах үйл явц, үндсэн хууль боловсруулалт, сонгуулийн улс төрийн сэдвээр голлон хичээл зааж, судалгаа хийж байна. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллага, Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн (IDEA), Их Британийн Олон Улсын Хөгжлийн газар, АНУ-ын Төрийн Департамент, Үндэсний Ардчиллын Институци, Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн, Европ дахь Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (OSCE) зэрэг байгууллагуудад ажиллаж байсан байна. Тэрээр сонгуулийн болон үндсэн хуулийн зохион байгуулалтын асуудлаар Афганистан, Ангол, Бирм, Фижи, Гаяана, Индонези, Ирак, Иордан, Либери, Нидерланд, Хойд Ирланд, Сьерра Леоне, Өмнөд Африк, Судан, Зимбабве улсуудад зөвлөхөөр ажиллаж байв.

Ноён Рейнольдсын судалгааны ажил АНУ-ын Энхтайвны Институци (USIP), Шинжлэх Ухааны Үндэсний сан, Фордын сангийн шагналыг хүртэж байв. Түүний бичсэн номуудаас *Ардчилалын архитектур: Үндсэн хууль боловсруулалт, зөрчлийн удирдлага ба ардчилал* (Oxford University Press, 2002), *Өмнөд Африкийн сонгуулийн тогтолцоо ба ардчилах үйл явц* (Oxford University Press, 1999), *Өмнөд Африкийн 99 оны сонгууль: Манделагаас Мбеки хүртэл* (Saint Martin's Press, 1999), *Африк дахь сонгууль ба зөрчлийн удирдлага* (Тим Сисктэй хамтран бичсэн, USIP, 1998) зэргийг дурдаж болно. Түүний бичсэн нийтлэлүүд *Дэлхийн улс төр* (World Politics), *Хууль зүй судлалын улирал тутмын сэтгүүл* (Legislative Studies Quarterly),

Ардчилах үйл явц (*Democratization*), Ардчилал, улс төр, нийгмийн сэтгүүл (*the Journal of Democracy, Politics and Society*), Хамтын нөхөрлөлийн орнууд ба харьцуулсан улс төрийн бодлогын сэтгүүл (*Journal of Commonwealth and Comparative Politics*), Улс төрийн шинжлэх ухаан улирал тутмын сэтгүүл (*the Political Science Quarterly*) зэрэг сэтгүүл дээр тавигдаж байжээ.

Бэн Рэйлли

Бэнжамин Рэйлли бол Австралийн Үндэсний Их сургуулийн Ази, номхон далайн эдийн засаг ба засгийн газрын сургуулийн ахлах багш хүн юм. Тэрээр өмнө нь Нью Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн (UNDP) ардчилсан засаглалын хөтөлбөрийн зөвлөх, Австралийн Үндэсний Их сургуулийн судалгааны ажилтан, мөн АСТОУХ-ийн хөтөлбөрийн ахлах ажилтнаар ажиллаж байв. Тэрбээр бүтээлүүдээ улс төрийн институциуд, ардчилах үйл явц, зөрчлийн удирдлага зэрэг сэдэвт голлон чиглүүлж ирсэн бөгөөд эдгээр асуудлаар олон орны засгийн газар, олон улсын байгууллагуудад зөвлөгөө өгч байв. Одоо тэрээр Ази-Номхон далайн бүсийн ардчилал, үндэс угсаатан, засаглалын тухай шинэ ном дээрээ ажиллаж байна.

Түүний бичсэн номуудаас *Хуваагдмал нийгэм дэх ардчилал: Зөрчлийн удирдлагад зориулсан сонгуулийн зохион байгуулалт* (Cambridge University Press, 2001), *Хуваагдмал нийгэм дэх сонгуулийн тогтолцоо ба зөрчил* (US National Research Council, 1999), *Ардчилал ба гүнзгий зөрчил: Хэлэлцээр хийгчдийн сонгох боломжууд* (International IDEA, 1998), *Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалтын тухай АСТОУХ-ийн гарын авлага* (International IDEA, 1997) зэргийг нэрлэж болно. Тэрбээр мөн *Ардчиллын сэтгүүл* (*Journal of Democracy*), *Олон улсын улс төрийн шинжлэх ухааны тойм* (*the International Political Science Review*), *Олон улсын аюулгүй байдал* (*International Security*), *Үндэсний ашиг сонирхол* (*The National Interest*), *Намын улс төрийн бодлого* (*Party Politics*), *Сонгууль судлал* (*Electoral Studies*), *Австралийн улс төрийн шинжлэх ухааны сэтгүүл* (*Australian Journal of Political Science*), *Австралийн гадаад хэргийн сэтгүүл* (*the Australian Journal of International Affairs*), *Олон улсын энхийг сахиулах ажиллагаа* (*International Peacekeeping*), *Хамтын нөхөрлөлийн орнууд ба харьцуулсан улс төрийн бодлого* (*Commonwealth and Comparative Politics*), *Төлөөлөл* (*Representation*), *Азийн судалгаа* (*Asian Survey*), *Номхон далайн тойм* (*Pacific Review*), *Номхон далайн асуудлууд* (*Pacific Affairs*), *Номхон далайн түүхийн сэтгүүл* (*Journal of Pacific History*), *Номхон далайн эдийн засгийн бюллетень* (*Pacific Economic Bulletin*) зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлэлээ хэвлүүлж байв. Тэрээр Австралийн Үндэсний Их сургуулиас улс төрийн ухааны PhD цол хүртжээ.

Эндрю Эллис

Эндрю Эллис одоогоор Стокгольм дахь АСТОУХ-д Сонгуулийн үйл явцын багийн ахлагчаар ажиллаж байна. Тэрбээр ардчилсан шилжилтийн орнуудад сонгуулийн болон институцийн асуудлаар техникийн зөвлөх хийж байсан өргөн туршлагатай. Тэр 1999-2003 онд Индонезид Үндэсний Ардчилсан Институцийн (NDI) ахлах зөвлөхөөр ажиллаж, Индонезийн хууль тогтоох байгууллагын гишүүдтэй үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, сонгуулийн ба улс төрийн хуулиудын шинэтгэлийн асуудлаар хамтран ажилласан төдийгүй төрийн бус байгууллагууд (ТББ), улс төрийн тоймчидтой ажиллаж байв. Мөн 1996 оны Палестиний анхны сонгуульд бэлтгэхэд бүхий л талаар дэмжлэг үзүүлэх Европын Комиссын шийдвэрийн дагуу Палестиний сонгуулийн комисст техникийн ахлах зөвлөхөөр ажилласнаас гадна тус Комиссоос Камбожийн 1998 оны сонгуульд туслалцаа үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж төлөвлөх ажлыг гүйцэтгэсэн байна.

Тэрбээр урьд нь Их Британийн Либераль Намын дэд дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, Их Британийн Либерал Ардчилсан намын даргаар ажиллаж байсан бөгөөд Их Британийн Парламентад дөрвөн удаа нэр дэвшиж, орон нутгийн захиргааны байгууллагад сонгуульг гишүүнээр ажиллаж байв.

Жозе Антонио Чейбаб

1994 онд Чикагогийн Их сургуулиас PhD цол хүртсэн Жозе Антонио Чейбаб нь Йелийн Их сургуулийн Олон улс судлалын хөтөлбөрийн бакалаврын сургалт хариуцсан захирал, улс төрийн ухааны дэд профессор хүн юм. Тэрбээр харьцуулсан улс төр, улс төр эдийн засаг, ардчилсан институциудийн чиглэлээр сонирхон судалж, хичээл заадаг. Тэр мөн *Ардчилал ба хөгжил: Дэлхий дэх улс төрийн институциуд ба сайн сайхан байдал, 1950-1990* (Cambridge University Press, 2000), *Ардчиллын сурвалж ном* (MIT Press, 2003) зэрэг номын хамтран зохиогч бөгөөд одоогоор *Парламентын болон Ерөнхийлөгчийн засаглал дахь ардчиллын тогтвортой байдлын тухай* номоо дуусгаж байна.

Карен Кокс

Карен Кокс Виржиниагийн Их сургуульд харьцуулсан болон Японы улс төрийн бодлогын чиглэлээр PhD цол горилогч юм. Тэрбээр Япон сангийн докторын тэтгэлэгт судалгааг Токиогийн Их сургуульдээр хийсэн. Түүний Леонард Шоппатай хамтран бичсэн 'Холимог гишүүнт сонгуулийн тогтолцооны харилцан нөлөөлөл: Онол ба Герман, Япон, Итали улсуудын

туршлага' хэмээх бүтээл *Харьцуулсан улс төр судлал* сэтгүүлийн 2002 оны 11 дүгээр сарын дугаарт нийтлэгджээ.

Донг Лишенг

Донг Лишенг Хятадын Нийгмийн ухааны академийн Улс төрийн шинжлэх ухааны хүрээлэнгийн профессор, орлогч дарга юм. Тэрээр 1996-2001 онд Хятадын тосгодын зөвлөлийн сонгуулиудын талаарх НҮБХХ-ийн хамтын ажиллагааны хөтөлбөр хариуцсан мэргэжилтнээр Хятадын Иргэний хэргийн яаманд ажиллаж байв. Одоо тэр ЕХ-Хятадын хамтарсан Тосгоны засаглалын тухай сургалтын хөтөлбөрийн Удирдах ба зөвлөх хорооны гишүүний үүрэг гүйцэтгэдэг (2003-2006). Түүнийг мөн ЕХ-Хятадын хамтарсан Европ судлалын төвүүдийн хөтөлбөрийн Хятадын талын захирлаар томилоод байна (2004.02-2009.01). Тэрээр тосгоны зөвлөлүүдэд зориулсан сонгуулийн сургалтын гарын авлага боловсруулж хэвлүүлжээ.

Юрген Элклит

Юрген Элклит Дани Улсын Архусын Их сургуулийн улс төрийн ухааны профессор юм. Түүний мэргэжлийн сонирхдог чиглэлийн тоонд сонгуулийн тогтолцоо, шинээр төрөн гарч байгаа болон бусад орны сонгуулийн удирдлагын асуудал ордог. Тэрбээр 1990 оноос хойш Ази, Европ, Африкийн орнуудад сонгууль, ардчилах үйл явцтай холбоотой хэд хэдэн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Мөн 1994 онд Өмнөд Африкийн Хараат бус сонгуулийн комиссын (IEC) гишүүн байв. Тэрбээр хамгийн сүүлд Афганистан, Өмнөд Африк, Хятад, Лесото улсад томилолтоор ажиллажээ. Түүний хамгийн сүүлд гаргасан ном нь Ларс Биллетэй хамтран бичсэн Данийн улс төрийн намын гишүүдийн судалгаа байлаа (*Partiernes medlemmer*, Aarhus Universitetsforlag, 2003).

Майкл Галлагер

Майкл Галлагер Дублиний Их сургуулийн Тринити коллежийн Улс төрийн ухааны тэнхмийн дэд профессор юм. Тэрбээр *Сонгуулийн тогтолцооны улс төр* (Oxford University Press, 2005), *Бүгд Найрамдах Ирланд Улсын улс төр*, дөрөвдэх хэвлэл (хамтран бичсэн, Routledge, 2005), *Европ дахь бүх нийтийн санал асуулгын туршилага* (Macmillan and St. Martin's Press, 1996), *Орчин үеийн Европын Төлөөллийн засгийн газар*, дөрөвдэх хэвлэл (Mcgraw Hill, 2006) зэрэг номыг хамтран бүтээжээ.

Аллен Хикен

Аллен Хикен Мичиганы Их сургуулийн улс төрийн ухаан болон Зүүн Өмнөд Азийн улс төрийн бодлогын дэд профессор, Зүүн Өмнөд Ази судлалын төв ба Улс төр судлалын төвийн туслах багш юм. Тэрбээр

хөгжиж байгаа орнуудын улс төрийн институциуд ба улс төр эдийн засгийг судалдаг. Голчлон хөгжиж байгаа ардчилсан орнуудын улс төрийн нам, намын тогтолцоо, тэдгээрийн бодлого боловсруулах үүргийн талаар судалдаг. Тэрбээр Зүүн Өмнөд Азийн бүсээр дагнан мэргэжсэн бөгөөд Тайланд, Филиппин, Камбожид ажиллаж, судалгаа хийж байв.

Карлос Хьюнеус

Карлос Хьюнеус Чилийн Их сургуулийн Олон улс судлалын хүрээлэнгийн улс төрийн ухааны дэд профессор бөгөөд CERC корпорацийн гүйцэтгэх захирал юм. Тэрбээр хамгийн сүүлд *Пиночетийн дэглэм* (Editorial Sudamericana, 2000), *Чили, хуваагдмал улс* (Catalonia, 2003) зэрэг ном бичжээ.

Южин Хаский

Южин Хаский нь Флорида дахь Стетсоны их сургуулийн улс төрийн ухаан ба Орос судлалын залуу профессор Уиллиам Р. Кенан юм. Түүний бичсэн ном, нийлэлүүдэд ЗХУ-ын улс төр, эрх зүйн асуудлууд, Зөвлөлтийн дараахь Оросын улсууд, Киргизстаны талаар судалсан байдаг. Түүний бүтээлүүдийн дотор Киргизстаны 1990, 1995, 2000 оны сонгуулиудын тухай нийтлэлүүд багтдаг.

Стина Ларсеруд

Стина Ларсеруд *Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалт: Ардчилал, Сонгуульд Туслах Хүрээлэнгийн олон улсын шинэ гарын авлага* номын судлаач бөгөөд Стокгольм дахь АСТОУХ-ийн Сонгуулийн үйл явцын багийн бүрэлдэхүүнд ажилладаг. Тэрбээр харьцуулсан улс төрийн бодлого, институцийн зохион байгуулалтын чиглэлээр Уппсалагийн Их сургуулиас улс төрийн ухааны магистр цол хүртсэн, Шведийн сонгуулиудад санал хураах байрны комиссын гишүүнээр ажилладаг.

Вижэй Патида

Вижэй Патида нь Энэтхэгийн төрийн ахлах албаны (Энэтхэгийн төрийн захиргааны алба) гишүүн бөгөөд энэтхэгийн үндэсний ба орон нутгийн түвшний сонгууль болон олон улсын хэмжээний сонгуулийн асуудлаар мэргэжсэн хүн юм. Тэрбээр Мадхя Прадеш мужийн сонгуулийн хорооны ахлах ажилтан, НУБ-ын энхийг сахиулах ажиллагааны сонгуулийн хэсэг хариуцсан зөвлөх, АСТОУХ-ийн Сонгуулийн багийн даргаар ажиллаж иржээ.

Найжел С.Робертс

Найжел С.Робертс Уэллингтон дахь Викториагийн Их сургуулийн улс төрийн ухааны дэд профессор юм. Тэрбээр Жонатан Бостон, Стефен Левине, Элизабет МакЛэйи нарын хамтаар Шинэ Зеландад пропорциональ төлөөллийг нэвтрүүлсний захиргааны болон улс төрийн үр дагаврыг судлах зорилгоор Шинэ Зеландын Судалгаа, шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлсэн судалгааны багийн гишүүнээр найман жилийн турш ажилласан байна. Тэр хамгийн сүүлд *Шинэ Зеланд саналаа өгч байна: 2002 оны бүх нийтийн сонгууль* (Victoria University Press, 2003) хэмээх номоо хэвлүүлжээ.

Ричард Венгрофф

Коннектикатын Их сургуулийн улс төрийн ухааны профессор Ричард Венгрофф долоон ном бичиж, редакторласнаас гадна эрдэм шинжилгээний сэтгүүлд 70 гаруй нийтлэл хэвлүүлж, олон ном хянан тохиолдуулжээ. Тэрбээр одоо ардчилсан засаглал, төвлөрлийг сааруулах, сонгуулийн шинэтгэлийн асуудлаар судалгаа хийж байна. Түүний хамгийн сүүлд гаргасан хоёр бүтээл нь ардчилсан шилжилт ба лалын шашин, Зүүн Европын таван орон дахь орон нутгийн ардчилсан шинэтгэлийн асуудалтай холбоотой байв.

Жеффри А.Уэлдон

Жеффри А.Уэлдон бол Мексикийн Технологи Автономо Институцийн (ITAM) улс төрийн ухааны профессор бөгөөд одоогоор Сан Диего дахь Калифорнийн Их Сургуулийн АНУ-Мексик судлалын төвд зочин судлаачаар ажиллаж байна. Тэр 2001 оноос хойш Стратегийн болон олон улс судлалын төвд (CSIS) туслах судлаачаар ажиллаж байна. Тэрбээр Мексикийн Конгресс ба Мексикийн сонгуулийн тогтолцооны талаар олон өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.

Талархал

Энэхүү шинэ гарын авлагыг боловсруулахад асар олон хувь хүн, байгууллага хувь нэмрээ оруулаад байна. Дэлхийн олон орны сонгууль удирдах байгууллага, хууль тогтоох байгууллагын гишүүд, элчин сайдын яамдын ажилтнууд өргөн хүрээтэй янз бүрийн асуудлаар мэдээлэл өгсөн билээ. Түүнчлэн энэхүү номын хүрээг нэгтгэн гаргахад цаг хугацаа, бодол санаа, хүч оюунаа харамгүй зориулсандараахь хүмүүс болон байгууллагад талархал илэрхийлмээр байна:

Жозе Мария Араназ, Шем Балдеосингх, Жюлий Бэллингтон, Бригалиа Бам, Виржиний Бераменди-Хайне, Саара Бирч, Андре Блайс, Невен Брандт, Напя Браун, Ингрид Бэкштрём-Воze, Николас Коттрелл, Бикаш Даш, Аша Элкариб, Юрген Елклит, Арпинэ Галфаян, Гүидо Галли, Мариа Гратчев, Лиза Хагман, Дональд Л. Хоровиц, Торкуато Ярдим, Еве Иоханссон, Сабхэш Кэшяп, Анна Катц, Терезэ Пийрс Лаанела, Лотта Ланн, Стефен Левине, Аренд Лижфэрт, Иохан Линдрот, Алонсо Люжамбио, Валенти Марти, Симон Массий, Ричард Матланд, Андрес Межиа-Акоста, Марсел Микала, Жозе Молина, Симон Пьер Нанителамио, Паоло Натале, Са Нигиди, Пиппа Норрис, Саймон Пачано, Вижэй Патидаар, Карина Перелли, Колвилле Петти, Иорам Рукамбе, Эндрью Расселл, Мэттью Шугарт, Ольга Швецова, Тимоти Д. Сиск, Бруно Спек, Антонио Спинелли, Сара Стэйно, Майкл Стийд, Торвальд Шолтенберг, Маркку Сюкси, Кэйт Сулливан, Иан Сандберг, Райн Таагепера, Маяа Тьернстрём, Дэниел Зоватто нар болон Сонгуулийн шинэтгэлийн асуудлаарх Бритиш Колумбийн Иргэдийн Ассамблей.

Мөн АСТОУХ-ийн хэвлэл нийтлэлийн менежер Надя Хандал Зандерт талархаж байна.

Юун түүэнд бид Стина Ларсерудад талархлаа илэрхийлмээр байна. Тэрбээр гарын авлагын төсөл боловсруулах олон үе шатад шаардлагатай асар их материал, текст, техникийн баримт бичгүүдийг эмхтгэн бүрдүүлж дэмжлэг үзүүлсэн юм. Түүнээс сайн, илүү идэвх зүтгэлтэй судлаач, редакцийн багийг дэмжигчийг бид хаанаас ч олохгүй байлаа.

*Эндрю Рэйнольдс
Бэн Рэйлли
Эндрю Эллис
2005 оны Хоёрдугаар сар*

АСТОУХ-ийн тухай

1995 онд байгуулагдсан Ардчилал, Сонгуульд Туслах Олон Улсын Хүрээлэн (АСТОУХ) бол дэлхий дахинд тогтвортой ардчиллыг дэмжих эрхэм зорилготой, бүх тивийн гишүүн орнуудаас бүрдсэн засгийн газар хоорондын байгууллага юм. АСТОУХ нь ардчиллын чиг хандлагад дүн шинжилгээ хийж, хяналт тавьдаг хүмүүс ба улс төрийн шинэтгэлд шууд оролцож буюу ардчиллыг дотооддоо болон гадаадад дэмжиж ажилладаг хүмүүсийн харилцаанд тулгуурлаж үйл ажиллагаагаа явуулдаг. АСТОУХ шинээр ардчилсан болон ардчилал тогтсон орнуудын аль алинтай нь хамтран ажиллаж, ардчилсан институци болон ардчиллын соёлыг хөгжүүлж, бэхжүүлэхэд туслалцаа үзүүлдэг. Тус байгууллага олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж, төрөл бүрийн байгууллагатай түншилж ажилладаг.

АСТОУХ-ийн зорилго

- Улс орнуудад ардчилсан институци хөгжүүлж бэхжүүлэх чадавхийг бий болгоход туслалцаа үзүүлэх
- Дэлхийн эргэн тойронд буй эрдэм шинжилгээний ажилтнууд, бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүдийн хооронд яриа хэлэлцүүлэг өрнүүлэх талбар болох
- Судалгаа болон бодит ажлын туршлагыг нэгтгэх, ардчилсан үйл явцыг сайжруулахад туслах практик хэрэгслүүдийг боловсруулах
- Сонгуулийн удирдлага дахь илт тод, хариуцлагатай, үр ашигтай байдлыг дэмжин сурталчлах
- Иргэдээс улс орондоо ардчиллын үнэлгээ, хяналт шинжилгээ, сурталчилгаа хийхэд дэмжлэг үзүүлэх

Хаяг:

International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA)

Stromsborg, S-103 34 Stockholm, Sweden

Утас: +46 8 698 3700

Факс: +46 8 20 24 22 Е-мэйл: info@idea.int

Вэбсайт: www.idea.int

